



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧТАЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

/Багшийн гарын авлага/



УЛААНБААТАР 2022 ОН



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧТАЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР 2022 ОН



	БОЛОВСРУУЛСАН:	ЭКСПЕРТ:
Зургаан настай хүүхдийн хөгжлийн онцлог, түүнийг судлах арга зүйн зөвлөмж	Ганболд БЯМБАТОГТОХ Доктор (Ph.D) МУБИС, Багшийн сургуулийн Бага боловсрол арга зүйн тэнхимийн сэтгэл судлалын багш	Бирваа ОЮУНЦЭЦЭГ МУБИС, Багшийн сургуулийн зөвлөх, доктор дэд профессор
Тэгш хамруулан сургах боломж, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж	Баатархүү НОРОВДОО БГД-ийн 38 дугаар сургуулийн багш	Цэдэнсодном ОТГОНБАЯР СБД-ийн 25 дугаар тусгай сургуулийн багш, хэл засалч
Бэлтгэл хөтөлбөр	Лхагважав УРТНАСАН Нийслэлийн Боловсролын Газрын мэргэжилтэн	Наянбаатар БОЛДБААТАР Нийслэлийн Боловсролын Газрын мэргэжилтэн
Монгол хэл	Шагдар ОЮУНЦЭЦЭГ Монгол хэл I сурах бичгийн зохиогч Даринчулуун АМАР-ЭНХ ХУД-ийн Жет Тэмүүлэл сургуулийн багш	Цэнд-Очир БАЯСГАЛАН БЕГ, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын мэргэжилтэн
Математик	Шаравдорж ЭНХ-АМГАЛАН БЕГ, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн Дагва ХИШИГЖАРГАЛ БЗД-ийн Шинэ Монгол сургуулийн багш	Цагаанбаатар НАРАНТУЯА БЕГ, Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газрын арга зүйч, ахлах мэргэжилтэн
Хүн ба Орчин	Цагаанбаатар НАРАНТУЯА БЕГ, Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газрын арга зүйч, ахлах мэргэжилтэн Олгаржав НАРАНЦЭЦЭГ БЗД-ийн Шинэ Монгол сургуулийн багш	Амирдаабазар ГАНЧИМЭГ Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн
Иргэний ёс зүйн боловсрол	Чимэд ЭНХТУЯА СБД-ийн 1-р сургуулийн багш	Амирдаабазар ГАНЧИМЭГ Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн
Дүрслэх урлаг, технологи	Нацагдорж ХҮДЭРЧУЛУУН МУБИС, Багшийн сургуулийн багш Цэндхүү ЗОЛЗАЯА МУБИС, Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн багш	Баатар БАТТУЛГА БЕГ, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн
Хөгжим	Халтар ЭНХЖАРГАЛ Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн ЭША Урансанаа УУГАНЦЭЦЭГ Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн	Даваадорж АРИУНБОЛД БЕГ, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн
Биеийн тамир	Даваасамба МЭНДБАЯР БЕГ, Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газрын арга зүйч, мэргэжилтэн Давааням НАРАНТУЯА БЕГ, Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газрын арга зүйч, мэргэжилтэн	Зоригт САМДАНЖАМЦ БМТТ-ийн цахим сургалтын хөтөлбөрийн зөвлөх



ГАРЧИГ

05

Өмнөх үг буюу Багш танаа

НЭГ. НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

06

1.1. Зургаан настай хүүхдийн хөгжлийн онцлог, түүнийг судлах арга зүйн зөвлөмж

20

1.2. Тэгш хамруулан сургах боломж, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

31

2.1. Бэлтгэл хөтөлбөр

47

2.2. Монгол хэл

65

2.3. Математик

87

2.4. Хүн ба Орчин

102

2.5. Иргэний ёс зүйн боловсрол

110

2.6. Дүрслэх урлаг, технологи

125

2.7. Хөгжим

139

2.8. Биеийн тамир

ГУРАВ. ХАВСРАЛТ

157

3.1. Хавсралт



БАГШ ТАНАА

Боловсрол, шинжлэх ухааны яам, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн дэмжлэгээр “Нэгдүгээр ангийн сурагчтай ажиллах арга зүй” багшид зориулсан гарын авлагын та бүхэндээ хүргэж байна.

2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж, 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургаж эхэлсэн нь ерөнхий боловсролын тогтолцоо, сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлсэн чухал алхам болсон.

Сүүлийн жилүүдэд ялангуяа цар тахал гарсан, цэцэрлэгийн хүртээмж бага зэргээс шалтгаалан сургуульд элсэгчдийн ялгаатай байдал, багшийн хүрэлцээ харилцан адилгүй байна. Иймд ялгаатай хэрэгцээ бүхий шинээр сургуульд элсэн орох сурагчдын нас, сэтгэхүйн онцлог, танин мэдэхүй, бие бялдрын хөгжлийн онцлогийг ойлгож, хүүхдийг сургуульд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх хэрэгтэй болоод буй энэ цаг үед багшлахуйд суралцаж, дижитал альфа эриний шинэхэн сурагчдыг ойлгон хөгжүүлцгээе.

Хүүхдүүд сургуульд орсноор тоглох үйл нь суралцах үйлд шилжинэ. Сургуульд элсэн орж буй бяцхан хүүхдэд баяр баясгалантайгаар суралцах бүх талын дэмжлэг тусалцаа нэн чухал. Шинэ сурагч хүлээн авах сургууль, багш нарын зүгээс 6 настай суралцагчийн нас, сэтгэхүй, оюун ухаан, бие бялдрын онцлогийг сайтар судалж, сургалтын орчинд дасан зохицох, үүрэг хариуцлага хүлээж сурах, суралцах арга барил эзэмшихэд нь онцгой анхаарч эцэг эх, асран хамгаалагчидтай мэдээлэл солилцон тэдэнд зөв дадал хэвшилтэй амьдрах ухааны анхан шатны суурь чадварыг эзэмшсэн шинэ зууны иргэн төлөвшүүлэхэд хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

2021-2022 оны хичээлийн жилийн эхэнд “Сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаа” авах аргачлал, судалгааны үр дүнг дүгнэн харахад сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын багш нар агуулгын залгамж холбоог судалж, хамтран ажиллах, эцэг эх, асран хамгаалагчид, дотуур байрын багш нар уялдаа холбоотой хүүхдийн хөгжлийн дэмжин ажиллах шаардлагатайг харуулсан.

Багш та альфа үеийн хүүхдүүдийн сонирхлыг судлах, сэтгэн бодох үйл явцыг олж мэдэх, мэддэг зүйлээ үе тэнгийнхэнтэйгээ болон дэлхий ертөнцтэй хуваалцах боломжийг олгохын тулд сургалтын орчин бүрдүүлж, сургуульд дасан зохицох, нийгэмших хэрэгцээнд нийцүүлэн сэтгэл, оюун, хүчээ дайчлан ирээдүй үеийн боловсролын төлөө хамтдаа зүтгэе.

Сургалтын бүх боломжуудыг ашиглах нь энэ үеийн суралцагчдын сэтгэлийг хөдөлгөж илүү үр дүнтэй технологийн туршлагыг бий болгохыг шаардана.




1.1. ЗУРГААН НАСТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ, ТҮҮНИЙГ СУДЛАХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

Зургаан настай хүүхдийн хөгжлийн онцлог

Хүүхэд суралцахад бэлэн болсон эсэх нь юуны өмнө түүний биологийн өсөлтөөр тодорхойлогдоно. 6 нас бол маш их эрч хүч агуулсан нас байдаг. Зарим судлаачид 6 насыг хүний хөгжлийн оргил үе гэж нэрлэдэг. Юуны түрүүнд хүүхэд сэтгэл санааны хувьд сургуулийн амьдралд татагдан, цэцэрлэгт байгаагүй шинэ содон зүйлстэй таарахыг ихэд хүсэн сонирхоно. Хүүхдийн тэргүүлэх үйл ажиллагаа нь хичээл, хөгжлийн тэргүүлэх нөхцөл нь “Хүүхэд-Багш-Нийгэм” гэсэн харилцаа болж өөрчлөгдөнө.¹ Хүүхэд нэгдүгээр ангид элсэн орсноор сэтгэцийн шинэ бүрдлүүд үүсдэг онцлогтой. Шинэ сурагч болох нь нийгмийн шинэ бүрдэл бөгөөд үүрэг, хариуцлагаа ухаарч зан байдлаа зохицуулан өөрчилж эхэлнэ. Өглөө бүр эрт босох, сургуульд явах, гэрийн даалгавар хийх зэрэг шинэ үүргийг биелүүлнэ.

Зургаан настай хүүхдийн хөгжлийн үндсэн чиглэл: Хүүхдийн тархи идэвхтэй ажиллах тусам улам хөгжиж байдаг. Хөгжил гэдэг нь хүүхдийн бие бялдрын өсөлт, сэтгэл хөдлөл, зан байдал, сэтгэн бодох чадвар, харилцааны ур чадварын өөрчлөлтүүдийг хэлнэ. Эдгээр чиглэлүүд нь өөр хоорондоо уялдаа холбоотой. Хүүхдийн хөгжлийн үндсэн 5 чиглэл байдаг.

Бүдүүвч зураг 1. Хүүхдийн хөгжлийн үндсэн чиглэл²



Эдгээр хөгжлийн нөлөөн дор хүүхдийн хөгжлийн насны онцлог нь ялгаатай байдаг. Үүнд:

Хүснэгт 1. 6-7 насны хүүхдийн хөгжлийн насны онцлог³

Хөгжлийн чиглэл	6 настай хүүхдийн онцлог	7 настай хүүхдийн онцлог
Бие бялдар	тархины жин 1250 г (насанд хүрсэн хүний тархины жингийн 90%)	Тархины жин 1280 г (насанд хүрсэн хүний тархины жингийн 91,4%)
	Хөдөлгөөн ихтэй, үсэрч харайх дуртай, хөгжмийн хэмнэлийг ялган сонсдог	Бие даан гутлаа үдэх, 2 дугуйтай дугуй унах чадвартай
	6 (7) нас хүрэх үед гавлын ясны эрчимтэй өсөлт явагдаж, ясжилт үндсэндээ дуусаж, зулай битүүрч, гавлын заадаснууд бэхэждэг.	
Сэтгэл хөдлөл	- Сэтгэлийн хөдөлгөөнөө барьж чаддаггүй хянах чадвар сул - Амархан баярлаж амархан гомддог - Өрөвдөх сэтгэлд суралцаж байдаг - Айдас түгшүүр үүсдэг	- Бусдын үзэл бодлыг ойлгох, сэтгэл хөдлөлөө удирдах талаар суралцаж байдаг - Өөрийгөө зохицуулах чадвартай болно - Илүү их өрөвдөх сэтгэлтэй болдог - Айдас түгшүүр хэвээрээ үргэлжилдэг
Нийгэмшихүйн хөгжил	- Шүүмжлэлд их мэдрэмтгий ханддаг. - Найз нөхдөө хүндлэх чадвартай - Хүйсийн ялгааны талаар ойлголттой болно	- Хамгийн сайн найздаа итгэдэг - Үе тэнгийнхэн манлайлагч нэгнийг сонирхоно
Танин мэдэхүйн хөгжил	- Сурч танин мэдэх сонирхол өндөр - Үсэг, үе, үг бичих чадвартай болно - “Яагаад” гэсэн асуудлыг хамгийн их тавьдаг - Хурдан тогтоож хурдан мартана.	- Буруу болон зөвийг тунгаадаг - Унших, математикийн ур чадвар улам бүр хөгжиж, бие даан бичиж чаддаг - Асуудлыг шийдвэрлэхийг эрмэлздэг - Шударга байх, шударга биш байх талаар ерөнхий ойлголттой болдог - Сэтгэхүйн нарийн үйлүүд хөгжиж эхэлдэг



Хэл яриа (харилцан ойлголцох ба хүлээн авах).	- Ярих дуртай - Хэл яриа хурц, идэвхтэй үгийн нөөц нэмэгдэнэ - Түүх, үлгэр зэргийг бусдад ярих, илэрхийлэх чадвараа хөгжүүлж байдаг	- Хэл яриа түргэн хөгждөг - Дүрмийн ур чадваруудыг илүү эзэмшдэг - Асуултуудад тодорхой хариулж чаддаг - Үг яриа олон утга санаатай болохыг таньж мэддэг
---	---	---

Эцэг, эх, асран хамгаалагчид хайртай үр хүүхдэдээ эрдэм ном заалгахаар багшид хүлээлгэн өгдөг.⁴ Энэ насны сурагчидтай ажиллах багш ямар байх ёстой вэ?, хүүхэд багшаас юу хүсэж байдаг талаар авч үзье.

Хүснэгт 2. Зургаан настай хүүхэдтэй ажиллах багш ямар байх ёстой вэ?

6 насны хүүхэд багшаас юу хүсдэг вэ?	6 насны хүүхэдтэй ажиллах багш ямар байх ёстой вэ?
✓ Намайг анхааралтайгаар сонсдог ✓ Надад санаа тавьдаг ✓ Чин сэтгэлээсээ ойлгож харилцдаг ✓ Миний сайн талыг амархан олж хардаг ✓ Царай зүс, гадна өнгө үзэмжээр ялгаварладаггүй ✓ Чанга дуугаар загнадаггүй	✓ Сэтгэл хөдлөлөө зөв удирддаг ✓ Инээмсэглэл, хүүхдийг хайрладаг ✓ Хүүхдүүдтэй харилцах дуртай, харилцаа тогтоохдоо сайн ✓ Өөртөө итгэлтэй, хөгжилтэй, өөдрөг ✓ Бусдын сайн талыг амархан олж хардаг ✓ Бүх сурагчаасаа амжилт хүлээдэг, тэдэнд боломж олгодог ✓ Хүүхдийг анхааралтай сонсдог

Багшийн сэтгэл хөдлөлөө удирдах чадвар, хүнлэг энэрэнгүй байх чанар зэрэг нь багш сурагчийн харилцаа, зан үйлийг удирдах арга барилтай шууд холбоотой. Гэвч зарим тохиолдолд бид өдөр тутмын амьдралын өөрчлөлт, өсөлт хөгжлийг дэмжихдээ анхаарал илүү хандуулдаг боловч үйл хөдлөл дээрээ бодлогогүй үг хэлэх, урам зоригийг мохоох, загнах, зандрах зэрэг үйлүүдийг санамсаргүйгээр илэрхийлэх тохиолдол байдаг. Тиймээс хүүхдүүдэд урам зориг өдөр бүр хэрэгтэй гэдгийг санах нь чухал. Үүний тулд тэдэнд дараах үгсийг байнга хэлж байгаарай. Жишээ нь: (гайхалтай, би чамаар бахархаж байна, сайн байна)

Хүүхэд 6 настайдаа юу хийж чадах вэ? Хүүхдийн хувьд одоо байгаа ур чадвар нь өргөжиж, сайжирч байдаг. Хүүхэд шинэ мэдлэг олж авч түүнийгээ практикт хэрэглэж сурдаг.⁵ Үүнд:

- Түүх, үлгэр ярих, өөрөө зохиож ярьдаг
- Бие даан хувцаслах, гутал өмсөх, өөртөө үйлчлэх
- Геометрийн дүрсүүдийг ялгаж танина
- Хэмжээ, өнгө, тоонуудыг ялган ангилдаг
- Төрөлх хэлний бүх авиаг дуудах
- Бөмбөгийг барьж авах, шидэх
- Цаасан дээр үзэг салгахгүйгээр шулуун шугамыг зурах
- Орон зайн зохион байгуулалтыг тодорхойлдог

Зургаан настай хүүхдийн бие даах чадвар

Энэ насанд өөртөө үйлчлэх чадвар сайжирч эхэлдэг. Тэд өөрсдийгөө хувцаслаж өдөр тутмын амьдралд оролцон маш сайн туслагч байдаг. Дараах гэрийн ажлыг хийж чадна.

- Цэцэг услах
- Тоглоом цуглуулах
- Шүүгээнд байгаа зүйлээ цэгцлэх
- Ширээгээ цэвэрлэх
- Шал шүүрдэх
- Гал тогооны ажилд тусалж чадна.

Зургаан настай хүүхдийн өдөр тутмын дэглэм ба эрүүл мэнд

Өдөр тутмын тодорхой дэглэм нь хэт идэвхжил, ядрахаас урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай. Энэ нь ачааллыг зөв хуваарилж амрах хугацааг тохируулахад тусалдаг. 6 насны хүүхэд томоохон өөрчлөлтөд орж байгаа тул өдөр тутмын хуваарь гаргахдаа түүний насны онцлог, ялангуяа бусад хүүхдүүдтэй харилцах хэрэгцээг харгалзан үзэх нь чухал юм. Энэ насны хүүхдүүд өдөрт тогтмол дор хаяж 10 цаг унтах нь хүүхдийн эрүүл мэнд бие бялдрын өсөлт хөгжилтөд эерэг нөлөө үзүүлнэ. Ихэнх хүүхдүүд өдрийн цагт унтахаас



татгалздаг ч олон хүүхэд эрүүлжихийн тулд өдрийн цагт унтах шаардлагатай хэвээр байна.

Зургаан настай хүүхдэд илрэх хөгжлийн тулгамдсан асуудлууд⁶

“Сургуульд бэлтгэгдсэн байдал”-ын судалгаа (Боловсролын хүрээлэн, 2009) “Сургуульд ороод шинэ орчинд дасан зохицоход ямар бэрхшээлтэй тулгардаг талаар” хийсэн судалгааны (IRIM, 2015) үр дүнгээс харахад хүүхдэд дараах бэрхшээл тулгардаг байна. Үүнд:

- ✓ Шинэ багш, танихгүй хүүхдүүдтэй танилцах, ойлголцох, өөрийгөө илэрхийлэх
- ✓ Бусад хүүхэдтэй зэрэг хичээлээ хийж эхлэх, дуусгах, багшийн хэлсэн зааврыг ойлгож харилцах, сургуульд баримтлах дүрмийг мөрдөх
- ✓ Хичээлийн хэрэглэлээ зүй ёсоор ашиглах, хямгадаж авч явах, бие даан анги танхим болон бие засах газрыг олж өөртөө үйлчлэх
- ✓ Тайван бус, удаан тогтвортой байж чаддаггүй
- ✓ Хэт ичимхий, харилцааны бэрхшээлтэй, насанд хүрэгчид болон үеийнхэнтэйгээ холбоо тогтооход хэцүү
- ✓ Өөрийн зан авирыг хянах чадваргүй байх
- ✓ Амархан айх, түгших хандлагатай
- ✓ Багшийн заавар дүрмийг дагаж мөрддөггүй

Жич: Эдгээр шинжүүд илэрвэл хүүхдийн мэргэжилтэнтэй холбоо тогтоох хэрэгтэй. Асуудлыг үл тоомсорлох нь сурлагын амжилтад нөлөөлж болзошгүй. Хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд орчин үеийн янз бүрийн арга техникийг ашиглаж болно. Жишээлбэл: нэн түрүүнд хүүхдийг сэтгэл зүйн үүднээс нарийвчлан оношлох, судлах, судалгааны үр дүнд тулгуурлан тухайн хүүхдэд тохирсон хөтөлбөр боловсруулан заслын аргуудыг мэргэжлийн багш нартай хамтран хэрэгжүүлэх.

Зургаан насны хүүхдийн сэтгэл зүйн хямрал

Хүүхдийн насны хямралын талаар Д.Б.Эльконин, Э.Эриксон нар дараах байдлаар тодорхойлсон. Хүн өөрийн хөгжлийн явцад найман зөрчлийг дамждаг бөгөөд зөрчил бүр нь хямрал болдог гэж үзсэн байна. Хүүхдийн хувьд сэтгэл зовнилоо мэдэрч ухаарах цоо шинэ дотоод амьдрал үүснэ. Хүүхэд ямар нэгэн зүйлийг бусдаас нуудаг болж, сэтгэл санаа, бодсон санасан бүхнээ бусдад дэлгэхгүй байхыг эрмэлзэж эхэлнэ. Өөрийн үзэл бодол томчуудын заасантай нийцэхгүй бол дуугаа хураан өөрийн байр сууриа зөвд үзэж зүтгэнэ.⁷ Жишээ нь:

- ✓ Сөрөг хандлага: Хүүхэд насанд хүрэгчдийн хүссэн зүйлийг хийх хүсэлгүй байх. Ятгах, тайлбарлах, шийтгэх нь тэдэнд нөлөөлдөггүй
- ✓ Би гэсэн үзэл хандлага: Бүх зүйлийг өөрөө хийх хандлага
- ✓ Зөрүүд байдал: Тэд өөрийгөө батлахыг хичээдэг.
- ✓ Зөрчил – Дүрэм хэм хэмжээг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах
- ✓ Эсэргүүцэл – Эцэг эх, бусадтай зөрчилддөг

Энэхүү хямрал нь хүүхэд бүрд ялгаатай байдаг. Хүүхэд хичээл дээрээ хичээнгүй суралцдаг ч гэртээ ирээд уурлах, бусдыг сонсохгүй байх зэрэг авир гаргадаг. Хөвгүүд илүү сайн байхыг хичээдэг ч заримдаа түрэмгийллийн шинжүүд ажиглагддаг. Тиймээс дараах зөвлөмжийг анхаарах хэрэгтэй.⁸

- ✓ Хүүхдийг үргэлж сонсож байх, хайрлах
- ✓ Үе тэнгийнхний харилцааг дэмжих хэрэгтэй
- ✓ Илүү их магтаж, жи жиг амжилтыг ч бахдаж, тэмдэглэж байх
- ✓ Хүүхдийг нэмэлт хичээлээс гадуурх үйл ажиллагаа, клуб, дугуйланд явуулсан ч бүү хэтрүүл
- ✓ Алдааны төлөө бие махбодын шийтгэл хэрэглэж болохгүй
- ✓ Сэтгэл хөдлөлөө хэрхэн удирдаж сурах талаар зааж өгөх
- ✓ Хүүхэдтэй нэгэн хэвийн биш өөр өөр сэдвээр ярилц



Жич: Хэрэв таны хяналтаас гарсан байвал заавал мэргэжлийн хүмүүсийн туслалцааг хүсэх хэрэгтэй.

Зургаан настай эрэгтэй, эмэгтэй хүүхдийн сэтгэл зүйн онцлог

Бүдүүвч зураг 2. 6 настай эрэгтэй эмэгтэй сурагчдын хөгжлийн онцлог, ялгаа⁹

Эрэгтэй хүүхдийн хөгжлийн сэтгэл зүйн онцлог ялгаа	* Хэл ярианы өгөгдөл сайн ч үгийн сан нь охидоос ихэвчлэн бага байдаг тул бодлоо илэрхийлэхэд хэцүү байдаг * Орон зайн талаарх ойлголт сайн байдаг * Янз бүрийн геометрийн дүрстэй холбоотой асуудлыг амархан шийдвэрлэдэг, технологийн чадварыг сайн харуулдаг * Охидыг бодвол хөдөлгөөнтэй байдаг тул сахилга бат дүрэм биелүүлэх нь хэцүү учир ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх, байнга сануулах. Энэ тохиолдолд хүү илүү хичээнгүй суралцагч болох боломжтой
Эмэгтэй хүүхдийн хөгжлийн сэтгэл зүйн онцлог ялгаа	- Аман ярианы хөгжил илүү чөлөөтэй - Яриандаа нарийн төвөгтэй өгүүлбэрүүдийг ашигладаг - Үг яриандаа сэтгэл хөдлөлийн өнгө аясыг хүчтэй илэрхийлдэг - Сургуульд дасан зохицох нь илүү хурдан - Сахилга бат, тогтоосон дүрэм зааврыг маш сайн биелүүлдэг - Бие бялдрын өсөлт хөгжил нь хөвгүүдээс бага зэрэг доогуур байх талтай

Хүүхэд бүр өөр өөр байдаг тул өөрчлөлтөд үзүүлэх хариу үйлдэл нь янз бүр байж болно. Зарим хүүхдүүд шинэ орчинд бэлэн, шинэ найз нөхөдтэй танилцах хүсэлтэй байдаг бол зарим нь эцэг эхээ дагах, наалдах, нулимс цийлгэнүүлэх, бусадтай харилцаа тогтоох хүсэлгүй байх жишээтэй. Энэ үед багшаас дасан зохицох цаг гаргаж өдөр бүр хамт олон, хүүхдүүд, эцэг эхтэй харьцах хэрэгтэй болно. Тухайн хүүхдийн хувийн онцлог, гэр бүлийн соёл, дадал хэвшил, сургуульд бэлтгэгдсэн байдал зэргээс шалтгаалан сургуульд дасан зохицох чадвар нь харилцан адилгүй өөр өөр байдаг

Зургаан насны хүүхдийг оношлох, судлах арга зүй

Багшлах үйл ажиллагаа гэдэг бол хүн судлалын үйл ажиллагаа, мөн тусгайлан судлах зүйлтэй үйл ажиллагаа юм. **Багш зөвхөн сургах төдийгүй, хүүхэд хэрхэн сурч байгааг ойлгож, судалж танин мэдэх ёстой.** Энэ бол хүүхэд нэг бүрийн хөгжлийг баримжаалсан сургалтын зорилт бөгөөд хэрэгжүүлэх аргын нэг нь судлан шинжлэх үйл ажиллагаа юм. **Сэтгэл зүйн судалгаа, оношлолын гол асуудал бол хүүхдийн хөгжил төлөвшлийг бодитой оношлох, түүний талаар үнэн зөв бүрэн дүүрэн мэдээлэл цуглуулж дүгнэлт гаргах явдал юм.**

Дараах аргууд нь хүүхдийн одоогийн хөгжил болон, хэрэгцээг тодорхойлоход танд туслах болно. Судалгаа шинжилгээ хийхдээ шинжлэх ухааны онолуудыг тухайн аргад хэрхэн ашиглагдаж байдгийг дараах агуулгаас эргэцүүлэн дүгнэлт хийгээрэй. Ингэснээр танд өмнөх туршлага дээр тулгуурлан судалгаа шинжилгээний арга, онол үзэл баримтлалын талаар мэдлэгээ нэмэгдүүлэх боломж бүрдэх юм. (Хүснэгт 2)

Хүснэгт 3. Сэтгэл зүйн үнэлгээний аргууд ба хүүхдийн хөгжлийн онолуудад ашиглагдах байдал¹⁰

Судалгааны арга	Онолуудад ашиглагдах байдал
Ажиглалтын арга	• Хүүхдийн хөгжлийн бүх онолууд нь ажиглалтын аргыг ашигладаг • Зан үйлийн болон нийгмийн танин мэдэхүйн онолууд нь лабораторийн ажиглалтад хамгийн их анхаарал хандуулдаг • Ёс суртахууны онол нь ажиглалтад чухал ач холбогдол үзүүлдэг
Ярилцлагын арга	• Танин мэдэхүйн тойм судалгаанд ярилцлагын аргыг ихэвчлэн ашигладаг. (Ж.Пиаже, Л.С.Выготский) • Зан төлөв, нийгэм танин мэдэхүй, ёс зүйн онолууд нь судалгаа хийхэд ярилцлагын аргыг хамгийн бага ашигладаг
Стандартчилагдсан тестийн арга	• Хүүхдийн оюун ухааны хөгжлийн онолуудад ашиглагддаг



Туршилтын арга	- Зан үйл, нийгэм, танин мэдэхүй, мэдээлэл боловсруулах зэрэг онолууд нь туршилтын аргыг хамгийн их ашигладаг - Сэтгэц задлан шинжлэл, танин мэдэхүйн онолуудад ашиглах магадлал хамгийн бага
Проектив тестийн арга	- Бие хүнийг судлахад хамгийн их хэрэглэгддэг. - Проектив аргууд нь бие хүнийг ерөнхийд нь үнэлэх үнэлгээний аргад тооцогдохоос гадна зан үйлийн болон нийгэмшихүйн онолуудад өргөн хэрэглэгддэг

Жич: Багш судалгаа хийхэд ерөнхий аргуудын талаар маш сайн мэддэг, хэрэгжүүлж чаддаг байх нь чухал юм. Хэрэв та эдгээр судалгааны аргуудын талаар хангалттай сайн биш гэж үзвэл сэтгэл судлалын ном зохиолуудаас уншиж судлаарай.

Судалгааны энгийн аргуудад аль алинд нь давуу болон сул тал бий. Судалгаа хийхдээ зөвхөн нэг аргыг ашиглах бус хэд хэдэн аргыг хослуулж, цогц мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийж, байж хүүхдийн талаар үнэн зөв дүгнэлт гарна.

Хүснэгт 4. 6 настай хүүхдийн хөгжлийг судлах чиглэлүүд

№	Үндсэн чиглэл	Судлах дэд чиглэл	Арга
1	Бие бялдрын хөгжил	- Бие махбодын хөгжлийн ерөнхий үзүүлэлт - Хүүхдийн жижиг булчингийн хөгжлийг үнэлэх	Ажиглалт Туршилт Асуулга
2	Танин мэдэхүйн хөгжил	- Танин мэдэхүйн хөгжил - Хүүхэд, эцэг эхтэй хийх ярилцлага - Хүүхдийн сонирхлын чиглэл	Ажиглалт Ярилцлага Стандарт тест
3	Нийгэмшихүй ба сэтгэл хөдлөл	- Гэр бүлийн харилцаа хандлага - Хүүхдийн тоглох үйл ажиллагаа болон нийгмийн харилцааны чадвар - Бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар	Ажиглалт Проектив тест

БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ

Багш бүр сурагчдын хөгжил, эрүүл мэндийн түвшинг үнэлэх боломжтой бөгөөд анхан шатны арга техникийг эзэмших нь чухал. 6 настай хүүхэд хүнд үүргэвч үүрэх, нэг байрлалд удаан хугацаагаар ширээний ард суух зэрэг хүнд ачааллыг даван туулах чадвартай. Зарим хүүхдүүдийн хувьд гар нь бичихээс болж өвддөг гэж гомдоллодог ч булчингийн идэвхтэй хөгжлөөс болж үүссэн ачаалалд хурдан дасан зохицдог. Хүүхэд гэртээ ихэнх цагаа хөдөлгөөнгүй байрлалд (ширээний ард суух, утас, TV) өнгөрөөдөг нь нууц биш. Энэ нь булчингийн хүч чадал, гүйцэтгэл, хурд, уян хатан байдал, хүч чадлыг саатуулдаг. Нүд, гарын хосолсон үйл ажиллагаа буюу бичих, гутлын үдээс үдэх зэрэг хөдөлгөөн хөгжсөөр хүүхдийн жижиг хөдөлгөөнүүд хөгжиж эхэлнэ. Тиймээс 6 насны хүүхдийн жижиг булчингийн хөгжлийг дараах загварын дагуу үнэлгээ хийж үзээрэй.

Судалгааны зорилго: 6 настай хүүхдийн жижиг булчингийн хөгжлийг үнэлэх зорилготой.

Судалгааны заавар: Дараах асуултуудыг уншаад, хүүхдийн байдалтай таарч байгаа дугаарыг дугуйлна.

Хүснэгт 5. Хүүхдийн жижиг булчингийн хөгжлийг үнэлэх жишиг загвар ашиглах хувилбар¹¹

Хүүхдийн нэр: _____ Хүйс: Эр () Эм ()

Багшийн нэр _____ Сургууль _____ Анги _____

№	Асуулт	Хангалттай	Тооцох боломжтой	Сайжирч байгаа	Тооцох боломжгүй
1	Үзэг, харандааг зөв бариад зурж, бичдэг	4	3	2	1





2	Хувцасны товчоо зөв товчилж, тайлдаг	4	3	2	1
3	Аливаа дүрсийг хайчилж, цавуудаж наадаг	4	3	2	1
4	Будгийн харандаа, эсгий үзгээр зураас давхардуулахгүй буддаг	4	3	2	1
5	Тобот, шоо, оньсон тоглоом эвлүүлж чаддаг	4	3	2	1
Нийт тэмдэглэгээний тоо (Хэдэн нэмэх тэмдэг байгааг бичнэ)					

Судалгааны үр дүн боловсруулах

№	Авбал зохих оноо	Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь	Багшийн тэмдэглэл
1	K1=20	K2=?	K3=(хувь)	
2				

Үнэлгээг гаргахдаа 5 шалгуурын 20 оноог 100% гэж тооцон, хувилж бодно. Жишээлбэл, хүүхэд 15 оноо авсан бол: Үнэлгээ= $(15/20)*100=75\%$

Дүн шинжилгээ хийх зөвлөмж:

1. Нийт анги хамт олны судалгааны ерөнхий үр дүнг математик тооцооллын аргаар бодох хөдөлгөөний чадварын түвшинг хувь үзүүлэлтээр тооцож нэгтгэн дүгнэлт хийнэ.
2. Хөдөлгөөний ялгаатай хөгжлөөс үүдэн хүүхдийн хөгжилд ямар ялгаа үүсэж байгааг дүгнэх бөгөөд дэмжлэг хэрэгтэй байгаа сурагчдыг тодруулан дүгнэх.
3. Сурагчдад аль хөдөлгөөний хэрэгцээ байгааг тодруулна.
4. Хөгжлийн хөтөлбөрт хамруулах хүүхдүүдтэй ажиллах санал дүгнэлтийг тусгана.

I. ТАНИН МЭДЭХҮЙ

Нэгдүгээр ангийн сурагчид өнгө, тэдгээрийг таних, 10 хүртэл өсгөх, уруудаж тоолох, геометрийн хэлбэрийг таних, оньсого, зураг зурах, төрөл бүрийн гар урлал хийдэг. Энэ үед хүүхэд логигоор сэтгэж эхэлдэг байна. Зурган дээрх нэмэлт хэв маягийг хялбархан тодорхойлж ижил төстэй тал, ялгааг олж чаддаг. Цээжилж сурна. Зориудын анхаарал хөгждөг. Эхний үед төвлөрөх хугацаа 20 минутаас ихгүй боловч аажмаар хагас цаг хүртэл нэмэгддэг онцлогтой.¹² 6 насны хүүхдийн үгийн сан нь 1500-2000 идэвхтэй үгийн нөөцтэй. Нарийн төвөгтэй өгүүлбэр зохиож чаддаг. Тэрээр нэр үг, ерөнхийлсөн үг гэх мэтийг идэвхтэй ашигладаг. Зураг дээр үндэслэн өөрийн түүхийг зохиож чаддаг. Энэ үед харилцан яриа чадвар идэвхтэй хөгжиж байдаг.

- Танин мэдэхүйн хөгжил
- 6 настай хүүхэд, эцэг эхтэй хийх ярилцлага (Хавсралт 1, 2)
- Хүүхдийн сонирхлын судалгаа (Хавсралт 3)
- Хүүхдийн тоглох үйл ажиллагаа болон нийгмийн харилцааны чадвар (Хавсралт 4)

6 насны хүүхдийн танин мэдэхүйн үйл ажиллагааг цогц байдлаар судалж үнэлгээ хийснээр хүүхдийн хөгжлийг илэрхийлэх баримжаатай болно.

Хүснэгт 6. Судалгааны чиглэл, даалгаврын төрлүүд:

№	Танин мэдэхүйн судалгааны чиглэл	Гүйцэтгэх даалгавар	Судалгааны арга
1	Хүртэхүй	Цаг хугацаа, хэлбэр хэмжээ	Туршилт
2	Сэтгэхүй	Юмс үзэгдлийн талаарх мэдлэгийн түвшин	Асуулт, ярилцлага
3	Ой тогтоолт	Сонссоноо хурдан тогтоох	Туршилт
4	Анхаарал	Тогтвортой байдал, анхаарлын төвлөрөл	Туршилт
5	Хэл ярианы хөгжил	Хэл ярианы хөгжлийн ерөнхий түвшин	Ажиглалт, асуулга



1. Хүртэхүйн хөгжлийн судалгаа

Хүснэгт 7. Цаг хугацаа болон хэлбэр дүрсийг таних чадвар

№	Цаг хугацаа	Хангалт тай	Тооцох боломжтой	Сайжирч байгаа	Тооцох боломжгүй
1	Өглөө, өдөр, оройг мэддэг	4	3	2	1
2	Өчигдөр, өнөөдөр, маргаашийг мэддэг	4	3	2	1
3	Гаригуудын нэрийг мэддэг	4	3	2	1
4	Нэг бүтэн цагны талаар мэддэг	4	3	2	1
5	Дүрс ялгаж чаддаг (дугуй, дөрвөлжин г.м)	4	3	2	1
	Нийт дүн				

Судалгааны үр дүн боловсруулах

№	Авбал зохих оноо	Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь	Багшийн тэмдэглэл
1	K1=20	K2=?	K3=%	
2				

Үнэлгээг гаргахдаа 5 шалгуурын 20 оноог 100% гэж тооцон, хувилж бодно. Жишээлбэл, хүүхэд 17 оноо авсан бол: Үнэлгээ= $(17/20)*100=85\%$

2. Сэтгэхүйн хөгжлийн судалгаа¹³

Зорилго: Юмс үзэгдлийн төсөөтэй ба ялгаатай шинжийг илрүүлж, шалтгааныг тайлбарлах, ухагдахуун тодорхойлолтыг судлах

Заавар: Хүүхдэд асуулт тавьж хариултыг бичиж тэмдэглэл хөтлөх

Хүснэгт 8. Сэтгэхүйн хөгжлийг үнэлэх асуулга

№	Асуулга	Хүүхдийн хариулт тэмдэглэх хуудас
1	Ямаа үхэр хоёрын аль нь том бэ?	
2	Нохой, тахиа хоёрын аль нь олон хөлтэй вэ?	
3	Хонины төлийг хурга гэдэг. Ямааны төлийг юу гэх вэ?	
4	Өдөр гэрэлтэй байдаг. Шөнө ямар байдаг вэ?	
5	Намар модны навч шарлан унадаг, өвөл яадаг вэ?	
6	Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг ялгаж ангилаарай	
7	Чи дэлгүүр дотор явж байгаад ээжээсээ төөрчихсөн. Энэ үед яах вэ?	
8	Тагтаа, болжмор хоёр юугаараа ижил төстэй вэ? юугаараа ялгаатай вэ?	
9	Чи хэн нэгний юмыг санамсаргүй эвдсэн бол яах ёстой вэ? Чи үүнийг яаж шийдэх вэ?	
10	Зүүн нүд, баруун чихээ заагаарай. Нүд чих ямар үүрэгтэй вэ?	
Нийт дүн		

Судалгааны үр дүн боловсруулалт

Асуулт бүрийн зөв хариулт 1 оноо (10 оноо – Дээд түвшин, 8-9 оноо дунджаас дээш, 4-7 оноо дундаж түвшин, 2-3 оноо дунджаас доош түвшин, 0-1 оноо доод түвшин)

3. Ой тогтоолт¹⁴

Зорилго: Богино хугацаанд хүүхдийн сонссоноо хурдан тогтоох чадварыг судалж тодорхойлох

Заавар: Би та нарт үгсийг хэлнэ. Анхааралтай сонсоод сайн тогтоож аваарай.

Хүснэгт 9. Судалгаанд хэрэглэх үг:

Сүүдэр	Чоно	Бөмбөг	Утаа	Тойрог	Туяа	Сарнай	Цох	Цув
--------	------	--------	------	--------	------	--------	-----	-----

Гүйцэтгэх журам: Цээжлэх үгсийг зөвхөн нэг удаа танилцуулна. Хэрэв хүүхэд эхний удаа юу





ч санахгүй байсан бол сөрөг мэдрэмж түрүүлэхгүйн тулд та үгсийг дахин давтаж, дараа нь хүүхдийг сонсож болно. Энэ тохиолдолд эхний удаагийн оролдлогыг харгалзан үзэж болно. Үгийн дараалал заавал хамаарахгүй.

Үр дүнг боловсруулах:

Үнэлгээний шалгуур: Нийт зөв илэрхийлсэн үг бүрд 1 оноо өгнө.

- ✓ 8-9 оноо өндөр түвшин 2 оноо сул түвшин
- ✓ 5-7 оноо дунджаас дээгүүр байна 0-1 оноо доод түвшин
- ✓ 3-4 оноо дундаж түвшин

4. Анхаарал

Зорилго: 6 настай хүүхдийн тогтвортой байдал, анхаарлын төвлөрлийг судлах

Заавар: Эдгээр зургуудыг анхааралтай ажиглаарай. Тэд юугаараа ялгаатай болохыг аль болох хурдан нэрлэхийг хичээгээрэй. (Зургийг хавсралт- 1-ээс үзнэ үү)


Гүйцэтгэх журам: Даалгаврыг гүйцэтгэх явцад даалгаврыг гүйцэтгэсэн цаг хугацаа, зөв нэрлэсэн, алдааны тоог бүртгэх шаардлагатай. Алдаа нь давталт, буруу нэрлэсэнд тооцогдоно. Зургийг танилцуулах хугацаа 3 минут байна.

Үр дүнгийн шинжилгээ: Бүх ялгааг (10) бие даан олж байгааг шинжилдэг. Хүүхдийн даалгавар гүйцэтгэсэн нийт хугацаа, хүүхдийн гүйцэтгэсэн онцлог, тусламж (судлаачийн тусламж, хүүхдийн анхаарлыг зургийн тодорхой хэсэг рүү чиглүүлэх) зэргийг тэмдэглэнэ.


Үнэлгээний шалгуур:

- ✓ 8-10 ялгааг нэрлэсэн бол энэ нь тогтвортой байдал, төвлөрөл өндөр байгааг илтгэнэ
- ✓ 5-7 ялгааг нэрлэсэн бол энэ нь тогтвортой байдал, төвлөрлийн дундаж түвшинг илтгэнэ
- ✓ 1-4 ялгааг нэрлэсэн бол энэ нь тогтвортой байдал, төвлөрөл сул байгааг илтгэнэ

Хувилбар 1а



Хувилбар 1б



5. Хэл яриа¹⁵

Зорилго: Хүүхдийн хэл ярианы хөгжлийг үзүүлэлт тус бүрээр үнэлж аль бүрдэлд дэмжлэг хэрэгцээ байгааг илрүүлэх

Заавар: Хүүхдийн хэл ярианы хөгжил ямар байна вэ? багш сургалтын үйл ажиллагааны явцад, хүүхэд тоглож байх үед, хичээлийн завсарлага, тарах, ирэх үед ажиглалт хийж хүүхдийн байдалтай таарч байгаа дугаарыг дугуйлна.

Хүснэгт 10. Хэл ярианы хөгжлийг үнэлэх жишиг загвар ашиглах хувилбар

Хэл ярианы ерөнхий хөгжил	Хангалттай	Тооцох боломжтой	Сайжирч байгаа	Тооцох боломжгүй
Ойлгомжтой тод, цэгцтэй ярьдаг	4	3	2	1
Хийх дуртай зүйлээ өөрийн үгээр тайлбарладаг	4	3	2	1
Хичээлийн цаг дээр чөлөөтэй, бодол санаа, мэдрэмжүүдээ ойлгуулж чаддаг	4	3	2	1
Бусдын ярьж байгаа зүйлд саад болохгүйгээр дуустал нь сонсдог	4	3	2	1



Уншиж өгсөн зүйлийн талаар асуулт асуухад хариулж чаддаг	4	3	2	1
Нийт дүн				

Судалгааны үр дүн боловсруулах

№	Авбал зохих оноо	Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь	Багшийн тэмдэглэл
1	K1=20	K2=?	K3=%	
2				

Үнэлгээг гаргахдаа 5 шалгуурын 20 оноог 100% гэж тооцон, хувилж бодно. Жишээлбэл, хүүхэд 17 оноо авсан бол: Үнэлгээ= $(17/20)*100=85\%$

Жич: Хэл ярианы хөгжлийн түвшин сул нормоос доогуур байгаа тохиолдолд энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтэнтэй холбоо барихыг зөвлөж байна.

ХҮҮХДИЙН НИЙГЭМШИХҮЙ БА СЭТГЭЛ ХӨДЛӨЛ

Харилцааны шинэ хэлбэр, шинэ харилцаа холбоо бий болж үе тэнгийнхэнтэйгээ болон насанд хүрэгчидтэй харилцах арга замаа олж авна. Хүүхдүүд энэ үед хичээнгүйлэн сурч, гэрийн даалгавраа хийхийг хичээдэг. Нийгмийн амьдрал ч идэвхтэй хөгждөг. Хүүхэд урьд өмнө нь мэдэхгүй байсан сэтгэл хөдлөлийг мэдэрч эхэлдэг. Сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийн нөлөөн дор хүүхдийн зан байдал өөрчлөгддөг. Зарим хүүхэд ичимхий, зарим нь цочимтгой байх жишээтэй. 6 настай хүүхэд бусад хүмүүс өөрөөс нь өөр сэтгэл санаатай байдаг гэдгийг мэдэрдэг болсон байна. Тэд өөрсдийгөө хэн гэдгийг ойлгож эхэлдэг ба сэтгэл санааны байдал нь тогтворждог. Мөн бусдыг хайрлах, хамгаалах хандлага илэрнэ. Энэ насны хүүхдүүд өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөний талаар ойлголттой болсон байдаг. Өөртөө итгэх итгэл нь бага байдаг учир насанд хүрэгчдээс урам, магтаал, сайшаалыг байнга хүсэж байдаг байна.

Гэр бүлийн хөрөг тест¹⁶

Зорилго: Хүүхдийн гэр бүлийн гишүүддээ хандах харьцаа хандлаг, гэр бүлийн дотоод уур амьсгал, гэр бүлийн дотор хүүхдийн эзэлж буй байр суурийг тодорхойлох.

Ашиглах хэрэглэгдэхүүн: Хүүхдэд хоосон цаас, өнгийн харандаа болон балын харандаа, баллуур өгнө.

Заавар: Гэр бүлийнхнийгээ зурна уу? Харин чи хэнийг зурахаа өөрийнхөө төсөөлж байгаагаар чөлөөтэй зурах юм шүү. Гэр бүл гэдэг үгийг ямар утга учиртай гэдгийг тайлбарлахыг зөвлөдөггүй бөгөөд юу зурах вэ? гэсэн асуулт гарч ирвэл та зааврыг дахин давтах хэрэгтэй. Зурах хугацааг хязгаарлахгүй.

Зурах явцад дараах асуултуудыг асууна

1. Чи хэн хэнийг зурсан бэ?
2. Чи хаана байна вэ?
3. Тэд юу хийж байгаа вэ?
4. Хэн нь хамгийн сайн нь вэ?
5. Хамгийн гунигтай нь хэн бэ?
6. Хамгийн аз жаргалтай нь хэн бэ?
7. Чи хэнд хамгийн их таалагддаг вэ?

Туршилт хийж байгаа хүн хүүхдийг зурахдаа ямар мэдрэмж төрж байсныг, гэр бүлийн зарим гишүүд яагаад ийм байдлаар дүрслэгдсэн, өөрөөр биш, ямар шалтгаанаар хэн нэгэн байхгүй байгааг ойлгох ёстой. Ярилцахад тохиромжгүй өнгө аясаар ярж болохгүй. Зөөлөн байдал, тайван байдал, хялбар байдал нь туршилтад оролцож буй хүүхдийг хамгийн бүрэн гүйцэд, илэн далангүй хариулт өгөхөд өдөөж өгдөг. Зарим асуултууд нь хүүхдийн мэдрэхүйн хүрээг нээх, хэлэлцэхэд хүргэдэг, бүх хүүхэд үүнд бэлэн байдаггүй.

Протоколд тэмдэглэх зүйл:

Бие даасан туршилтыг явуулахдаа мэдээлэл цуглуулах тэмдэглэлийг дараах байдлаар бичнэ.

- а) Ямар объектоос эхэлж, цаасны аль хэсэгт зурж байна.
- б) Тухайн зурж байгаа зурагтаа ямар хандлага гаргаж байна вэ? (Хэр зэрэг дарж зурж байна вэ? Хэр идэвхтэй эсвэл тойм маягаар зурж байгаа эсэх, өнгөөр ялгаж байгаа



эсэх гэх мэт)

с) Чиглүүлэх асуултад ямар хариулт өгч байна?

Сорилын үр дүнг боловсруулах

Зурган сорилын үр дүнд тоо болон чанарын үнэлгээ хийж болно. Хүүхдийн зурсан зургийн чанарын үнэлгээ зуралтын онцлог болон агуулгын үзүүлэлтийг гол болгоно. Үүнд: Зургийн байрлал, Объектуудын байрлал, хэмжээ, бүтэц, гүйцэд эсэх

Зургийн цаасны баруун дээд өнцөгт зурсан бол тухайн хүнээ хүндэлдэг. Яг голд нь зурсан бол сайнаар хүлээн авдаг. Баруун гар зурсан байвал өнгөрсөн, зүүн гар ирээдүйд чиглэсэн байна.

Зуралтын онцлог:

- Цаасан дээр гэр бүлийн гишүүдийг байрлуулсан байдал (Цаасны дунд, захад, доод хэсэгт)
- Зураасны онцлог (шулуун, тасралтгүй, хөнгөн дарж зурсан гэх мэт)
- Зарим гишүүдийн биеийн тодорхой хэсгийг баллуурдаж, дарж зурсан зуралтууд

Зургийн агуулгыг харуулсан үзүүлэлтүүд:

- Гэр бүлийн гишүүдийн гүйцэтгэж байгаа ажлын онцлог (Хамтарч байна уу эсвэл ганцаараа гэх мэт)
- Гэр бүлийн гишүүдийн хоорондын зай байршил (холдуулсан эсвэл заагласан)
- Зурган дээрх эд юмс, хүмүүст хандах хандлага харьцаа (сэтгэл дундуур, зовуур, түгшүүр)

Дээрх үзүүлэлтийг харгалзан 3 чиглэлээр хүүхдийн зургийг тайлбарлах боломжтой.

1. Гэр бүлийн гишүүдийн зургийн бүтэц бүрэлдэхүүн, тооны байдлыг харгалзан тайлбар хийх

1. Хүүхэд гэр бүлийн гишүүдийг бүгдийг зурахгүй байх тохиолдол гардаг. Ялангуяа харилцааны хувьд зөрчилтэй, өөрт таалагддаггүй, сэтгэл дундуур байдаг тэр гишүүнийг орхиж зурах нь олонтоо. Гэр бүлийн жинхэнэ гишүүдээс гадна өөр хүнийг нэмж зурах тохиолдол байдаг. Гол төлөв салсан гэр бүлд амьдарч байгаа хүүхдүүд гэр бүлийнхээ дотор гадны хүнийг оруулж зурдаг.
2. Гэр бүлийн гишүүдийн хоорондын зай байрлал, тэдний харьцаа хандлагын онцлогийг илэрхийлж байдаг. Сэтгэл зүйн ойр дотно байдлыг илэрхийлэгч гол үзүүлэлт бол гэр бүлийн гишүүдийн хоорондын зай.
3. Заримдаа хүүхэд гэр бүлийн гишүүдийн хоорондох зайнд ямар нэгэн юмсыг оруулж зурсан байдаг. Энэ нь тэдгээрийн хоорондын харилцаанд хаалт саад болж харагдана.
4. Гэр бүлийн гишүүд ямар нэгэн зүйлийг хамтран хийж байгаагаар зурсан байвал тухайн гэр бүлийн гишүүдийн харьцаа эвсэг дотно болохыг илэрхийлж байдаг. Ямар нэгэн ажлыг тус, тусдаа хийж байгаагаар дүрсэлсэн байвал тухайн гэр бүлийн дотор үзэл бодлын зөрчил, зөрөлдөөн дотоод бүлэглэл байна гэж тайлбарлаж болох юм.
5. Удаан хугацаагаар өвдөж, эмнэлэгт хэвтэж байсан хүүхдүүд гол төлөв өөрийгөө гэр бүлийн зурагнаас хасаж зурах нь олонтоо. Оюун ухааны хэвийн хөгжилтэй хүүхдийн 85% нь өөрийгөө гэр бүлийнхэнтэйгээ хамт зурдаг.

2. Гэр бүлийн гишүүдийг зурсан зуралтыг онцлог байдлыг харгалзан тайлбар хийх

Зуралтын онцлогт гэр бүлийн гишүүдийн зургийн хэмжээ, хэлбэр, харьцаа, дүрсийг илэрхийлсэн хэв маягууд орно.

1. Зарим хүүхдүүд гэр бүлийнхээ гишүүдийг маш жижиг хэмжээтэй зурж хуудасны доод хэсэгт байрлуулсан байдаг. Энэ нь тухайн хүүхдийн гэр орныхоо одоогийн нөхцөл байдал, харьцаанд сэтгэл дундуур, зовнин түгшиж байгааг илэрхийлнэ.
2. Зарим хүүхдүүд гэр бүлийнхээ гишүүдийг бус эд юмс, тавилгыг голлон зурсан байдаг. Гэр бүлийн тогтсон уур амьсгал, хандлага харилцаанд сэтгэл зовниж байгаагаас тэднийг зуралгүй орхиж, өөрийн хувьд төдийлөн ач холбогдолтой биш, сэтгэл санаа төдийлөн зовуурилахгүй байгаа эд юмсыг зурах тохиолдол гардаг.



3. Хүүхэд өөрийн дотно хайртай хүнийхээ нүүр царай, биеийн төрх байдлыг маш тодорхой нарийвчлан зурах төдийгүй зарим нэгэн чимэг гоёлыг оруулж баяжуулж зурна. Харин өөрийн дотно биш дургүй хүнийг зурахдаа биеийн хэлбэр төрхийг хагас дутуу юм уу? нүүр царайг тодорхой бус байдлаар гол төлөв зурдаг.
4. Харилцааны хувьд зөрчилтэй, сэтгэл санааны болон биеийн хүчирхийлэл, дарангуйлал үзүүлж байдаг тэр гишүүнийг зурахдаа харандаагаа хүчтэй дарж, дүрсийг дахин дахин тодруулан зурах буюу баллуурдаж зурах онцлог байдал илэрнэ.
5. Зарим хүүхдүүд гэр бүлийнхээ хэн нэгэн гишүүний хэмжээ хэлбэрийг бодит байдлаас зориудаар өөрчлөн зурдаг. Жишээлбэл, Хамгийн бага дүүгээ өөрөөсөө болон аав, ээжээсээ том хэмжээтэй зурсан байх жишээтэй. Энэ нь отгон дүүд нь илүү анхаарал халамж тавьж, бусдад нь тэгш бус ялгавартай хандаж харьцдаг болохыг харуулах гэх мэт.
6. Зурган дээрээс нь өөр хоорондоо ялгаатай зуралтын хэд хэдэн янзын хэв маягийг харж болно. Тухайлбал, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг ялгаж өөр өөр хэв маягаар дүрслэн илэрхийлж зурдаг. Ялангуяа өөрийгөө гэр бүлийн гишүүд дотроос хамгийн ойр дотно харьцаатай байдаг тэр хүнтэй ижил хэв маягаар зурах нь олонтоо.

3. Гэр бүлийн гишүүдийг зурах явцын онцлогийг харгалзан тайлбар хийх

Зурах явцад зургийн дараалал тайлбар хийх онцлог нэг зургаас нөгөөд шилжих хурд, зогсолт, нүүр царайны хувирал, өөрчлөлт, санаа алдалт зэрэг үзүүлэлтүүд орно.

1. Хүүхэд гэр бүлийн гишүүдийн хэн нэгнийг зурж байхдаа санаа алдах буюу санамсаргүй байдлаар хараасан, зүхсэн үг хэлэх тохиолдол гардаг. Энэ нь тухайн гишүүнтэй харилцааны зөрчилтэй болохыг илэрхийлнэ.
2. Зурах дарааллыг нь авч үзвэл хүүхэд гол төлөв өөрт нь ойр дотно хандаж харьцдаг тэр гишүүнийг эхлэн зурах хандлагатай байдаг.
3. Хүүхэд хэн нэгэн гишүүнийг зурж эхлэхийн өмнө эргэлзэж, зогсолт хийж дургүйцсэн байдлаа илэрхийлэх нь цөөнгүй. Энэ нь тухайн гишүүн хүүхдэд хөндий хүйтэн харьцаж ханддаг болохыг илэрхийлж болно.
4. Хүүхэд зургийг тайлбарлахдаа гэр бүлийн гишүүдийнхээ хэн нэгнийг илүү ойлгон авч үзэж, түүнийг буруутгах юм уу, магтан дотночлох хандлагатай байдаг. Ялангуяа биеийн болон сэтгэл санааны хувьд дарангуйлал үзүүлж байдаг, харилцааны зөрчил бүхий гишүүдийг шүүмжлэн буруутгаж эсэргүүцдэг.

Хүүхдийн сэтгэл зүйн нэгдсэн дүгнэлт бичих загвар

Хүүхдийн овог нэр _____ Сургууль _____ Анги _____

Хүүхдийн нас _____ (эр) (эм)

Судалгаа хийсэн огноо _____ Багшийн нэр _____

Хүүхдийн насны хөгжлийн ерөнхий үзүүлэлт

Бие махбодын хөгжил _____

Танин мэдэхүйн хөгжил

Хүртэхүй (өнгө, хэлбэр хэмжээ, цаг хугацаа) _____

Сэтгэхүйн хөгжил _____

Ой, анхаарлын хөгжил _____

Хэл ярианы хөгжил _____

Нийгэм ба сэтгэл хөдлөл

Гэр бүлийн гишүүдтэй харилцах харилцаа _____

Хүүхдийн зан араншин _____

Бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар _____





Хүүхдийн тоглох үйл ажиллагаа болон нийгмийн харилцааны чадвар _____

Хөгжлийн онцлог _____

Хөгжлийн асуудлууд _____

Зөвлөмж _____

Судалгааны үр дүнд тулгуурлан хүүхдийн хөгжлийг сургалтын үйл ажиллагаанд дэмжих боломж

Хөгжлийн чиглэл	Сургалтын үйл ажиллагаанд дэмжих боломж
Хүүхдийн жижиг булчингийн хөгжил	Гарын жижиг булчинг хөгжүүлэх дасгалыг аль болох эрт эхлэх хэрэгтэй. ✓ Хурууны дасгал хийх. (товчийг тайлах, товчлох, гутлын үдээсийг зангидах) ✓ Үр тариа, бөмбөлгүүд, товч, жижиг чулуу зэргийг ялгаж ангилах ✓ Элсэн дээр бүтээл хийлгэх (дотоод хурцадмал байдлаас гарах боломж олгодог) ✓ Хайчаар хайчлах дасгал (дүрс, хээ, цасан ширхэг) ✓ Цаастай ажиллах –Оригами, сүлжих, нэхэх (даавуу сүлжих, оригами нь энгийнээс нарийн төвөгтэй рүү шилждэг) ✓ Зураг зурах, будах дасгалууд (нүд гарын хосолсон үйл ажиллагааг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй)
Танин мэдэхүйн хөгжил	Хүүхэд бодох асуудлыг шийдвэрлэх, бие даасан үйл ажиллагааг хөгжүүлэхэд дараах дэмжлэг чухал нөлөөтэй. ✓ Асуулт хариулт хэлбэрийн тоглоом байж болно. ✓ Шоо, дутуу элементүүдийг зурах будах, оньсого тайлах, онлайн тоглоомууд байж болно ✓ Үсгэн дундаас үг олж бүтээх дасгал: Хүүхдэд зарим үгсийн зөв бичгийн дүрмийг сурах, анхаарлыг хөгжүүлэх мөн унших дасгал хийхэд тусална. ✓ Долоо хоног, өдрүүд, цаг хугацаа, орон зайн тухай хялбар эзэмшүүлэхийн тулд өнгөөр ялгах, үлгэрийн баатруудтай нь холбох, шүлэг, оньсого, дуу зэргийг нэмж хөгжилтэй хялбараар суралцах боломжтой. (харааны хүртэхүйтэй холбох нь илүү үр дүнтэй) Жишээ нь жилийн 4 улирлыг өнгөөр будуулах. Хүүхдэд анхаарал, жижиг булчингийн хөгжил, гар нүдний зохицуулалтыг сургах бөгөөд санах ой, сэтгэхүйг хөгжүүлэх боломжтой. ✓ Хүүхдийн логик сэтгэхүйг хөгжүүлэхийн тулд дасгал, тоглоомын аргаар дэмжих: ✓ Үлгэр засал маш чухал үүргийг гүйцэтгэнэ. (Шинэ үг сурах, бодол санаагаа боловсруулдаг, уран зөгнөл, төсөөллийг хөгжүүлдэг, ертөнцийн талаарх мэдлэгээ өргөжүүлдэг, эерэг зан чанарыг бий болгодог, өөрийн зан чанарын асуудлыг шийдвэрлэдэг, эцэг эхтэйгээ харилцаа холбоо тогтоодог гээд олон давуу талтай)
Нийгэмшихүй ба сэтгэл хөдлөл	Орчин үед нийгэмд сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийг хөгжүүлэх шаардлагатай, учир нь хүмүүнлэгийн мэдрэмж, хүмүүс хоорондын харилцааг хөгжүүлэхэд тусална. ✓ Ойр дотно хүмүүс хүүхдийг хайрлаж, түүнд сайнаар хандаж, эрхийг нь хүлээн зөвшөөрч, онцлог, ялгааг харгалзаж, анхаарал хандуулж байх үед өөртөө итгэх итгэл, аюулгүй байдлыг мэдэрдэг. ✓ Хүүхдүүдтэй ярилцлага хийж болно. (Найз чинь гүйж яваад унавал чи инээж чадах уу? Яагаад? Гэх мэт) ✓ Хүүхдийн зураг, эвлүүлэг, уран зураг, жижиг баримал дээр ажиллах явцад уур уцаар, түрэмгийлэл, айдас, бухимдлаас ангижрах боломжтой, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн арга зам нь бүтээлийн заслын аргууд юм. Энэ нь аюулгүй, үр дүнтэй арга юм. сэтгэл хөдлөлийн болон булчингийн хурцадмал байдал, учир нь ухамсаргүй дотоод зөрчилдөөн, хүчтэй мэдрэмжийг үгээр засахаас илүүтэйгээр бүтээлч дүрслэлээр илэрхийлэх нь ихэвчлэн хялбар байдаг. ✓ Тоглоомын арга ашиглах: “Уурыг зурж үзэцгээе” зорилго нь түрэмгийллийг арилгах, сэтгэл хөдлөлийн байдлыг ойлгох, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, ярих, тайлбарлах зэрэгт тусалдаг ✓ Тоглоомын арга: Хэн илүү хөгжилтэй инээх вэ? Энэхүү тоглоом нь сэтгэл хөдлөлийн баяр баясгаланг дамжуулах чадварыг хөгжүүлдэг.



Дижитал эриний үеийн хүүхдийн хөгжил, сурах үйлийн онцлог

(2010-2025 онд төрсөн Альфа үе)

Цаг үе, нийгмээ дагаад 15-20 жил тутамд шинэ үеийн сурагчид суралцахаар ирдэг. Тэдний хүлээлт, ур чадвар, зан төлөв, тухайн үеийн өвөрмөц нөхцөл байдлаас шалтгаалж шинэ сорилттой тулгардаг. Альфа үе гэдэг нь 2010 -2025 оны хооронд төрсөн хүүхдүүд бөгөөд том нь 2022 онд арван хоёр нас хүрсэн. Тиймээс тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөх, ирээдүйд бэлтгэхэд чиглэсэн шинэ хэтийн төлөв, шинэчилсэн анхаарал гарч ирдэг. Альфа үе бол шинэ үеийнхэн бөгөөд тэд аль хэдийн ирсэн. Гэхдээ тэдний сурах орон зай, нөхцөл, боломж нь тэдэнд бэлэн байж чадаж байна уу? Тэд хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд төрсөн бөгөөд улам бүр хөдөлгөөнтэй, мэдрэмжтэй нь хувь хүнд тохирсон технологиор тодорхойлогдож байна.



Альфа нь технологийн мэдрэмжтэй, дижитал холболттой, чадварлаг бүтээгчид байдаг. Тиймээс агуулга эзэмших чадвараас илүү утга учиртай, хамааралтай, ур чадварт суурилсан туршлага руу шилжүүлэх нь гол зорилго болж байна. Альфад шинэлэг санаа гаргаж, мэддэг зүйлээ хуваалцах боломжийг олгодог. Сургалтын үйл явцыг идэвхтэй, сурагчдыг удирдлага, практик үйл явц болгон нэгдмэл нэгдсэн арга хэрэгсэл, технологиор бүрдүүлдэг бөгөөд энэ нь ангийн орчны дизайныг өөрчлөх шаардлагатай болно. Сургалтын оновчтой орон зайг төлөвлөхийн тулд бид эхлээд тэдний хүлээлт, хэрэгцээ, тулгарч буй бэрхшээлийг ойлгох хэрэгтэй. 2025 он гэхэд дэлхий даяар 2 тэрбум альфа амьдарч, сурч боловсрох болно. Альфа нь ихэвчлэн Z үеийн ах дүүстэй. Тэд угсаатны хувьд хамгийн олон янзын үеийнхэн байхаас гадна албан ёсны боловсролтой, дижитал бичиг үсэгт тайлагдсан, хамгийн урт наслалттай, дэлхийн хэмжээнд холбогдсон үе байх төлөвтэй. Альфачууд бага наснаасаа хамгийн их албан бус боловсролд илүү их хамрагдсан бөгөөд цаашид ч үргэлжилнэ. Альфагийн дийлэнх нь их дээд сургууль төгссөн ямар нэгэн албан ёсны боловсрол эзэмшинэ. Альфа нь төрсөн цагаасаа эхлэн гар утасны технологитой холбогдож, iPad хэрэглэгчдийн зах зээлд гарсан тэр жилээс эхэлсэн.

Альфа үеийн хүүхдүүдийн онцлогт технологийн хөгжлийн нөлөөлөл

Эерэг үр дагавар	Сөрөг үр дагавар
Өндөр мэдрэмжтэй технологийг хэрэглэх чадвар өндөр	✓ Дэлгэцийн цаг нэмэгддэг
✓ Онлайнаар хурдан нэвтрэх	✓ Анхаарлын төвлөрөл багасдаг
✓ Дижитал бичиг үсэг тайлагдах	✓ Нийгмийн ур чадварын хөгжүүлэлт сул
✓ Хязгааргүй мэдээлэл, илүү их нөлөө үзүүлж байна	✓ Эрсдэлд орох зан үйл ихсэх хандлагатай
✓ Тархины хөгжилд эрс өөрчлөлт гарч байгаа	✓ Бэрхшээлүүд тулгарах нь элбэг
✓ Бие даасан хүсэл эрмэлзэл их	
✓ Бие бялдар, нийгэм, эрүүл мэнд, боловсролд ихээхэн нөлөө үзүүлж байгаа	

Суралцах үйлийн онцлог

Альфа нар COVID -19 цар тахлын нөлөөнд автсан нийгэмд өсөж торних тусам тогтвортой байдал, эрүүл мэнд, нийгмийн шударга ёс зэрэг дэлхийн сорилтуудын талаарх тэдний мэдлэг, чадвар нэмэгдэж байгаа нь энэ насны хувьд ногоон байгаль, эрүүл ертөнцийг дахин төсөөлөх сонирхол улам бүр нэмэгдэх болно.

Сурах нь Альфа үеийнхний хувьд шинийг санаачлах, ур чадвар бий болгох, бодит ертөнцтэй харилцах явдал юм. Тэд утга учиртай, хамааралтай суралцах туршлагыг нэн тэргүүнд тавьдаг





бөгөөд тэд анги доторх болон гаднах ертөнцийн хоорондын тэгш байдлыг эрхэмлэх болно. Тэдний эргэн тойрон дахь дижитал хэрэгсэл, технологи нь мэдээлэл цуглуулах, загвар гаргах, үнэ цэнийг бий болгох, дэлхийн өнцөг булам бүртэй харилцах чадвар нь байгалиас заяагдсан өгөгдөл юм.

Альфа үеийн хүүхдүүдийн сонирхлыг судлах, сэтгэн бодох үйл явцыг олж мэдэх, мэддэг зүйлээ үе тэнгийнхэнтэйгээ болон дэлхий ертөнцтэй хуваалцах боломжийг олгохын тулд сургалтын орчин саадгүй байх учиртай. Сургалтын бүх боломжуудыг ашиглах нь энэ үеийн суралцагчдын сэтгэлийг хөдөлгөж илүү үр дүнтэй технологийн туршлагыг бий болгохыг шаардана. Технологийн тархалт болон хүн хоорондын харилцан үйлчлэлийн тэнцвэрийг бий болгосноор энэ үеийнхэнд шаардлагатай зөөлөн ур чадвар, нийгмийн ур чадварыг хөгжүүлэх нь нэн чухал. Мөн зан үйлийг зохицуулж сурах, бусадтай харилцах, зорилго тавих, сэтгэлгээний дадал, зуршлыг хөгжүүлэх зэрэг нь ангид бий болох чухал чадварууд юм. Дэлхийн эдийн засгийн форумын тооцоолсноор өнөөдрийн бага сургуулийн сурагчдын 65% -нь хараахан байхгүй байгаа ажилд ажиллах болно. Ажил мэргэжил өөрчлөгдөж, хөгжиж байгааг харахад насан туршийн боловсролыг дэмжихийн тулд тасралтгүй боловсрол, ур чадварын сургалтад хамрагдах нь нэн чухал.

Үр дүнтэй сургалтын онцлог нь: Хүүхдүүдийн сурахын тулд ашигладаг зан үйлийг тодорхойлдог. Үр дүнтэй сурах үйлийг дараах чиглэлээр дэмжих нь чухал. Үүнд:



Сургалтын болон хөгжлийн чиглэлүүд:

1. Харилцаа холбоо хэл яриаг хөгжүүлэх нь хүүхдүүдэд математикийн санааг ойлгож, тайлбарлахад тусална.
2. Бие бялдрын ур чадварыг хөгжүүлэх нь хүүхдэд илүү идэвхтэй судлаач болох боломжийг олгож улмаар ертөнцийг ойлгох хичээлийн ахиц дэвшлийг нэмэгдүүлнэ. Ертөнцийг ойлгох нь хичээлийн хүрээнд хэдий чинээ номноос олж мэдсэн зүйлтэйгээ холбогдох боломжтой болж, бичиг үсгийн хөгжилд нь дэмжлэг үзүүлэх болно.
3. Суралцах хөгжүүлэх талбартай холбоотой туршлага, үйл ажиллагаа нь хүүхдүүдэд бие даасан байх, өөрийн санаа бодлыг хөгжүүлэх боломжийг олгодог бол хүүхдүүдэд зан үйлээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, үр дүнтэй сургалтын шинж чанарыг бэхжүүлдэг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Пермьякова В.А. Возрастное развитие детей, его предпосылки и закономерности (внорме и при отклонениях) Учеб. Пособие, Иркутск: Иркут. Ун-т, 2004, 60 стр
2. Child Development and Education (2010) Teresa M. Mc. Devitt, Jeanne Ellis
3. Оюунцэцэг Б, Энхмаа Т. (2018) Сургуулийн бага насны хүүхдийг судлах арга зүй. х 19-21
4. Цэвээнлхазал Я, Энхээ Д, Бэгз Н, Цэдэнбал Ч, нарын. (2009) Бага боловсролын сурган хүмүүжүүлэх зүй
5. Ичинхорлоо Ш. (2009). 6 настай хүүхдийн тухай өгүүлэх нь.46-р тал
6. Одгэрэл Д., Бямбаотогтох Г., Түмэнцэцэг Б. (2017) Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдыг дэмжих төслийн тайлан 17-18 тал
7. Дарьмаа Д., Туул Д. (2008) Та хүүхдээ хэрхэн эрт хөгжүүлж болох вэ? Цуврал №1.
8. Ичинхорлоо Ш. (2009) 6 настай хүүхдийн тухай өгүүлэх нь 20 тал
9. <https://ddu55grodno.schools.by/pages/>
10. John Shamrock. (2011)-6 Child Development. USA: Mc. Grew Hill. 1(19), 36 20
11. Хишиг-Ундрах. М. (2013) Сэтгэл зүйн зурган тестүүд



1.2. ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОМЖ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

Бидэнд нийтлэг байдаг нэг зүйл бол бидний ялгаатай байдал юм. Энэхүү ялгаатай байдлаас үүдсэн ялгаатай хэрэгцээ хүүхэд бүрд байдаг. Бид нэлээд хэдэн жилийн өмнөөс “Хүүхэд төвт сургалт” гэж ярьсаар ирсэн боловч угтаа багш төвт сургалтын тогтолцоо амь бөхтэй байсаар байна. Үүний шалтгаан нь **бид хүүхэд бүрийг яг ижил байх ёстой мэтээр сэтгэж**, нэг ижил агуулгыг ижил арга, хэрэгслээр эзэмшүүлэхийг зорьж ирсэнтэй холбоотой юм. Хүүхэд бүрийг нэг хайрцагт, нэг хэвэнд зутгах гэж буй мэт яг адилхан зүйл сурах, яг адилхан сэтгэх ёстой мэт, яг адилхан амьдралаар амьдрах ёстой юм шиг хандлагаар сургаж байгаа нь үнэхээр харамсалтай юм.

Бидний дунд хөгжлийн ялгаатай онцлогтой хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээтэй, сурлагаар хоцрогдсон, амжиргааны түвшин доогуур өрхийн, малчны, алслагдсан, тааруу сурлагатай, завсардсан гэх мэтээр нэрлэн ялгаварлан гадуурхах хандлага байсаар байна. Хүүхдийн боловсрол эзэмшихэд тулгарч буй гол бэрхшээлийг **согог доголдол эсвэл хөгжлийн бэрхшээл, эмзэг бүлгийн, тусгай хэрэгцээт** гэх мэтээр ангилан хаягласнаар асуудлыг шийдвэрлэж чадахгүй. Ингэж харах нь **ялгаварлан гадуурхах** бүхий л нөхцөлийг бүрдүүлж байдаг. Эсвэл энэ ангиллын хүүхдүүдэд илүү анхаарал хандуулж, хаяг ангилалгүй **бусад сурагчдад** тулгардаг бэрхшээлийг анзааралгүй **үл хайхрах** байдлыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл зөвхөн согог, хөгжлийн бэрхшээл, эмзэг бүлгийн тусгай хэрэгцээтэй хүүхэд гэсэн нүдээр хүүхдийг харахыг урьтал болгож, **хүн бүрд бэрхшээл учирч хэрэгцээ үүсдэг** гэдэгт анхаарал хандуулж чадахгүй байна.

1994 онд UNESCO-гийн гишүүн орнуудын баталсан Саламанкагийн тунхаглалын 3 дугаар бүлэгт: “Хүүхэд бүр боловсрол эзэмших бүрэн эрхтэй. Сургуулиуд бүх хүүхдийг сургах ёстой. **Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгмийн сэтгэл зүй, хэлний болон бусад нөхцөл байдлаас үл шалтгаалан сургана.** Сургалтыг хүүхэд бүрийн сурах боломжид тохирсон хэлбэрээр өгөх хэрэгтэй. Хүүхэд болгон өөрийн гэсэн онцлог шинж чанар, сонирхол болон сурах хэрэгцээтэй” гэжээ.¹

Өнөөдөр манай сургуульд сонсголын бэрхшээлтэй хүүхдэд хичээл заах дохионы хэлтэй багш байна уу?, Брайль үсэг мэддэг багш хэд байна вэ? Багш надад аутизмтай хүүхэдтэй ажиллах чадвар байгаа юу? гэх мэт асуултуудыг өөрсдөөсөө асуугаад үзээрэй. Хэрэв энэ асуултуудад байхгүй гэсэн хариулт өгч байвал бид “Бүх хүүхдийг бие бялдар, оюун ухаан, нийгмийн сэтгэл зүй, хэлний болон бусад нөхцлөөс үл шалтгаалан сургана” гэсэн шаардлагыг биелүүлж чадахгүй байна гэсэн үг юм.

Сүүлийн жилүүдэд манай улс “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулан сургах” асуудлыг чухалчилж байгаа боловч багш нар бүх нийтээрээ энэ асуудлыг талаарх ойлголт харилцан адилгүй, ялгаатай ойлголттой байна. Тэгш хамруулан сургах гэдгийг зарим сургууль багш нар зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан сургах асуудал мэтээр харж байгаа нь өрөөсгөл ойлголт юм.

Багш бидний хичээл сургалтаа зохион байгуулж байгаа арга туршлага өнөөгийн нийгмийн болон хувь хүний хэрэгцээ шаардлагад нийцэж байна уу? Хүүхэд юуны тулд сургуульд суралцдаг вэ? Бид хүүхэд бүрт юуг зааж сургах нь чухал вэ? Тэд багшаас, сургуулиас юуг хүсдэг вэ?, Хүүхдүүд хэрхэн шинэ зүйлд суралцаж, хөгжиж байдаг вэ?, Тэд ямар онцлогтой вэ? Хүүхдийн хэрэгцээ сонирхол юу вэ? гэх зэргээр олон талаас нь судлан хүүхэд бүрийн онцлог ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгцээ шаардлага



байгааг мэддэг боловч сургалтаа хэрхэн яаж, ямар арга замаар үр дүнтэй зохион байгуулах вэ? гэдэг нь багш бидний өмнө тулгамдсан асуудал хэвээр байна. Багш нар хүүхэд бүрийн ялгаатай байдлыг таньж мэдэх, сурах үйл явцад тохиолдох бэрхшээлүүдийг тодорхойлох, тэдний хэрэгцээнд нийцүүлэн сургалтыг зохион байгуулах, орчин нөхцөлийг бүрдүүлэх, арга зүйд суралцах нь чухал.

Багш бидний өмнө

- Сурагч бүр хувийн онцлогтой, оюуны чадамж, хүйс, хэл соёл, авьяас зэргээрээ бусдаасаа ялгаатай байдгийг таньж мэдэх
- Хүүхэд бүрийн хувийн онцлог, ялгаатай байдал, хангагдаагүй хэрэгцээнд үндэслэн хичээлийн үйл ажиллагааг хөтлөн явуулах арга чадвартай болох
- Хүүхэд бүр хувийн онцлогтой, бусдаас ялгаатай, өөр өөр чадваруудтай тул нэг түвшинд байлгах гэсэн хандлагаа өөрчлөх
- Сурагчид мэдлэг, туршлагыг зөвхөн хичээлээр олж авдаг гэсэн өрөөсгөл ойлголтыг өөрчлөх шаардлага тулгараад байна.

Тэгш хамруулан сургах боловсролын зорилго юу вэ?

Хэлэлцүүлэг 1. Юуны өмнө та өөрөөсөө дараах 2 асуултыг асуугаад үзээрэй.

1. Танд хөгжлийн бэрхшээл бий юу?
2. Таны хүүхэд боловсролд тэгш хамрагдан суралцаж чаддаг уу?

Хариулт нь юу гэж байна вэ? Ихэнх нь “1. Би хөгжлийн бэрхшээлгүй, 2. Манай хүүхэд сургуульд сурдаг” гэж хариулах болов уу?

Таны чадахгүй болгон нь таны хөгжлийн бэрхшээл юм.

Учир нь та англи хэл огт мэддэггүй гэж бодъё. Та Америкт очвол орчуулагч байхгүй л бол

Одоо та дараах хүснэгт дэх асуултуудад хариулаад үзээрэй. Асуултанд хариулхдаа тийм, үгүй гэсэн хариултаас сонсож “+” тэмдэглээрэй

Асуулт	Тийм	үгүй
Та онгоц жолоодож чадах уу?		
Та морин хуур хөгжим тоглож чаддаг уу?		
Та усанд сэлж чадах уу?		
Та англи хэл мэдэх үү?		

сонсголын бэрхшээлтэй хүнтэй ижил нөхцөлд орно. Хэрэв усанд сэлж чаддаггүй гэж бодъё. Айхтар их устай үер болоход усанд живж үхэх магадлал усанд сэлж чаддаг хүнийхээс өндөр байна. Энэ нь танд хөгжүүлээгүй чадвараасаа болоод бэрхшээл учирч байна

гэсэн үг юм. Иймд хүн бүрд бэрхшээл байдаг гэсэн үг юм.

Хэлэлцүүлэг 2. Дараах 2 тохиолдлыг харьцуулан уншаад танд ямар сэтгэгдэл төрж байна вэ? Аль хичээл үр дүнтэй байна вэ? Яагаад? Тэгш хамруулан сургах боловсролын асуудалтай ямар холбоотой вэ?

Тохиолдол 1. Нэгэн ЕБС-ийн биеийн тамирын хичээл орж байв. Тухайн анги 36 сурагчтай. Өнөөдөр сагс тоглож сурах хичээл 40 минут орох хуваарьтай. Багш сагсны 1 ширхэг бөмбөгтэй. Хүүхдүүд хувцсаа солиход 5 орчим минут зарцууллаа. Шударга байх үүднээс багш охид хөдгүүдийг ижил хугацаанд тоглуулахаар болов. Багш эхлээд хөвгүүдийг 15 минутын хугацаанд тоглуулав. Энэ хугацаанд охидууд хөвгүүдийн тоглохыг харан элдэв зүйлийг ярилцаж сууна. Дараа нь охид 15 минут сагс тоглох, хөвгүүдийн харж суух ээлж ирлээ. Сагс тоглож байгаа явцыг ажиглахад өндөр нуруутай хүүхдүүд давуу тоглож, харин намхан нуруутай нэгэн охин маш идэвхтэй тоглосон боловч нэг ч удаа бөмбөг авч чадалгүй хий дэмий л бөмбөгний араас гүйсээр хугацаа дууслаа.



Тохиолдол 2. Нэгэн сургуулийн биеийн тамирын хичээл орж байв. Тухайн анги 24 сурагчтай. Хүүхдүүд 12,12-оороо групп болж нэг хэсэг нь усанд сэлэлт, нөгөө хэсэг нь сагс тоглохроо явлаа. Залны урд хэсэгт 6 цагираг, хойд талд мөн 6 цагираг, хүүхэд бүрд 5 бөмбөг оногдож байв. Хүүхдүүд хувцсаа солиход 5 орчим минут зарцууллаа. Багш хүүхдүүдэд нэг, нэг бөмбөг авч залалтын техникүүд зааж, дараа нь хосороо дамжуулалт хийх дасгал хийлээ. Мөн хүүхэд бүр шидэлтийн дасгал хийлээ. Хичээлийн бүхий л хугацаанд нэг ч хүүхэд зүгээр суусангүй. Маш их идэвхтэй суралцлаа.

Хэлэлцүүлэг 1: “Үнэгний санаа” үлгэрийн хэсгээс уншиж өгөөд “Энэ тэгш байдал мөн үү?”

хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Араатны хаан арслан ойн хамгийн мундаг амьтныг шалгаруулахаар болов. Хамгийн эхний шалгуур нь сэлэлтийн уралдаан байлаа. Хоёр дах шалгуур нь нисэх уралдаан, гурав дах шалгуур нь

гүйлтийн уралдаан байлаа.



Хэн нь ойн хамгийн мундаг амьтан болох вэ?

Зөвхөн нэг төрлийн тэмцээнээр ойн хамгийн мундаг амьтанг шалгаруулсан бол яах байсан бэ? Арслангийн зохиосон тэмцээнд амьтан бүр өөр өөрийн онцлогоороо ялагч болдог бөгөөд хамгийн мундаг амьтныг шалгаруулж чаддаггүй ажээ. Харин амьтад энэ цагаас хойш бие биенээ хүндэтгэн, бие биедээ туслан аз жаргалтай амьдарч байгаагаар төгсдөг. Энэ үлгэрээр “Бидний сонирхол, харагдах байдал, авьяас чадвар өөр өөр байдаг. Хүн бүрд давуу болон сул чадвар бий. Давуу талаа

нөөц боломж, сул талаа хөгжих хэрэгцээ, ялгаатай байдлыг хөгжих нөөц боломж, хүчин чадал болгох хэрэгтэйг ойлгуулж, тэгш байдлыг хүндэтгэсэн оролцоонд тулгуурлан өөрөө өөрийгөө таньж мэдэх, байгаагаараа хүлээн зөвшөөрөгдөж үнэлэгдэх, бусдын сайн сайхны төлөө зүрх сэтгэлээ зориулан хандлага төлөвшүүлэн тэгш хамруулах соёлыг хөгжүүлэх зорилготой.²

Хүн бүр суутан. Гагцхүү та загасыг мод руу авирахыг шаардаж байгаа бол тэрээр бүх амьдралынхаа туршид өөрийгөө тэнэг гэж бодсоор дуусна. /Альберт Эйнштейн/ Тэгш байдал гэдэг нь хүн бүрт адилхан хандах тухай ойлголт биш юм. Харин хүн бүрийн онцлогийг харгалзан үр дүнд хүрэх боломжийг олгох тухай ойлголт юм. Хүүхэд бүрийн нөөц боломжийг бүрэн дүүрэн нээж гаргах, үнэт зүйлийг нь бий болгоход тэгш хамруулан сургах боловсролын гол зорилго оршино.³

Тэгш хамруулан сургах боловсрол юуг чухалчилж үздэг вэ?

- Эмзэг бүлгийнхнийг тодорхойлох нь чухал биш, хүн бүр өөрийн онцлогтойг хүлээн зөвшөөрөх нь чухал.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг тодорхойлох нь чухал биш, хүүхдийн хангагдаагүй хэрэгцээг тодорхойлох нь чухал.
- Тусгай нэмэлт дэмжлэг үзүүлэх нь чухал биш, харилцан дэмжлэг үзүүлэх нь чухал.
- Хүүхдийг чадварын түвшингээр нь ангилах нь чухал биш, ялгаатай байдлыг хөгжих нөөц болгон ашиглах нь чухал
- Бүгдийг оролцуулах нь чухал биш, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжих орчинг бий болгох нь чухал.
- Тусгай сургууль, ганцаарчилсан сургалт чухал биш, сургуулийг бүх нийтийн болгож хөгжүүлэх нь чухал
- Хүүхдүүд бүх зүйлээрээ төгс байх нь чухал биш, хүүхэд бүрийн нөөц боломжийг бүрэн дүүрэн нээж гаргах, үнэт зүйлийг нь бий болгох нь чухал.⁴

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯЛГААТАЙ БАЙДАЛД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

Хүүхэд бүр ялгаатай чадвар чадамжтай.

1. Хүүхэд бүр хүртэхүйн хэв маягаараа ялгаатай.⁵



Вестер (Vester, 1975) хэлэхдээ:

“Бидний бүр багаас хүртэхүйн эрхтнүүд маань хүн бүрт ялгаатай хөгжсөн байдаг. Эдгээр ой тогтоолтын хэв маягийг сургалтад харгалзан үзсэнээр сурагчдыг амжилттай сурах боломжтой” гэжээ.



Хараагаар суралцагч
Сонсголоор суралцагч
Хөдөлгөөнөөр буюу хийж гүйцэтгэх замаар суралцагч

Аргачлал 1: Шүлэг цээжлүүлэх арга- видео хичээл 1.

- Хүүхдийг Ивээх Сангийн “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” (2015-2018) төслийн хүрээнд хийгдсэн “Шүлэг цээжлүүлэх аргачлал” видео хичээлийг (<https://www.youtube.com/watch?v=loCmahi4w6k>)⁶ линкээр үзээрэй.

Энэ арга нь хараа, сонсгол, хөдөлгөөнөөр суралцагч бүрт шүлэг, үлгэр, оньсого, зүйр үг зэргийг тогтоолгон, хэл яриа болон ой тогтоолтыг хөгжүүлэх тэгш боломж олгодгоороо онцлогтой аргачлал юм. Хараагаа ашиглан суралцдаг хүүхэд зураг нь, хөдөлгөөнөөр суралцагчид хөдөлгөөн нь шүлгээ сэргээн санахад нь тулгуур дохио болно гэсэн үг юм. Хүүхэд аливаа зүйлийг сурахдаа чихээ эсвэл нүдээ, хөдөлгөөнөө ашиглан суралцах нь тэдний өөрсдийн сонголт байх учиртай болов уу? Багш хүүхдийг заавал зурагт номоо харж унш, хөдөлгөөнөө заавал хий гэж шахааж шаардах албагүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл багш хүүхдэд тухайн зүйлийг сурахад хэрэглэгдэх олон хувилбарт аргачлал болон хэрэглэгдэхүүнийг санал болгож, хүүхдүүд өөрт тохирсноо сонгож суралцах боломж олгох нь чухал юм.

2. Хүүхэд бүр хувийн онцлогтой.⁷

- Экстрроверт суралцагч
- Шинэ хүмүүстэй танилцах, харилцах дуртай.
- Өөрийн эргэн тойронд болж буй зүйлд анхаарлаа хандуулж байдаг сониучхан зантай.
- Бусадтай хамтран хичээллэх дуртай.
- Аливаа шийдвэрийг түргэн гаргадаг.
- Турших дуртай. Эхлээд туршаад дараа нь нарийвчлан ойлгодог.
- Хурдан ойлгоод, хурдан мартдаг талтай.
- Анхаарал нэг зүйлээс нөгөөд шилжихдээ хурдан.
- Амархан уйддаг тул хийж байгаа ажлаа дутуу орхих талтай.



Интроверт суралцагч

- Дуу цөөтэй. Хүмүүстэй танилцахдаа удаан.
- Ганцаараа хичээллэх дуртай.
- Багаар ажиллах үедээ аль болох чимээгүйхэн сонсохыг илүүд үзнэ.
- Аливаа шийдвэрийг бодож байж гаргана.
- Сахилга баттай. Өөрийн байр сууриа мэддэг.
- Удаан ойлгож, удаан мартаx талтай.
- Анхаарал нэгээс нөгөөд шилжихдээ удаан.
- Нэг зүйлд төвлөрөхдөө сайн. Эхэлсэн ажлаа дуусгахыг эрмэлздэг.

Хэлэлцүүлэг 2: Дараах хэрэглэгдэхүүн экстрроверт ба интроверт хүүхдийн хэнд нь тохирох вэ? Яагаад?

Экстраверт хүүхдүүдийн анхаарал нэгээс нөгөөд шилжихдээ хурдан байдаг тул олон өөр өөр зүйл хийх нь сонирхолтой байдаг бөгөөд хурдан ойлгоод, хурдан мартдаг тул давталт хэрэгтэй байдаг байна. Тэдэнд нэг хэвийн дасгалууд нь уйтгартай санагддаг байна. Харин интраверт

хүүхдэд олон төрлийн дасгалыг нэг доор ажиллуулах нь тийм ч тохиромжтой биш. Энэ нь сайн ойлгож ухаараагүй байхад нь дараагийн ухагдахууныг зэрэгцүүлэн өгөх нь тохиромжгүй гэсэн үг юм. Учир нь тэд удаан ойлгож, ойлгосноо удаан мартдаг тул нэг ухагдахууныг сайн ойлгуулсны дараа шинэ ухагдахууныг олгох нь чухал. Тэд нэг л ойлгосон бол дахин дахин давтах шаардлагагүй байдаг. Тэгэхлээр дээрх хэрэглэгдэхүүн маань интравертүүдэд тохиромжгүй юм. Багш бидний сургалтын аргачлал, хэрэглэгдэхүүн маань хэнд илүү тохиромжтой хэнд тохиромжгүй байна вэ? гэдэгт анхаарлаа хандуулж, хүүхэд бүрт хүртээмжтэй, тохиромжтой олон хувилбарт арга, хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, хүүхэд өөрт тохирсоноо сонгох, эсвэл багш тохируулан өгөх маягаар хэрэглэх шаардлагатай.

Тарааж өгөх материал 1.

1. $1+3=$ $2+5=$ $9-4=$ $8-5=$
2. $x+3=6$ $6+a=9$
3. Дараах тоонуудыг өсөх эрэмбээр бичээрэй. 1, 9, 3, 5, 8, 4, 2, 6, 7
4. Тоонуудыг стандарт хэлбэрээр бичээрэй. арван зургаа, хорин өс
5. Жишээрэй. 19 ... 20, 38 ... 29
6. Бат 6 дэвтэр, Шүрээ 2 дэвтэр авав. Тэд нийт хэдэн дэвтэр авсан бэ?

Сурах үйл ажиллагаанд тулгардаг бэрхшээл хүүхэд бүрт ялгаатай.⁸

<u>Сонсох чадвар тааруу хүүхэд</u>	<u>Ярих чадвар тааруу хүүхэд</u>	<u>Тоо бодох чадвар тааруу хүүхэд</u>
➤ Урт үгийг буруу сонсдог. ➤ Сонсголын ой тогтоолт сул. Хүний хэлснийг мартдаг. ➤ Төстэй дуудлагатай эгшиг, гийгүүлэгч авиаг ялгаж сонсохдоо тааруу. ➤ Нэг зүйлийг ахин дахин асуудаг. ➤ Анхаарч сонсдоггүй, анхаарлын төвлөрөлт тааруу. ➤ Зааврыг ойлгох чадвар сул. ➤ Сул сонсголтой.	➤ Асуултанд хариулдаггүй, нэг үгээр эсвэл толгой дохих, сэгсрэх зэргээр хариулдаг. ➤ Бодсоноо сайн хэлж илэрхийлж чаддаггүй. ➤ Сандран үгээ давхцуулан яарч, амьсгаадаж, эсвэл хэт удаан сунжруулж ярьдаг. ➤ Ээрүү, дультраа, гуншаа болон авиа дуудлагын бэрхшээлтэй.	➤ Тоолохдоо тааруу, алдаа гаргадаг. ➤ Тоо хэмжээг ойлгох чадвар сул. ➤ Юмсын хэлбэр дүрс, харьцааг харьцуулах, ажиглах чадвар сул. ➤ Математик үг хэллэг, өгүүлбэртэй бодлогыг ойлгохдоо тааруу. ➤ Тооны дугаарлал, үйлдэл хийхдээ тааруу.
<u>Бичих чадвар тааруу хүүхэд</u>	<u>Амархан мартдаг хүүхэд</u>	<u>Унших чадвар тааруу хүүхэд</u>
➤ Үсгээ уншиж чаддаг ч бичиж чаддаггүй. ➤ Цэвэр нямбай, дэгийн дагуу хичээнгүй бичихдээ тааруу. ➤ Хуулж бичихдээ тааруу. ➤ Сонссоноо бичихдээ тааруу. ➤ Зохиож бичихдээ тааруу.	➤ Хэт хөдөлгөөнтэй бусдыг анхаарч сонсдоггүй. Сонссон ч амархан мартдаг. ➤ Ажиглах чадвар сул, харснаа сэргээн санахдаа тааруу ➤ Хичээлийн хэрэгсэл, эд зүйлсээ мартдаг, хаяж гээдэг.	➤ Бичиг, үсэг сонирхдоггүй. ➤ Үсэг нүдлэхдээ тааруу. ➤ Үсэг, үеийг холбож уншихад бэрхшээлтэй. ➤ Буруу уншдаг. (үсэг орхиж, мөр алгасч, тааж уншдаг) ➤ Уншиж чаддаг ч агуулгыг ойлгодоггүй.
<u>Хөдөлгөөний эв дүй муутай хүүхэд</u>	<u>Харилцааны чадвар сул хүүхэд</u>	<u>Асуудалтай зан гаргадаг хүүхэд</u>
➤ Хөдөлгөөний эвсэл муу. Алхах, харайх, гүйхдээ тааруу, амархан ядардаг. ➤ Хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийхдээ тааруу. ➤ Товчоо товчлох, гутлаа үдэж чаддаггүй. Хувцсаа хайш, яйш өмсдөг. ➤ Зурах, будах, хайчлах, наах, гар урлал хийхдээ тааруу.	➤ Олон хүний өмнө ярихдаа айж түгшдэг, сандардаг. ➤ Өөрийн бодол санааг үгээр илэрхийлж чаддаггүй. ➤ Зөвхөн өөрөө л ярьж, бусдыг сонсдоггүй. ➤ Бусдын үзэл бодол, санаа сэтгэлийг ойлгодоггүй. ➤ Дүрэм, журам, үүрэг хариуцлагыг ойлгодоггүй. Бусдаас хэт хамааралтай.	➤ Огцом цочмог зан үйл гаргадаг. ➤ Ангис гарч явдаг. Дураар холхидог. ➤ Бусдын юмыг зөвшөөрөлгүй авдаг. ➤ Юм хийхгүй зүгээр суудаг. ➤ Амархан уйлдаг. ➤ Чанга дуу чимээнээс айдаг. ➤ Бүдүүлэг үг хэллэг хэрэглэдэг. ➤ Өөрийн болон бусдыг зохиж, хаздаг. ➤ Нэг зүйлийг дуустал хийж чаддаггүй.



СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛИЙГ БАГАСГАХАД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

Сурахад тохиолддог бэрхшээл ¹	Суралцахад дэмжлэг үзүүлэх боломж, аргачлал
1. Үсэг нүдлэхэд бэрхшээлтэй байвал: Харааны ой тогтоолт, ажиглах, харьцуулах чадвар сул хөгжилтэй хүүхдэд үсэг нүдлэхэд бэрхшээл тохиолддог.	Аргачлал-2. “Дүрсэн цээж бичиг” нь харааны ой тогтоолтыг хөгжүүлэхийн зэрэгцээ ажиглах, анхаарах, эрж хайх, эрэмбэлэх, орон зайг баримжаалах, эгнээ байрыг олох, өөрийгөө үнэлэх, алдаагаа олох, засах, аливаад хариуцлагатай хандах, ээлж дараагаа хүлээх, харилцах чадварыг хөгжүүлэх дасгал, тоглоомыг дараах линкээр үзээрэй (https://www.facebook.com/100014752845184/videos/858942107940876). Аргачлал-3. “Ижил үсгүүдийг олцгооё” сургах тоглоом нь хүүхдийн дүрс, тэмдэгт, цифр, үсэг зэргийг ажиглах, жишиж, харьцуулах, анхаарлын хуваарилалт, харааны ой тогтоолтыг хөгжүүлж, үсэг, үеийг нүдлэн тогтоох чадварыг хөгжүүлнэ. (https://www.youtube.com/watch?v=Pyl-94ejoi0)¹⁰
2. Авиаг зөв дуудан холбож уншихад бэрхшээлтэй байвал: Сонсголын чадвар сул хөгжилтэй хүүхэд авиаг зөв ялган сонсох болон хэлэхэд бэрхшээл тохиолддог.	Аргачлал 4. “Би үг бодож оллоо” сургах тоглоом нь хүүхэд үгийн эхэнд болон төгсгөлд байгаа авиаг ялган сонсох, үг таах таавар таах, таамаглах, санаа бодлоо илэрхийлэх, авиаг нийлүүлж үг болгон хэлэх зэрэг сонсох чадварыг хөгжүүлэх, үгийн баялаг нэмэгдүүлэх, танин мэдүүлэх зорилготой. Энэхүү аргачлалыг бэлтгэл хөтөлбөрийн үед хүүхдүүд үсэг үзэхээс өмнө хэрэглэнэ. Цагаан толгойн үед шинэ үсэг үзэхийн өмнө, үзээгүй үсэг авианы үед хэрэглэж болно. (https://www.youtube.com/watch?v=ju42q27_7uo)¹⁰
3. Үг, өгүүлбэрийн утгыг ойлгон уншихад бэрхшээлтэй байвал: Үгийн баялаг цөөн хүүхэд хүүхдэд уншсан зүйлийнхээ утгыг ойлгоход бэрхшээл тохиолддог.	Аргачлал 5. “Хосоор асуулттай унших” арга Хүүхдээр үг, өгүүлбэр уншуулаад асуултаар ярилцаарай. Жишээлбэл: “Эмээ сүү уув” өгүүлбэрийг уншуулаад “Хэн сүү уусан бэ?, Эмээ юу уусан бэ?, Сүү гэж юу вэ?, Чи сүү уудаг уу? Сүү уух дуртай юу? гэх мэтээр ярилцаж байгаарай. (https://www.facebook.com/100014752845184/videos/896804890821264) Аргачлал 6. “Үгийн утгын зурагт толь хийх” аргачлал нь хүүхдийн танин мэдэх чадвар, үгийн баялгийг нэмэгдүүлэх, уншаад ойлгох чадварыг хөгжүүлэх, унших сонирхлыг төрүүлэх, уншихад дэмжлэг үзүүлэх зорилготой. (https://www.youtube.com/watch?v=oyA9252pkE)¹⁰ Энэхүү аргачлалыг цагаан толгойн үед хэрэглээрэй. Тухайн хүүхдийн эцэг эхтэй хамтран хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй.
4. Тоолох, тоо бодоход бэрхшээлтэй байвал: Бодит юмсыг тоолох, жиших, харьцуулах, ажиглах, тогтоох чадвар сул, математик үг хэллэгийн утгыг ойлгохгүй байвал бэрхшээлтэй учирна.	Аргачлал 7. “Бинго-Лото” сургах тоглоом нь хүүхдийн тоолох, ажиглах чадвар, тооны бүтцийг хараагаар тогтоох, анхаарал, анхаарлын хурд, анхаарлын багтаамжийг хөгжүүлдэг. (https://www.facebook.com/100014752845184/videos/858942107940876) Аргачлал 7. Дүрсээр наадагч- Тархины шуурга аргачлал нь хүүхдийн сэтгэлгээний хурд, ажиглах, зохиомжлох, сэтгэн бодох чадваруудыг хөгжүүлэхээс гадна математик үг хэллэгийг ойлгоход тусална. (https://www.youtube.com/watch?v=6MdVFd1F99M)² Аргачлал 8. Манай мал- шагай наадам аргачлал нь ажишлах чадварыг хөгжүүлэх, бодит юмсыг тоолох, жиших, харьцуулах, нэмэх, хасах, зөрөөг олох үйлэлд суралцах, тооны бүтцийг тогтоох, математик үг хэллэгийг ойлгоход тусална (https://www.youtube.com/watch?v=hgdw5kd9ndm&t=48s)¹⁰ 27 дүрс 9 нүд аргачлал нь өнгө, дүрс, хэмжээг таних, ялгах, ангилах, бүлэглэх, ажиглах, харьцуулах, жиших, зүй тогтлыг олох зэрэг чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (https://www.youtube.com/watch?v=BF1FHNFTmr0)¹⁰
5. Үсэг, үгийг дэгийн дагуу бичихэд бэрхшээлтэй байвал: Гар сарвууны жижиг булчин сул хөгжилтэй хүүхэд бичихэд бэрхшээлтэй байдаг.	Аргачлал 9. Гарын жижиг булчинг хөгжүүлэх аргачлал гарын жижиг булчингийн хөгжлийг дэмжихэд тусална. Хүүхдийг Ивээх Сангийн “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” (2015-2018) төслийн хүрээнд хийгдсэн “Гарын жижиг булчин хөгжүүлэх” аргачлалыг (https://www.youtube.com/watch?v=ezwzuldGaVw)¹⁰ -



ЗУРГААН НАСТНУУДАД ТУЛГАМДДАГ БЭРХШЭЭЛ, ТЭДЭНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ¹¹

Зургаан настнуудад тулгамддаг бэрхшээл		Зургаан настанд үзүүлэх дэмжлэг
Бие, бялдрын хөгжлийн хувьд	Яс булчингийн систем гүйцэд хөгжөөгүй байдаг тул хүнд цүнх үүрэх, хол газар алхах зэрэгт амархан ядардаг.	Тэд алхаж явах нь тун ховор, байнга гүйж харайж явахаас гадна ноцолдох, уралдах дуртай байдаг тул хичээлийн завсарлагаанаар гүйх, ноцолдох, хөөцөлдөх боломж олгох орчинг бүрдүүлж өгөх, хөдөлгөөнт тоглоомоор тоглуулаарай. Цүнхний ачааллыг тохируулах, хоёр мөрөндөө үүрдэг өргөн мөрөвчтэй, бүсэлхийгээрээ бүсэлдэг цүнх сонгох хэрэгтэй. Цүнхний жин 2 кг-аас хэтрүүлэхгүй байхыг анхаараарай.
	Гар сарвууны жижиг булчин сул хөгжсөн эв дүй муутай байдаг тул удаан хугацаагаар бичүүлбэл гар хуруу чилж өвдөн амархан ядардаг.	Удаан хугацаагаар бичүүлэхийн чухалчлахгүйгээр гарын жижиг булчин хөгжүүлэх дасгал хийлгээрэй. Жишээлбэл шагай няслах, будаа, савх, чүдэнз түүлгэх, шүр хэлхэх, дүрс хайчлах, зураг зурах, будах, баримлын шавраар бүтээл урлах гэх мэт.
	Амьсгалын систем сул хөгжсөн байдаг тул тэвчээр шаардсан дасгал хөдөлгөөн хийх, удаан хугацаагаар суухад маш хэцүү байдаг.	Зарим багш нар суулгаж сургахыг чухалчилдаг нь буруу юм. Харин тэд сонирхолтой зүйл хийж байхдаа тэвчээртэй сууж чаддаг. Иймд бид хүүхдийн сонирхолд нийцсэн олон янзын хувилбартай аргуудыг хэрэглэж байхыг эрмэлзэх хэрэгтэй.
Танин мэдэхүйн хөгжлийн хувьд	Хөдөлгөөнгүй суулгахад анхаарал нь маш их сарнимтгай байдаг.	Хөдөлгөөн хийх явцдаа оюун ухаан нь цэгцтэй хурдан сэтгэдэг тул хичээлийг хөдөлгөөнт дасгал, тоглоомоор тоглох явцад нь уншуулах, сэтгэн бодуулах, тогтоолгох үйлийг хийлгэх нь чухал юм.
	Хүртэхүйн задлан ялгах чадвар сул хөгжсөн байдаг тул юмсыг хүртэх үедээ хурц тод нүдэнд харагдах зүйл дээр анхаарлаа төвлөрүүлээд гол зүйлийг нь орхигдуулдаг талтай.	Зургаан настнууд бодит байдлаас харах, үнэрлэх, сонсох, амтлах, хүртэх гэсэн 5 мэдрэхүйн тусламжтайгаар хүртэж мэдэрдэг. Иймд хичээлийн хэрэглэгдэхүүн нь хүүхэд бүрт хүртээмжтэй бодит эд зүйл, дүрс биетүүд, тооллын материал, шагай, товч, чулуу, савх, хэрчмэл үсэг, үе, тоглоомууд чухал байдаг.
	Утгын ой сул байдаг тул сонссон зүйлээ хурдан мартдаг.	Харин тэд харсан, хийж оролдож үзсэн зүйлээ удаан мартдаг тул тогиоохгүй байгаа үсэг, үеийг баримлын шавраар хийлгэх, шүлэг, зүйр үг, оньсого, үлгэр тогтоолгохдоо зураг илэрхийлж дүрслэх, хөдөлгөөнтэй унших зэргээр тогтоолговол мартах нь удаан байдаг.
Нийгэмшихүйн хөгжлийн хувьд	Томчуудын болон үзсэн харсан киноныхоо зөв буруу үйлийг ялгах чадвар сул тул шууд дуурайх хандлагатай байдаг.	Томчууд тэдэнд байнга зөв үлгэр дуурайл үзүүлэх хэрэгтэй бөгөөд үзэж байгаа зүйл дээр нь анхаарал хандуулж, шүүлтүүртэй зөв үлгэр авах, хүмүүжилд эергээр нөлөөлөх кино, контент үзүүлэх хэрэгтэй.
	Сургуулийн шинэ орчин, дүрэм журам, цаг баримтлах, хүссэн хүсээгүй ч хичээл хийх ёстой гэсэн шаардлага зэрэг нь хүүхдэд хэцүү байдаг.	Шүлгээ чанга дуугаар унш гэхийн оронд арслангийн дуугаар, яриарай, уншаарай. Хулгана шиг шивнэж яриарай, Хурдан хий гэхийн оронд цагтай уралдах уу?, чимээгүй бай гэхийн оронд загас шиг чимээгүй болцгооё, жагсаад яв гэхийн оронд жаран хөлт болцгооё эсвэл гал тэрэг болцгооё гэх мэтээр тоглоом болговол тэдэнд илүү сонирхолтой.
	Сэтгэлийн хөдөлгөөнөө барьж чаддаггүйгээсээ болж уйлах, гомдох, муудалцах, зөрүүдлэх, хашгирах зэрэг хандлага гаргадаг.	Тэд тоглоомд ялагдах дургүй, шоолоход эмзэглэдэг, зэмлэлийг хүлээн авах дургүй байдаг тул аль болох шүүмжлэхгүйгээр эерэг аргаар ойлгуулах, тайвшруулах зэрэг зөөлөн аргыг тохируулан хэрэглэх хэрэгтэй.

ХӨГЖЛИЙН ЯЛГААТАЙ ОНЦЛОГТОЙ ХҮҮХДИЙН, СУРАЛЦАХУЙД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ¹²

Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог	Сурахуйд үзүүлэх дэмжлэг
- Хөөрөл саатлын процесс тэнцвэргүй - Хүртэхүйн хүрээ бага - Сэтгэхүйн нарийн үйлдэл гүйцэтгэх чадвар сул - Учир шалтгаан, уялдаа холбоо хамаарлыг олох, ерөнхийлөн дүгнэх чадвар сул - Биеэ барих өөрийгөө удирдах чадвар муу - Нэг зүйлийг олон удаа тасралтгүй давтамжтай хийлгэж удаан сурдаг - Бусдын нөлөөнд автах хандлагатай - Хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хооллох, нүүр гараа угаах, худцаслах, бие засах зэргээр гэр бүлийн орчинд бие дааж чадна - Унших, бичих үед бэрхшээл үүсдэг хэдий ч хөнгөвчилсөн сургалттай тусгай сургууль болон ердийн сургуульд сургах боломжтой	- Танин мэдэхүйн үйл ажиллагааны хувьд бодит юмсыг амьдрал дээр хэрэглэж буй байдлаар суралцвал илүү үр дүнтэй. - Сургалт зөвхөн 5 мэдрэхүйгээр дамжуулан өдөөж өгөх байдлаар явагддаг. - Сургалтын агуулгаа сонгохдоо тэдний хүнд, хүндэвтэр, хөнгөн зэргээс хамаарч сонгох бөгөөд тэдний биеийн болон сэтгэхүйн дутуу хөгжлийг засан сайжруулахад чиглэнэ. Өөртөө үйлчлэх, ахуйн энгийн хөдөлмөр, бусадтай харилцаж сурах чиглэлтэй үйлчилгээг үзүүлдэг. Хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүүхэд бичиг үсэг, тоо сурах бүрэн боломжтой. - Эдгээр хүүхдүүд шоолуулах, ичих, бухимдах, ганцаардах зэрэг зан төлвийн өөрчлөлт гарч болзошгүй байдаг тул гадуурхах, дээрэлхэхээс хамгаалах - Бусдаасаа илүү тусламж, дэмжлэг шаардлагатай хүүхэд шүү гэдгийг үе тэнгийнхэнд болон эцэг эхчүүдэд зөвөөр ойлгуулж, хамтран ажиллахад анхаарах хэрэгтэй. - Ярилцах үедээ нүд рүү нь харах, нүүрний хувирлаа тод харуулж, сэтгэл хөдлөлөө харуулах - Заавар өгөхдөө тодорхой цөөн үгээр хэлэх, зураг ашиглах - Заавар өгөөд бодох, эргүүлээд хариулт өгөх хугацаа олгох - Тэвчээртэй хүлээцтэй байх - Таны зааврыг аваад гаргасан хариу үйлдэл бүрт нь урамшуулах, баяр хүргэж, сайшаан магтах хэрэгтэй. - Ажиглалтын дэвтэрт хүүхдийн зан төлөв, сэтгэл хөдлөл, үйлдлийн талаар гарч буй өвөрмөц онцлогийг сар өдөр, багшийн зүгээс авсан арга хэмжээ, ямар үр дүн гарсан, юу сурч мэдсэн талаар тэмдэглэл хөтлөх нь зүйтэй.

Харааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог	Сурахуйд үзүүлэх дэмжлэг
1. Огт хараагүй хүүхэд Гэрлийн ямарч мэдрэмжгүй, харааны задлан ялгах хэсэг бүрэн устсан үед үүсдэг. Энэ нь харааны согогын хамгийн хүнд хэлбэр бөгөөд үлдсэн мэдрэхүйн эрхтнүүдийн тусламжтай орчинтой танилцана. 2. Үлдэгдэл хараатай - Гэрэл мэдэрдэг хэсэгт: нарны ба хурц туяаг бага зэрэг мэдэрдэг хүүхдийг - Хуруу тоолдог хэсэгт: хараа шалгах самбараар шалгах боломжгүй, зөвхөн ойрын зайнаас хүний хуруу тоолох чадвартай хүүхдийг - Хөдөлгөөнтэй буюу томоохон биет зүйлийг харж чадах хэсэгт: өөрийн өмнөх замыг муухан харж чаддаг, орчин тойрондоо байгаа том овортой, эсвэл хөдөлгөөнт зүйлийг ялгаж байгаа хүүхдийг тус тус хамааруулна. 3. Сул хараатай Сул хараа гэдэг нь хүүхдэд дараах байдлуудаас аль нэг нь юм уу түүнээс илүү байдлууд байхыг хэлнэ. Үүнд: - Холын зайд юмсыг тод харах чадвар нь буурсан - Ойрын зайд юмсыг харах чадвар нь буурсан - Төвлөрсөн буюу, хажуугийн юмсыг харах харааны алдагдлыг хамруулна.	- Багш сургалтандаа брайл үсэг, бусад тэмтрэх болон, аудио материалыг ашиглах шаардлагатай. - Зүг чиг, хөдөлгөөн орон зайн баримжааны сургалтыг тусгайлан явуулах хэрэгтэй. - Орчны орон зай, өөрийн болон бусдын орон зайн баримжаагаар орчноо мэдрэх чадварт сургах - Орчин тойрондоо чөлөөтэй явах чадвар, шилжин чвах сургуулилт хийлгэх - Ганцаараа явах, цагаан таяг ашиглаж сурах - Хөтөчлөх аргаар орон зайн баримжааг хөгжүүлж, айдсыг арилгах, өөртөө итгэлтэй айдасгүй алхуулах дадлыг суулгах - Сул хараатай сурагчид үсгийн хэмжээ, фонтыг харгалзан үзэх, фонт 18-аас дээш байх - Цагаан цаасан дээр тод хар өнгөөр бичиж өгөх - Аливаа бие харагдахуйцаар гэрлийн тусгалыг тохируулах - Хэл яриагаар болон тэмтрэх мэдрэхүйгээр дамжуулан тайлбарлах аргыг хэрэглэх



Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог	Сурахууд үзүүлэх дэмжлэг
- Хэл яриаг хүлээн авах бэрхшээл гэдэг нь сонгол, хараа нь хэвийн боловч сонсож байгаа үг яриаг хүлээн авч ойлгож чадахгүй байхыг хэлнэ. - Ярианы бэрхшээлд үг авиаг зөв дуудах, хэлэх үг ярианы хурд, хэмнэлийг зөв хэрэглэх чадвар багтана. - Дуу хоолойны өнгөний өөрчлөлт нь огт дуугүй болох, эсвэл дууны хөвч, хоолойн өнгө өөрчлөгдөх байдлаар илэрнэ. - Хэл ярианы эмгэг удаашралт, эмгэг түргэсэлтийг хэл ярианы хурд, хэмнэлийн алдагдал гэж үздэг ба энэ үед ярианы аялгуут, уянгалаг, хэм хэмнэл чанар алдагддаг. - Авиаг огт дуудаж чадахгүй байх, буруу дуудах, хооронд нь солих байдлаар авиа дуудлагын согог илэрдэг. - Авиа нь гарч өгөхгүй гацах, олон дахин давтан ярих, жигд ярьж чадахгүй байхыг эерүү гэнэ. - Өгүүлэх эрхтний бүтэц, үйл ажиллагааны өөрчлөлтийн улмаас өнгө авиа дуудлага дуу хоолойны өнгө өөрчлөгдөхийг гуншаа гэдэг. - Нүүр амны өгүүлэх эрхтний сулралаас хэл ярианы дуудлагын эмгэг өөрчлөлтийг дультраа гэдэг.	- Эдгээр хүүхдүүдийг хэл заслын сургалтад хамруулах, өгүүлэх эрхтнийг хөгжүүлэх дасгалуудыг хийлгэж байх нь чухал юм. - Эрүүл хүүхдүүдээс өөрийгөө дутуу гэжэмзэглэх, сэтгэл санаагаар унах үе гардаг тул бусад хүүхдүүдэд зөвөөр ойлгуулж, хүндэтгэлтэй хандаж байхыг ойлгуулах - Тэдэнд өөрийгөө илэрхийлэх дохио зангаа, картыг ашиглуулж болох юм. - Уншсан ойлгосон зүйлээ бичгээр, зургаар илэрхийлэх боломжийг олгосон аргуудыг ашиглах - Хүүхдийн яриаг тэвчээртэй сонсох, - Цуврал зураг, үйл явдлыг харуулсан зураг, түүхийг өгүүлсэн зургийг ашиглан хэлэх, ярих зүйлд нь дэмжлэг үзүүлэх

Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн онцлог	Сурахууд үзүүлэх дэмжлэг
- Хөдөлгөөний бэрхшээлд бие махбодь хөдөлгөөнөө удирдан хянах чадварын бэрхшээлүүдийг хэлнэ. Бие махбодын хөдөлгөөнд биеийн байрлалаа өөрчлөх, нэг газраас нөгөөд шилжих, ямар нэг зүйлийг өргөх, зөөх, ачих, алхах, гүйх авирах зэрэг том болон жижиг булчингуудын үйлдлийг хэлнэ. - Эрүүл хүнтэй харьцуулахад биеэ хөдөлгөх хэмжээ бага - Бие булчингийн хөдөлгөөний хязгаарлагдмал хэсэгт ачаалал өгдөг. Булчингаа ашигладаггүй. - Булчин нь чангарч чулуу шиг хатуурдаг. Булчингийн үйл ажиллагаа нь сул, нурууны яс мурийж амьсгалахад бэрхшээл үүсдэг. - Олон цаг нэг байрлалаар удаан байснаар бие нь чилж өвдөнө. - Биеэ санаснаараа хөдөлгөж чадахгүйн улмаас бухимдана. - Биеийн хөдөлгөөн чөлөөтэй бус учир хичээл сургалтанд оролцох боломж хязгаарлагдмал байдаг.	- Хөдөлгөөний бэрхшээлтэй гэж нэг үгээр хэлж байгаа боловч бэрхшээлтэй байгаа эрхтэн нь хүүхэд бүрт өөр өөр байна. - Хүүхдэд туслахдаа заавал өөрөөс нь тусалцаа хэрэгтэй эсэхийг асуух хэрэгтэй. Энэ нь хүүхдийн бие даасан эрхэм чанарыг хүндэтгэж байгаа бөгөөд өөрт холбоотой асуудалд өөрөө шийдвэр гаргаж байх нь чухал. - Тэргэнцэртэй хүүхдэд туслахдаа гэнэт түлхэх, зогсох, хэт гэдийлгэх зэрэг үйлдлээс болгоомжлох - Анги танхимын зохион байгуулалтыг хүүхэд чөлөөтэй зорчиход саад болохгүйгээр тохижуулах - Тэргэнцэртэй ажиллах арга зүйг багш, ажилчид, хүүхдүүдэд зааж өгөх. Өөрсдөө зорчиж үзэн хаана ямар бэрхшээл байгааг үнэлж шийдвэрлэх - Хөдөлгөөн засал ба идэвхтэй хөдөлгөөнийг идэвхжүүлэх - Ахуйн сургалт ба өөрөө өөртөө үйлчлэх дадал эзэмшүүлэх



Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог	Сурахууд үзүүлэх дэмжлэг
- Сонсох чадварын алдалтын түвшнөөс хамааран огт сонсголгүй, сул сонсголтой гэж ангилдаг. - Огт сонсголгүй: Сонсгол бүрэн алдагдсан - Сул сонсголтой: Сонсголын аппаратын тусламжтайгаар бусадтай харилцах боломжтой. - Сонсголын чадвараа алдалт хүн бүрт өөр өөр байдаг. Жишээлбэл: нам дуу чимээг сонсдог ч хүчтэй дуу чимээг сонсдоггүй байх, харин дууг сонсдог хэрнээ бүдүүнийг сонсохгүй байх, зарим өдөр сонсохгүй болох, эсвэл муу сонсох тохиолдол ч байна.	- Сонсголгүй болон, сул сонсголтой хүүхдэд боловсрол олгох дэлхий нийтэд дэлгэрсэн үндсэн 3 арга байдаг. Хос хэл, соёлын арга зүй: Сонсголгүй хүүхдийн эх хэл болох дохионы хэлээр сургалтыг зохион байгуулах арга юм. дохионы хэлээрээ дамжуулан “бичгийн монгол хэл”-ийг хоёр дах хэлээ болгон эзэмшинэ. Аман хэлний арга зүй: Сул сонсголтой хүүхэд амны хайрцаг буюу уруулын хөдөлгөөнийг унших байдлаар аман хэлийг ойлгож, сургалтын үйл ажиллагаанд оролцох арга юм. Хавсарсан хэлний арга зүй: Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг аман хэл, амны хайрцагнаас унших, дохион хэл, бичгийн хэл, хурууны үсэг, дохио зангаа гэх мэт боломжих бүх арга барилаар сургах арга зүй юм. - Ангид сул сонсголтой сурагчийг сургалтын үйл ажиллагааг бүрэн хүлээн авахад тохиромжтой, үзэгдэх орчин сайтай суудалд суулгах - Хичээлийн агуулгыг бичвэр мөн зургаар илэрхийлсэн байх нь чухал - Хараагаар дамжуулан мэдээллийг хүргэх аргуудыг ашиглах - Сонсголын алдагдлаасаа хамаарч яриаг сонсох уртын зай гэж байдаг тул тухайн сурачийн сонсох уртын зайг мэдэх шаардлагатай. Ярих тайлбарлах, цээжээр бичүүлэхдээ тухайн сурагчийн сонсох уртын зайнаас дотогш байрлалд хэлэх нь зүйтэй. - Хичээл ба сургалтыг эхлэх гэж байгааг илэрхийлсэн дохиог хэрэглэх - Харааны ижил түвшинд харилцах, дохио зангаа, биеийн хэлэмжээ хичээл сургалтанд ашиглах - Үгээ тод бөгөөд тайван хэлэх, энгийн үг хэллэгийг яриандаа ашиглах - Ойлгосон эсэхийг тодруулж, шаардлагатай бол нэмэлт давтлага өгөх

Зан үйлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог	Сурахууд үзүүлэх дэмжлэг
Зан үйлийн бэрхшээл нь доорх нэг буюу хэд хэдэн шинж тэмдгээр илэрч хүүхдийн суралцах үйл ажиллагааны гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөхүйц байдлаар тодорхойлогдоно. - Суралцах бэрхшээл нь окуны, мэдрэхүй, эрүүл мэндийн хүчин зүйлээс хамааралгүй - Үе тэнгийн хүүхдүүд, багш, бусадтай харилцах харилцааг үргэлжлүүлэх чадваргүй байдаг. - Ердийн нөхцөлд хэвийн бус зан үйл гаргаж, зохисгүй байдлаар мэдрэмжээ илэрхийлдэг. - Ерөнхийдөө сэтгэлийн хямралтай, гуниг гутралын төрх байдалтай. - Хувийн болон сургуулийн асуудалтай холбоотой айдастай, эрүүл мэндийн таагүй байдал бий болох хандлагатай.	- Хүүхдийг ажиглаж, тодорхой бус зан аашийг гаргаж байгаа шалтгааныг илрүүлж, юу илэрхийлэхийг хүсэж байгааг тодорхойлох - Тухайн сурагчийг хэрэгцээгээ хангах арай илүү тохиромжтой арга олоход туслах - Ангид тухайн хүүхэд ямар үед ямар зан үйлдлийг хэр давамжтайгаар гаргаж байгааг ажиглах зорилгоор бичлэг хийж, хүсэл, сонирхол, хэрэгцээг нь тодорхойлох - Зан үйлд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан зохистой зан төлөвийг төлөвшүүлэх үр дүнтэй төлөвлөгөөг боловсруулах - Хүүхдийн гаргасан зан араншинг болон авсан арга хэмжээ, түүний үр дүн өөрчлөлтийг тухай бүр сар өдөртэй нь тэмдэглэн баримтжуулах

Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн онцлог	Сурахууд үзүүлэх дэмжлэг
Аутизмын эмгэгтэй хүүхэд нийгмийн харилцан үйлчлэл, бусадтай харилцах харилцаанд дутагдал илэрдэг, хүсэл сонирхлын хувьд хязгаарлагдмал нэг зан үйлээ олон дахин давтдаг зэрэг шалтгаанаар сурч боловсрох, өдөр тутмын амьдралд дасан зохицоход тусламж шаардлагатай байдаг. - Аутизмын эмгэгтэй хүүхдийн хүлээн авах болон илэрхийлэх, хэл яриа, харилцааны чадвар өөрчлөлттэй. Бусдын хэл яриаг ойлгоход хүндрэлтэй, мөн нийгэмшихүйн чадвар алдагдсан. - Өөрийн санаа бодол сэтгэгдэлээ илэрхийлэхэд хүндрэлтэй, бусдаас ямар нэг зүйлийг хүсэн хэлж чаддаггүй. Үе тэнгийнхэнтэйгээ ойлголцох, харилцан холбоо тогтоох, хамтрахад бэрхшээлтэй. - Сонирхол нь хязгаарлагдмал, хөдөлгөөний өөрчлөлттэй. - Ямар нэг зүйлийг өөрчлөхөд бухимдаж, дарамтад ордог. - Гол төлөв өөрийнхөө мэддэг зүйлд анхаарлаа хандуулж, түүнийг сонирхдог, тэр зүйлдээ гацдаг, донтдог. Энэ нь зөрүүд буюу хатуу чанга байр суурь илэрхийлж байгаа хэрэг биш мэдрэхүйн үйлийн өөрчлөлтүүд юм. - Мэдрэхүйн хариу үйлдлүүд дуу авиа, үнэр, хөдөлгөөн, амт чанар тэдгээрт үзүүлэх хариу үйлдэл нь өөрчлөлттэй хэвийн бус байдаг. мэдрэлийн системийн байдал нь хэт мэдрэмтгий хүлээн авдаг.	- Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн харааны ой тогтоолт маш сайн байдаг тул харах, барих, ажиглах үйлийг илүү ашиглан ойлгуулах - Нэн тэргүүнд өөрөө хооллох, бие засах, хувцсаа солих, унтах зэрэг өдөр тутмын амьдралын дадал чадвар, хэмнэлд сургах нь чухал. Түүнчлэн эцэг эх, бусад хүүхэд, гэр бүл, ойр төрлийн хүнтэйгээ харилцах чадварт тоглоомоор дамжуулан сургаж, зориуд эзэмшүүлэх - Өвөрмөц содон зураг зурах, хуулж зурахдаа гарамгай байдаг чадварыг ашиглан сонихолтой зураг дүрслэл болон зурах үйлээр дамжуулан хөгжүүлэх - Тодорхой нэг зүйлд ажиглагддаг авьяас чадвар Туйлширмал сонирхолтой, тодорхой нэг зүйлийг маш хурдан сурч эзэмшдэг. - Аливаа зүйлийг ангилж цэгцлэхдээ сайн байх нь элбэг. Тэдний зарим нь дуртай зүйлээ туйлын нарийн нямбай хийдэг, эд зүйлүүдийг өнгө, хэлбэрээр нь ялгаж төрөлжүүлэхдээ онцгой сайн байдаг чадварыг нь сургалтад ашиглах - Дуу хөгжмийн мэдрэмж маш сайн Нэг сонссон дуугаа тэр дор нь цээжилнэ. Дууны хэмжээг сайн ялгаж чаддаг. Төгөлдөр хуур тоглож сурах чадвар маш сайтай. Хөгжмийн чадварыг хөгжүүлэх сургалтад хамруулах.



Анхаарал дутмаг, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй хүүхдийн онцлог	Сурахууд үзүүлэх дэмжлэг
- Анхаарлаа төвлөрүүлэхгүй ба ба хэт хөдөлгөөнтэй байх - Хийж байгаа зүйлээсээ өөр зүйлд анхаарал нь амархан сарнидаг. - Нарийн жижиг зүйлүүдэд анхаарахгүй байх, анхааралгүй байдлаас болж алдаа гаргах - Нүүр нүүрээ хараад ярилцаж байхад сонсохгүй байгаа мэт байх - Даалгаврыг дуустал хийж чаддаггүй. Дэс дараалалтайгаар юмыг хийж чаддаггүй. - Юмыг амархан мартдаг мартамхай. - Хэт хөдөлгөөнтөх, цочмог зан үйл гаргадаг. - Суудалдаа суух ёстой нөхцөл байдалд ч дураараа босдог. Сууж байсан ч гар хөлөө хөдөлгөн зүгээр сууж чаддаггүй. - Тохиромжгүй үед гүйж харайж, өндөр юманд авирдаг. - Асуулт дундуур хариулах, харилцан ярианд бусдыг сонсолгүй ярьдаг. - Бусдад саад учруулдаг. - Сонирхсон зүйлдээ шууд хүрч үзэх, барьж авахгүй бол санаа нь амардаггүй. - Ээлж дараалал хүлээж чаддаггүй.	- Аливаад амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлэх - Өдөр тутам алдаа их гаргадгаасаа болоод үргэлж загнуулж шүүмжлүүлж байдаг. Байнга ийм нөхцөлд байдаг тул өөрийгөө үнэлж, хүндлэхээ больдог. Тэднийг анхаарч, хэрэгтэй үед нь бусадтай муудалцах, болчимгүй үйлдэл хийхээс нь сэргийлэх, алдаа дутагдал гаргахгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлж өгөх хэрэгтэй. - Мөн аливаа зүйлийг хичээж хийсэн үед нь, тэвчээртэй суугаад хүлээж чадсан үе бүрт нь сайн магтаж урамшуулж байх нь зүйтэй. - Тэд яг төвлөрөөд хийвэл жирийн хүүхэд удаан цаг зарцуулах хэмжээний даалгаврыг ердөө 15 минутад л дуусгаж чаддаг. - Түүний хичээл хийх орчныг нь өөрчлөөд үзээрэй. Ширээн дээр суугаад л дэвтэр номтой зууралдахыг л хичээл хийх гэж ойлгож болохгүй. Хэрвээ хичээлээ хийж өгөхгүй хэцүү байвал ТВ, Youtube зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглаж хийлгээд үзээрэй. Мөн компьютерийн хэрэглээний программ болох power point ашиглаж илтгэл тавиулах, дасгал сургуулалт хийлгэх зэрэг нь их үр дүнтэй байдаг. Өмнө нь хийлгэж байгаагүй аргачлал, орчинд хичээл хийлгэх нь хүүхдийн авьяас чадварыг нээх тохиолдол байдаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Д. Одгэрэл, Д. Ганболд, О. Мөнхцэцэг, Ч. Нямдорж, А. Бадамцэрэн, Б. Бат-Оюун. Тэгш хамруулах боловсрол ЕБС-ийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль. ХИС. УБ. 2020. Хуудас 4
2. Норовдоо Б, Тэгш хамруулах боловсрол, Эцэг эх, олон нийт, сургуулийн ажилтнуудын мэдлэг ойлголтыг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх арга зүй. 2020. Хуудас120-121
3. Д.Одгэрэл, Д. Ганболд, О.Мөнхцэцэг, Ч.Нямдорж, А. Бадамцэрэн, Б. Бат-Оюун. Тэгш хамруулах боловсрол ЕБС-ийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль. ХИС. УБ. 2020. Хуудас 20
4. Норовдоо Б, Баясгалан Ц, Тэгш хамруулах боловсрол, Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй, 2021, хуудас15
5. Азжаргал М, Сувд-Эрдэнэ Ч, Сургалтанд сурах хэв маягийг харгалзах нь, хуудас 2
6. Хүүхдийг Ивээх Сангийн “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” (2015-2018) төслийн хүрээнд хийгдсэн видео хичээл
7. Азжаргал М, Сувд-Эрдэнэ Ч, Сургалтанд сурах хэв маягийг харгалзах нь, хуудас 3
8. ХИС, Одгэрэл Д, Ганболд Д Сургалтын үйл ажиллагааг дэмжих Тусгай хэрэгцээт боловсролын арга зүй бага ангийн жишээн дээр 172 шинэлэг санаа, хуудас 15
9. ХИС, Норовдоо Б, Хажидсүрэн Н, Эцэг эх-багштай харилцах дэвтэр, 2017, хуудас35-37
10. Хүүхдийг Ивээх Сангийн “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” (2015-2018) төслийн хүрээнд хийгдсэн видео хичээл
11. Норовдоо Б, Хажидсүрэн Н. (2016). Эцэг эх- Багштай харилцах дэвтэр”- тэй ажиллах арга зүй сургалтын модуль. Хуудас 18-19
12. Д. Одгэрэл, Д. Ганболд, О. Мөнхцэцэг, Ч. Нямдорж, А. Бадамцэрэн, Б. Бат-Оюун. Тэгш хамруулах боловсрол ЕБС-ийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль. ХИС. УБ. 2020. Хуудас



2.1. БЭЛТГЭЛ ХӨТӨЛБӨРИЙГ АРГА ЗҮЙ

Бяцхан суралцагчдыг сургуулийн шинэ орчинд дасан зохицоход багшийн халамж анхаарал шаардагдах торгон агшин бол бэлтгэл хөтөлбөрийн үе учир багшаас хүүхдийнхээ нас бие сэтгэхүйн онцлогийг харгалзан анхаарлыг нь татах хичээлийг бүтээлчээр зохион байгуулах, сурах орчинг бүрдүүлэх, нэгж хөтөлбөрийг сонголттойгоор төлөвлөх, гарын доорх материалаар хэрэглэгдэхүүнийг хийж ашиглахыг шаардаж байна.

Нэгдүгээр ангид элсэж орж буй сурагч сургуулийн орчинд дасаагүйгээс цоо шинэ орчин, шинэ нөхцөлд шинээр харилцаанд орж, “суралцах” үйл ажиллагаанд оролцох болсноор ихээхэн бэрхшээлтэй тулгардаг. Бэрхшээл үүсэхэд дараах хүчин зүйлс нөлөөлдөг байна. Үүнд:

- Сургууль, анги танхимын орчин, сургалтын үйл ажиллагааны дэгд дасаагүй байдал
- Нарийн цагийн хуваарь бүхий шинэ харилцаанд оролцох, олон хүнтэй харилцах
- Сурагчдын сургуульд бэлтгэгдсэн байдал харилцан адилгүй байх
- Өмнө хийж байгаагүй зурах, бичих, цээжлэх, тогтоох, гэрийн даалгавар хийх зэрэг заавал хийх ажлуудад ихээхэн цаг зарцуулснаар тоглох, дуртай зүйлээ хийх цаг хугацаа багасах гэх мэт.

Иймд гэр бүлийн орчин нөхцөл, амьдралын хэв маягийн ялгаатай орчинд өсөж торнисон, сургуулийн өмнөх боловсролыг харилцан адилгүй эзэмшсэн хүүхдүүдийг “сургууль” хэмээх шинэ орчинд дасан зохицоход үүсэж буй бэрхшээлийг аль болох богино хугацаанд арилгах, суралцахад бэлтгэх явдал тэдний эн тэргүүний хэрэгцээ юм. Сургуульд дасан зохицож чадаагүй, суралцах бэлтгэл хангагдаагүйн улмаас хүүхэд сурлагаар хоцрох, түүнээс шалтгаалан сургуульд дургүй болох эрсдэл бий болох талтай. Иймээс хүүхдэд сургуульд элсэх үед бий болдог бэрхшээлийг даван туулахад нь туслах, сургуулийн орчин, сурах үйл ажиллагаанд дасан зохицох, сурах сонирхол, сурах арга барил эзэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор БСШУС-ын сайдын 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” А/226 дугаар тушаалаар баталсан “Бэлтгэл хөтөлбөр”-ийг нэгдүгээр ангийн сургалтын төлөвлөгөөнд 60 цагт багтаан хэрэгжүүлэхээр тусгасан.

Зургаан настай хүүхдийн онцлогоос шалтгаалан бэлтгэл хөтөлбөрийн үед багш нараас маш өндөр мэдрэмж, ур чадвар, заах арга барил, идэвх санаачилга, харилцааны өндөр соёл, хариуцлага шаардан олон хүндрэл бэрхшээл тулгарч байсан боловч багш нар үүргээ ухамсарлан хүндрэлийг даван туулж, амжилттай ажиллаж ирлээ.

Бэлтгэл хөтөлбөрийг заахдаа багш нар үйл ажиллагаагаа аль болох зургаан настны онцлог дээр тулгуурлахыг эрмэлзэн хэрэглэж буй хэрэглэгдэхүүн, зургийн сонголт, арга барил зэргээ тэдний нас сэтгэхүйн онцлогт зохицуулан сонгож ажиллаж байгаа нь тэдний анги доторх орчин, хүүхдүүдээр хийлгэсэн бүтээл, хичээлийн загвар болохуйц хэрэглэгдэхүүний байдлаас харагдаж байна.

Багш нар зургаан настай хүүхдийн өвөрмөц онцлогт тохируулан тоглоомын арга хэлбэрээр хүүхэд бүрийн гарт бариулж мэдрүүлэх, үзүүлж харуулах, дүрд тоглуулах, будах, зурах, ангилах, нөхөх дасгал хийлгэх зэрэг олон үйл ажиллагаагаар хичээл сургалтыг зохион байгуулжээ. Энэ насны хүүхэд хурц тод өнгийг ялган хардаг учир хийж буй хэрэглэгдэхүүн ангийн орчныг бүрдүүлэхэд өнгийн цаас, өнгийн хуулгыг их хэмжээгээр ашиглаж байлаа. Эдгээрт харин их цаг зав, мөнгө хөрөнгө шаардагдсан нь мэдээж.

Бэлтгэл хөтөлбөрийн үед эцэг эхчүүдийн хүч нөөц боломжийг нилээн сайн түлхүү авч чадсан багш нар дээрх бэрхшээлээс амархан гарч чадсан байна. Харин эцэг эхчүүдэд зарим багш нар өөрсдийн ажлын онцлог, хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, хэрэглэгдэх зүйлсийн талаар бодит ойлголтыг өгч чадаагүйгээс дан ганц өөртөө бүх үүрэг хариуцлагыг авч тулгамдсан асуудлуудаа шийдэхэд бэрхшээл учирч байсан нь ажиглагдлаа.

Энэ хөтөлбөрийн үед багш нар тэдний хэл яриаг хөгжүүлэх богино шүлэг, үлгэр, үгэн тоглоом, түргэн хэллэг, хэл зүгшрүүлэх үг, жороо үг, оньсого, зүйр цэцэн үг, таавар зэргийг өргөн ашиглахаас гадна бусадтай зөв харилцах анхан шатны чадварт сургах зорилгоор аялал хийх, хүмүүстэй өөрсдийнх нь түвшинд харилцаанд оруулах, өдөр тутмын болон хэвшмэл үг



хэллэг, талархал болон уучлалт, эелдэгээр гуйх үг хэллэгийн түүвэр хийж хичээл сургалтдаа ашиглаж байна. Зургаан настай хүүхэд нь сонирхсон зүйлээ эхэлбэл дуусгах гэж хичээдэг учир хичээлд үйл явдлын дараалалтай зурган өгүүлэл, үлгэрийн цуврал зургуудыг өргөн ашиглаж тэдний бүтэн өгүүлбэрээр ярих хийсвэрээр зохиох чадварыг хөгжүүлж байна.

Багш нараас ярилцлага хийх явцад хичээлийн хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг маш тодорхой үйл ажиллагааны дараалалд оруулж, тэр бүрд ашиглагдах хэрэглэгдэхүүн бэлдцийг олон хувилбартайгаар сонгон бэлтгэх нь хичээлийг бүтээлч, сонирхолтой болгох, сурагчдыг уйдаахгүй олон төрлийн үйл ажиллагаанд хамруулах гол үндэс нь болсон гэж тодорхойлж байсан нь дараа дараагийн зургаан настны багш нар хичээлийн төлөвлөлт, хэрэглэгдэхүүн, бэлдцэд гол анхаарлаа хандуулах ёстойг бидэнд сануулж байна.

Үнэлгээний хувьд бэлтгэл хөтөлбөрийн үед аман урамшуулал, үгэн дэмжлэг, идэвхийг сэргээх үг хэллэг, цаашид бүр сайн хийх урам зоригийг бадраах үгсийг зөв оновчтой ашиглаж хэвшүүлэхийг зорин ажиллаж байна. Харин эцэг эхийн зүгээс ямар нэгэн бодит дүн үнэлгээг шаарддаг учир энэ үед багш хүүхдийн өөрийн түвшингийн ахицаар хүүхэд нэг бүрийн ахиц дэвшлийн график хөтөлж байлаа. Гэвч зургаан настай хүүхдийн сургуульд элсэх үед бий болдог бэрхшээлийг даван туулахад нь туслах, сургуулийн орчин, сурах үйл ажиллагаанд дасан зохицох, сурах сонирхол, сурах арга барил эзэмшиж эхлэхэд бага ангийн багш нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй хэрэгтэй байна.

БЭЛТГЭЛ ХӨТӨЛБӨР

Өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах

- Өөрийгөө танилцуулах, өөрийн мэддэг, дуртай ямар нэг зүйлийг тайлбарлах
- Мэндлэх, хүндлэх, туслах, талархах, зөвшөөрөл авах, уучлал хүсэх, тусламж хүсэх үг хэллэг хэрэглэх, бусадтай эелдэг, найрсаг харилцах
- Анги танхим, сургуулийн орчинтой танилцах (анги танхим, ариун цэврийн өрөө, хувцасны өлгүүр, цайны газар, урлагийн заал, номын сан, биеийн тамирын заал, сургуулийн гадаад орчин гэх мэт)
- Сургуулийн гадаад дотоод орчин дахь тэмдэг тэмдэглэгээг таних, хэрэглэх
- Анги танхимд байгаа эд юмс, хичээлийн хэрэгслийг нэрлэх, зориулалтыг мэдэх, зөв хэрэглэх
- Сургуулийн дэгтэй танилцах, ойлгох, анги хичээлийн дэг зохиоход оролцох, дагаж мөрдөх (хичээлийн явцад бусдыг сонсох, бусдын хийсэн ажилд хүндэтгэлтэй хандах гэх мэт)
- Тоглоом, үйл ажиллагаанд дүрэм заавар баримтлан оролцох, тоглох, бусадтай хамтран ажиллах
- Тухайн нөхцөл байдалд багш, найз нөхдийнхөө сэтгэлийн хөдөлгөөн, санаа бодлыг ойлгох, өөрийгөө илэрхийлэх

Танин мэдэх

- Богино хэмжээний үлгэр сонсох, ярих, шүлэг унших, хэл зүгшрүүлэх үг хэлэх, оньсого таах, утга санааг ойлгох
- Зургийг ажиглах, зургийн үйл явдлын талаар ярих, зургийг үйл явдлын дагуу байрлуулах
- Зураг зурах, зургаа чимэглэх
- Хүрээлэн буй орчин, байгалийн дуу чимээ сонсох, ялгах, дуурайх дуулах
- Эд юмсыг ажиглах, нэрлэх, тоолох, харьцуулах, тайлбарлах
- Танил сэдвийн хүрээнд асуулт тавих, асуултад хариулах

Эрүүл мэнд, хөдөлгөөний ур, эв дүйг хөгжүүлэх

- Булчин хөгжүүлэх дасгал хийх
 - Том булчин (тэнцвэр, уян хатан, хурд, хүч, хөдөлгөөний эвслийг дэмжсэн дасгал хийх, хөдөлгөөнт болон спортын тоглоом тоглох гэх мэт)
 - Жижиг булчин (үдэх, барих, нугалах, наах, хайчлах, зурах, будах гэх мэт)
- Хувийн ариун цэвэр сахих (гар угаах, хооллох, хувцаслах, бие засах гэх мэт)
- Хайч, шугам, будаг, харандаа, үзүүртэй зүйлсийг аюулгүй ажиллагааны зааврын дагуу



хэрэглэх, осол, аюултай орчинд гэмтэж, бэртэхээс сэргийлэх

СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАГЧ БОЛОХОД БЭЛТГЭХ

5-6 нас нь хүүхдэд унших чадвар эзэмшүүлэх, 6-7 нас нь сурах чадвар суулгах хамгийн тохиромжтой үе гэдгийг эрдэмтэн судлаачид тодорхойлжээ. Зургаан настай хүүхдийг сургаж эхлэхэд маш тохиромжтой нас гэдгийг дэлхийн олон улс оронд хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэхдээ 6 настнууд 7 настай хүүхдээс ялгаатай байдаг. 6 настай хүүхэд нь нийгэм ёс суртахууны болон танин мэдэх сонирхлоороо 7 настай хүүхдээс доогуур байдаг. Иймээс эхний хагас жилд нь биеэ барих, анхаарлаа төвлөрүүлэх, хамтран суралцах, хичээлдээ хариуцлагатай хандах зэрэгт сургахад анхаарна.

- Зургаан настай хүүхэд тухайн үед төрсөн сэтгэгдэлд хөтлөгдөн, санаанд орсноо тэр дор нь биелүүлэх хандлагатай. Тэдний зан үйлийн туршлага нимгэн, өөрийгөө хянах чадвар дутмаг байдаг.
- Зургаан настай хүүхдийн амьдралд тоглоом чухал үүрэгтэй хэвээрээ байдаг. Тэдний зонхилох үйл ажиллагаа нь тоглоом юм.
- Зургаан настнууд сурах сонирхолтой, суралцахад зайлшгүй шаардагдах чадварууд эзэмшсэн, бусадтай хамтран ажиллах, хариуцлага хүлээхэд бэлтгэгдсэн байх нь чухал.

Хичээлийн жилийн нэгдүгээр улирлын эхний гурван долоо хоногт бэлтгэл хөтөлбөр хэрэгжүүлээд дуусах боловч хүүхэд бүрийн хөгжлийн онцлог ялгаатай байдлаас хамаараад зарим хүүхдүүд бүрэн дасаж амжаагүй байх талтай. Иймээс хүүхэд сургуульд дасан зохицох нь нэгдүгээр ангийг төгсгөл буюу хамгийн багадаа нэг жил хүртэл үргэлжилж ч болно. Бидний туршлагаас үзэхэд багшийн зүгээс сурах үйл ажиллагаанд голлон анхаарч харин эцэг эхчүүд нь хүүхдийнхээ хичээл зүтгэл, нягт нямбай байдал, бие даах чадвар, сахилга бат, сурах үйл ажиллагаанд илүүтэй анхаарал хандуулдаг. Гэтэл хүүхдийн нийгэмшихүй буюу найз нөхөдтэйгөө харьцах харилцаа, хамт олны үүрэг хариуцлага зэрэг нь хоёрдугаарт тавигдах хандлагатай байдаг. Тиймээс анх сургуульд орж байгаа хүүхэд сургуульд дасан зохицоход хамгийн түрүүнд тохиолдож буй бэрхшээл болох “үл таних ертөнц”-ийг тэдэнд ойртуулах нь бэлтгэл хөтөлбөрийн үед багшийн зайлшгүй анхаарал хандуулах асуудал юм. Иймд бэлтгэл хөтөлбөрийн эхний өдрүүдэд багш, хүүхэд, эцэг эхчүүдтэй хамтран чөлөөт орчинд сэтгэл хөдөлгөсөн сонирхолтой тоглоом тоглох, бүх хүүхдийг жигд хамруулах, идэвхтэй үйл ажиллагаа зохион байгуулах байдлаар хоорондоо танилцах, нүүр хагарах боломжийг бүрдүүлэх нь чухал. Энэ үед хүүхдүүд хараахан бие биетэйгээ танилцаагүй, өөрийн болон бусад хүүхдийн боломж, чадвар, сул талыг үнэлэх чадваргүй байдаг. Иймээс өөртөө болон найз нөхдөдөө хандах тэдний хандлага нь үндсэндээ багшийн хандлага харилцаагаар тодорхойлогддог. Хүүхэд бүр сургуульд орсон эхний өдрөөс л өөрийн боломж, чадвар, анги бүлэг дотор эзлэх байр сууриараа бусад хүүхдийн адил гэдгийг мэдрэх нь чухал. Иймээс багш энэ тал дээр анхаарч, дэмжих, сайшаах, үйл ажиллагаанд оруулж, бусадтай хамтран ажиллуулах, хүчин чадалд нь тохирсон, амар хялбар даалгавар өгч, гүйцэтгэлийг нь урамшуулах гэх зэргээр тэдэнд сургууль дасан зохицоход нь дэмжлэг үзүүлнэ. Харин удаан болхи байдалд дургүйцлээ илэрхийлэхээс зайлсхийж, хэт өндөр шаардлага тавихгүй, яаруулж загнаж зандрах, цохих сүрдүүлэх зэрэг арга хэрэглэхгүй байхад анхаарна.

Түүнчлэн багш нэг үйлээс нөгөө үйлд шилжихийн тулд зэрэг эхлэх, дуусахад хэдэн минут үлдэж байгааг сануулах зорилгоор хонх дуугаргах, хөгжим сонсгох гэх мэт аргыг байнга хэрэглэж хэвшил болговол хүүхэд өөрийгөө удирдан хянаж эхэлнэ. Мөн шинэ дэгд суралцаж хэвшихийн тулд хүүхдээс ихээхэн чармайлт, анхаарал, тэвчээр шаардах учраас хүүхдийн гаргаж буй чармайлтыг багш ойлгож, урамшуулах хэрэгтэй юм.

Зургаан настай хүүхдийг сургуульд дасан зохицоход дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж болно.

Сургуулийн зүгээс багш, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа:

- Хүүхэд сургуульд дасан зохицох асуудлаар сургуулийн захирал, багш, цэцэрлэгийн багш нар, хорооны нийгмийн ажилтан оролцуулсан уулзалт зохион байгуулах
- Хүүхэд сургуульд дасан зохицох асуудлаар сургуулийн төлөвлөгөөг эцэг эх, багш нарын төлөөллийг оролцуулан боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх



- Анги танхим, сургуульд хүүхэд дасан зохицоход тааламжтай орчин бий болгох, ялгаатай хэрэгцээ бүхий хүүхэд, гэр бүлд туслалцаа үзүүлэх
- Орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Хүүхдийг дасан зохицоход шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тооцож босгох, зарцуулах
- Багшийг ажлын байран дээр нь хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах

Сургууль, багшийн зүгээс эцэг эхэд чиглэсэн үйл ажиллагаа:

- Эцэг эхчүүдийг сайн дурын оролцооны хэлбэрээр сургуулийн орчинд хүүхдэд туслах, шийдвэр гаргах зэрэг ажилд оролцуулах
- Эцэг эхэд зориулсан зөвлөмж, гарын авлага бэлтгэх, түгээх
- Эцэг эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөө гаргах, хэрэгжилтийг хэлэлцэх
- Эцэг эхчүүдэд зориулсан семинар, уулзалт, хурлын хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах
- Сургалтын хөтөлбөр танилцуулах
- Оролцооны хуваарь гаргах

Багшийн зүгээс хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа:

- Хүүхдийн онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх, хүүхэдтэй ажиллах ганцаарчилсан хөтөлбөр хэрэгжүүлэх, зөвлөгөө өгөх
- Хүүхдийн дунд сонирхолтой урлагийн болон спортын арга хэмжээ зохион байгуулах
- Хүүхдийн хөгжлийн талаар долоо хоног бүр мэдээлэл цуглуулж цэгцлэх
- Хувийн эрүүл мэнд, эрүүл ахуйн дадал хэвшилтэй холбоотой зөвлөгөө өгөх
- Хүүхдийн танин мэдэх, бие бялдар, нийгэмшихүйн ерөнхий болон тусгай чадваруудыг ажиглах, үнэлэх мэдээлэл цуглуулах¹

НЭГДМЭЛ АГУУЛГААР СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ

Тоглоом бол энэ насны гол үйл ажиллагаа юм. Аливаад сониучхан, бүтээлч хандах эрхтэйг нь хүлээн зөвшөөрч түүний уран сэтгэмжийг хөгжүүлэх, сайн үлгэр дуурайл үзүүлэх, хүүхдийн зан үйлийн энгийн дадалд аажмаар сургах, зураг наах, зохион бүтээх зэрэг ажил нь тэдний хөгжилд чухал үүрэгтэй байдаг. Сургалтын явцад тоглоомын үйл ажиллагаагаар 6 настнуудад ерөнхий хөгжлийг хангах дараах чадваруудыг эзэмшүүлэх нь амжилттай суралцахын үндэс болно. Үүнд:

- Эд юмсыг өнгө, хэмжээ, хэлбэр гэх мэтээр харьцуулан жишиж бүлэглэдэг.
- Юмсын байрлалыг дээр доор, дэргэд, хажууд, ард, урд, гадна, дотор гэх мэт зөв тодорхойлдог.
- Зүг чигийг өөрийн байрлалаас тодорхойлдог.
- Үйл явдлын үргэлжлэх хугацааг, дэс дарааллыг 12 жил, жил улирал, сар, долоо хоног, цаг минут, эхлэл, төгсгөл гэх мэт зөв тодорхойлдог.
- Үндсэн ба завсрын өнгийг мэддэг, нэрлэдэг.
- Нэгж хэмжээсийг ашиглан эд юмсыг хэмждэг.
- Хавтгай эзлэхүүнт дүрсийг хооронд нь ялгадаг.
- Геометрийн гурвалжин, дөрвөлжин, гонзгой, дугуй, зууван дугуй, олон өнцөгт дүрсүүдийг таньж, ялгаж нэрлэдэг.
- Үгээр илэрхийлснийг сонсоод зурдаг.
- Өгөгдсөн загварын дагуу дүрс бүтээдэг гэх мэт

Тухайн өдрийн хичээлийн зорилгоос хамааран хичээлийг танхимд болон танхимаас гадуур зохион байгуулж болно. Хөдөлгөөнт тоглоом тоглох, сургуулийн гадаад дотоод орчинтой танилцах, биеийн тамирын уралдаан тэмцээн зохиох зэрэг үйл ажиллагааг сургуулийн гадна зохион байгуулж болно. Хүүхэд бүр өөрийн төрөлх зан төлөв, авьяас билэг, сурах арга барил,



өмнөх туршлагаараа өөр өөрийн онцлогтой. Сургалтыг зохион байгуулахдаа суралцагчдын өмнөх төсөөлөл, мэдлэг, чадварт тулгуурлан дараах үйл ажиллагааг хослуулан сонгож хэрэглэнэ:

1. тоглох үйл ажиллагаа (дүрд тоглох, хөдөлгөөнт тоглоом тоглох, хэрэглэлтэй ба хэрэглэлгүй тоглох);
2. харилцаа (өөрийгөө илэрхийлэх, бусдыг сонсох, багаар ажиллах, тусламж хүсэх, туслах, талархах, хамтран ярилцах, бүтээлийг тайлбарлах, хүндэтгэлтэй харилцах гэх мэт)
3. танин мэдэх үйл ажиллагаа (ажиглах, ярих, сонсох, унших, бичих, тоолох, харьцуулах, биечлэн үзүүлэх);
4. хийж бүтээх үйл ажиллагаа (зурах, наах, эвлүүлэх, хайчлах, хийж бүтээх, дуулах, бүжиглэх, жүжиглэх)²;

Бэлтгэл хөтөлбөрийн үед дараах үйл ажиллагааг зайлшгүй төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарна. Үүнд:

- ▶ Зураг харж ярилцах
- ▶ Хүүхэд зохиол уншиж өгөх
- ▶ Хэл яриаг хөгжүүлэх
- ▶ Шүлэг зохиолоос цээжлүүлэх
- ▶ Хөдөлгөөнтэй байлгах
- ▶ Дуу дуулах, хөгжим сонсох, шүлэг унших
- ▶ Урлан бүтээх ажил хийлгэх
- ▶ Бичүүлж сургахад бэлтгэх

Багшийн хувьд:

Бэлтгэл хөтөлбөрийн үед багш суралцагчдад үлгэр, өгүүллэг, шүлэг уншиж, эсвэл зураг дээр ярилцаж, эдгээрт юуны тухай өгүүлж байгаа, ямар үйл явдал гарч байгааг ойлгуулахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулна. Мөн аудио, видео бичлэг, сургалтад зориулсан кино ашиглаж болно. Суралцагчдын яриаг багш асуултаар чиглүүлж болно. Түүнчлэн ярилцсан зүйлээс сэдэвлэн зурах, будах, хайчлах, наах, барих, эвлүүлэх, зэргээр ямар нэг хийж бүтээх, тухайн сэдэвтэй холбоотой дуулж бүжиглэх, шүлэг цээжилж унших, дасгал хөдөлгөөн хийх, хөдөлгөөнт тоглоом тоглох зэрэг үйл ажиллагааг хийлгэж болно. Эдгээр үйл ажиллагааг хүүхдээр албадан хийлгэхээс аль болох зайлсхийж, тэдний сонирхол, хүсэл тэмүүлэл дээр тулгуурлахыг хичээх хэрэгтэй.

Сургуулийн хувьд:

6 настай хүүхдийг хүлээн авах бэлтгэл хангаж, суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарна. Багш, эцэг, эхийн уялдааг хангаж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээ авна. Хичээлийн жилийн туршид хүүхдийн сургууль, суралцах үйл ажиллагаанд дасан зохицох, сургалтад бэлтгэгдэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, багшид дэмжлэг үзүүлнэ.

Эцэг эх, асран хамгаалагчийн хувьд:

Хүүхдийг суралцахад нь зайлшгүй шаардлагатай хичээлийн хэрэглэлээр бүрэн хангана. Хүүхдийн ангид гүйцэтгэсэн оношилгоо, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны арга зүйг ойлгож, багшийн зааврын дагуу дэмжиж ажиллана.

6 настай суралцагчдыг сурах арга барилд сургахад багшаас

- ▶ Хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогийг харгалзах
- ▶ Сонирхлыг нь татах хичээлийг бүтээлчээр зохион байгуулах
- ▶ Сурах орчинг бүрдүүлэх
- ▶ **Нэгж хөтөлбөрийг оновчтой төлөвлөх, бэлтгэх**
- ▶ Гарын доорх материалаар хэрэглэгдэхүүнийг хийж ашиглах зэрэг үйл ажиллагаанууд шаардагдана.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАГВАР

Бэлтгэл хөтөлбөрийн агуулгыг гурван долоо хоногоор багцлан дараах байдлаар бүлэглэсэн загварыг танилцуулж байна. Үүнд:

- Нэгдүгээр долоо хоногт “Сургуулийн ертөнцөөр” буюу өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах чадвар
- Хоёрдугаар долоо хоногт “Тоглоомын ертөнцөөр” буюу тоглох үйлээр дамжуулан ажиглах, нэрлэх тоолох, харьцуулах, ангилах, зүй тогтлыг олох тайлбарлах чадвар
- Гуравдугаар долоо хоногт “Үлгэрийн ертөнцөөр” буюу ярих сонсох, ойлгосноо илэрхийлэх чадварыг голлон хөгжүүлэхэд анхаарна. Долоо хоногт 5 сэдэв байхаар төлөвлөсөн бөгөөд сэдэв бүрийг нэг өдөр хэрэгжүүлнэ³.

“Сургуулийн ертөнцөөр” бүлгийн хүрээнд хийх үйл ажиллагааны төлөвлөлтийн загвар (I долоо хоног)

Сэдэв	Чадвар/ үйл ажиллагаа
Сурагч боллоо	Өөрийгөө танилцуулах, бусадтай харилцах тоглоом, үйл ажиллагааг багш зохион байгуулна. “Танилцъя” тоглоом тоглох
Би	Цүнхэн доторх зүйлсийг ширээн дээр нь гарган тавьж, нэг бүрчлэн нэрлэж, зориулалтыг ярилцах Зааврын дагуу дасгал хөдөлгөөн хийх, “Нарны цацраг” хөдөлгөөнт тоглоом тоглох, “Нар” сэдвээр зураг зурах /гэрийн даалгаварт өгч болно/ Хичээлийн хэрэглэлийн нэрийг хэлж, “Үг дамжуулах тоглоом” тоглох Багш болон ангийн суралцагчидтай харилцах /танилцах, хүндэтгэх/, найз нарынхаа нэрийг тогтоох “Би хэн бэ?” үйл ажиллагаанд оролцох Өөрийгөө болон мэддэг чаддаг зүйлээ танилцуулах, “Би” үйл ажиллагааг зааврын дагуу хийх Багшийн зааврыг дагаж “Хөдөлгөөнт тоглоом” тоглох
Миний цүнх	Ангид байгаа эд юмс, хичээлийн хэрэглэлийг нэрлэх, зориулалтын талаар ярилцах, “Хаана байсан бэ?” тоглоом тоглох Багшийн заавар, бусдын ярихыг анхааралтай сонсох, ойлгосноо илэрхийлэх, “Тохирох үг” тоглоом тоглох Гарын жижиг булчин хөгжүүлэх дасгал хийх: “Бүгдийг хийгээрэй” өртөөчлөн тоглох
Бид нэг ангийнхан	Ангийн дэг зохиоход оролцох, сургуулийн дэгтэй танилцах, ойлгох, дагаж мөрдөх, “Шоргоолж” шүлгийн утгыг ярилцах Тухайн нөхцөл байдалд сэтгэл хөдлөл, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг таниулах, “Багшаа туслаарай” зааврыг ашиглах Гарын жижиг булчин хөгжүүлэх дасгал хийх : Багшийн хэвлэж өгсөн зургийг будах, ямар өнгөөр будсан талаар ярилцах
Миний сургууль	Сургуулийн дотоод орчин дахь тэмдэг, тэмдэглэгээг таних, хэрэглэх, тоглоом, үйл ажиллагаанд дүрэм, зааврыг баримтлан оролцох, “Хосыг нь олоорой” тоглоом тоглох Сургуулийн орчинтой танилцах, хэлбэр дүрс таних “Уралдаж олоорой” тоглоом тоглох Багш болон ангийн суралцагчидтай харилцах /танилцах, хүндэтгэх/, найз нарынхаа нэрийг тогтоох “Тэр хэн бэ?” тоглоом тоглох Хэлбэр дүрсийг таних нэрлэх “Дүрсийг таниарай” тоглоом тоглох
Гар зүгшрүүлэх зурлага	Энэ долоо хоногт Хавсралт дахь гар зүгшрүүлэх дасгал: 1-3 дугаар гар зүгшрүүлэх дасгалын загварыг ашиглаж болох юм.

Сэдэв: БИ СУРАГЧ БОЛЛОО

Зургаан настны хувьд сургууль гэдэг цоо шинэ орчинд орж ирснээр мэдэхгүй чадахгүй зүйлүүд тэдэнд бэрхшээл болж байдаг. Иймд сургуульд орсны эхний өдрийн хичээл хүүхэд бүр багш, ангийн найз нөхөдтэйгөө танилцах, өөрийгөө танилцуулах үйл ажиллагаагаар эхэлнэ.



Сэдэв: БИ

Би хэн бэ?: Багш сурагчдад өөрийгөө танилцуулах хоёр ширхэг зүйл авчирсан байна. Үүнд гэр бүлийн зураг, дуртай зүйл, тоглоом г.м Эхлээд багш авчирсан зүйлсээ ашиглан өөрийгөө дэлгэрэнгүй танилцуулна. Дараа нь сурагчид өөрсдийгөө танилцуулна. Мөн авьяасаа үзүүлж болно.

Би: Сурагчдаар хийлгэх эхний үйл ажиллагаанд өөрийгөө танилцуулах зураг зуруулж болно. Ингэхдээ өөрийн дуртай өнгө, сонирхдог зүйлс, хайртай амьтан, гэр бүл зэргийг оролцуулж болохыг сануулна. Зурсан зургаа багшдаа хураалгана. Хавар нэгдүгээр анги төгсөхийн өмнө бас дахин зурж, намар сургуульд орохдоо зурсан зурагтайгаа харьцуулж харна. Нэгдүгээр ангид суралцсан есөн сарын хугацаанд маш их зүйл өөрчлөгдөж, их зүйл сурсан гэдгээ сурагчид харах болно. Уншиж бичиж, бодож чаддаг болсон байна.

Хөдөлгөөнт тоглоом: Сургуулийн гадаа талбайд тоглоно. Цөөн тооны эцэг эхчүүдийн туслалцаатайгаар сурагчдыг 3-4 тойрогт хувааж, өртөөчилсөн байдлаар өөр өөр тоглоом тоглуулна. Үүнд: Цагаан тэмээцэх, Чоно тарвагацах, Муур хулгана г.м Багш өртөөний талбайг дараах байдлаар зассан байна. Гарааны тэмдэг, түүнээс 1-2м орчим зайд барианы тэмдэг, хажууд нь доорх хэрэглэгдэхүүнээс тухайн хүүхдэд тохирохыг сонгон тавьсан байна.

Багш өртөөндөө ирсэн сурагчдыг дараах байдлаар тоглуулна. Нэг сурагч барианы тэмдэг дээр ирж зогсоно. Багш заавар өгнө. Эхний хоёр заавар нь энгийн хялбар байна. Жишээ нь: Хоёр удаа алгаа ташаарай, хоёр гараа дээш өргөөрэй, гараа алдлаарай, арагшаа нэг алхаарай, урагшаа нэг том алхаарай, суугаарай босоорой гэх мэт. Хүүхэд сандрахгүй, өөртөө итгэлтэй болоод ирмэгц хоёр алхамт зааврууд өгнө. Сурагчид баруун зүүнийг ялгадаг байх нь чухал тул багшийн өгөх заавруудад баруун, зүүн тийш хийх командууд байх нь зүйтэй. Жишээ нь: урагшаа гурав харайгаад зүүн тийш нэг алх, арагшаа хоёр том алхаад баруун тийш нэг алх гэх мэтээр хүүхдийг барианы шугам хүртэл явуулна. Барианы тэмдгийн хажууд байгаа хэрэглэгдэхүүнийг ашиглан, багшийн зааврын дагуу дээрх үйлдлүүдээс гүйцэтгэнэ. Ингэхдээ тухайн хүүхдийн хөдөлгөөний эвсэл, хурд хүчийг харгалзан сонгоно. Хэрэглэгдэхүүн:

- Дарцаг – тойрч явах
- Задгай жижиг картон хайрцаг – дотор нь орж зогсох эсвэл гартаа барих, дотор нь юм хийх
- Цагираг – дотор нь үсэрч орж зогсох, газраас авах, эргүүлэх
- Дээс – авч хажуугийн хайрцагт хийх, ямар нэг зүйлийг түүгээр ороох, доогуур нь шургах гэх мэт.

Сэдэв: МАНАЙ СУРГУУЛЬ

Эхний долоо хоногт сурагчдыг сургуулийн нэн тэргүүнд мэдэж байх шаардлагатай өрөө танхимуудтай танилцуулж, тэдгээрийн тэмдэг тэмдэглэгээг нь таньдаг болоход багш анхаарна. Зургаан настнууд уншиж чадахгүй учир анги танхим, шаардлагатай өрөө тасалгаануудыг таних тэмдэгжүүлсэн байх шаардлагатай. Сургуульд байдаг анги танхим, өрөө тасалгаануудтай танилцуулна. Үүнд: захирлын, сургалтын менежерийн, эмчийн, урлагийн заал, биеийн тамирын заал, багш нарын өрөө, ангиуд гэх мэт. Мөн сургуульд ажилладаг багш, ажилтнуудтай танилцуулна.

Уралдаж олоорой: Хувилбар 1. Сургуулийн гадна орчинд гарч, эргэн тойронд байгаа зүйлсийг ажиглуулан, тэдгээрийн өнгө, дүрс, өндөр, нам зэргийг сурагчдаар ажиглуулна. Хэсэг хугацааны дараа багш:

- Бидний эргэн тойронд улаан өнгөтэй зүйл байна уу? Олоорой.
- Гурвалжин хэлбэртэй ямар нэгэн зүйл байна уу?
- Цагаан өнгөтэй, дөрвөлжин хэлбэртэй зүйл байна уу?
- Хоёр /гурван/ ижил зүйл байна уу?
- Биднээс намхан зүйл юу байна вэ?
- Бидэнд харагдаж байгаа хамгийн өндөр зүйл нь юу байна вэ? гэх мэт асуултаар ярилцлагыг чиглүүлнэ.



Хувилбар 2. Сурагчдад дээрх байдлаар бусдаас асуулт асуух, хариулах боломж олгоно. Мөн хичээлийн дараа аав ээж, ах эгчээсээ ийм асуулт асуугаарай гэвэл хичээл дээр асуулт асууж чадаагүй сурагчид дуртайяа хийх болно.

Тэр хэн бэ? Сурагчид тоглоомын дүрмийг чанд биелүүлэхийн тулд хамтран тоглогчийн үйлдлийг анхааралтай хянаж, мөн өөрийнхөө алдаа оноог мэдэрч байдаг. Түүнчлэн тоглох явцад бэрхшээлийг даван туулах, анхаарлаа төвлөрүүлэх, сэтгэх үйлийг шаардсан байх нь тэдний бие хүн төлөвшихөд ихээхэн үүрэгтэй тул иймэрхүү байдлаар хөгжөөнт тоглоом тоглуулж байх нь зүйтэй.

Ангиараа тойрч зогсоно. Багш тоглоомын дүрмийг танилцуулна. Хэн нэг хүүхдийн гадаад төрх, өмссөн зүүсэн зүйлээс нэрлэж, бусад нь хэн болохыг нь таах тул хүүхэд бүр дотроо хоёр хүүхэд сонгож, бусдад юу гэж хэлж таалгахаа бодох хугацаа өгнө. Багш жишээ болгон нэгэн сурагч хэн болохыг таалгах ба зөв таасан сурагч цааш үргэлжлүүлэх эрхтэй болно.

- Улаан зангиатай, хар гуталтай, тэр хэн бэ?
- Ногоон зүүлттэй, цагаан тиркотой, тэр хэн бэ?
- Эмэгтэй, дандаа эмээгээрээ хүргүүлж ирдэг, тэр хэн бэ?
- Буржгар үстэй, том нүдтэй, тэр хэн бэ?

Гарын жижиг булчин хөгжүүлэх. Сайн будаж сураагүй сурагчийн хувьд цаашид бичих даалгавар хэцүү байж, сургуульд сурах нь ядаргаатай санагдаж, улмаар сурахад дургүй болоход хүргэнэ. Тиймээс сурагчдад будах, зурлага зуруулах даалгавар өгөхөөс өмнө гарын жижиг булчин хөгжүүлэх маш олон төрлийн сонирхолтой даалгавар өгч байх нь зүйтэй.

Бүгдийг хийгээрэй: Дараах ажлууд нь гарын жижиг булчин хөгжүүлэх зорилготой бөгөөд Сурагчдыг 5-6 хүүхэд бүхий баг болгон, өртөөчилсөн байдлаар хүүхэд бүр дараах даалгавруудыг хийсэн байхаар төлөвлөнө. Үүнд:

1. Шүр хэлхэнэ. Том амсартай саванд 10 ширхэг шүрийг нэг үзүүрийг нь зангидаж бэхэлсэн 20-30 см урттай утсанд сүвлэж хэлхэнэ.
2. Хэсэг хэсэг бүхий зургийг эвлүүлэх
3. Товч товчлох эсвэл гутлын үдээс үдэх
4. Баримлын шавраар дуртай зүйлээ хийх
5. Шүдэнзний модоор дүрс бүтээх
6. Зураасын дагуу хайчлах зэргээр гарын жижиг булчинг хөгжүүлэх олон үйл хийлгэж болно.

“Тоглоомын ертөнцөөр” бүлгийн хүрээнд хийх үйл ажиллагааны төлөвлөлтийн загвар (II долоо хоног)

Сэдэв	Чадвар/ үйл ажиллагаа
Дуртай тоглоом	Эд юмсыг ажиглах, нэрлэх, тоолох, харьцуулах, ангилах, зүй тогтлыг олох, тайлбарлах: “Тоглоомоо өрөөрэй”, “Тоглоомоо ангилаарай”, “Ялгаатай зүйлийг олоорой”, “Харьцуулан яриарай” тоглоом, үйл ажиллагаанаас сонгон ажиллах.
	Эвлүүлдэг тоглоом тоглох, багаар ажиллах, “Лего” тоглоомыг зааврын дагуу тоглох
	Зураг ажиглах, ойлгох, зургийн үйл явдлыг ярих “Эвлүүлээрэй” дасгал ажиллах
Эвлүүлдэг тоглоом	Зураг будах, зохиомжлох, “Будаж чимэглээрэй” үйл ажиллагаа
	“Зүй тогтлыг олох” тоглоом тоглох
	Бусдын ярих, уншихыг анхааралтай сонсох, ойлгосноо илэрхийлэх: “Хошин бодлого” бодох, учрыг ярилцах



Үгэн тоглоом	Багшийн заавар, бусдын ярих, уншихыг анхааралтай сонсох, ойлгосноо илэрхийлэх: “Тата тунгаа” үгэн тоглоом тоглох
	Танил сэдвийн хүрээнд энгийн асуулт тавих, асуултад хариулах: “Асуулт хариулт” үгийн баялаг нэмэгдүүлэх үйл ажиллагаа
	Зүй тогтлыг олох: “Аль нь вэ?” дасгал ажиллах
Хуруун хүүхэлдэй	Бусдын ярих, уншихыг анхааралтай сонсох, ойлгосноо илэрхийлэх: “Зөв үү? Буруу юу?” тоглоом тоглох
	Зааврын дагуу дасгал, хөдөлгөөн хийх “Бороо орлоо” шүлгийг тохирох хөдөлгөөн хийж унших, гэрийн даалгаварт цээжлэх
	Дүрс зурах, хайчлах, зохиомжлон наах: “Дүрс эвлүүлээрэй” дасгал ажиллах
	Мэндлэх, хүндлэх, туслах, талархах, зөвшөөрөл авах, уучлал хүсэх үг хэллэг хэлж, хэрэглэх: “Хуруун хүүхэлдэй”, “Юу гэж хэлсэн бэ?” тоглоом тоглох
	Зааврын дагуу дасгал, хөдөлгөөн хийх, бүжиглэх: “Алдалгүй хийгээрэй” тоглоом тоглох
Зурган тоглоом	Зүй тогтлыг олох: “Хайчилж наагаарай” дасгал ажиллах
	Багшийн заавар, бусдын ярих, уншихыг анхааралтай сонсох, ойлгосноо илэрхийлэх, багаар ажиллах: “Жишиж хэлээрэй” дасгал ажиллах
	Багшийн заавар, бусдын ярих, уншихыг анхааралтай сонсох, ойлгосноо илэрхийлэх, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх: “Таагаарай” тоглоом тоглох
Гар зүгшрүүлэх зурлага	Эд юмсыг ажиглах, тогтоох, ойлгосноо илэрхийлэх: “Дүрсэн цээж бичиг” дасгал ажиллах
	Энэ долоо хоногт Хавсралт дахь гар зүгшрүүлэх дасгал: 4-8 дугаар гар зүгшрүүлэх дасгалын загварыг ашиглана.

Зорилго: Тоглоом ашиглан эд юмсыг ажиглах, нэрлэх, тоолох, харьцуулах, ангилах, зүй тогтлыг олох, тайлбарлах, зөв харилцах гэх мэт чадваруудыг хөгжүүлэх

Тоглоом нь:

- оюун ухаан, нийгэмшихүй, бие бялдар, сэтгэлийн хөдөлгөөн гэх мэт хүүхдийн хөгжилд бүхий л талаар эерэг нөлөө үзүүлнэ.
- хүүхэд тоглох явцдаа санал бодлоо илэрхийлэх, төсөөлөн бодох, шинийг эрэлхийлэх, туршиж үзэх, асуудал шийдвэрлэх, хамтарч ажиллах зэргээр өөрсдийгөө хөгжүүлдэг.
- Хэдийгээр сургуулийн орчин ч гэсэн өөрийнхөө зөнгөөр, хүсэл сонирхлоороо чөлөөтэй тоглох цаг гаргаж байх нь чухал. Тоглоомын явцад хүүхдийн зан төлөв, харилцаа хандлага, танин мэдэх арга, хүсэл сонирхлын талаар багш ажиглах боломжтой.
- Харин хүүхэд хэн нэгний хүсэл сонирхлын дагуу ямар нэг хүрээ хязгаарт баригдаж, ямар нэгэн зорилго хангахын төлөө тоглох нь дээрхээс огт өөр зүйл юм.
- Энэ нь тоглож буй хэрэг бус харин тоглоомыг хэрэгсэл болгон ашиглаж, тоглонгоо суралцаж буй хэрэг юм.

Сэдэв: ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

Лего: Багаар ажиллана. Сурагч бүрт ижил өнгө, ижил хэлбэртэй 4-5 ширхэг лего тоглоом байна. Багшид ч мөн адил байна. Багш тэдгээрийг дурын байдлаар холбон, өргөж сурагчдад тодорхой хугацаанд ажиглуулна. Ингэхдээ багшийн хийснийг маш анхааралтай ажиглаад, хугацаа эхлэхэд дуурайж хийгээд, хугацаа дуусахад багийн гишүүд хоорондоо хэлэлцэж, аль нь зөв болохыг ярилцаад, зөв гэж үзсэнээ багшийн дохиогоор өргөх даалгавар өгнө.

Эвлүүлээрэй: Багш зургийн сан болон хуучин сэтгүүл /боломжтой бол БСШУЯ-ны цахим хуудаснаас сурах бичиг гэсэн хэсэг рүү орж сурах бичгийн зургаас хуулах/ ашиглан өгүүлэмж, үйл явдал бүхий зураг олж хувиан, түүнийгээ 4-8 тэнцүү хэсэгт хуваан багуудад эвлүүлэх даалгавар өгч болох юм. Мөн эвлүүлсний дараа зураг дээрх үйл явдлыг яриулна. Зураг нь цуврал зураг байж, нэг бүтэн үлгэр, үйл явдал бүтэж болох юм.

Сэдэв: ҮГЭН ТОГЛООМ

Үгийн утгыг ойлгох, бусдын яриаг сонсоод ойлгох, өөрийнхөө санаа бодлыг чөлөөтэй илэрхийлэх зэрэг чадварыг хөгжүүлэхийн бэлтгэл болгож үгэн тоглоомуудаар тоглуулж болох



юм. Сурагчдын үг яриаг хөгжүүлэхэд заавал уншиж өгсөн зүйлийн талаар ярихдаа биш, өөрсдийнхөө хийсэн зүйлийг тайлбарлах, асуулт тавих, асуултад хариулах, бусдын яриаг сонсох, эцэст нь юу гэж бодож байгаагаа хэлэх гэх мэт чадваруудад алхам тутамдаа сургаж байх хэрэгтэй.

Тата тунгаа: Багш өөрийн зургийн сангаас хялбар зурагнууд гарган ширээн дээр доош харуулан тавьсан байна. Арван сурагч самбарын өмнө эгнэн зогсоно. Эхний сурагч нэг зураг сугалан авч, түүнийг өөр үгээр илэрхийлж, дараагийнхаа сурагчаар таалгахыг оролдоно. Таасан сурагч хамгийн ард очиж зогсоно. Хоёр дахь удаагаа таагаагүй сурагч сууна. Авсан зургаа гурван сурагчаар дарааллан таалгаж чадаагүй бол мөн сууна. Жишээ нь: “Нар”-ны зураг сугалсан хүүхэд тэнгэрт байдаг, шар өнгөтэй гэх мэтээр таалгана.

Зөв үү? Буруу юу?: Хувилбар 1. Багш өмнө үзсэнийг үнэлэх мөн давтах зорилгоор нэг өгүүлбэр хэлнэ. Сурагчид өгүүлбэр зөв бол баруун гараа, буруу бол зүүн гараа өргөнө. Дараа нь яагаад зөв эсвэл буруу гэсэн талаар ярилцана.

Хувилбар 2. Дараа нь багш хоёр өгүүлбэр хэлнэ. Энэ хоёр өгүүлбэр нь хоёулаа зөв, нэг нь зөв, эсвэл бүр хоёулаа буруу өгүүлбэр байна. Багш эхлээд хоёр өгүүлбэрээ хэлнэ. Сурагчид анхааралтай сонсоно. Багшийн дохиогоор хоёулаа зөв бол хоёр гараа өргөнө, хоёулаа буруу бол хоёр гараа буулгана, эхний өгүүлбэр зөв бол зүүн гараа өргөөд баруун гараа буулгана, хоёр дахь өгүүлбэр зөв бол баруун гараа өргөөд, зүүн гараа буулгана гэх мэт байж болох юм. Эсвэл сурагчидтайгаа яриад шийдэж болно.

Хувилбар 3. Багш гурван өгүүлбэр хэлнэ. Сурагчид анхааралтай сууж, өгүүлбэрүүдийг сонсоод багшийн дохиогоор буруу өгүүлбэрийн дугаарыг хуруугаараа үзүүлнэ.

Жишээ нь: а) 1. Нар гарав. 2. Сүү давхив. 3. Хүү сэрэв.

б) 1. Ус урсав. 2. Цэцэг ургав. 3. Жимс цангав.

Мөн хоёр буруу, нэг зөв өгүүлбэрийг олох болгон өөрчилж болно. Хэлэх өгүүлбэрээ үзсэн сэдэвтэйгээ холбож сонгох нь илүү үр дүнтэй.

Жишээ нь: а) 1. Алим улаан өнгөтэй. 2. Лийр хөх өнгөтэй. 3. Тарвас ногоон өнгөтэй.

б) 1. Үзэм бол жимс. 2. Лууван бол хүнсний ногоо. 3. Саримс бол чихэр.

Сэдэв: ХУРУУН ХҮҮХЭЛДЭЙ

Хуучин хуруутай бээлийгээр эсвэл цаасан конус хэлбэрийн хуруувч дээр хүний нүүр /жаахан хүү, охин, эмээ өвөө, аав ээж гэх мэт/ зурж хайчлан нааж, хуруун хүүхэлдэй бүтээнэ. Эсвэл багш хуруун хүүхэлдэйн нүүрийг урьдчилан зуруулсан байна. Багш хоёр хүүхдийг саналаар нь гаргаж хуруун хүүхэлдэй өмсгөн тоглуулна. Үүний өмнө багш хоёр гартаа ахмад настай болон хүүхдийн зураг бүхий хуруун хүүхэлдэй хийж дараах харилцан яриаг дуу хоолойныхоо өнгийг сольж, жүжигчлэн тоглож үзүүлнэ.

Нэгэн хоньчин хүү хургаа хариулж яваад, ноёнттой тааралдаж гэнэ. Хүү: Та амархан сайн байна уу? Сайн явж байна уу? гэж мэхийн ёслоход /хуруугаа бөхийлгөн/ Ноён: Амархан сайн явж байна. Чи сайн явж байна уу? гэж мэндчилэв.

Багш: Хэн нь эхлээд мэндэлсэн бэ? Яагаад хүү эхэлж мэндэлсэн бэ? гэх мэт асуултаар дамжуулж, ахмад болон өөрөөс дээд албан тушаалтай хүнтэй түрүүлж мэндэлдэг гэдгийг ойлгуулна.

Дараа нь сурагчид хосоор ажиллах ба нэг нь хүүхдийн, нөгөө нь ахмад хүний зураг бүхий хуруун хүүхэлдэй сонгож, харилцан мэндэлнэ.

Жишээ нь: - Хүүхэд: Сайн байна уу? эгч ээ. Ахмад настай хүн: Сайн сайн байна уу? гээд гар барин мэндэлнэ.

Хоёроос дээш хуруундаа хуруун хүүхэлдэй өмссөн сурагчидтай нэг хуруун хүүхэлдэйтэй хүүхэд мэндэлнэ. Олон хүнтэй мэндлэхэд: - Сайн байцгаана уу? гэж хэлдэг талаар мөн ярилцана.

Дүрийн тоглолтоор мэндчилгээний үгийг хэлж, бататгах: багш-сурагч, хоёр найз, аав-охин, сурагчид-жижүүр, үйлчлэгч нар-сурагчид гэх мэт.



Сэдэв: ЗУРАГТ ТОГЛООМ

Доорх дасгалыг ашиглахдаа зураг болон үг хэллэгийг хялбар дүрс, үг хэллэгээр солин хялбаршуулан хэрэглэж болох юм. Энэ насанд дахин давтан хийсээр чадвар дадал болохыг ямагт санаж, аливаа дасгал даалгаврын өгөгдлийг өөрчлөх, түвшнийг ахиулах зэргээр хувирган ашиглаж байх нь сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх давхар ач холбогдолтой.

Таагаарай: Хоёр ширээний сурагчид нийлж, дөрвүүл нэг баг болж ажиллана. Нэг хос нь ажиглагч болно. Нөгөө хос нь нуруу нуруугаараа харж сууна. Багш баг бүрийн ширээн дээр дөрвөн зураг доош харуулан тавьсан байна. Багшийн дохиогоор эхний сурагч зургаа авч, ажиглагч хосод харуулсны дараа өөрийнхөө хосод зургийнхаа нэрийг хэлэхгүйгээр өөр үгээр тайлбарлаж таалгана. Ажиглагч хос хариулт зөв буруу эсэхийг ажиглаж, тоглогчдод хэлнэ. Сурагч зургийн нэрийг зөв таасан бол өөрийнхөө зургийг таалгана. Үүний тулд мөн л эхлээд ажиглагч хосод харуулна. Дараа нь ажиглагч хос таагч хос болж, таасан хосууд ажиглагч болж солигдоно. Эхний удаад багш сурагчид тоглоомын дүрмийг баримталж суртал цаггүй тоглуулсны дараа цагтай болгож, дохио дуугармагц зургийг дараагийн хосод шилжүүлэх мөн сурагчид тааж чадаагүй зураг дээр ажиллах өөрөөр хэлбэл юуны зургийг юу юу гэж тайлбарлахад таахгүй байсан, үүний оронд юу гэж хэлбэл тохиромжтой байсан зэргээр ярилцах гэх мэтээр багш сурагчдынхаа чадварт тохируулан өөрчлөн хөгжүүлж болох юм. Энэхүү дасгал нь сурагчдын үг яриа, хийсвэр сэтгэхүй, бусдыг сонсох чадваруудыг хөгжүүлэх мөн тоглоомын дүрмийг баримталж сургах зорилготойгоос гадна хамгийн чухал нь сурагчдад багаар ажиллах чадварт сургах зорилготой юм.

Дүрсэн цээж бичиг: Багш ямар нэг үсэг эсвэл цифр бүхий цаас /шоо/-ыг сурагчдад хэсэг хугацаанд харуулна. Багш ийм үсэг, тийм тоо цифр гэж хэлэлгүйгээр “Миний өргөсөн дүрсийг ажиглаарай. Дараа нь харсан дүрсээ өмнөх цаасан дээрээ бичээд, зэрэг өргөөрэй” гэсэн заавар хэлнэ. Хэдийгээр үсэг, тоо үзэх болоогүй ч энэ мэт байдлаар дасгах, сурч мэдэх хүсэл тэмүүлэл төрүүлж байх нь чухал. Мөн нэгдүгээр ангийн сурагчдын хувьд нэрээ дармалаар бичээд сурчихсан байх нь сурагч төдийгүй эцэг эх нь хүүхдийнхээ хийсэн бүтээснийг олон дундаас олох, багш ч мөн адил хэний бүтээл болохыг мэдэхэд тустай. Гэрийн даалгаварт эхний долоо хоногийн хугацаанд нэрээ дармалаар бичиж сурсан байх даалгавар өгч болох юм⁴.

“Үлгэрийн ертөнцөөр” бүлгийн хүрээнд хийх үйл ажиллагааны төлөвлөлтийн загвар (III долоо хоног)


Сэдэв	Чадвар/ үйл ажиллагаа
Заан яагаад дүү нь болсон бэ?	Багшийн заавар, бусдын ярих, уншихыг анхааралтай сонсох, ярилцах, асуулт тавих, ойлгосноо илэрхийлэх: “Эвтэй дөрвөн амьтан үлгэр” уншиж өгөх, үйл явдлыг ярилцах, Үйл ажиллагаа 1, Үйл ажиллагаа 2
	Эд юмсыг ажиглах, нэрлэх, тоолох, харьцуулах, ангилах, зүй тогтлыг олох, тайлбарлах: “Солигдсон уу?” дасгал ажиллах
	Зааврын дагуу дасгал, хөдөлгөөн хийх, бүжиглэх: “Ямар амьтан бэ?” хөгжөөнт тоглоом тоглох
Алимыг хэрхэн авах вэ?	Танил сэдвийн хүрээнд энгийн асуулт тавих, асуултад хариулах, орон зайн баримжаатай болох: “Байр байрандаа” эвлүүлэх дасгал ажиллах
	Гарын жижиг булчин хөгжүүлж, эвлүүлдэг тоглоом тоглох, багаар ажиллах: “Өрлөгчин” дасгал ажиллах
	Тоглоом, үйл ажиллагаанд дүрэм, зааврыг баримтлан оролцох, бусдын зааврыг дагах, үгийн баялаг нэмэгдүүлэх: “Амьтны хүрээлэн” дасгал ажиллах
Тагтаа яагаад ах нь болсон бэ?	Үлгэр, оньсого, зүйр үг, шүлгийн утга санааг ойлгох, тогтоох, ойлгосноо илэрхийлэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх: “Зүйр цэцэн үг” утгыг ярилцах, тогтоох
	Зураг ажиглах, ойлгох, хялбар зурлага зурах, гүйцээх, юмсын зүй тогтол, холбоо хамаарлыг олох: “Харгалзуулаарай” дасгал ажиллах
	Эд юмсыг ажиглах, нэрлэх, тоолох, харьцуулах: “Харьцуулаарай” дасгал ажиллах
Дүрсээр амьтан бүтээгээрэй	Хэв хэрэглэн дүрс зурах, хайчлах, зохиомжлон зурах, наах “Хэв хэрэглэн дүрс зураарай” дасгал ажиллах
	“Зохиомжлон бүтээх” дасгал ажиллах
	“Дүрсээр амьтан бүтээгээрэй” дасгал ажиллах
	“Алимны модыг урлах” бүтээл хийх



Зүй тогтлыг олоорой.	Алимны өнгийг ажиглан зүй тогтлыг таних, өнгө ялган будах: “Алимыг гүйцээж будаарай” дасгал ажиллах
	Хавсралтад өгсөн сармагчны зургийг өгсөн өнгөөр будах /боломжтой бол бусад амьтдын зургийг будаж болно/
	Үлгэрийн үйл явдлын дарааллыг харуулсан зураг харж, үлгэрийг ярих дасгал
	Баг болон хуваагдаж, Эвтэй дөрвөн амьтан үлгэрээр дүрийн тоглолт бэлтгэж, бусад багтаа тоглож үзүүлэх
Гар зүгшрүүлэх зурлага	Энэ долоо хоногт Хавсралт дахь гар зүгшрүүлэх дасгал: 9-12 дугаар гар зүгшрүүлэх дасгалын загварыг ашиглаж болох юм.

Бэлтгэл хөтөлбөрт тусгагдсан өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах, багаар ажиллах, бусад талархах, туслах, бусдыг хүндлэх, бусадтай эв нэгдэлтэй, хүлээцтэй байхад суралцах чадваруудыг эзэмшүүлэхдээ бие биеэ хүндлэх, эвтэй байснаар амжилтад хүрдэг болохыг харуулсан “Эвтэй дөрвөн амьтан” үлгэрийн сэдвийг сонгож, түүний хүрээнд дасгал даалгаврыг боловсруулан, хичээл сургалтдаа ашиглах жишээг танилцуулж байна⁵.

Дараах бүдүүвч зургаар бэлтгэл хөтөлбөрийн хүрээнд эзэмшүүлэхээр зорьж буй чадваруудыг нэг үлгэрээр хэрхэн хөгжүүлэх, төлөвлөхийг харуулж байна.



Сэдэв: ЗААН ЯАГААД ДҮҮ НЬ БОЛСОН БЭ?

/Эвтэй дөрвөн амьтан үлгэр сонсох, үйл явдлыг ярилцах/

Үйл ажиллагаа 1. Үлгэрийг бүрэн эхээр нь уншиж өгнө.

Эвтэй дөрвөн амьтан

Эрт урьд цагт Энэтхэг орны сайхан ой модонд тагтаа шувуу, туулай, сармагчин, заан дөрөв олон жил хамт амьдарч байжээ. – Бид дөрөв эвтэй сайхан суухаас гадна бидний хэн нэгэн нь ах болбол дүү нар нь ахыгаа хүндлэн өргөж тааллаар нь явъя гэж хэлэлцээд хэн нь ах болохыгоо бие биенээсээ асууж гэнэ. Тэнд нэг том мод ургаж байжээ. Заан тэр модыг зааж: - намайг тугал байхад энэ мод надтай чацуухан байсан. Би шөргөөдөг байв гэжээ. Үүнд сармагчин хэлэв: - Намайг жаахан байхад энэ мод тоглож дүүлэх мөчиргүй надтай адилхан байсан тул сүүдэр нь намайг арай чамай халхалдаг байсан гэв. Туулай хэлэв: намайг бага байхад энэ мод сая үндэслэж байсан тул би үндэснээс нь малтаж иддаг байв гэжээ. Гэтэл тагтаа хэлжээ: - Би энэ модны үрийг зууж ирээд энд унагачихсан юм. Тэгээд энэ мод ургасан билээ гэв. Ийм болохоор хамгийн ахмад нь тагтаа, дүү нь туулай, туулайн дүү сармагчин, отгон дүү нь заан болж таарчээ. Дүү нь ахыгаа хүндлэхээр хэлэлцсэн тул заан сармагчныг хүндэлж нуруун дээрээ гаргав. Сармагчин нь туулайг ахаа гэж мөрөн дээрээ суулгав. Туулай нь тагтааг ахаа гэж дээрээ гаргавал өнөөх том модны үр жимсэнд хүрч, дүү нартаа түгээн өгч ивээдэг болжээ. Тийнхүү энэ дөрвөн амьтан хүндлэх ба тэтгэх ёс төгс болж эвтэй найртай байснаар жаргалтай болов гэнэ.

Үйл ажиллагаа 2. Үлгэрийг ярих явцдаа үйл явдлыг тодруулан асууна. Жишээ нь: “Сармагчин юу гэж хэлсэн бэ?”, “Сармагчны хэлсэн үгийг хэн хэлэх вэ?” (туслах зорилгоор бич модны доор зогсож буй зураг үзүүлэх), “Тагтаа юу гэж хэлсэн бэ?” гэх мэт асуултыг үлгэр ярих явцдаа тавих мөн танил биш үгийн утгыг тайлбарлаж өгнө. Жишээлбэл: шөргөөх - биеэ модонд үрэх, дүүлэх - амьтны нэгээс нөгөө мөчир лүү харайх үгийн утгыг хүүхдүүдэд үгээр тайлбарлахаас илүү үйлдлээр үзүүлэхэд илүү ойлгоно.

Үйл ажиллагаа 3. Эхийг хүүхдэд сонирхолтой болгохын тулд ерөнхий сэдвээ асуулт болгон задалж болох юм. Жишээлбэл: “Заан яагаад дүү нь болсон бэ?”, “Тэдний хэн нь ч алим авч чадсангүй. Яах вэ?” гэх мэт асуудал дэвшүүлсэн сэдвээр нэг өдрийн хичээлийг зангидаж,



түүнийг шийдвэрлэхийн тулд дасгал даалгаврыг гүйцэтгүүлж болно.

Солигдсон уу?: Хувилбар 1. Ширээн дээр дөрвөн амьтны зурагтай карт байна. Эхлээд амьтдыг нэрлүүлэх, дарааллыг сайтар ажиглуулсны дараа картыг хольж анх байсан дарааллаар өрүүлнэ. Энэ дасгалаар хүүхдийн харааны ой болон ажиглах чадвар хөгжих ач холбогдолтой.

Дөрвөн амьтны зурагтай картыг ажиглуулаад, хүүхдүүдийг цааш харуулан анх байсан байрлалыг өөрчлөн, өөр амьтны зурагтай карт нэмэх буюу дөрвөн картнаас нэгийг хасаж харуулан ямар ялгаа гарсныг хэлүүлж дасгалыг хувирган ашиглаж болно.

Ямар амьтан бэ?: (Багшийн заавар, бусдын ярих, уншихыг анхааралтай сонсох, ойлгосноо илэрхийлэх, хөгжмийн аялгуу, байгалийн дуу чимээ, авиаг сонсох, ялгах, дуулах)

Ангийн бүх сурагчид оролцоно. Багшийн хэлсэн зааврын дагуу зөв хөдөлгөөн хийсэн буюу авиа гаргасан сурагчид тоглоомыг үргэлжлүүлж алдсан сурагчид хасагдах журмаар тоглоно.

Хувилбар 1. Багш амьтны нэрийг хэлэхэд сурагчид тухайн амьтны хөдөлгөөнийг дуурайна.

- Тагтаа гэхэд хүүхдүүд гараа далавч болгон дэвж хөдөлгөнө.
- Туулай гэхэд хоёр гараа атгаж эрүүн дороо нийлүүлэн барьж дороо үсэрнэ.
- Сармагчин гэхэд доод уруул шүд хоёрын хооронд хэлээ хийж төмбийлгэн, хоёр чихээ татаж дэлдийлгэнэ. Энэ үйлдэл нь хэлний булчин ба хэлний хөдөлгөөнийг хөгжүүлдэг өгүүлэх эрхтний дасгал болно.
- Заан гэхэд толгойгоо хоёр тийш сэжилнэ.

Эхлээд хоёр амьтны нэрийг ээлжлэн хэлэх, дараа нь гурав, дөрөв гэх мэтээр амьтны нэрийг олшруулан тоглуулаарай.

Хувилбар 2. Багш амьтны нэр хэлэхэд сурагчид авиа гаргана.

- Тагтаа гэхэд гүрр гүрр гэж дуугарна.
- Туулай гэхэд хошуугаа сорж дуугарна.
- Сармагчин гэхэд алгаа таших, заан гэхэд ширээ тогшино. Багш амьтдаас гарах авиаг хэрхэн илэрхийлэхээ өөрчилж болно.

Хувилбар 3. Багш амьтны зураг харуулахад сурагчид амьтныг илэрхийлэх хөдөлгөөн хийх эсвэл авиа гаргана. Тоглоомыг эсрэгээр багш хөдөлгөөн хийхэд хүүхдүүд нэрлэх, эсвэл тохирох зургийг өргөх байдлаар тоглуулж болно.

Сэдэв: АЛИМЫГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Байр байрандаа: Хувилбар 1. Энэ дасгалыг үлгэрийн утгыг ойлгосны дараа хийлгээрэй. Эвтэй дөрвөн амьтны зурагтай картыг зааврын дагуу байрлуулна. Ахмадаас нь эхэлж дараалуулан байрлуулах, дүүгээс эхлэн дараалуулан байрлуулах, дүүгээс эхлэн дээш өрсөн байдлаар байрлуулах гэх мэтээр дасгалыг хувирган ашиглаж болно.

Хувилбар 2. Самбарт амьтны зурагтай хэрчмэл картыг байрлуулсан байна. Энэ дасгалыг хийснээр хүүхдийн орон зайн баримжааны тухай ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой тул багш дараах асуултыг тавьж ярилцаж болно. Хамгийн эхэнд (урд нь) ямар амьтан байна вэ?, туулайны баруун талд, зүүн талд ямар амьтан байна вэ? Хамгийн доор ямар амьтан байна вэ?, сармагчны доор, дээр ямар амьтан байна вэ? гэх мэт.

Хувилбар 3. Сурагчдад амьтдын зурагтай карт өгнө.


Туулайг сармагчны баруун талд, зааныг тагтааны зүүн талд байрлуулаарай. Тагтааг туулайн дээр байрлуулаарай.

Өрлөгчин: Нэг баг дөрвөн гишүүнтэй. Баг бүрийн гишүүд амьтдаас аль нэгийг сонгож, түүний нэрээр өөрийгөө нэрлэнэ. Ийнхүү багийн дөрвөн гишүүн заан, сармагчин, туулай, тагтаа нэртэй болно. Заан дөрвөн ширхэг аяга, сармагчин гурван ширхэг аяга, туулай хоёр ширхэг аяга, тагтаа нэг ширхэг аяга авна. Бэлтгэл хөтөлбөрийн хүрээнд тоо цифр заахгүй ч амьдралын туршлагаар тоолдог болсон бол түүнийг хэрэглээ болгох зорилготой.

Заан болсон сурагч эхлээд дөрвөн аягаа хөмрөн ширээн дээр нийлүүлэн эгнүүлж тавина. Зааны өрсөн аяган дээр сармагчин болсон сурагч гурван аягаа хөмрөн тавина гэх мэт зураг дээрх



шиг өрнө. Энэ дасгалыг хийх явцад сурагчид олон цөөнийг харьцуулах, жиших, тоглоомын дүрэм баримтлах, анхаарлаа төвлөрүүлж сурах, гарын жижиг булчинг хөгжүүлэх гэх мэт маш олон талын ач холбогдолтой.



Амьтны хүрээлэн: Хувилбар 1. Бүх сурагч оролцоно. Сурагчид тойрог хэлбэрээр зогсоод эхний хүүхэд: “Би амьтны хүрээлэнд очлоо. Чоно харлаа” гэж хэлнэ. Дараагийн хүүхэд өмнөх хүүхдийн хэлснийг давтаад өөрийн мэдэх амьтны нэрийг нэмж хэлнэ. Жишээ: “Би амьтны хүрээлэнд очлоо. Чоно, үнэг харлаа. ”Гурав дахь хүүхэд өмнөх хүүхдийн хэлснийг давтахгүй эхний хүүхдийн адил шинээр амьтны нэр хэлнэ. Дөрөв дэх хүүхэд гурав дахь хүүхдийн хэлсэн дээр нэмж өөр нэг амьтны нэр хэлж тоглоно. Аль нэг үгийг орхиж хэлсэн болон хэлж чадаагүй хүүхэд тоглоомоос хасагдана.

Хувилбар 2. Хувилбар 1-ийн дагуу эхэлнэ. Гурав дахь хүүхэд эхний хоёр хүүхдийн хэлснийг давтаад нэмж шинээр амьтны нэр хэлнэ гэх мэтээр өмнө нь хэдэн хүүхдийн хэлсэн амьтны нэрийг давтаж хэлэхээ нэмэгдүүлэн тоглоно. Нэг ч алдаагүй буюу хамгийн олон үг тогтоон хэлсэн хүүхэд ялагч болно. Багш хүүхдүүдэд туслах зорилгоор ангид тоглоомон амьтад эсвэл амьтдын зураг байрлуулаарай.

6 настай сурагчдын багаар ажиллах чадварыг хөгжүүлэх

Сурагчдыг нэгдүгээр ангиас нь багаар ажиллаж сургахад анхаарна. Ялангуяа бэлтгэл хөтөлбөрийн хувьд чадварлаг хүүхдүүд нь түрүүлж хийгээд, удаавтар нь үлдэж хоцрох биш, харин баг дунд нь хэн бүхний чадах зүйл өгч, багаар ажиллах соёлд аажмаар сургах нь чухал. Бүлгээр ажиллахад анхаарах асуудлууд:

- Эхний удаад хосоороо, цаашид 4-6 хүнтэй багаар ажиллаж сурах
- Багаар хийх ажил нь дүрэм, хугацаатай байх ба багш танилцуулж, заавал баримтлах
- Хүн бүр гүйцэтгэх үүрэгтэй оролцохоор багийн ажлыг төлөвлөх, хамтран нэг баг болсон ч хүн бүр тусдаа ижил зүйл хийх нь багийн ажил биш гэдгийг анхаарах
- Хүүхдийн гүйцэтгэх боломжит хугацаа төлөвлөх
- Багаар ажиллаж хэвшсэний дараа багийн ажлын үр дүнгээ бусдад танилцуулж сургах
- Ялагдах, хожигдох дургүй тул багуудыг уралдуулахгүй байх, багийн ажил бол хамтран асуудал шийдэх, бүтээл хийх зорилготойг ухааруулах
- Хичээл бүр багаар ажиллах шаардлагагүй гэдгийг анхаарах, тухайлбал, хүүхэд үсэг, тоо бичих нь хүүхэд бүр тус бүрдээ хийх ажил
- Багийн ажлын үед хүүхдийн хэл яриа, нийгэмшихүй, зан харилцаа, сэтгэлийн хөдөлгөөнийг ажиглах боломжтой.

Багууд ажиллаж байх явцад багш үнэлгээ хийж, сурагчдын багаар ажиллах чадвар, хурд, манлайлах чадвар, зан харилцааны онцлог, бие даан шийдвэр гаргах, сэтгэн бодох чадвар зэргийг үнэлж, дараагийн удаа баг хуваарилахдаа харгалзана. Үүний зэрэгцээ даалгавар нь сурагчдын түвшинд тохирч байгаа эсэхэд дүгнэлт хийж, сайжруулах, өөрчилж болох хувилбарыг бодно.

Багаар ажиллах явцад ямар чадвар хөгжих вэ? Бие биеэ хүндлэх, бусдыг мэдрэх, зэрэгцэж ярихгүй байх, анхааралтай сонсох, хамтдаа бүтээх, харилцан суралцах, бодол саналаа чөлөөтэй илэрхийлэх, хэлэлцэх, эргэцүүлэн бодох, давуу сул талаа мэдрэх, хүлээцтэй хандах, сурагч бүр хэлэлцүүлэгт оролцох боломж бүрдэх гэх мэт олон талын ач холбогдолтой.

Хэрэглэгдэхүүн

Багш нар сургалтын хэрэглэгдэхүүнийг олон хувилбартай, олон хэлбэрээр ашиглаж болохоор сонгон бэлтгэх нь хичээлийг бүтээлч, сонирхолтой болгох, сурагчдыг уйдаахгүй



байхаар үйл ажиллагаанд татан оролцуулах гол үндэс нь болно. Иймд багш нар хичээлийн төлөвлөлт, хэрэглэгдэхүүнийг бэлтгэхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй. Ялангуяа 6 настай хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн нь тэдний сонирхол хэрэгцээнд нийцсэн, өнгө будгийн зөв зохицолтой, танин мэдэхүйн үйлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгохдоо зөвхөн зурагт үзүүлэн байдлаар бус үйл явдал бүхий зураг, дүрийн тоглолт, хуруун хүүхэлдэй, өрж угсрах, эвлүүлэх, бүтээх, хүүхдийн оюуны үйлийг хөгжүүлэх тоглоомууд, төрөл бүрийн карт, шоо, туршилтын материалууд гэх зэрэг сэтгэхүйн үйлдлийг хөгжүүлэх тоглоомуудыг олон хувилбар хэлбэрээр ашиглахад анхаарна.

Мөн дасгал ажлын ном, зурагт ба биет үзүүлэн, дэлгэцэн үзүүлэн, карт, сургалтын тоглоом, биеийн тамирын хичээлийн хэрэгсэл зэргийг ашиглан сургалтыг идэвхтэй, сонирхолтой зохион байгуулах шаардлагатай.

Үнэлгээ

Хөтөлбөрийн хэрэгжилтийн эхэнд болон төгсгөлд эцэг эхтэй хамтран хүүхэд бүрийг оношилж, үр дүнд тулгуурлан сургалтын цаашдын үйл ажиллагааг төлөвлөн, хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

Сургалтын явцад суралцагчийг сурч танин мэдэх арга, сэтгэхүйн үйлд суралцаж эхлэх, суралцах идэвх сонирхолтой болоход нь дэмжсэн явцын үнэлгээний арга, хэлбэрүүдийг хэрэглэнэ. Энэ насны хүүхэд өөрийнхөө бодит байдлаас дээгүүр байдлаар өөрийгөө үнэлдэг. Өөрийн чадлаас хэтэрсэн зүйлийг “би хийнэ, би чадна” гэж хэлдэг. Өөрийгөө магтах, магтуулах дуртай. Хийсэн зүйлийг нь магтах тусам урамшин хийхийг хичээнэ. Энэ насны хүүхдэд үнэлгээний аман урамшууллын арга үр дүнтэй гэж судлаачид бичсэн байдаг. Ийм учраас “сайн байна”, “зүйтэй”, “баяр хүргэе”, “хичээгээрэй” гэх мэт урамшуулсан үг хэллэг хэлэх нь зүйтэй. Сурагчдыг байнга уралдуулж, хооронд нь харьцуулан үнэлгээ хийхээс татгалзах хэрэгтэй. Харин “өмнөхөөс сайн болсон байна”, “ингэж хийдэг байснаа ийм сайн хийдэг болсон байна” гэх мэтээр өөрийнх нь ахицыг хэлж урамшуулах нь зохистой.

Багш өөрийн үнэлгээг сэтгэлийн хөдлөлийн янз бүрийн хэлбэрээр илэрхийлж болно. Жишээ нь: шагшин гайхсан, хүүхдийн зүтгэлийг үнэлэн, амжилтыг нь ахиулах зорилгоор баярлаж байгаагаа илэрхийлсэн, сэтгэл нь зовсон, итгэж найдсан, гайхан эргэлзсэн зэрэг үгээр сурагчдын урам зоригийг сэргээж болно. Мөн биеийн хөдөлгөөнөөр суралцагчдыг үнэлэх (инээмсэглэх, толгой дохих, гарын хөдөлгөөн, нүдний хөдөлгөөнөөр үнэлгээг илэрхийлэх), өөрийн чадвараа хэрхэн дээшлүүлэх талаар зөвлөгөө өгөх зэргээр урамшуулан дэмжинэ.

Багш, эцэг эх сурагчдыг урамшуулан дэмжихдээ дараах аргыг хэрэглэнэ.

Аман үнэлгээ:

- гайхамшигтай, гайхалтай
- сайн байна
- дөхөж байна
- уран санаа гаргалаа
- дахиад нэг хийгээд үзээрэй гэх мэт
- найддаа өөрийн хийсэн зүйлээ үзүүлээрэй
- дагаад хийгээрэй
- баяр хүргэе гэх мэт

Дүрсээр үнэлэх:

- геометрийн дүрс
- үлгэрийн баатрын дүрс
- жимс, хүнсний ногооны дүрс
- нар, сар, одны дүрс гэх мэт

Бүтээлийн сан: Суралцагчдын хийсэн ажлаас хүүхдийг нээн харуулж буй үнэлгээ юм. Бүтээлийн санд бүтээлийн цүнх эсвэл хавтас, зурсан зураг, бүтээлүүд, суралцагчдын бүтээсэн ном, сэдэвт цуглуулга, зургийн цомог, суралцагчдын бүтээлийн талаар хийсэн багшийн тэмдэглэл гэх мэт зүйлс багтаж болно. Бүтээлийн санг ямар нэг зураг, бусад зүйлийн цуглуулга мэтээр өрөөсгөлөөр ойлгодог хандлага зарим багш нарт байдаг.



“Бүтээлийн сан” – гаар сурагчдыг үнэлэх нь тодорхой хугацааны туршид суралцагчид хамтарч буюу бие дааж гүйцэтгэсэн ажлын ахицыг үнэлэх, суралцагчдын танин мэдэх үйлийг хөгжүүлэх, сурах идэвхийг өрнүүлэх, бие даан бүтээлч эрэл хайгуул хийх, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээнд суралцахад дэмжлэг болдог.

Ш.Амонашвилигийн “6 настай хүүхдийг сургуульд сургах нь” номноос сургалтад хэрэглэж байсан хамт олны үнэлгээний жишээнээс авч үзье.

Самбарт гарсан сурагч шүлгийг гоё уншсан боловч алдаа гаргажээ.

Багш: -Бид Гивид юу хэлмээр байна!

Суралцагчид: -Гоё сайхан уншлаа...

-Үгээ хурц тод хэллээ...

-Гиви шүлгийг сайхан уншиж чадаж байна... гэх мэтээр шагшин магтжээ.

Багш: -Би та нартай санал нэг байна. Гиви гоё, сайхан уншлаа. Түүнд та нар юу гэж хэлмээр байна вэ?

Суралцагчид: -Тэр унших үедээ алдаа гаргаж байна. Шүлгээ бүрэн сайн цээжлээгүй байна.

-Зарим үгээ санахгүй үедээ “ээ..., ээ...” гээд бувтнаад байна.

-Шүлгээ сайн цээжлээд маргааш бидэнд уншиж өгөөрэй гэж хэлмээр байна.

Багш: -Гиви чи юу гэж бодож байна?

Гиви: -Хүүхдүүд зөв хэллээ. Би үнэхээр сайн мэдэхгүй байгаа... Маргааш сайн цээжилж ирье ээ!

Багш: -За сайн байна. Чи үүнийг хийж чадна аа!

Иймд багш та бэлтгэл хөтөлбөрийн үед сурагчдыг бүтээлээр үнэлэх, урмын үгээр үнэлэх, найзаар нь үнэлүүлэх, эцэг эхээр нь үнэлүүлэх үнэлгээний олон арга хэлбэрийг өргөн ашиглаарай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. БСШУСЯ Нэгдүгээр ангийн “Бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвлөмж (2017) 10-11 дэх тал
2. БСШУЯ, “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” буцалтгүй тусламжийн хөтөлбөр. Зургаан настай хүүхдийн сурах, сургах арга зүй (2008) 50 дахь тал
3. БСШУСЯ Нэгдүгээр ангийн “Бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвлөмж (2017) 16-34 дэх тал
4. БСШУСЯ Нэгдүгээр ангийн “Бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвлөмж (2017) 26-33 дахь тал
5. БСШУСЯ Нэгдүгээр ангийн “Бэлтгэл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвлөмж (2017) 34-37 дахь тал



2.2. МОНГОЛ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

ЕБС-ийн үндсэн хичээлийн нэг бол монгол хэл. Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөрийн зорилгыг¹ “Сурагч нь эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэн, бүтээлээр уншиж, бичин, хэл соёлоороо бахархдаг болно” гэж тодорхойлжээ. Нэгдүгээр ангийн сургалтын төлөвлөгөөнд монгол хэлний хичээлийг 29 долоо хоногт долоо хоногт тус бүр 7 цаг, нийт 203 цаг судлах учиртай.

Судлаачдын үздэгээр зургаан настай хүүхдийн хөгжилд тоглоом, тоглох нь чухал байр суурьтай хэвээр байдаг. Гэтэл сургуульд орсноор сурах үүрэг нэмэгдэнэ. Мөн тэдний бодит үйлдлийн сэтгэхүй нь илүү хөгжсөн байдаг ч монгол хэлний хичээлээр нүдэнд харагдаж гарт баригдахгүй хэлний авиаг тусгай тэмдэгтээр хийсвэрлэсэн дүрс буюу үсгүүдийг уншиж, бичиж сурах шаардлага гардаг. Зургаан настай монгол хүүхдийн үгийн нөөцийн дорвитой судалгаа хийгдээгүй бөгөөд сургалтын орчин, суралцахуйн үйл явцад “томчуудын” үг хэл зонхилдог. Энэ бүхэн нь сурагчдын суралцахуйд бэрхшээл учруулдаг.

Өнөөдрийн зургаан настнууд нь альфа үед хамаарах бөгөөд хэлд орохоосоо ч өмнө ухаалаг дэлгэцтэй харилцаж сурсан, дижитал ертөнцийн асар их мэдээлэлд хил хязгааргүй нэвтрэх чадвартай хүүхдүүд. Гэвч энэ нь тэдэнд амьд харилцаанаас хөндийрөх, үгийн нөөц баялаггүй болох, хүмүүжлийн доголдол үүсэх эрсдэл бий болж байна. Иймд монгол хэлний хичээлээр сурагчдынхаа сурах хөгжих хүслийг унтраахгүй, эдгээр онцлог байдлыг тооцсон сургалтын шинэлэг арга, аргачлалыг хичээлдээ сонгон хэрэглэх шаардлага багш бидэнд тулгарч байна.

Монгол хэлний сургалтын хөтөлбөр


Нэгдүгээр ангийн монгол хэлний хичээлийн зорилго нь сурагчдын хэл яриаг хөгжүүлж, тэдний эх хэлээрээ уншиж бичих анхан шатны чадвар эзэмшүүлэх явдал болно. Ер нь арван хоёр жилийн сургуулийн нэгдүгээр ангид зургаан настай хүүхдийг хөгжлийнх нь онцлогт тохирсон үйл ажиллагаанд оролцуулах замаар сурах арга барилын энгийн чадвар дадалд сургаж, улмаар бага боловсролын хөтөлбөрт дэвшүүлсэн зорилгод хүрэх суурь үндсийг тавихад чиглэх юм.

Нэгдүгээр ангид сурагчид монгол хэлний авиа, үсэгтэй дараах үе шатаар танилцаж, эх хэлээрээ уншиж, бичих анхан шатны чадвар эзэмшихийн зэрэгцээ үсэг, авиа, үе, үг, өгүүлбэр, эх зэрэг хэлний нэр томъёог ойлгож, сургалтын явцад хэрэглэж чаддаг болох учиртай. Сургалтын хөтөлбөрийн “Үсэг бичигт эхлэн суралцах” буюу цагаан толгойн бэлтгэл ба үндсэн үе, цагаан толгойн дараах үе нь бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

- ✓ Сонсох-ярих
- ✓ Бичих
- ✓ Унших
- ✓ Хэл зүй-Үгийн сан

Ийнхүү хөтөлбөрийн агуулгыг хэл зүйн айгаас гадна эх хэлний хэрэглээ, хэлэхүйн үйл ажиллагааг үндэслэн “Сонсох-ярих”, “Унших”, “Бичих” гэсэн ай болгож бүлэглэсэн хэдий ч хэлний авиа, үсэг таниулахад эдгээр нь тус тусдаа бус харин хоорондоо салшгүй холбоотойгоор хэрэгждэг онцлогтой. Өөрөөр хэлбэл ямар ч авиа, үсгийг таниулахад авианы хэлэгдэх ба сонсогдох онцлог, тухайн авиаг тэмдэглэсэн үсгийн дуудлага, бичлэг зэргийг хамтад нь заадаг.

Нэгдүгээр ангийн монгол хэлний хичээлийн агуулга нь цагаан толгойн бэлтгэл /35 цаг/, цагаан толгойн үндсэн үе /140 цаг/, цагаан толгойн дараах үе /28 цаг/ гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.



Монгол хэлний сургалтын хөтөлбөрийн “Үсэг бичигт эхлэн суралцах” гэсэн хэсэгт цагаан толгойн бэлтгэл ба үндсэн үеийг хамруулан үзэж 0 цифрээр, цагаан толгойн дараах хэсгийг 1 гэсэн цифрээр тус тус кодолжээ. Хөтөлбөрийн “Сонсох-ярих”, “Унших”, “Бичих”, “Хэл зүй-Үгийн сан” гэсэн дөрвөн ай тус бүрд холбогдох суралцахуйн зорилтыг дараах хүснэгтэд харууллаа.

№	Сэдэв		01 / 1.3 Сонсох- ярих	02 / 1.1 Унших	03 / 1.2 Бичих	04 /14 Хэл зүй
Үсэг бичигт эхлэн суралцах үе						
1	Цагаан толгойн бэлтгэл үе:		0.1а, 0.1б		0.3а	
2	Цагаан толгойн үндсэн үе	Эгшиг үсэг а,э,и /ы/,о,у,ө,ү	0.1а, 01б	0.2а	0.3б	0.4а
		Нэгдүгээр шатны гийгүүлэгч: м,с,х,р,в,л,н,ш	0.1а, 0.1б	0.2б	0.3в	0.4а
		Хоёрдугаар шатны гийгүүлэгч: б,г,д,т,ц,ч,з,ж ба зөөлний тэмдэг ь	0.1а, 0.1б	0.2в, 0.2г	0.3г	0.4а
		Я,е,ё,ю эгшиг, к,п,ф,щ гийгүүлэгч ба хатуугийн тэмдэг ь	0.1а, 0.1б	0.2д, 0.2е	0.3д	0.4а
		Том үсгээр эхлэн бичих			0.3е	0.4б
		Өгүүлбэрийг дэлгэрүүлэх	0.4в	0.4в	0.4в	0.4в
Цагаан толгойн дараах үе						
3	Цагаан толгойн дараах үе:		1.3а, 1.3б 1.3в	1.1а, .1б,1.1в, 1.1г, 1.1д	1.2а, 1.2б, 1.2в, 1.2г 1.2д,1.2е	1.4а ,1.4б, 1.4в, 1.4г

Монгол хэлний сургалтын хөтөлбөрийн агуулга буюу суралцахуйн зорилт нь цуваа бус, зэрэгцсэн бүтэцтэй. Өөрөөр хэлбэл унших, бичих, сонсох-ярих чадварыг сурагчид нэг удаа заалгаад, эсвэл нэг удаа хийгээд сурчихдаг чадвар биш тул нэг суралцахуйн зорилтууд хичээлийн жилийн турш үргэлжлэн хэрэгжих учиртай.

Одоо мөрдөж байгаа сургалтын төлөвлөгөө ёсоор тус ангид монгол хэлний хичээл нь долоо хоногт 7 цагаар, нийт 203 цаг оногдож байна. Тус ангийн жилийн нийт цагийн үлгэрчилсэн төлөвлөлтийг дараах хүснэгтэд үлгэрлэн харуулж байна. Энэхүү төлөвлөлт сурагчдын суралцах чадвараас хамаарч бүх ангид ижилхэн таарах албагүй ч та бүхнийг жилийн төлөвлөлтийг хийхэд баримжаа болно гэж үзэж байна.

Монгол хэлний хичээлийн цагийн үлгэрчилсэн төлөвлөлт

Долоо хоног	Пү	Баа	Бя	Ня	Да	Мя	Лх	Заах агуулга
I, II, III	IX/01- IX/24 Бэлтгэл хөтөлбөр							
IV	25	26	27	28	29	30	X/1	Цагаан толгойн бэлтгэл (35 цаг)
V	2	3	4	5	6	7	8	
VI	9	10	11	12	13	14	15	
VII	16	17	18	19	20	21	22	
VIII	23	24	25	26	27	28	29	
IX	30	31	XI/1	2	3	4	5	Эгшиг үсэг (21 цаг)
X	6	7	8	9	10	11	12	
XI	13	14	15	16	17	18	19	
XII	20	21	22	23	24	25	26	I шатны нийгүүлэгч: м, с, р, х, в, л, н, ш (35 цаг)
XIII	27	28	29	30	XII/1	2	3	
XIV	4	5	6	7	8	9	10	
XV	11	12	13	14	14	15	16	
XVI	17	18	19	20	21	22	23	
АМРАЛТ	24	25	26	27	28	29	30	I улирлын амралт
	31	I/1	2	3	4	5	6	
	7	9	10	11	12	13	14	
	15	16	17	18	19	20	21	



	22	23	24	25	26	27	28	
	29	30	31	II/1	2	3	4	
I	5	6	7	8	9	10	11	I шатны нийгүүлэгч: үргэлжлэл (7цаг)
II	12	13	14	15	16	17	18	II шатны нийгүүлэгч: г, д, т, б, ь, ц, ч, з, ж (42 цаг)
III	19	20	21	22	23	24	25	
IV	26	27	28	III/1	2	3	4	
V	5	6	7	8	9	10	11	
VI	12	13	14	15	16	17	18	
VII	19	20	21	22	23	24	25	
VIII	26	27	28	29	30	IV/1	2	я, е үсэг (7 цаг)
АМРАЛТ	3	4	5	6	7	8	9	II улирлын амралт
I	10	11	12	13	14	15	16	ё, ь, ю, п, к, ф, щ (28 цаг)
II	17	18	19	20	21	22	23	
III	24	25	26	27	28	29	30	
IV	V/1	2	3	4	5	6	7	
V	8	9	10	11	12	13	14	Цагаан толгойн дараах үе (28 цаг)
VI	15	16	17	18	19	20	21	
VII	22	23	24	25	26	27	28	
VIII	29	30	31	VI/1	2	3	4	

нийт 203 цаг

Боловсролын мэдээллийн технологийн төв /БМТТ/-өөс баталсан цахим хичээлийн жилийн төлөвлөлттэй дараах холбоосоор орж танилцаарай. Энэ төлөвлөлтийг 192 цагаар хийсэн байна. <https://medle.mn/static/media/Baga%20angiin%20mongol%20helni%20jiliin%20tulu-viult%20-beltgel,%201-5.96c951f5.xlsx>.

Хэрэв та бүхэн энэхүү үлгэрчилсэн төлөвлөлтийг ашиглахаар бол дутуу 11 цагийг цагаан толгойн бэлтгэлийн цагт оруулахыг зөвлөж байна. Энэхүү цахим хичээлийн төлөвлөлтийг БМТТ-ийн үндэсний цахим контентын нэгдсэн сангийн medle.mn хаягаар орж, “Багш” хэсгийг сонгож орно.

НЭГ. ЦАГААН ТОЛГОЙН БЭЛТГЭЛ ҮЕ

Цагаан толгойн бэлтгэл үеийн зорилго нь хүүхдэд авиа, үсэг зааж, уншиж бичиж сурахад нь бэлтгэх зорилготой. Өөрөөр хэлбэл авиа үсэгтэй танилцаж унших, үсэг, үе, үг, өгүүлбэр бичиж сурахын өмнө сурах шаардлагатай зүйл байдаг. Энэ үед хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, гар зүгшрүүлэх үйл ажиллагааг голчилдог. Хүүхдийн хэл ярианы хөгжил гэдэг нь эх хэлнийхээ авиаг зөв, цэвэр дуудах, үг өгүүлбэрийг тодорхой дуудаж сурах, ярьж уншихдаа утгын зогсолт хийх, дуу хоолойн өнгийг өнгийг зөв тохируулж ярьж сурахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл утга зохиолын хэлний дуудлагын дагуу зөв дуудаж сурах болно.

Цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлэгт үг өгүүлбэрийг зөв хэлж сурах, эх хэлнийхээ бүх авиаг зөв хэлж сурах зорилт байдаг ч сургуульд орохдоо зарим сурагч дараах алдаа гаргадаг. Үүнд:

- авиаг сольж дуудах /бороо-[дороо], чадахгүй-[гадахгүй]/
- авиаг дутуу, илүү хэлэх /малгай- [малга], атгаж-[хатгаж]/
- зарим үг, өгүүлбэрийг анх сонсож тогтоосноороо буруу хэлж хэвшсэн байх /тоглоом-тосоом, нээж өгч та- [нээжушка]/ гэх мэт.

1.1. Сонсох-ярих чадварыг хөгжүүлэх

Хүүхдийн үг яриа, сонсголыг хөгжүүлэхэд сургахад үгэн тоглоом ихээхэн үүрэгтэй. Ийм үгэн тоглоом нь хүүдийн эх хэлнийхээ үндсэн авиануудыг ялган зөв сонсож чаддаг, тэдгээр авиа бүхий үгийг зөв, цэвэр хэлж чаддаг чадвар дадал олгох, хэлний авианы бүтэц, дуудлагыг нарийн ялгаж сурна.

Сургах үгэн тоглоомыг дараах зорилгоор цагаан толгойн бэлтгэл үед болон цагаан толгойн үед



тоглуулж болно.

- ✓ Алсаас авианы ялгарлыг таньдаг болох
- ✓ Шивнэн хэлсэн авиаг сонсож, ялгаж чаддаг болох
- ✓ Төстэй хэлэгддэг авиануудыг ялгаж чаддаг болох
- ✓ Авиа солигдоход үгийн утга өөрчлөгддөгийг ойлгох
- ✓ Хүүхдийн өгүүлэх эрхтний хөгжлийг дэмжсэн байх

Сургах тоглоомыг дараах хэлбэрт хувааж болно.

1. Авиа, үсгийг зөв дуудах, хэл ярианы аппаратыг хөгжүүлэх тоглоом
2. Орчны юмс үзэгдэлтэй танилцуулан үгийн нөөцийг нэмэгдүүлэх тоглоом
3. Харилцааны соёлд сургах

• Авиа, үсгийг зөв дуудахад сургах тоглоом- Хүүхдийн амьсгал авах, гаргах ажиллагаа бүрэн хөгжөөгүй байдаг тул тэдний амьсгалыг задлах зорилгоор ярихдаа амьсгалаа хэрхэн авч, хэрхэн гаргах, хэрхэн хуваарилахад сургах тоглоомыг зохион тоглуулж болно. Ийм үгэн тоглоом нь хүүхдийн хэлийг зүгшрүүлэх, түргэн тод ярьдаг болгох, амьсгалаа зөв хуваарилан ярьж сургахад ач холбогдолтой.

• Хүүхдийн сонсголыг хөгжүүлэх тоглоом- Хүний хэлж ярьж байгааг шууд зөв ойлгож сургах ба дуудлагын хувьд төсөөтэй үгийн утгыг зөв ойлгоход сургах тоглоом бий. Хүний шинвэж хэлсэн үгийг таах дасгал тухайн хүний нүүрний хувирал, хөдөлгөөн, амны хайрцгийг ажиглан таалгаж болно. Энэ дасгал нь хүүхдийн анхаарал, харааны эрхтний тусламжтайгаар мэдрэхэд оршино. Эсвэл хүний нүүр лүү харахгүйгээр хэлснийг нь тааж хэлүүлэх бөгөөд энэ нь сонсголын эрхтний тусламжтайгаар хүртэж мэдрэх болно.

• Хүүхдийн хэл ярианы аппаратыг хөгжүүлэх тоглоом- Хэл ярианы гол эрхтэн болох уруул, хэлний булчин, эрүүг хөгжүүлэх тоглоом тоглуулж, хэлний олон авиаг зөв, цэвэр дуудах дасгал хийлгэж болно.

• Уруулын дасгал- Уруулаа нийлүүлж, салгах, хажуу тийш нь болгох, буйлаа гаргалгүй дээд уруулаа дээш өргөх дасгал хийлгэж болно.

1.2. Уншиж сурахад нь бэлтгэх. Авианы задлаг нийлэг аргаар үсэг бичиг зааж сургах гол зарчим нь хүүхдийн аман яриан дээр тулгуурлаж сургадаг учир тэдний сэтгэхүй, хэл яриаг хөгжүүлэх үйл ажиллагааг “Бэлтгэл” хөтөлбөрийн үргэлжлэл болгон зохион байгуулж, сурагчдад санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгоход анхаарах хэрэгтэй. Үүнд:

• Багшийн ярих, уншихыг сонсож ярилцах. Энэ нь нэг талаас багш шигээ сайхан ярьж, уншиж сурах хүсэл эрмэлзлийг өрнүүлэхийн зэрэгцээ нөгөө талаас үлгэр, өгүүллэгийг сонирхон сонсох, ойлгох, тусган хүлээж авах эрмэлзэл бий болгоно. Багш үлгэр, өгүүллэгийн үг, өгүүлбэрийг тод хэлж, аялга, хэмнэл, дууны өнгийг тохируулан унших явдал чухал. Зарим үед томоохон хэмжээтэй үлгэр, өгүүллэгийг товчлон ярьж өгч болно. Ийнхүү ярихдаа зурагт үзүүлэн таниулах ашиглах хэрэгтэй. Энэ нь яриаг илүү сонирхолтой, бодитой болгоно. Мөн аль болох урт нийлмэл өгүүлбэр, далд, шилжсэн утгатай үг хэллэг цөөн ашиглах хэрэгтэй.

• Зураг, видео бичлэг үзэж ярилцах. Сонгосон зураг, эсвэл видео бичлэгийг үзүүлэхийн өмнө сурагчдыг сэдэлжүүлж, тэдгээрийг үзүүлсний төсөөлсөнтэйгөө харьцуулан бодох хугацаа өгнө. Хэсэг хугацааны дараа ярилцах үйлийг хийлгэнэ. Ярилцлагын асуултаар чиглүүлэхээс гадна тэдэнд бусдаасаа асуулт асуух, хариулах боломж өгвөл нэн сайн.

• Сурагчдаар дуртай зүйлийг нь яриулах. Сурагч бүр сонсож мэдсэн, үзэж харсан, хийж бүтээсэн зүйлтэй төдийгүй ямар нэг зүйлийг буруу, зөв хийсэн өөрийн гэсэн туршлагатай болсон байдаг. Тэднээр ийнхүү дуртай зүйлийг нь яриулахад санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ярьсан хэлсэндээ итгэлтэй байхад нь дэмжлэг болдог төдийгүй багш нарт тэдний сонирхол, хэрэгцээг нь ойлгох боломж олгодог.



- Шүлэг, зүйр цэцэн үг, хэл зүгшрүүлэх үг хэллэг цээжлүүлэх. Хэл зүгшрүүлэх үг (түргэн хэллэг, жороо үг) хэлүүлэх нь өгүүлэх эрхтний гажиг засах, учир зүйн дараалалтай ярих, авиаг утга зохиолын хэлний нормоор зөв хэлж сурахад тустай. Авиа, үсгийг зөв дуудах нь зөв, хурдан, ойлгож унших нэг бэлтгэл болдог. Мөн ийнхүү цээжлэх нь сурагчдад сонсох, сонсож мэдсэнээ мартаггүй тогтоох, тогтоосноо хэлж сурах зорилготой. Хүүхэд уг зүйлийг сонирхож, утгыг нь сайн мэдвэл тогтоож чадна. Иймд бэлтгэлийн үед цээжлүүлэх шүлэг нь хөнгөн, тэдний сонирхолд нийцсэн байвал зохино. Шүлгийг цээжлэх даалгавар хийхийн өмнө бүхэлд нь багш үлгэрлэн уншиж, үзүүлэн таниулах материал ашиглан танил биш үгийн утгыг нь сайн ойлгуулах хэрэгтэй. Утгыг нь ойлгоогүй нэг л үг байхад хүүхдэд бэрхшээлтэй байдаг. Жишээ нь “Унага” шүлэг цээжлүүлэх гэвэл унаганы зураг, бичлэг үзүүлж “Урт сайхан зоотой” гэхэд зоо нурууг нь, “Уужим сайхан ташаатай” гэхэд ташааг заах зэргээр юуны тухай уншиж байгааг нь ойлгуулж “масстай” хэрэгтэй. Шүлгийг хэд хэдэн хэсэгт хувааж бага багаар нь цээжлүүлэх бөгөөд сүүлийн хэсгийг цээжилж байхад нь эхний хэсгийг давтан уншуулна.

- Дүрийн тоглолт хийлгэх. Үлгэр зохиолын баатруудын үг хэллэгийг хэсэгчлэн цээжлүүлж, дүрийн тоглолт хийлгэх нь ач холбогдолтой дасгал болдог.

1.3. Бичиж сурахад нь бэлтгэх. Зургаан настай хүүхдийн гарын сарвууны жижиг булчинг хөгжүүлэх, бичихэд гар дасгах хөдөлгөөнийг янз бүрийн хэлбэр чиглэлээр хийлгэж гарын хөдөлгөөнөө удирдах, мөн дэвтрийн шугамыг баримжаалан үсэг бүтээдэг зурлагуудыг бичихэд анхаарна. Хүүхдийн сарвуу, хурууны үе, булчин, мөрний хөдөлгөөн бүрэн гүйцэд хөгжөөгүй, зурлага яаж зурах, үсэг, үгийг зөв бичих чадвар дадал нь бүрэлдээгүй байдаг тул үсэг, үсгийн холболтыг бичих эв дүй, эвсэл олгох дасгал, мөн гар, хурууг чөлөөт хөдөлгөөнийг хөгжүүлэх дасгалуудыг хийлгэнэ. Үүнд:


- Зураг зурах, зураг будах. Энэ нь хүүхдийн сарвууны жижиг булчинг хөгжүүлж, бичихэд гарыг зүгшрүүлдэг сайн дасгалын нэг болдог. Иймд заавал монгол хэлний хичээлийн цагийг хүлээлгүй математик, дүрслэх урлагийн хичээлээр дүрс, зураг будах даалгавар өгсөн бол аль болох үсгийн зурлагын дагуу нар зөв эргүүлэн ташуу будаж сурахад нь туслах хэрэгтэй.

- Зурлага “зурж” бичих. Монгол хэлний хичээлийн дэвтрийн хол, ойр болон налуу шугамтай танилцуулж, эдгээр шугамыг ашиглан үсэг бүтээх зурлага бичүүлнэ. Үсгийн зурлагыг зөв бичиж сурах нь үсгийг зөв бичих, үсгийн ялгаа ба төсөөг таньж мэдэх улмаар дүрсийг нь хялбар тогтооход тустай.

- Үндсэн зурлагыг таньж нэрлэх. Үндсэн зурлагыг энгийн, хөнгөн бичлэгтэйгээс эхлэн хүндрүүлэх зарчмаар сонгож бичүүлнэ. Зурлага бичүүлж сургахдаа шугаман арга, тооллын арга, тодруулан бичих арга, баримжаалах аргуудыг (агаарт хий бичих, өгөгдсөн тодорхой хэмжээнд үсгээ багтаан бичих, зурлага болон үсгээ савх, утас, шагай, баримлын шавар гэх мэт материал ашиглан бүтээх) хэрэглэнэ.

- Зөв суух, үзэг, барих, дэвтрээ зөв тавихад сургах. Бичүүлж сургахдаа хүүхдийн харааны хүртэхүй болон гарын хөдөлгөөний эвсэл хоёрын хоорондын холбоог зөв тогтооход ихээхэн анхаарч, гарын хөдөлгөөн хараа хоёрыг тохируулан бичүүлж сургана.

1.4. Хэлний нэгжийн тухай ойлголттой болгох. Цагаан толгойн бэлтгэлийн үед хэл яриа буюу эхийг өгүүлбэр; өгүүлбэрийг үг; үгийг үе; үеийг авиа болгон задлах анхны төсөөлөлтэй болгох явдал зайлшгүй шаардлагатай. Хэлний нэгжийг үгээс эхлэн хоёр тийш нь харьцаа үүсгэн таниулна. Зургаан настай хүүхдийн харааны хүртэхүйн хөгжил сайн байдаг тул орчны хүн, амьтан, эд юмсыг нэрлэж сурсан байдаг. Иймээс үг нь хүүхдэд хамгийн ойр, танил байдаг.



• Эхлээд үгс нийлж өгүүлбэр бүтээдэг, өгүүлбэр нийлж эх болдгийг ойлгуулна. Тухайлбал, бодит юмс, тэдгээрийн зургийг нэрлүүлэх замаар үгийн тухай, үйл явдал бүхий зураг дээр ярилцаж үгс нийлж өгүүлбэр, өгүүлбэр нийлж эх болдгийг ойлгуулна.

• Дараа нь үг нь үеэс бүтдэг, үе нь авиа-үсгээс бүтдэгийг ойлгуулна. Харин үеийг хүний хурууны үеэр жишээлэн үг нь бас үеэс бүтдэг гэдэгтэй харьцуулан тайлбарлаж болно. Үүний тулд үг, үе бичсэн хэрчмэл үзүүлэн, карт, эвлүүлдэг дүрс /пазал/ зэрэг хэрэглэгдэхүүн ашиглаж, тэдгээрийг нийлүүлэн үг, өгүүлбэр зохиох, эсвэл хэсэглэн хуваах үйл ажиллагаа хийлгэж болно.

• Мөн авиа гэж юу болохыг бэлтгэлийн үед ойлгуулах хэрэгтэй. Хүний чихэнд сонсогдох элдэв дуу чимээний бичлэг сонсон ажиглуулна. Хүүхэд уйлахдаа, хүн хурхирахад, нохой архирахад ямар чимээ гаргадаг вэ? Салхи салхилах, бороо ороход ямар чимээ гардаг вэ? гэх мэтээр асууж байгалийн болон хэлний авианы тухай ойлголт өгнө. Мөн үсэг үзэхээс өмнө үгийн бүтцээс тодорхой авиа сонсох, тухайн авиа орсон үг хэлэх зэрэг дасгал хийлгэх нь шинээр авиа үсэгтэй танилцах нэг бэлтгэл болдог. Жишээ нь: Багш “Арслан” гэж хэлээд би “А” авиагаар эхэлсэн үг хэллээ. Та нар “А” орсон үг хэлээрэй гэх мэтээр хэлүүлж болно. Мөн “Арзайсан үстэй, араатны хаан” Энэ ямар амьтан бэ? гэж таалгаж болно.

Цагаан толгойн бэлтгэлийн үед “Манжин” үлгэрийг заах явцад хэлний нэгжийн тухай энгийн ойлголт өгөх дасгал сурах бичиг³ байгаа. Энэ үлгэрийг сонгож хэлний нэгжтэй танилцуулахыг зорьсон нь сурагчдын уг үлгэрийг сайн мэддэг өмнөх мэдлэгт нь тулгуурласан хэрэг болно. Гэхдээ “эх, өгүүлбэр, үг, үе, авиа-үсэг” гэж юу болохыг хэл шинжлэлийн онолын үүднээс юу гэж тодорхойлдогийг заах бус харин эдгээр нэр томъёог хичээл сургалтын явцад сурагчид ойлгон хэрэглэхэд сургах нь чухал. Өөрөөр хэлбэл “3-4 үгтэй өгүүлбэр зохио”, “Эхээс өгүүлбэр олъё”, “Энэ үгийг үеэр задалъя” гэх мэтээр харилцахад сурагчид саадгүйгээр ойлгож даалгаврыг гүйцэтгэх чадварт сургана гэсэн үг. Хэлний нэгжийн талаар заах арга, аргачлалыг багшийн ном⁴, суралцахуйн удирдамж⁵ -аас дэлгэрүүлэн үзнэ үү.



Энэ үлгэрийн дараа үеийн тухай ойлголтыг “Унага”, “Эвтэй дөрвөн амьтан” үлгэрийг ярилцахдаа заан, таг-таа, туу-лай, сар-маг-чин гэсэн үгсийг үеэр таслан хэлж үг үеэс бүтдэгийг ойлгуулж болно. “Ухаант туулай зэрэг тодорхой үйл явдал бүхий эхийг өгүүлбэрийн зөв дараалалд оруулан бүтээснээр үлгэр буюу эх бүтнэ гэдгийг таниулах зорилгоор сонгосон бол дараагийн эхийг ярилцахдаа тодорхойгоос ерөнхий рүү чиглэсэн мэдлэг бүтээх үйлийг нарийн болгосон шинжлэх ухааны богино эх орж ирж байгаа.

Зураг харж өгүүлбэр зохиолгохдоо эхлээд “Ус урсана”, Мод ургана”, Хүүхдүүд гүйсэн” гэх мэтээр үйлийн эзэн ба түүний хийсэн үйлийг нэрлэсэн хоёр үг бүхий бүрэн өгүүлбэр зохиолгоход анхаарах бөгөөд түүнийг ямар?, хэдэн?, хаана? гэх мэт асуух үгээр дэлгэрүүлэн асууж, 3-5 үгтэй өгүүлбэр болгон хэлүүлэхэд анхаарах хэрэгтэй. Жишээ нь:

Болд	дуртай.		
Болд	тоглох	дуртай.	
Болд	надтай	тоглох	дуртай.



Ийнхүү нэг үгийг нэг өнгөөр төлөөлсөн өнгөт карт ашиглах нь тухайн үйлийн эзнийг нэрлэсэн үгийг цэнхэр өнгөөр, үйл хөдлөл нэрлэсэн үгийг шар өнгөөр төлөөлүүлье гэж анхааруулаад самбарт цэнхэр, шар цаас тогтооно. Дараа нь “Болд яах дуртай вэ?” гэж асуун “тоглох” гэсэн үг хэлэхэд ягаан, “Болд хэнтэй тоглох дуртай вэ?” гэж асуун “надтай” гэвэл ногоон цаас дунд нь байрлуулна. Энэ мэтээр хураангуй өгүүлбэрт үг нэмэн дэлгэрүүлэхийг хялбар ойлгуулж болно.

ХОЁР. ЦАГААН ТОЛГОЙН ҮНДСЭН ҮЕ

Энэ үеийн зорилго нь хүүхдэд эх хэлний авиа, үсэг таниулж, уншиж бичих анхан шатны дадал олгоход оршино. Өөрөөр хэлбэл хэлний авиа үсгийг үе шаттайгаар таниулж, задгай ба битүү үе холбон уншиж, бичихээс бүтэн үгээр, улмаар өгүүлбэрийг утгат хэсгээр зааглан уншиж бичихэд сургана гэсэн үг. Уншиж сурахын тулд үсгийг таних ёстой. Үсгийг танихын тул тэдгээрийг тэмдэглэсэн авиаг мэдэх ёстой.

Сурагчдыг үсэг бичигт эхлэн сургахдаа авианы задлаг, нийлэг аргаар голлон таниулж ирсэн уламжлал хэвээр байна. Энэ нь эхийг өгүүлбэрээр, өгүүлбэрийг үгээр, үгийг үеэр, үеийг авиагаар задлах ба үсгүүдийг үе, үеүдийг үг, үгсийг өгүүлбэр болгон нийлүүлж уншиж, бас энэ дарааллаар бичиж сурна. Гэхдээ зарим үсгийг үсгийн аргаар таниулдаг. Үсгийн арга нь авианы задлаг хийлгүй үсгийг шууд нэрлэж, дуудлагыг нь таниулж уншуулж, бичүүлж сургадаг арга юм. Зарим багш үсгийн аргаар таниулдаг эгшиг, гийгүүлэгчийг авианы задлаг нийлэг аргаар таниулсан байдаг нь энэ хоёр аргын онцлогийг сайн мэддэггүйтэй нь холбоотой. Иймд авианы задлаг, нийлэг арга ба үсгийн аргыг дараах хүснэгтэд харьцуулж харууллаа. Энэ талаар “Монгол хэл 1” Багшийн ном, “Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж”⁶ зэрэгт авиа, үсэг бүрийг таниулах арга, алхмыг дэлгэрэнгүй тайлбарласан тул тэндээс үзнэ үү.

	Авианы задлаг нийлэг арга	Үсгийн арга ⁷
Аргын онцлог	Авианы задлаг нийлэг арга нь үсгийг авианаас нь эхэлж таниулдаг арга. Эхийг өгүүлбэрээр, өгүүлбэрийг үгээр, үгийг үеэр, үеийг авиагаар задлах ба тухайн авиаг тэмдэглэсэн үсгүүдийг үе, үеүдийг үг, үгсийг өгүүлбэр болгон нийлүүлж уншиж, бас энэ дарааллаар бичиж сургадаг арга.	Үсгийн арга нь авианы задлаг хийлгүй үсгийг шууд нэрлэн хэлж, дуудлагыг нь таниулж уншуулж, бичүүлж сургадаг арга юм. Өөрөөр хэлбэл тухайн авиаг тэмдэглэдэг үсгээс нь эхэлж таниулдаг арга.
Энэ аргаар ямар авиа үсэг заах вэ?	• Эгшиг үсэг а,э,и /ы/,о,у,ө,ү • I шатны гийгүүлэгч: м,с,х,р,в,л,ш • II шатны гийгүүлэгч: б,г,д,т,ц,ч,з,ж	• я,е,ё,ю эгшиг • к,п,ф,щ гийгүүлэгч • Тэмдэг үсэг “ь, ъ”
Яагаад?	• Монгол хэлний үндсэн авиа, үсэг • Н,Г хоёроос бусад нь авиа, үсэг хоорондоо тохирдог. • Н,Г хоёр гийгүүлэгч тус бүр хоёр авиа тэмдэглэдэг.	• я, е, ё, ю эгшиг нь тус бүр хоёр авианаас бүтдэг үет үсэг • к,п,ф,щ гийгүүлэгч нь гадаад үгэнд ордог гийгүүлэгч үсэг • Хатуу, зөөлний тэмдэг нь хэлний авиа тэмдэглэдэггүй, тэмдэг үсэг
Аргыг хэрэглэх үндсэн алхам	Задлаг хийх: 1. Зураг харан ярилцана. 2. Эхээс нэг өгүүлбэрийг сонгоно. 3. Өгүүлбэрийг үг үгээр задална. 4. Үгийг үе болгон задална. 5. Үгийг авиа болгож задлаад, шинэ авиаг судална. /хэлэх, сонсох/ 6. Судалсан авиаг тэмдэглэсэн үсэгтэй танилцана. (дармал ба бичмэл том жижиг) Нийлэг хийх 7. Хэрчмэл үсгээр үеэр үг бүтээнэ. 8. Бүтээсэн үг, өгүүлбэрийг уншина. 9. Сурах бичгээс үг, өгүүлбэр уншина. 10. Үсэг, үе, үг, өгүүлбэрийг бичнэ.	1. Үг ба зургийг харьцуулна. 2. Үгээс танил ба танил бус үсгийг олно. 3. Танил бус үсгийн дүрс юутай адил төсөөтэйг ярилцана. 4. Танил бус, шинэ үсэгтэй танилцаж, (дармал ба бичмэл том жижиг) хэлэгдэх байдал, дуудлагыг нь судална. 5. Үсэг, үе, үгийг бичнэ. 6. Сурах бичгээс үе, үг, уншина. 7. Өгүүлбэр, эх уншина.
Тайлбар	• Эгшгийг үгийн эхэнд үе болж орсон байрнаас таниулна. • Гийгүүлэгчийг үгийн төгсгөлөөс таниулна. • Авианы задлаг хийхэд багш гол үүрэгтэй бол нийлэг хийж үе, үг, өгүүлбэр, эхийг унших, бичихэд сурагчид гол үүрэгтэй.	• я, е, ё, ю эгшиг үсгийг үгийн эхэнд тод хэлэгдэж, дангаараа үе бүтээж байгаа үгийг сонгож таниулна. • к, п, ф, щ гийгүүлэгч үсгийг үгийн эхнээс таниулна. • Үгийг үсгээр задлахад багш гол үүрэгтэй бол нийлэг хийж үе, үг, өгүүлбэр, эхийг унших, бичихэд сурагчид гол үүрэгтэй.



2.1.а. Эгшиг авиа, үсэг таниулах

Богино эгшиг	Урт эгшиг	Хос эгшиг	Я-ийн төрлийн үсэг
а, э, и, о, у, ө, ү	аа, ээ, ий, ы, оо, уу, өө, үү	ай, эй, ой, уй, үй	я, е, ё, ю

Үндсэн долоон эгшиг ба й,ы үсэг

Эхлээд үндсэн долоон эгшиг авиа, үсгийг авианы задлаг нийлэг аргаар таниулна. Эгшиг авиаг үгээс ялган сонсох, хэлэх, тогтооход хялбар; авианы дуудлага, үсгийн нэр нь адил; эдгээр үсэгт бичгийн үндсэн зурлагууд орсон байдаг учраас цаашдаа унших, бичихийн суурь болдог. Мөн эгшиг авианууд нь бие даасан үе, үеийн орой болох ба гийгүүлэгч авиаг эгшигжүүлэн холбож үе, үе нь нийлж үг бүтээснээр унших боломж нээгддэг гэх мэт олон онцлогтой тул гийгүүлэгчийн өмнө заадаг. Мөн богино эгшгээс гадна урт, хос 19 авиалбарыг багцлан нэгжийг томсгох аргаар заадаг болсон. Эгшиг авиа нь гийгүүлэгчийг бодвол хэлэхэд амархан, уушгинаас гарсан хийн урсгал саадгүй гардаг, дан дуунаас бүтдэг, дангаараа үе болж хэлэгддэг учраас үгээс задлан ойлгуулахад төвөг багатай гэж арга зүйчид үзсээр ирсэн байна.

Богино эгшигийг авианы задлаг, нийлэг аргаар таниулдаг бол урт, хос эгшигийг харьцуулан жиших аргаар таниулна.

- Богино эгшиг авиаг монгол хэлний тэргүүн үеийн богино эгшиг нь тод сонсож, өргөлттэй хэлэгддэг онцлогийг харгалзан үгийн эхэнд үе болж орсон байрнаас авианы задлаг хийж таниулна.
- Урт эгшиг нь үгийн аль ч үед тод сонсогддог тул байрыг төдийлөн харгалзах шаардлагагүй бөгөөд тухайн урт эгшиг бүхий үсгийг хэлж сонсон, үгийн хаана нь байгааг нь олж хэлүүлэх, ялгуулах зэргээр таниулна.
- Урт “ий” авиа, үсгийг таниулсны дараа хос эгшиг гэсэн ойлголт өгч, “ай, эй”-г нөхөж таниулна. Бусад эгшигийг заахдаа богино, урт, хос үсгийг хамтад нь хэлэгдэх хугацаагаар нь харьцуулан заана. Хос эгшиг бүхий үсгийг хэлж сонсон үгийн хаана нь хэлэгдэж, сонсогдож байгааг нь ажиглуулж таниулна.

Эгшиг авиаг таниулах үе бол багшийн хамгийн хариуцлагатай мөч билээ. Хэлний авиаг сонсож, хэлж болдог, авиаг тэмдэглэсэн үсгүүдийг харж уншиж болдгийг сайтар ойлгуулах хэрэгтэй. Үүний тулд үзсэн авиа үсгийг уралдаж олох, үсэгт хөзөр, шоогоор тоглуулах нь сурагчдад сонирхолтой бүтээлч болохыг анхааралдаа ямагт авч байхыг зөвлөж байна. Эгшиг авиа, үсэг таниулахад тодорхой үг унших нөхцөл бүрдэхгүй тул шинээр таниулж байгаа эгшиг авиа, үсэг орсон төрөл бүрийн зураг, эхийг хичээлдээ ашиглах явдал чухал байдаг.

https://youtu.be/_Inwa9A1CBc Энэ холбоосоор орж эгшиг авианы дуудахад өгүүлэх эрхтэн байршил ямар байхыг сурагчдаар ажиглуулж дуурайн хэлэх дасгал хийж болно.

Эгшиг авиа, үсэг таниулахдаа дараах холбоос, QR кодоор нэвтэрч, танилцаарай.

А, э, и эгшиг үсэг	О, у, э, ү эгшиг үсэг	“О, У, Ө, Ү эгшиг үсэг”
		
https://econtent.edu.mn/interactivelessonAll/1/10001	https://econtent.edu.mn/interactivelessonAll/0/10003	https://econtent.edu.mn/interactivelessonAll/1/200002440538157

Я-ийн төрлийн үсэг

Сурагчид зургаан туслах эгшгээс “й, ы” үсэгтэй үндсэн долоон эгшигтэй хамт танилцаж уншиж, бичиж сурсан байдаг. Харин “я,е, ё,ю” дөрөв нь гийгүүлэгч+эгшиг гэсэн хоёр авианаас бүтсэн бүхэл үеийг тэмдэглэсэн үсэг. Ийм учраас Я-ийн төрлийн үсэг гэдэг. Мөн үет үсэг ч гэдэг. / Гийгүүлэгчийг “i” гэж тэмдэглэв./

Я= i+a

Е=i+э, i+ө

Ё=i+о

Ю= i+y, j+y



Авиа зүйн энэ онцлогийг бага насны хүүхдэд ойлгуулахад төвөгтэй тул шууд үсгийн дуудлага ба дүрсээр нь таниулах нь зохимжтой. Иймд эдгээрийг авианы задлаг аргаар биш, үсгийн аргаар зааж таниулдаг. Үсгийн арга гэдэг нь тухайн авиаг тэмдэглэсэн дүрсээс нь эхэлж таниулахыг хэлнэ. “Янзага, ямаа, янгир” гэх гэх мэтээр үгийн эхэнд тод хэлэгдэж, дангаараа үе бүтээж байгаа үгийг харуулж, танил биш үсгийг олж нэрлэх, замаар зааж ойлгуулна.

Я-ийн төрлийн үсгийг таниулах үлгэрчилсэн хөтөлбөрийг Хавсралтаас үзнэ үү.

2.2. Гийгүүлэгч авиа, үсэг

I шатны гийгүүлэгч	II шатны гийгүүлэгч	Онцгой гийгүүлэгч
Удаан хэлэгддэг буюу саадгүй хэлэгддэг	Түргэн хэлэгддэг буюу саадтай хэлэгддэг	Гадаад үгэнд хэрэглэгддэг
м, с, х, р, в, л, ш	б, г, д, т, ц, ч, з, ж + ь	к, п, ф, щ

2.2.1. Нэг, хоёрдугаар шатны гийгүүлэгч авиа, үсэг

Гийгүүлэгч авиа, үсгийг гурван хэсэг болгон таниулна. Нэг, хоёрдугаар шатны гийгүүлэгчийг тус тусад нь бүлэг болгон таниулах бөгөөд “Бб”-ээс бусад гийгүүлэгчийг сонгосон үгийн төгсгөлөөс нь авианы задлаг, нийлэг аргаар таниулна. Аль ч гийгүүлэгч үгийн төгсгөлд байхдаа дуудлага нь хамгийн цэвэр, тод сонсогддог тул энэ онцлогийг тооцож авиа, таниулах үгийг сонгодог. Харин монгол хэлэнд “Бб” гийгүүлэгчээр төгссөн үг байдаггүй.

Гийгүүлэгчийг яагаад нэг, хоёрдугаар шат болгон заадаг вэ?

Өгүүлэхийн талаас авч үзвэл, гийгүүлэгч авиаг хэлэхэд уушгинаас гарсан хийн урсгал мөгөөрсөн хоолойгоор дамжин, төвөнхөд орж, ам хамрын хөндийгөөр гадагш гарахдаа ямар нэгэн саад хашлагатай тохиолдож анир үүсгэнэ. Уушгинаас гарсан хийд өгүүлэх ямар эрхтэн ямар нэг саадтай хэлэгддэг авиаг гийгүүлэгч гэнэ. Гийгүүлэгчийг сонсгол зүйн болон өгүүлэхийн талаас нь сонсголт, шуугиант гэж хоёр ангилдаг.

I шатны гийгүүлэгч Удаан буюу саадгүй хэлэгддэг гийгүүлэгч	II шатны гийгүүлэгч Түргэн буюу саад ихтэй хэлэгддэг.
- Сонсголт гийгүүлэгчийг өгүүлэхэд дууны хөвч доргин чичирч, зонхилон дуу давамгайлж бүтнэ. - Хийн урсгал хамрын хөндийгөөр саадгүй урсан гардаг. - Сонсголт гийгүүлэгч авиаг үндсэн өнгөөр нь удаан дуудаж болно. - Өгүүлэх эрхтний булчингийн үйл ажиллагааны хүчдэл бага шаардана.	- Хамжих, хамжин шүргэх гийгүүлэгчийг удаан хэлж болдоггүй. - Хийн урсгалын камд тохиолдох хашлага, саад ихтэй хэлэгддэг. - Үндсэн өнгөөр нь удаан дуудах боломжгүй, түргэн хэлэгддэг. - Өгүүлэх эрхтний булчингийн үйл ажиллагааны хүчдэл их шаардана.
Мм, Сс, Хх, Вв, Рр, Лл, Нн, Шш	Дд, Тт, Гг, Бб, Цц, Чч, Зз, Жж

Сурагчдаар гийгүүлэгч авиаг хэлүүлж, мөн бусдын хэлэхийг сонсгож, уушгинаас гарсан хийд өгүүлэх ямар эрхтэн саад болж байгааг ажиглуулах замаар хэлэхэд саадтай гардаг авиаг гийгүүлэгч гэдгийг тэдэнд ойлгуулна. Жишээ нь, “м” авиаг хэлэхэд хоёр уруул нийлж, “л” авиаг хэлэхэд хэлний үзүүр дээд үүдэн шүдтэй нийлж байна гэх мэтээр хэлүүлнэ.

Практикаас харахад зарим үсгийг авианы дуудлагаар нэрлэж сургасан багш цөөнгүй таардаг. Энэ нь үсгийн нэр ба авианы дуудлагыг ижил гэж ойлгосонтой нь холбоотой. Иймээс хүүхэд “в” үсгийг “эв” үсэг, “х” үсгийг “их” үсэг, хэлний угийн “н”-ийг энхлэг үсэг гэж хэлдэг. Иймд шинэ залуу багш нар энэ алдааг давтахгүй байх, олон жил ажилласан туршлагатай ч ингэж зааж ирсэн багш байгаа бол арга барилаа өөрчлөх хэрэгтэй.

Гийгүүлэгчийн үндсэн дуудлагыг нь зөв таниулах шаардлага тавигддаг. Үүнийг биелүүлэхэд гийгүүлэгчийн авиа зүйн онцлогийг мэдэж байх шаардлагатай.

1. Монгол хэлэнд үгийн эцэст гийгүүлэгч авиа эгшиггүй орох тохиолдол элбэг байна. Ийм гийгүүлэгч авиаг хүүхэд хэлж сурсан, ярианы аппарат нь хэвшил болсон байдаг.
2. Гийгүүлэгч авианы зөв дуудлага нь эгшиг авианаас хол байгаа байрлалд дээр илүү тод цэвэр сонсож дуудагддаг байна. Жишээ нь: Элс, алт, талх



3. Монгол хэлэнд хэлний гүн угийн Г, хэлний үзүүрийн Н-ээр төгссөн бага, хана, оно гэх мэт хэдэн үгээс өөр тийм задгай үеэр төгссөн үг маш ховор юм.

4. Ихэвчлэн ам, сам, муур, хав гэх мэт гийгүүлэгчээр төгссөн үг эхлэн уншуулж сургадаг онцлогтой.

Ийм учраас гийгүүлэгч авиаг эхлэн үгийн эцэст байгаа тохиолдлоос нь ялгаж таниулаад дараа нь үгийн төгсгөлд, дунд, эхэнд орсон үгсийг уншуулж дасгал ажиллуулж бататгана. Жишээ нь: амм-мма, самар, алим, мөөг, хэрэм гэх мэт.

Нэгдүгээр шатны удаан хэлэгддэг гийгүүлэгчээс “н” үсэг хэлний угийн ба үзүүрийн хоёр авиаг тэмдэглэдэг бол хоёрдугаар шатны гийгүүлэгчээс “г” үсэг нь мөн хэлний гүн уг буюу хоолойн “г” ба гүн биш уг буюу хэлний “г” гэсэн хоёр авиаг тэмдэглэдэг. Ийм үгсийг бага насны хүүхдэд зэрэгцүүлэн заахад төвөгтэй тул нарийн дэс дараа чухал. “Н” үсгийн хувьд эхлээд “ан, он, сан, хун” гэх мэт үгээс хэлний угийн “н” авиа үсгийг, дараа нь “ана, оно, сана” гэх мэтээр харьцуулан хэлний үзүүрийн “н” авиаг таниулж, уншиж сургахаар сурах бичигт оруулсан байгаа. “Н” үсгийн хоёр өөр дуудлагыг заах явцад хэлний үзүүрийн “н” ардаа эгшиг үсэгтэй, хэлний угийн “н” ардаа эгшиггүй бичигддэг болохыг ойлгуулна. Ийм үгсийг харьцуулан уншуулснаар шууд уншдаг, жишээ үг хэлж чаддаг болно.

Нэгдүгээр шатны гийгүүлэгч ялангуяа эхний гурван гийгүүлэгчийг \м,с,р\ таниулахдаа яаралгүй, нухацтай, анхааралтай хандах шаардлагатай. Ингэснээр унших бичих суурь зөв тавигддаг. Нэгдүгээр шатны гийгүүлэгч үзэх явцад хүүхэд бүрд үе холбон үг унших, уншсан нүдлэн тогтоох эхлэл тавигдсан байх ёстой. Эхний 5 гийгүүлэгчийг үзэх хугацаанд багш яаралгүй тогтуун ажиллаж, хүүхэд нэг бүрд унших анхны дадлага олгох ёстой. Энэ үед үл хүүхэд уншлагад сурахгүй бол цаашид хоцорно гэдгийг хатуу анхаарах хэрэгтэй. *Цагаан толгойн гийгүүлэгч авиа, үсэг таниулах арга зүйн санаатай энэ QR кодоор нэвтэрч танилцаарай*



2.2.2. Онцгой гийгүүлэгч К, П, Ф, Ц

Гадаад үгэнд ихэвчлэн бичигддэг “к, п, ф, ц” авиаг бүх үсгийн сүүлд үзэхээр оруулсан. П авиа нь зарим монгол үгийн эхэнд хэлэгдэж бичигддэг. Жишээ нь: пагдгар, пар пар, пас пүс, пал пүл гэх мэт. Харин “к, п, ф, ц” авиа орсон гадаад үгийг багш өөрөө зөв хэлж сонсоод, зөв хэлүүлж сургана. Эдгээр авиаг задлаг нийлэг аргаар бус мөн үсгийн аргаар таниулна.

Монгол хэлний авиа таниулахад гардаг хэд хэдэн бэрхшээл байдаг. Тухайлбал

1. Нутгийн аялгуутай холбогдон бий болдог. Тухайлбал, баруун аймагт хэлний угийн “н” авиаг хэлний үзүүрийн “н” тэй ижилхэн хэлдэг тул (Жнь: ...арван(а) дөрвөн(ө) он(о), номын(о) сан(а) хэлний угийн “н” авиаг таниулахад, хэлний “г” гийгүүлэгчийг хоолойн “г”-тэй ижилхэн дуудаг нутагт (багш –багаш, “Цага яага хэд болж байна?, Өөл нүүх, ногаан өнгө) хэлний “г” авиа таниулахад бэрхшээлтэй байдаг.

2. Хүүхдийн хэл ярианы хөгжил харилцан адилгүй байдаг. Зарим авиаг, тухайлбал р, с,ш,ж,з,ц,ч зэрэг авиаг зөв хэлж чаддаггүй хүүхэд байдаг. Жишээ нь “р” гийгүүлэгчийг “л”-ээр сольж хэлдэг, эвсэл хэлж чаддаггүй хүүхэд байгаа бол “р” авиаг хэлж сургахад өгүүлэх эрхтнийг идэвхжүүлэх, өгүүлэх эрхтнийг зөв байршуулж “р” авианы тавилтыг зөв болгох, дуудлагыг зүгшрүүлэх дасгал зааж, хэвшүүлэх ажил тусгайлан хийж болно. Энэ мэтээр ажиллахын зэрэгцээ хэл зүгшүүлэх үг хэллэг хийлгэж байх нь үр дүнтэй. “Р” авиаг зөв дуудаж сургахдаа битүү ба задгай үе, эсвэл үгийн эхэнд, дунд, адагт “р” авиа бүхий үгээр өгүүлбэр зохиолгож хэлүүлнэ. Тухайн хүүхдийн хэл ярианы боломж, байдалд тулгуурлан авиа хүртэх чадварыг хөгжүүлэх, өгүүлэх эрхтнийг идэвхжүүлэх, өгүүлэх эрхтний байршлыг тогтоох, авиа зөв хэлүүлж сургах, хэл зүгшрүүлэх дасгалуудыг унших, бичих, ярилцахтай хослуулан явуулбал үр дүнтэй. Харин хэлний холбоос нь богино, тагнай өндөртэй хүүхдийн хэлний үзүүр нь тагнайд хүрэхгүй. Ийм хүүхэд байвал мэргэжлийн хэл засалчид хандах хэрэгтэй.⁸

Жишээ нь: Идэвхжүүлэх дасгал:



- Хэлээ амнаасаа гаргаж, “бөөрөнхийлөх”
- Аяга хэлбэртэй болгох
- Хэлний үзүүрийг дээд тагнайд хүргэх
- Дээд уруулаа долоох
- Хэлээр тагнайгаа “цэвэрлэх”
- Тагнай таших, шогшрох

“Р” авианы өгүүлэх эрхтний байршил

- Хэлний үзүүр дээд үүдэн шүдний ард
- Хэл дундуураа хотойно
- Хэлний уг дээшээ ялимгүй өргөгдөнө
- Хэлний хоёр хажууг нь дээд араанд тулна
- Зөөлөн тагнай дээш өргөгдөнө
- Дууны хөвч чичирнэ
- Агаарын урсгал хэлний дундуур явж, хэлний үзүүрт чичиргээ үүсгэнэ.

“Р” авианы тавилт

- Хэлээ аяга хэлбэртэй болгож, дээд уруулд наана . Хэлээ тэр хэвээр нь дээд шүдний ард аваачна. Энэ дасгалыг удаан хийж дасгасны дараа хэлний үзүүрт чичиргээ үүсгэнэ. Үүний тулд хэлний үзүүрийг тагнайд хүргээд салгахдаа амьсгалаа хүчтэй гаргаж тр... (дуугуй), дараа нь тр ... (дуутай) гэж хэлүүлнэ.
- Ддд ...да да ди ди ди гэсэн авиа хэлүүлж байгаад хэлний дор савх хийн чичрүүлэхэд УРФ гэсэн авиа гарна.
- Хатуу тагнай зөв байрлалтай бол хэлний үзүүрийг түүнд хүргэн чичрүүлж, хүйтэн амьсгал гарган дуугарна.

Нэг, хоёрдугаар шатны гийгүүлэгч таниулах үлгэрчилсэн хөтөлбөрийг Хавсралт 4.5-аас үзнэ үү.

2.3 Тэмдэг үсэг

Цагаан толгойн үсэгт ямар ч авиа тэмдэглэдэггүй хоёр үсэг /ъ, ь/ байдаг. Тэдгээрийг тэмдэг үсэг гэдэг. Зөөлний тэмдгийг хоёрдугаар шатны гийгүүлэгч заахдаа таниулдаг бол хатуугийн тэмдгийг Я-ийн төрлийн үсэг заахдаа таниулна. Хатуу, зөөлний тэмдэг нь тусгай авиа тэмдэглэдэггүй учраас үүргийн талаас нь үсгийн аргаар таниулна.

- ✓ Зөөлрүүлэх үүрэгтэй: Эр үгэнд орсон зарим гийгүүлэгчийг уг хэлэгдвэл зохих байрнаас урагшлуулах, тагнайшуулах зэргээр хэлэхийг зөөлрүүлэх гэнэ. Ийм гийгүүлэгчийг зөөлөрсөн гийгүүлэгч гэдэг. Жишээ нь:

ам – амь тав – тавь хар – харь бар – барь

Зөөлний тэмдгийн дараа туслах эгшиг “я,ё, орвол зөөлний тэмдэг хэвээр байна.

Жишээ нь: барья, сахья, сольё

- ✓ Тусгаарлах үүрэгтэй:

1. Эр үгэнд “я,ё” эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдаж байвал өмнө нь хатуугийн тэмдгээр тусгаарлаж бичнэ. Жишээ нь:судалъя, олъё, танилцъя,
2. Эм үгэнд “е” эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдаж байвал өмнө нь зөөлний тэмдгээр тусгаарлаж бичнэ. Жишээ нь: өгье, хүрье, тэнцье, биелүүлье

ГУРАВ. УНШИХАД СУРГАХ

Унших чадварын анхны суурь үндэс цагаан толгойн үед тавигддаг. Сурагчдад авиа үсэг таниулахтай зэрэгцэн унших аргад сургана. Цагаан толгойн үе эхлэхэд 20 гийгүүлэгчийг 7 эгшгээр амилуулж 140 задгай үе, мөн тооны битүү үе болох бөгөөд хийсвэр утгатай эдгээр үеийн дуудлага, бичлэгийг нүдлэн тогтоох нь хүүхдэд амаргүй. Уншиж сургах гол аргыг үеийн арга гэж үзэж байгаа хэдий ч зөвхөн энэ аргаар сургана гэж туйлширч болохгүй. Үг бүрийг үелэн уншуулах нь цаашдаа буруу дадал болох эрсдэлтэйг манай арга зүйчид тэмдэглэсэн байдаг⁹.

Хүүхэд сайн уншиж сураагүй байхад үсэг үсгээр, эсвэл үе үеэр салгаж хэл, үсэглээд унш гэх хэлэх нь зохисгүй. Харин өгүүлбэр, эхийг уншуулахад их, бага зогсолтыг хийж сургах хэрэгтэй. Унших явцад таслал байвал бага зэрэг, өгүүлбэр төгсөж цэг тавьсан байвал харьцангуй удаан зогсолт хийж сургана.

Иймд цагаан толгойн үед үеийн аргыг уншлагын гол арга гэж үзэж буй ч үеийн аргыг бүтэн үгээр унших, шаардлагатай үед үсэглэх аргатай хослон хэрэглэвэл зохино. Тухайлбал,

- Цагаан толгойн үед хүүхдийг уншиж сургах гол арга бол нэг үетэй буюу богино, хөнгөн үгийг нүдлүүлж аль болох бүтэн үгээр уншуулах явдал юм.
- Харин олон үетэй, урт үгийг үелэн уншуулах бөгөөд үгийг үеийн тоогоор олон тасалж уншуулах шаардлагагүй, харин хүүхэд хэлж чадвал аль болохоор цөөн таслах хэрэгтэй. Жишээ нь: “ажилласнаас” гэдэг үгийг заавал “а-жил-лас-наас” гэж үелэхгүй, харин “ажиллас-наас” гэж үелүүлбэл зохино. Үг бүрийг заавал үелэхийг шаардаж, байнга үелж, эсвэл үсэглэж уншаад байвал удаан уншихын зэрэгцээ уншсанаа ойлгохгүйд хүрдэг.
- Богино боловч хүүхдийн зөв хэлж уншихад төвөгтэй хүнд үгийг уншихад үсэглэн унших аргыг хэрэглэж болно. Жишээ нь:
- Өгүүлбэр, бичил эхийг зөв уншуулахад их, бага зогсолтыг зөв хийлгэж сурах хэрэгтэй. Энэ уншсан зүйлийн утгыг ойлгоход тустай.

Үг нь авиануудын нэгдэл учраас тухайн үгийг бүтээж байгаа авианууд (үсгүүд) хэллэгийн урсгалд эгшин зуур холбогддог хуультай. Ийм учраас авианууд нэг нэгдээ харилцан нөлөөлдөг. Үсгээ бүрэн таньж нүдэлсэн ч зарим сурагч уншиж чаддаггүй шалтгаан нь авианы ийм огцом нарийн холбоог гаргаж чадахгүй байгаагаар холбоотой. Өөрөөр хэлбэл үг хэллэгийн урсгалд авиануудын эхлэл, төгсгөл тус тусдаа хэлэгддэггүй харин түрүүчийн авианы төгсгөл дээр дараагийн авианы эхлэл давхцаж байдагтай холбоотой

Иймд “ма” гэж уншихад хоёр үсгээ мэдэж байгаа ч “м-а, м-а, м-а” гэж уншиж байгаа нь авиануудын төгсгөл ба эхлэлийн давхцалыг хийж чадахгүй байгаа хэрэг. Энэ холбоосыг хийж, ма гэдгийг уншуулахын тулд хоёр уруулаа нийлүүлэн “м” авиаг хэлэхэд бэлтгээд, араас нь “а” авиаг шууд хэлэх зэргээр эдгээр задгай үеийг уншуулж сургах нь зохистой. Ийм учраас уншуулж сургахдаа үсгүүдийн холбоос буюу нэг авиаг нөгөө авиатай, нэг үеийг нөгөө үетэй огцом холбож сургахад анхаарах хэрэгтэй. Сурагчид бүтэн үгээр уншиж сурах хүртэл энэхүү огцом холбоог шалмаг тогтоож чаддаг дадал олгох хэрэгтэй. Уншуулж сургахад гардаг нэг бэрхшээл бол сурагчид үсгийг нэрлэж хэлэх боловч холбон уншиж чаддаггүй. Энэ тохиолдолд эхний авианы төгсгөлийг хэлэхэд бэлтгээд, өөрөөр хэлбэл эхний авианы хэлэх байдлаас дараагийн авиаг залгуулан шууд хэлж сургах нь хэрэгтэй.


Нэгдүгээр шатны гийгүүлэгчийг таниулах явцад багш дараах чадвар эзэмшүүлэхэд анхаарах хэрэгтэй.

- Хүүхэд бүр үзсэн үсгийг нүдэлж тогтоох, зөв уншиж сурах
- Үеийг маш сайн нүдэлж, чадварлаг уншиж сурах
- Үе холбон үг бүтээн унших уншсан зүйлийн утгыг ойлгох. Жишээ нь “са+мар”,

“Са+раа, Со+сор 2 сүү уув.” гэх мэт

Хүүхэд үг өгүүлбэр уншиж сурахад далд байгаа үсгийг олох, тохирох үеийг холбох зэрэг дасгалыг өдөр бүр хийх нь үр дүнтэй. Даалгаврыг сурагчдад өгөхдөө “Алимын ард нэг үсэг нуугдсан байна. Түүнийг олъё” гэх мэтээр хэлэхэд хүүхдэд сонирхолтой.

Мөн үеийн хүснэгийг томоор хийж ангийн хананд байрлуулах нь үсэг, үе нүдлэх үе холбон уншиж сурах нэг нөхцөл болдог.



Үеийн хүснэгт ашиглан унших дасгал хийлгэх. Багш үеийн хүснэгтийг ангид томоор бичиж бэлтгэх эсвэл баг бүрт нэг нэг байхаар бодож урьдчилан бэлтгэсэн байвал зохино. Эдгээр ч таниулах явцад үеийн хүснэгт ашиглан үеийг нүдлүүлэх тогтоолгох уншуулж сургах үйл ажиллагааг маш чухалчлах хэрэгтэй. Хүүхэд бүр үсгийг нүдэлж үе холбон унших арга дадлагад суралцаж байгаа эсэхийг сайтар ашиглаж судалбал зохино.

Уншлагын хэлбэр. Уншлага бол бусдад унших, өөртөө унших гэсэн хоёр хэлбэртэй. Нэгдүгээр ангийн сургалтад энэ хоёр хэлбэрийн аль алийг нь хэрэглэдэг.

Чангаар дуудан өөртөө уншихыг дэмжих. Анхлан уншиж сурч байхдаа сурагчид өөртөө уншихдаа чангаар дуудан уншиж, уншсанаа сонсож байж ойлгодог онцлогтой. Учир нь тэд харааны уншлагад сайн суралцаагүй байдаг. Иймд сурагчдыг цагаан толгойн үед ангид болон гэртээ сурагчид чангаар дуудан уншихыг нь дэмжиж байх хэрэгтэй.

Шинэ үгийг уншуулах. Шинээр авиа үсэг таниулах бүрд тухайн үсэг орсон шинэ шинэ үг сурах бичигт байгаа тул өмнө нь уншиж байгаагүй шинэ үг бүрийг тусгайлан танилцуулж, уншихад бэлтгэх хэрэгтэй. Самбарт бичих, проектороор харуулах, үзүүлэн таниулах, тарааж өгөх материал зэрэгт бичих зэргээр сурагчдаар уншуулж болно. мөн “Энэ хуудаст өмнө уншаагүй шинэ үгийг хэн олох вэ?”, “Шинэ үгийг хэн уншиж үзүүлэх вэ” гэх мэтээр асууж, сонирхолтой хэлбэрээр таниулж болно.

Уншиж байгаа эсэхийг нь шалгах. Сурах бичиг дэх баганын үг, холбоо үгийг хүүхдүүд дарааллаар нь цээжлэн тогтоодог. Иймд тэд үнэхээр уншиж байна уу?, эсвэл цээжилж тогтоосноо эргүүлэн хэлээд байна уу? гэдгийг багш анхаарч, зарим үед энд тэндээс нь уншуулж шалгахад буруудахгүй.

Уншлагын дөрвөн чанар. Сурагчдад уншлагын дөрвөн чанарыг уншиж эхлэхээс нь эзэмшүүлэхийг зорьдог. Унших чадвар нь цаашид олон төрлийн хичээл судлах гол үндэс суурь болдог.

Зөв уншлага- Үсгийн дуудлагыг зөв тайлж, үгэнд хөрвүүлж, утгыг танихыг унших гэнэ.¹⁰ Өөрөөр хэлбэл хүүхэд тухайн үгийг хармагц бүхэл бүтнээр нь зөв уншихыг хэлэх бөгөөд амьсгалыг тохируулан үе, үсгийг сольж гээлгүй, өргөлт, зогсолтыг зөв өгүүлж бичгийн хэлний үндсэн хэв журмын дагуу уншихыг хэлнэ. Зөв уншлагын суурь нь цагаан толгойн үед эхлэн тавигдах бөгөөд анги ахих тусам улам өргөжнө.

Ажиглалтаас үзэхэд муу уншдаг хүүхэд уншиж байгаа зүйлээ төдийлөн сайн ойлгодоггүй байна. Зөв уншлага нь голдуу бусдад уншихаар илэрхийлэгддэг. Сурагчдын уншлагыг ажиглахад

- а. Үгийн төгсгөлийг буруу унших
- б. Ойролцоо дуудлагатай үсгийг сольж унших
- в. Урт, хос, богино эгшгийг буруу унших зэрэг дутагдал ихээхэн гардаг. Иймээс хүүхэд

бүрд унших боломж олгож, ийм үйлийг хэвшил болгохын тулд дараах асуудлыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Үсэг, үгийг зөв хэлж дуудах
2. Үсэг, үе орхихгүй гүйцэд унших
3. Үсэг, үе, үгийг давтан хэлэхгүй байх

4. Үсэг, үеийг сольж уншихгүй байх
5. Үсэг, үе нэмж уншихгүй байх
6. Өгүүлбэр уншихдаа өргөлтийг зөв хэлэх
7. Их, бага зогсолтыг зөв хийх
8. Дууны өнгийг тохируулан унших

Зөв уншиж сургахад хүнд үгийг ялган урьдчилан уншуулах нь үр дүнтэй аргын нэг. Уншлагын хичээлээр хэд хэдэн сурагчаар нийтэд уншуулж, магтаал, шүүмжийг хэлүүлж, гаргасан алдааг нь хамтран засах зөвлөгөө өгүүлж сургах хэрэгтэй. Энэ нь зөвхөн уншиж байгаа хүүхдэд төдийгүй сурагчдын бусдыг анхааралтай сонсох, бусдад зөвлөгөө өгөх, бусдаас суралцах чадвар төлөвшихөд дэмжлэг болох болно.

Хурдан уншлага- Эхлээд зөв уншиж сурах, уншсанаа ойлгох, улмаар уншлагын хурдыг нэмэгдүүлнэ. Энэ чадварыг аажмаар эзэмшдэг. Уншлагын хурд нь хурдан, эсвэл хэт удаан байвал уншиж байгаа зүйлээ ойлгохгүйд хүрдэг. Уншлагын хурдны хэмжээ ярианы хэлний хурдтай ойролцоо байхыг зохистой гэж үздэг. Хүн нэг минутад 30-40 орчим үг хэлдэг. Өөртөө унших уншлага бол бусдад унших уншлагын бэлтгэл болдог. Богино, хялбар үгийг анхнаас нь нүдлэн бүтэн үгээр нь уншиж сурвал хурдан унших нэг нөхцөл болно..

Ухамсартай уншлага. Унших явцдаа утгыг бүрэн ойлгож авахыг хэлнэ. Ухамсартай уншихын тулд үг бүрийн утгыг мэдэж, өгүүлбэр бүрийн, улмаар тухайн эхийн агуулга, утга санааг саадгүй ойлгохыг хэлнэ. Үүний тулд урт өгүүлбэрийг үг үгээр нь бус аль болох утгат хэсгээр зааглан, улмаар бүтэн өгүүлбэрээр нь унших аргад сургана. Зөв, хурдан унших чанарыг эзэмшсэн байх нь уншсанаа ойлгох, ухамсарлах гол нөхцөл болно. Уншсан сэдвийнхээ үндсэн агуулгыг ойлгож байна гэдэг бол өгүүлбэр болон цогцолборын гол санааг ялгаж салган, тэдгээрийн хоорондын учир шалтгааныг тогтоож чаддаг байхыг хэлнэ. Зарим сурагч хэт түргэн уншдаг ч ойлгосон зүйлгүй хоцордог нь ухамсартай уншиж сураагүйтэй нь холбоотой. Сурагчид эхнээс нь үг үгээр нь биш, аль болох утгат хэсгээр нь зааглан, улмаар бүтэн өгүүлбэрээр нь уншиж сургах хэрэгтэй

Сайн уншигч болж төлөвшихөд уншсанаа ойлгож тогтоох явдал чухал. Ийм учраас сурагчдаар тодорхой сэдэв уншуулсны дараа асуулт асууж хариулт авах, зураг зуруулах, яриулах, үйл хөдлөл нэрлэсэн үгийг дарааллаар нь байрлуулах, зурагт харгалзуулах, тохирох хариултыг олох гэх мэт олон аргаар хэрхэн ойлгосныг илрүүлж болно.

Сурагч зарим эхийг нэг уншаад сайн ойлгодоггүй тул хэд хэдэн уншиж, утгыг ойлгох боломж олгох хэрэгтэй. Тухайлбал:

Эхлээд багш эхлэн үлгэрлэн уншиж өгөх

Дараа нь хамтын уншлага хийх

Эцэст нь бие дааж уншуулах гэх мэт

Бусдад унших уншлагыг байна нэг нэгээр нь уншуулж болох ч үүнийг хосоор, багаар, анги нийтийн уншуулах нь тэднийг айдсаас холдуулна. Эхний үед багш өөрөө, эсвэл сайн уншдаг сурагчийг дагуулан уншуулж аль болох тод чангаар зөв уншуулж зүгшрүүлэхийг зорих хэрэгтэй. Сурагчдад сонирхолтой аудио, видео бичлэгийг дагуулан уншуулж болно.

Уран тод унших- Уншиж байгаа эхийн утга санаанд тохируулан аялга хэмнэл, зогсолт, хурд хэмжээг тохируулан амьсгалаа хуваарилж, дуу хоолойн өнгийг тохируулан нүүр царайны хувирал, дохио зангаа ашиглан уншихыг хэлнэ. Уран уншлага бол утгыг ойлгож ухамсартай уншихтай нягт холбоотой. Гэхдээ уншиж сурч байгаа үед уран уншихаас илүү өөртөө илтгэлтэй, тод чанга дуугаар уншихыг нь дэмжих хэрэгтэй.

Тод чанга дуугаар уншихад сургах бичлэгийн холбоосоор орж танилцаарай.

http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/05_oilgoj_uran_unshih_1.pdf

Ухамсартай уншлага нь уран уншлагын бэлтгэл болдог бол зөв унших нь уншиж буй зүйлээ сайтар ойлгоход тусалдаг харилцан холбоотой үйл ажиллагаа юм. Уран уншихад утгын өргөлт





гаргах, их, бага зогсолт гаргах, уншлагын хурд, өнгө аялга зэрэг чухал үүрэгтэй байдаг. Уран тод уншуулж сургахын тулд эхлээд үг, өгүүлбэрийг тод уншиж сургах, аажимдаа урнаар уншуулж сургах хэрэгтэй. Уран уншлагыг дараах хэлбэрээр хийж болно: Үүнд:

1. Цээжилсэн шүлэг, магтаалыг уншихдаа шүлгийн утга санааг сонсож байгаа хүмүүст яаж хүргэх нь зохистойг зөвлөх хэрэгтэй.
2. Үлгэр, өгүүллэгийн баатрыг сурагчдаар сонгоуулан эхээс төлөөлөн уншуулж болно. Энэ нь дүрийн тоглолтын бэлтгэл болно. Жишээ нь: “Долоон ногоон өндөгтэй доголон шаазгайн үлгэр”-ийн үнэг, шаазгай, хулганын дүрийг сонгосон хүүхдүүд тэдний хэлдэг үгийг цээжилж уран тод хэлж сурсан байна.
3. Нэг сурагч зохиолын хэд хэдэн баатрыг төлөөлөн уншиж болно. Энэ тохиолдолд дүр бүрийн онцлогийг гарган уншихын хичээллэнэ. Жишээ нь: дээрх үлгэрийг уншихаар бол үнэгний зальжин, дээрэнгүй байдал, шаазгайн аймхай байдал, хулганын аргатай, ухаантай байдлыг харуулахаар дуу хоолойн өнгийг гарган уншвал нэн сайн болно.

Сурахад тохиолддог гурван гол бэрхшээл. Хүүхдийн суралцахуйд, ялангуяа уншиж сурахад тохиолддог гурван бэрхшээл байдгийг судлаачид тогтоосон байдаг.

- ✓ Үгийн утгыг ойлгохгүй байх. Ийм учраас шинэ үг уншуулахдаа зураг, эсвэл холбоо үг, өгүүлбэр зохиолгож зэргээр үг бүрийн утгыг ярилцаж таниулахыг зорих хэрэгтэй. Жишээ нь: “Соёмбо бол Монголын ард түмний бэлгэ тэмдэг” гэдэг өгүүлбэрийг зургаан настай хүүхэд цээжлээд эргүүлэн хэлж чаддаг ч утгыг нь ойлгоход бэрхшээлтэй байна. Энэ өгүүлбэрийг уншуулсны дараа “Соёмбо гэж юу вэ?” гэж асуухад энгэрээ заагаад “Тэмдэг” гэж хариулж байсан баримт бий. Энэ өгүүлбэрийн хувьд соёмбо, бэлгэ тэмдэг зэрэг үгийг ойлгохгүй байгаа тул тайлбар хэрэгтэй, зургаан настай хүүхдэд тайлбарлахад ч амаргүй өгүүлбэр. Иймд унших эх, өгүүлбэрийг сонгохдоо энэ насны хүүхдийн нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт тохирсон байхыг чухалчлах хэрэгтэй.
- ✓ Хоёр дахь бэрхшээл бол “массгүй” буюу ямар ч төсөөлөлгүй байх. Уншиж байгаа зүйлийг харж, сонсож, үнэрлэж, амталж, хүрэлцэж мэдэрсэн бол ойлгоход бэрхшээлгүй. Ийм учраас цагаан толгойн үсэг таниулаад юутай төсөөтэй байгаа талаар нь ярилцаж, үсгийн дүрсийг тогтоолгох зорилгоор шагай, баримлын шавар зэргээр үсгийн дүрсийг бүтээлгэдэг нь үүнтэй холбоотой. Хүүхдийг үсэг бичигт эхлэн сурч байгаа үед нь үзсэн үсгийн хүрээнд тэдний ахуй амьдрал ойр, бодит утгатай үг хэллэг, өгүүлбэр, эхийг сонгон уншуулах нь зохистой байдаг.
- ✓ Шатлал алгасах. Нэг зүйлийг сураагүй байхад нь дараагийн зүйлийг заасантай холбоотойгоор мэдлэг, чадварын ялгаа үүсдэг. Зарим сурагч багшийн төлөвлөсний дагуу уншиж бичиж сурч байхад зарим нь бусдаасаа хоцорч үлддэг. Багш ийм сурагчийг ойлгож, хаана, юу мэдэхгүй үлдсэнийг нь оношлон тогтоож, тусгайлан ажиллах шаардлага гарна. Эсвэл зарим сурагч багшийн төлөвлөснөөс түрүүлж сурсан бол мөн ялгаатай ажиллах шаардлага гарна. Ийм тохиолдолд БСҮХ болон БМТТ-өөс боловсруулсан дасгал ажлын дэвтэр, цахим хичээл зэргээс сонгон тусгайлан ажиллуулж болно.

ДӨРӨВ. БИЧИЖ СУРГАХ

Бичүүлэх арга барил эзэмших нь мөн нарийн зүйл. Үсэг бүрийг бичих дэс дараа, технологи байдаг, бас хоорондоо ялгаатай. Үсгийг гараа салгахгүйгээр бичнэ, элементийн дэвтрийн шугамд тохируулж бичүүлэх тусгай техник бий. Бичих үед багш хүүхэд бүртэй тулж ажиллана. Гэтэл буруу бичээд, түрүүлж уншаад сурсан хүүхдийн буруу эзэмшсэн арга техникийг засах нь шинээр сурахаас илүү хүндрэлтэй, багшаас тэдэнтэй ажиллах өөр арга барил шаардсан ажил болдог. Гэхдээ эхлэн бичүүлж сургахдаа сурагчдын сарвууны жижиг булчин сайн хөгжөөгүй байдагтай холбоотой хүүхдэд тулгардаг гар нь өвддөг, хэт их хичээснээс амьсгал давхацдаг, ядардаг зэрэг бэрхшээлийг тооцон үзэх хэрэгтэй.

Цагаан толгойн үеийн нэг онцлог бол шинэ үсэгтэй танилцаж өдөр тутам бичих үйл хийдэг. Бичмэлээс хуулан бичих нь үндсэндээ үлгэр жишээ бичлэгийг дуурайн бичих үйл явц болно. Цагаан толгойн бэлтгэлийн үед эзэмшсэн зурлагуудыг ашиглан шинээр үзсэн үсгийг бичиж сурна. Ихэнх багш нар сурагчдын дэвтэр шинээр бичих үсгийг бичиж өгдөг бол зарим багш



хичээнгүй бичгийн дэвтэр ашиглах нь бий.

Цагаан толгойн үсгийг дэвтрийн хос шугамд бичих нь эхлэн сурч буй хүүхдэд үсгийн эхлэх, үргэлжлэх, төгсөх баримжааг авахад тустай байна. Үсгийн өндөр нам, ташууг зөв гарган бичихэд ийм шугам чухал үүрэгтэй байдаг. Хос шугамд жижиг үсэг нь 4мм, том үсэг нь 7,5-8мм орчим байна. Ийнхүү цагаан толгойн үсэг бичүүлж сургах дараар аргыг багш нар түгээмэл хэрэглэдэг. Үүнд:

1. Тооллын /тактын / арга: Эхний үед үсгийн зурлагын тоогоор тоолж бичүүлнэ. Дараа нь үеийн тоогоор бичүүлж болно. Эл аргыг хэрэглэснээр ангийн сурагчдын бичгийн хурд жигд болно. Хэт хурдан элемент муутай бичдэг хүүхдийн бичлэгийг тогтоох, удаан бичдэг хүүхдийн бичих хурдыг нэмэгдүүлнэ. Мөн дэгийн дагуу сайхан бичдэг болоход хүүхдийн гарын хөдөлгөөнийг зөв зохицуулахад тусална. Энэ аргыг нэг цагийн хичээл дээр удаан хугацаагаар хэрлэх нь үр дүнгүй, өөр аргатай хослуулан явуулах нь зохимжтой.

2. Баримжааллын арга: Үсгийн дүрсийг сурагчдад харуулаад хэлбэрийг нь хүүхдэд нүдлүүлэн ярилцах, дэвтэрт бичүүлэхийн өмнө агаарт бичих хөдөлгөөн хийх, хөдөлгөөнөө сурагчдаар дуурайлгах, самбар, эсвэл том цаасан дээр үсэг бичээд дээгүүр нь дагуулан бичүүлэх зэргээр тухайн үсгийн эхлэл, үргэлжлэх байдал, төгсгөл, мөн бичих маягийг гарт нь баримжаа болгох дасгал хийлгэсний эцэст бичүүлнэ гэсэн үг.

Эхлэн бичүүлж сургахад бичмэл үсэг тус бүрийг бүтээх зурлага, үсгийн дүрс хэлбэрийг хэрхэн бичих, бусад үсэгтэй холбох, үсгийн налуу ташууг яаж зөв гаргах аргуудыг анхнаас нь хүүхдэд зөв зааж бичих дадал эзэмшүүлснээр хичээнгүй сайхан бичиж сурах эхлэл тавигдана. Багш шинээр үсэг бичүүлэхийн өмнө үлгэр жишээ бичлэгийг сурагчдад үзүүлж, үсгийн зурлага тус бүрийг хаанаас эхэлж, ямар шугамд тааруулж бичих журмыг багш самбарт бичиж үзүүлнэ. Үүний тулд самбарт хос шугам зурж бэлтгэсэн байх хэрэгтэй. Дараа нь эдгээрийг нийлүүлэн үсэг болгон бичих жишээг багш мөн самбарт бичиж үзүүлнэ. Үүнийг алхамчлан тайлбарлавал:

1. Багш эхлээд бичмэл үсэг, мөн үсгийн зурлагыг үлгэрлэн бичиж, сурагчдад үзүүлж, бичмэл үсэгтэй танилцуулна. Мөн дармал үсэгтэй нь харьцуулан ялгааг ярилцана.

2. Үсгийн зурлага хаанаас нь эхэлж, ямар шугамд хэрхэн тааруулан бичих журмыг багш, самбарт бичиж үзүүлнэ. Ийм учраас багш самбарт хос шугам татан бэлтгэсэн байх шаардлагатай. Багш үүнийг харуулж тайлбарлахдаа самбарыг биеэрээ халхлахгүй зогсож, хаанаас эхлэн ямар шугамаар бичиж, хаана дуусгахыг харуулахын зэрэгцээ тайлбарлан ярьж байж бичнэ. Мөн заримдаа агаарт дүрсэлж ч үзүүлнэ.

3. Эдгээр зурлагыг нэгтгэн үсэг болгон бичихийг үлгэрлэн үзүүлнэ. Сурагчид шинэ үсгээ дэвтэр дээрээ бичнэ.

4. Мөн тэр үсгийг үг, өгүүлбэрт оруулж бичих, үүнд багш самбар дээр үг бичихдээ үсгүүдийг хооронд нь яаж холбох, хоёр үгийн хооронд ямар хэмжээтэй зай үлдээх зэргийг сурагчдад бүрэн ойлгуулсны дараа бичүүлнэ. Тэгээд уншиж ярилцсаны дараа сурагчид дэвтэртээ яаралгүй сайхан бичнэ.

Энэ талаар монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжаас¹¹ дэлгэрүүлэн уншаарай.

Сурагчдыг шинэ үсэг, үе, үг, өгүүлбэр бичиж байгаа үед хурдан бичихийг шаардаж болохгүй. Их бага ямар боловч бичих ажлыг хийлгэж гүйцсэний дараа өөрсдөөр нь уншуулж хянуулах ба бүгд ижил зүйлийг бичсэн тохиолдолд нэг сурагчаар уншуулж, бусад бичсэнээ түүнтэй тохируулан шалгаж болдог. Нэгдүгээр улиралд нэг хичээлд хоёр мөрөөс илүү бичүүлэх шаардлагагүй. Дундаж бичдэг хүүхдийн хувьд энэ хоёр мөрийг бичихэд бараг 5-10 орчим минут зарцуулах болно. Гэрийн даалгаварт ч их зүйл бичүүлэх шаардлагагүй. Зарим багш сурагчдад нүүр нүүрээр нь бичих даалгавар өгдөг нь сайхан бичиж сургахаас илүү бэрхшээх, бушуухан дуусгахын тулд хааш яаш бичихэд хүргэдэг. Гэрийн даалгавар хэтэрхий их байвал хүүхэд удаан сууж ядраад, сонирхол нь буурч алдаатай, муухай бичихэд хүрдэг. Бичих даалгаврыг бага хэмжээтэй өгч, харин түүнийг маш зөв, нямбай, цэвэр бичүүлэх нь чухал.

Сурагчдын бичих чадвар нэмэгдэх тусам бичих зүйлийн хэмжээг аажмаар (1 мөрөөр)



нэмэгдүүлэх хэрэгтэй. Сурагчдын бичих чадвар харилцан адилгүй тул бичих дадал хурдан эзэмшиж байгаа болон хоцорч байгаа сурагчидтай ялгаатай ажиллах хэрэгтэй. Өөр нэг анхаарах асуудал бол солгой гараар бичдэг хүүхэдтэй ялгаатай ажиллах хэрэг гарна. Дэвтэр тавих, үзэг барихаас эхлээд бусад хүүхдээс ялгаатай байна.

Бичүүлж сургахдаа багш юу анхаарах вэ?

- Бичих даалгаврын хэмжээг ихдүүлж болохгүй. Нүүр нүүрээр нь бичүүлэхийн орон бага зүйлийг зөв, анхааралтай бичүүлж сургахыг анхаарах хэрэгтэй. Хүүхдийн сарвууны жижиг булчингийн хөгжилтэй холбоотой тэд гоё сайхан бичиж чадахгүй. Харин үсгийг зөв бичиж, үүнийгээ мартаггүй уншиж чаддаг байх нь чухал.
- Зарим үсэг уншиж бичихэд хялбар /Лл, Мм, Нн, Оо, Өө.../ бараг үндсэн дүрс нь ижил, ойролцоо байдаг бол зарим үсэг 3-4 өөр дүрс хэлбэртэй байдаг. Жишээ нь Аа, Бб үсэг дармал болон бичмэл том жижиг үсэг тус бүр өөр дүрстэй. Олон дүрстэй үсгийг уншуулж бичүүлэхэд арай илүү цаг зарцуулах шаардлага гарна.
- Зургаан настай хүүхдийн анхаарал төвлөрөх хугацаа 7-10 минут байдаг тул ангид бичих даалгаврыг энэ хугацаанаас хэтрүүлж болохгүй. Гэрт ч бичих даалгаврыг хэтрүүлж болохгүй. Үсгийг аль болох зөв, нямбай бичихийг шаардаж болно.
- Цээжээр бичүүлж бичмэл үсгийг нүдэлсэн эсэхийг нь шалгаж болох ч үүнийг хэтрүүлж болохгүй. Хичээл бүрээр 2-3 минут байхаар Өдөрт бага багаар

Зөв бичих, цэг тэмдэг бичихэд сургах бичлэгийн холбоос, QR код

http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/07_zuv_bichih_1.pdf/



Уншиж бичиж сурахдаа сурагчдын гаргадаг нийтлэг алдаа:

	Сурагчдын гаргадаг алдаа	Алдааны жишээ	Алдаа гаргадаг шалтгаан	Анхаарах
Ярих	Ойролцоо дуудлагатай авиаг сольж дууддаг	с-ш, г-х, р-л, м-н, ж-з, ц-ч		Тухайн авиаг хурц тод хэлэх дасгал, хэл зүгшрүүлэх үг, түргэн хэллэг хэлүүлэх
Унших	Үсгээ таньдаг ч холбож чаддаггүй	м-а, м-а, м-а ...	Үе нүдлээгүй, унших арга техник эзэмшээгүй	• 1-2 үетэй богино үгийг нүдэлж тогтоон бүтэн үгээр уншиж сургах • Урт үгийг хэлж чадах хэмжээгээр цөөн үелж уншихыг нь дэмжих • Хичээл бүрээр уншлагын өмнө хүнд, шинэ үгийг тусгайлан таниулж бэлтгэх • Ойролцоо бичлэгтэй үгийг харьцуулан ялгааг олож унших дасгал хийх
	Ихэнх үгийг үсэглэж уншдаг	М а - н - м а н - д - манд-а- манда-л-мандал	Унших буруу арга техник эзэмшсэн	
	Ойролцоо дуудлага, дүрстэй үсгийг сольж уншдаг.	/г-т, и-н, д-т/	Юмсын ижил төстэй шиж чанарыг ялгах чадвар сул хөгжсөн байдаг.	
	Тааж уншдаг	Лаа- "гэрэл"/ "чийдэн"	Үсгээ бүрэн нүдлээгүй утгачлан тогтоосон	
	Баганын үгийг цээжилдэг	энд тэндээс уншихаар алддаг.	Баганын үсгийг дэс дарааллаар нь цээжилсэн.	
Бичих	Үсгийг эргүүлж бичдэг	С-Э, Я-Р, З-Е	Харааны линз нь бүрэн эргээгүй байдаг.	Ийм үсэг орсон үгийг харьцуулан ялгааг олж дахин дахин бичүүлэх
	Үсгийн холболтыг буруу бичдэг	М-үсгийг буруу холбовол үсэгтэй адил болдог.	Тухайн үсгийг заах үедээ холбоосыг нь сайн ойлгуулаагүй	Өмнөө жижиг холбоос хийж бичдэг М, Л, Я үсгүүд, а, э, о үсгийн холболтыг зөв бичихэд анхаарах
	Үсэг хоорондын зайг буруу бичих	Хоорондын зайн хэт хол, эсвэл хэт ойр	Эхнээс нь үсэг хоорондын зайг сайн ойлгуулаагүй	Үгийн үсэг хооронд нэг үсэг бичихээр зай байхаар бичиж сургах
	Буруу бичих	Бороо- Дороо	Үсгээ бүрэн нүдлээгүй	Үсэг

ТАВ. ҮНЭЛГЭЭ

Монгол хэлний сургалтын үр дүнг “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур¹²”-ыг баримтална.

Энэхүү шалгуурт нэгдүгээр ангийн монгол хэлний хичээлийн суралцахуйн үр дүнг “Сурагч үсэг, бичигт эхлэн тайлагдах, эх хэлээрээ зөв ярьж, бие биедээ хүндэтгэлтэй сонсох, бүтээлчээр



уншиж, бичи чадвар эзэмшиж, эх хэлээ сонирхон судлах хүсэл эрмэлзэлтэй болно” гэж тодорхойлсон бөгөөд сургалтын хөтөлбөрийн “Үсэг бичигт эхлэн суралцах үе” хэсгийн агуулгыг үнэлгээний дөрвөн нэгж, “Цагаан толгойн дараах үе” хоёр хэсгийн агуулгыг үнэлгээний хоёр нэгж болгожээ. Үүнд:

Үсэг бичигт эхлэн суралцах үе	Цагаан толгойн дараах үе
1. Сонсож ойлгосноо харуулах 2. Унших арга барил эзэмших 3. Бичих арга барил эзэмших 4. Алдаагүй бичихэд суралцах	1. Уншаад ойлгох, уран унших 2. Өгүүлбэр эх зохиож бичих

Үнэлгээний нэгж бүр нь дараах 3 хэсгээс бүрдэх бөгөөд тэдгээрийн холбоо хамаарлын зургаар харууллаа.

1. Суралцахуйн үр дүн
2. Суралцахуйн үр дүнгийн шалгуур
3. Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин



Боловсролын үнэлгээний төвийн <https://ebook.eec.mn/books/200/#p=4> холбоосоор орж дараах шалгуур, зөвлөмжөөс монгол хэлний хичээлийн үр дүнг үнэлэх шалгуур болон шалгуурыг хэрэгжүүлэх зөвлөмжийг судлан хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Зөвлөмжид шалгуурын бүрэлдэхүүн хэсэг бүрийг нарийвчлан тайлбарлаж, хэрэгжүүлэх арга замыг тодорхой тайлбарласан болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Бага боловсролын сургалтын хөтөлбөр, 2019, 16-р тал
2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/244 тушаалаар батлагдсан хичээлийн жилийн бүтэц
3. “Монгол хэл 1” сурах бичиг, 2014 он, Бест Колор Интернэшнл ХХК., 12-13-р тал
4. “Монгол хэл 1” Багшийн ном, Бест Колор Интернэшнл ХХК., 2014 он, 13-р тал
5. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж I-V анги, 2019, 6-14
6. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж. 2019. I-V анги
7. Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх зарим арга хэрэгсэл Багш нарт зориулсан гарын авлага. УБ, 2018. 44-р тал
8. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж, 2019
9. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/180 дугаар тушаалаар баталсан
10. Бямбацэрэн, Г. (2020). Эх хэлний цагаан толгойд суралцахуйн онол, арга зүй, УБ, Амжа принтинг” ХХК.
11. Лхажуу, Г. (2007). Багшийн зөвлөмж. УБ, Содпресс ХХК, 1.25хх
12. Наранцэцэг, Ц. (2007). Нэгдүгээр ангийн цагаан толгой, монгол хэлний сурах бичиг зөвлөмж. 3,7 хх
13. Одсүрэн, П. (2020). Бага ангийн багш нарт Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж. УБ, Гоо дизайн ХХК.
14. Оюунцэцэг, Ш. (2009). “Зургаан настай суралцагч” гарын авлага. Урлах эрдэм ХХК. 25.0хх. 32-34, 53, 58, 74-73, 98, 108-110- тал
15. Оюунцэцэг, Ш. Хадаа, Ө. (2008). Монгол хэл Зургаан настай хүүхдийн сурах, сургах арга зүй. УБ. Урлах эрдэм хэвлэлийн компани, 74-92-р тал
16. Оюунцэцэг, Ш нар. Монгол хэл 1 Багшийн ном. УБ Адмон ХХК, 6.0хх 13. Шарав, С.П. Батчулуун (19941). Кирилл бичгийн цагаан толгой заах арга товч



2.3. МАТЕМАТИКИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөрийн зорилгыг¹ “Математикийн суурь мэдлэг, хэл сэтгэлгээнд суралцаж, асуудлыг тооцоолон шийдвэрлэх чадвартай, математикт суралцах хүсэл, эрмэлзэлтэй, байгаль орчинд ээлтэй хэрэглээг эрхэмлэх хандлагатай болсон байна” гэж тодорхойлжээ.

Дэлхий даяар технологийн дэвшилтэт эрин рүү шилжин орж буй энэ цаг үед тархи судлалын шинжлэх ухаан нь хүүхдийн математик сэтгэлгээг сургуулийн өмнөх жилүүдэд хөгжүүлэх, ялангуяа сургуулийн өмнөх болон сургуулийн бага ангийн шилжилт, залгамж холбоог сайтар анхаарч, ач холбогдол өгөх нь дараа дараагийн амжилтын чухал холбоос болно гэж үзэж байна. (Эриксон Институт, 2019. Орч Мягмар. Б нар)

Тиймээс багш нэгдүгээр ангийн математикийн сургалтын хөтөлбөрийн агуулгын залгамж холбоог судалж, хөтөлбөрийн зорилгыг хангахад чиглэгдсэн арга зүйн санаа бүхий нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтөд тулгуурлан сурагчдыг багаас нь математикт суралцах хүсэл эрмэлзэлтэй, асуудал шийдвэрлэх чадварт сургах хэрэгтэй. Мөн математик хэл харилцаанд сургах шаардлагатай. Иймээс энэхүү зөвлөмжид нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах, ээлжит хичээлийг төлөвлөн зохион байгуулах, хичээлээ үнэлж хөгжүүлэх дасгал даалгаврын санаа, математикийн хичээлд хэрэглэж болох тодорхой үйлүүд, багшийн анхаарвал зохих зарим зөвлөгөөг оруулсан болно.

Математик бидний амьдралд зайлшгүй хэрэгцээтэй гэдгийг илүү хялбархан ойлгуулах арга юу вэ гэдгийг л судалж, тэд орчин тойрныхоо юмсыг цэгцэлж, удирдлагын товчлуур товчиж байхдаа орон зай, зүг чигийн баримжааг мэдэрч, хаалга хаашаа хаагддаг, хоолонд хэдэн ширхэг төмс хэрэгтэйг тооцоолоход математик л хариулт өгч чадна гэдгийг мэдрүүлээрэй.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

1-р ангийн Математикийн сургалтын хөтөлбөр 15 суралцахуйн зорилттой бөгөөд дараах байдлаар судална.

Хүснэгт 1. Агуулгын тогтолцоо, түүнд харгалзах суралцахуйн зорилт ба заах цаг

1	Тоо тоолол	8	1-10 хүртэлх тооны бүтэц	18	20 хүртэлх тоо Нэмэх, хасах үйлдэл-I (1.1а,ж)
			10 дотор нэмэх, хасах 0-ийн чанар	14	
			Дараалан нэмэх, хасах	8	
			20 хүртэлх тоо	9	100 хүртэлх тоо Нэмэх, хасах үйлдэл-II (1.1а,ж)
			20 хүртэлх тооны нэмэх, хасах	6	
			100 хүртэлх тоо	6	
			100 хүртэлх тооны нэмэх, хасах	15	
2	Хэмжигдэхүүн	3	Хүнд, хөнгөн, багтаамж	7	Уртын хэмжээ, мөнгө, хүнд хөнгөн, шингэн/багтаамж (1.2в) Цаг хугацаа (1.2а)
			Уртыг хэмжих	4	
			Цаг хугацаа	5	
3	Геометр	2	Хэлбэр дүрс	7	Биет, дүрс, тэгш хэм (1.3а) Байршил, хөдөлгөөн (1.3б)
			Байршил хөдөлгөөн	8	
4	Өгөгдөлтэй ажиллах	2	Юмсыг нэг ба хоёр шинжээр ангилах	5	Карролын диаграмм (1.4а)
			Хүснэгтэд бүртгэх, диаграммыг унших, илэрхийлэх	4	Зурган диаграмм/пиктограмм (1.4б) Бүртгэл (1.4б)

Математикийн сургалтын хөтөлбөрийн хувьд хоорондоо уялдаа холбоотой агуулгуудыг нягтруулан нэг суралцахуйн зорилтоор илэрхийлсэн. Иймд нэг суралцахуйн зорилт нь хэд хэдэн нэгж хичээлүүдээр төлөвлөгдөж хэрэгжих юм. **Тухайлбал.** 8 + 5 нийлбэрийн утгыг олоход 10, 20 хүртэлх тооны үйлдэл гүйцэтгэх чадвар хамт хэрэглэдэх бөгөөд нэг суралцахуйн зорилт нь зөвхөн нэг нэгж хичээлийн хүрээнд судлагдах бус суралцагчид хичээлийн жилийн туршид тухайн эзэмших чадвараа тасралтгүй судлах, бататгах, хөгжүүлэх боломжтойг дараах хүснэгтээс харж болно.



Хүснэгт 2. Агуулгын өргөсгөл

Суралцахуй зорилт	Агуулгын өргөсгөл		
	10 хүртэлх тоо	20 хүртэлх тоо	100 хүртэлх тоо
1.1а.Зуу хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах	✓	✓	✓
1.1е.Тоон илэрхийлэл бичиж утгыг олох; нэмэх үйлдлийн байр солих, 0-ийн чанар хэрэглэх; үйлдлийн мэдэгдэхгүй байгаа (дүрсээр тэмдэглэсэн) гишүүний утгыг олох, математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдэг бичих	✓	✓	✓
1.1з. Энгийн бодлогыг загварчлах, бодох, хариуг шалгах, өгсөн загвар, зураг дүрслэлд тохирох энгийн бодлого зохиох	✓	✓	✓

Нэгдүгээр ангийн сургалтын төлөвлөгөөнд математикийн хичээлийг 29 долоо хоногт, долоо хоногт тус бүр 4 цаг, нийт 116 цаг судлахаар төлөвлөсөн. Иймд багш та сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг сайтар судалж, суралцагчдын математикийн нэр томьёо, дүрэм, чанар, хамаарал, зүй тогтлын талаар суурь ойлголттой болох, математик хэл харилцаанд суралцан асуудлыг загварчлах, төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэх, шалгах, үнэлэх, өөртөө итгэлтэйгээр санаа бодлоо илэрхийлэх, бусадтай хамтран ажиллах чадвар эзэмших, асуудлыг шийдвэрлэх арга барилд суралцахад дэмжлэг үзүүлээрэй.

Хүснэгт 3. Жишиг цагчилсан төлөвлөлт

Улирал 7 хоног	I улирал																II улирал									III улирал						
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7
Нэгж хичээл	Бэлтгэл	Байршил, хөдөлгөөн	1-5 хүртэлх тоо	6-10 хүртэлх тоо	Дүрсийг таних	Арав дотор тоог нэмэх, хасах	Дараалан нэмэх, хасах	20 хүртэлх тоо	20 хүртэлх тоог нэмэх	20 хүртэлх тоог хасах	Уртыг хэмжих	100 хүртэлх тоо	100 хүртэлх тооны нэмэх үйлдэл	100 хүртэлх тооны хасах үйлдэл	Цаг хугацаа	Хүнд, элэхүүн	Үйлдлийн нэг гишүүнийг нөгөө өгөгдөлтэй ажиллах	Нэгдсэн багтрал														
Судлах цаг																																
Суралцахуйн зорилт																																

Багш нар хөтөлбөрөө сайтар судалж, хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онцлог, аливааг өөр өөр хэлбэрээр олон давтаж ойлгох, асуудал тулгамдсан үед ямар тусламж дэмжлэг хэрэгцээтэй болох онцлог талуудыг урьдчилан тооцоолсноор сурах хүсэл дүүрэн сургуульд элсэн орж буй бяцхан шавь нарын суралцахуйг амжилттай чиглүүлэх, хөгжүүлэх боломжтой.

1. Хүүхдийн оюун ухаан, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих
2. Сурах арга барилд суралцуулах
3. Ахуй амьдралын математик тооцоог зөв хийдэг болох гэсэн нийтлэг үр дүнг хүлээгдэж байгаа тул математик ухагдахуун, тэдгээрийн шинж чанарыг ашиглан асуудлыг шийдвэрлэхүйц оновчтой төлөвлөлт чухал.

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ

Математикийн хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, зөвлөмж танд арга зүйн дэмжлэг үзүүлэх хөтөч болж чадна. Гэхдээ одоо цагийн дижитал эриний хүүхдүүд багаасаа л мэдээлэл технологи, компьютерийн хэл мэддэг байх хэрэгцээ үүсээд байгаа энэ цаг үед бид программын хэл заахгүй ч гэсэн цахим материал, сургалтын нээлттэй эх нөөцүүд ашиглан асуудал, үйл явдалд дүн шинжилгээ хийж сурах, аливаа зүйлийг аль болох шинжлэх ухаанчаар харж хандах, бүтээлчээр сэтгэх чадварыг нэмэгдүүлэн тулд тухайн насны онцлогт тохирсон суралцахуйн зүй тогтолд нийцсэн **дидактик тоглоомын** арга зүйгээр сургалтаа төлөвлөж, зохион байгуулах, бие даан суралцахад нь чиглүүлэг, дэмжлэг өгч ажиллах боломжтой юм.

Математикийн хичээлээр сурагчдын сурах арга барил, хэв маягийг харгалзан сургалтын үйл ажиллагааг бодит юмс дээр ажиллах, бодит юмсын зураг, дүрслэл, загвар дээр ажиллах, хийсвэр үйл хийх гэсэн үе шатын дагуу зохион байгуулна. Багшийн хувьд сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэйг математикийн сургалтын хөтөлбөрт² тусгасан байна. Үүнд:






- Сургалтын зорилго, зорилтыг сурагчийн хэрэгцээ, мэдлэг, чадварт баримжаалан тодорхойлох
- Судлагдахууны агуулгад тогтолцоо шинжилгээний үүднээс хандах, дидактик нэгжийг томсгох, нягтруулах, интеграцчилах

Сурагчдын хувьд математик хэл, тэмдэглэгээг ойлгож, өөрийн санаа бодлоор илэрхийлэх нь чадвар эзэмших нь шинээр гадаад хэл сурахтай адил тул багш унших, сонсох, бичих, ярих чадварыг дэмжих хэрэгтэй. Мөн багшийн анги зохион байгуулалт, **дөхүүлэх асуултыг** багш оновчтой төлөвлөх, алдаа болон буруу төсөөллийг эерэг байдлаар засах боломжийг хайх хэрэгтэй. Мөн танин мэдэхүйн зүй тогтолд нийцсэн үйлийн баримжааг тодорхой, гүйцэд, асуудалд зөөж хэрэглэх боломжтой байхаар бодит юмс, түүнийг загварчлан жиших, харьцуулах, үйлдэл гүйцэтгэхэд чиглэгдсэн байхаар ТДХ (тодорхой, дүрслэл, хийсвэр) арга зүйг хэрэглэхийг зөвлөмжилж байна.

ТДХ гэдэг нь дээрх зүй тогтлын түвшнийг илэрхийлэх “Тодорхой”, “Дүрслэл”, “Хийсвэр” үгийн товчлол юм.

Бага ангийн сурагчдын математик чадварыг хөгжүүлэх ТДХ арга зүй нь хүүхдийн өмнөх мэдлэг дээр нь суурилан бодит юмс, биет зүйл ашиглан математикийн хийсвэр ухагдахууныг таниулах арга зүй юм. **Жишээ нь.** 10 хүртэлх тоог таниулахдаа жимс, хүнсний зүйлийг тоолох, дараа нь тэдгээрийг нэгэн ижил шоогоор төлөөлүүлж тоолох, үйл ажиллагаа хийснээр ямар ч бодит юмсыг нэгэн ижил загвараар илэрхийлж болохыг ойлгоно. Үүний дараа уг тоог илэрхийлж болох цифртэй танилцаж, уншиж, бичиж сурна. (<https://vimeo.com/584146014>)



ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

Сургалтын агуулга, хөтөлбөр, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор судлагдахуун тус бүрийн суралцахуйн удирдамж боловсруулагдсан. Суралцахуйн удирдамжид суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх сурагчдын сурах үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэглэдэхүүнийг санал болгосон. **Тухайлбал:**



Танхимын сургалтад дэмжлэг үзүүлэх хэрэглэгдэхүүн	- “Математик I” сурах бичиг, 2020 он (medle.mn) - Бага боловсролын сургалтын хөтөлбөр, 2019 он (meds.gov.mn/curriculum-baga) - “Математик” хичээлийн зөвлөмж ба суралцахуйн удирдамж, 2019 он (mier.mn)
Цахим сургалтад дэмжлэг хэрэглэгдэхүүн	- “Математик”-ийн 38 теле хичээл (medle.mn) - “Математик I”-ийн 12 интерактив хичээл (medle.mn) - Үлгэр, бяцхан түүхүүд” 3 нэмэлт контент (medle.mn)
Бие даан суралцах ажлын дэвтэр	http://content.mier.mn/ - Тоо тоолол, асуудал шийдвэрлэх - Хэмжигдэхүүн, асуудал шийдвэрлэх - Геометр, асуудал шийдвэрлэх - Өгөгдөлтэй ажиллах, асуудал шийдвэрлэх
Бусад	1. Хуваарьтай тууз болон шугам: Тоог нэмэгдүүлэх, хорогдуулах, тоон шулуун дээр тэмдэглэх, үйлдэл гүйцэтгэхэд ашиглах тууз, шугам 2. Ам дөрвөлжин цаас: Тоо, дүрс таниулах цаасан нугалмал загварчлал 3. 100 хүртэлх тоотой танилцах үед аравт, нэгж зуут бүтээх тоолох хэрэгсэл 4. Тоолох хэрэгслүүд: Тоолж сурах, нэмэх хасах үйлдэл гүйцэтгэх, аравт, нэгж зуут бүтээх хэрэгсэл (лего, ундааны бөглөө, товч, шагай, хавтан загвар)



Багшийн төлөвлөх суралцахуйн үйл ажиллагаа нь суралцагчдын идэвхтэй бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлаж байж хичээл амжилттай зохион байгуулагддаг. Иймд суралцагчдыг идэвхжүүлэх хэрэглэгдэхүүнийг танин мэдэхүйн хөгжлийг дэмжсэн, бие даан гүйцэтгэхэд сонирхолтой, дүгнэлт гаргах, өөртөө болон бусдыг үнэлэхэд боломжтой талыг судалж, туршиж, бэлтгэнэ. Жишээ нь.

Цифрийн орны утгыг таниулахад:

Аравт	Нэгж
3	4



ҮНЭЛГЭЭ:

Бага боловсролын математикийн хөтөлбөрт сургалтын үнэлгээний зорилт, шалгуур, жинг ерөнхий байдлаар тодорхойлсон байдаг. Хөтөлбөрийн үнэлгээний зорилтыг “Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх үнэлгээний шалгуур”-ын танин мэдэхүйн түвшний шалгууруудтай (мэдлэг ойлголт, мэдлэгээ холбон хэрэглэх, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх) уялдаа холбоотой авч үзнэ. Тухайлбал: “Тоо тоолол ба асуудал шийдвэрлэх” үнэлгээний нэгжийн нэг дэх суралцахуйн үр дүн нь 1.1. 1.2. 1.3. гэсэн суралцахуйн үр дүнгийн шалгуураар тодорхойлогдоно.

Бага боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур (www.ebook.eec.mn), шалгуурыг хэрэглэх зөвлөмжийг сургалт үйл ажиллагаандаа ашиглаарай. Мөн явцын үнэлгээг тогтмол ашиглах чухал.

БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨН

Зорилго: Орон зай (дээр, доор, хойно урд), чиглэлтэй холбоотой(баруун, зүүн) үг хэллэг хэрэглэн юмсын байршил, чиглэл хөдөлгөөнийг тайлбарлаж, 1.3б. суралцахуйн зорилтыг хэрэгжүүлнэ.

Мэдлэг	Чадвар	Хандлага
A1. Математик үг хэллэг ойлголт (Наана цаана, дээр доор, баруун зүүн, өндөр нам)	B1. Математикийн мэдлэг ойлголтоо танил бус нөхцөлд хэрэглэх (Наана цаана, дээр доор, баруун зүүн, өндөр нам үгсийг мэдэх хэрэглэх)	B1. Сонирхол идэвх оролцоо Математикийн мэдлэгээ өдөр тутмын ахуй амьдралдаа хэрэглэх, өөртөө итгэх итгэлтэй болох

Тооны дугаарлал, тоо тооцоолол агуулгыг судлах бэлтгэл болгож орон зай, зүг чигийн баримжааг ахуй амьдралын хэрэгцээнд тулгуурлан тоглоом, үлгэр яриагаар дамжуулан наана, цаана, дээр доор, баруун зүүн, өндөр нам ойлголтуудыг олгоно. Жишээ нь: Бэлтгэл хөтөлбөрийн үед “Эвтэй дөрвөн амьтан”, “Манжин” зэрэг сонголтыг оновчтой хийж, үлгэрийн ертөнцөөр аялна. Хүүхдүүдийг дэргэд, хажууд нь зогсоож, хаана байгааг нь бусдаар хэлүүлэх, төрөл бүрийн үлгэрийг зургийг хэсэгчлэн хувааж эвлүүлэх тоглоом бэлтгэн ашиглах зэргээр тоглоомын үйлд тулгуурлана.

№	Нэгж хичээл	Суралцахуйн зорилт	цаг	№	Ээлжит хичээлийн сэдэв	Зорилго
1	Байршил, хөдөлгөөн	1.3б. Орон зай, чиглэл, хөдөлгөөнтэй холбоотой үг хэллэг хэрэглэн гэр, сургуулийн орчин дахь юмс, аюулгүй тоглоох зорчих замын байршлыг хэлэх	5	1	Наана цаана, дээр доор-1	Наана цаана, дээр доор /хол ойр/ зэрэг үг хэллэгийг мэдэх, хэрэглэх тайлбарлах
				2	Наана цаана, дээр доор-2	Гэр, сургуулийн орчин дахь юмсын байршлыг дээрх үг хэллэгийг ашиглан хэлэх тайлбарлах
				3	Өмнө хойно, баруун зүүн	Өмнө хойно, баруун зүүн гэдэг үгийн утгыг мэдэх, хэрэглэх тайлбарлах
				4	Өмнө хойно, баруун зүүн	Гэр, сургуулийн орчин дахь юмс зорчих замын байршлыг орон зай, байршлыг заасан үгс ашиглан хэлэх тайлбарлах
				5	Өөрийн гөө сорих	Юмсыг наана цаана, дээр доор, өмнө хойно, баруун зүүн талд байрлуулах, зурах, тайлбарлах

Хичээлийн санаа: **Наана цаана, дээр доор**

Зорилго: Наана цаана, дээр доор /хол ойр/ зэрэг үг хэллэгийг мэдэх, хэрэглэх тайлбарлах

Алхам	Сурагчийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг	Анхаарах зүйл/Үнэлгээ
Хичээлийн зорилгыг ойлгох	Анги, сургуулийн орчин ажиглалт хийнэ. Танай гэр аль чиглэлд байдаг вэ? гэх мэтээр ярилцана.	Багш сурагчдын өмнөх мэдлэг, чадварыг оношилсон байна.
Орон зай, чиглэлтэй холбоотой үг хэллэгийг ялган таних	Орон зай, чиглэлтэй холбоотой “хол ойр, наана цаана, дээр доор, өмнө хойно, баруун зүүн” гэх мэт үг хэллэгийг бодит юмс, хөдөлгөөнт үзүүлэн, зураг ашиглан таниулна. Асуулт: Хаана юу байна вэ? - Багш хаана зогсож байна вэ? - Самбарын цаана юу байна вэ? - Модны цаана юу байна вэ? - Модны наана юу байна вэ? - Ширээн дээр юу, юу байна вэ? - Ширээний доор юу байна вэ? - Ямар амьтан хамгийн хол харагдаж байна вэ? - Ямар амьтан ойр харагдаж байна вэ? гэх мэт	Зөвхөн нэг сурагч л зөв хариулт түрүүлж хэлээд, яриад байх үед сурагчдад хүлээх цаг гаргах, ээлжээр ярих, өөрийн санаагаа бусадтай хуваалцаач гэж хүснэ.
Зааврын дагуу өгсөн чиглэлд дүрс зурах	Багшийн зааврын дагуу даалгавар гүйцэтгэнэ. 1. Нар хаана байрлах вэ ? 2. Тэнгэрт нарнаас өөр юу байх вэ? *Бид сая нар зурсан ,тэгвэл одоо юу зурах бол /Яагаад?/ ярилцана. 3. Хамгийн доор өвс ногоо зураарай 4. Голд нь байшин зураарай 5. Байшингийн цаана мод зураарай 6. Модны наана мөөг зураарай	Гэрлэн дохионы арга: Улаан өнгөөр: Ойлгоогүй. Шар өнгөөр: Дэмжлэг хэрэгтэй. Ногоон өнгөөр: Ойлгосон Багш дээрх хэлбэрээр хариу мэдээллийг авч, хүүхэд бүрт тохирсон чиглүүлэг, дасгал даалгаврыг өгч ажиллуулна.
Зааврын дагуу үйлдлийг гүйцэтгэх	Зааврын дагуу дасгал гүйцэтгэнэ. Юмсыг байршуулах Урагшаа, хойшоо алхах, гараа дээш өргөх, доош буулгах	Сурагчид хариу мэдээллээ гэрлэн дохио өргөж, дасгал ажил бүрийн гүйцэтгэл дээр өнгөөр ялган тэмдэглэж өөрийн үнэлгээг хэрэгжүүлэх боломжтой.
Байршлыг хэлэх тайлбарлах	http://43.228.131.34/mieredu/bdsad2/math_baga/G31_Bairshil.pdf  Гэр, сургуулийн орчинд байгаа юмсын байршлыг асууж, ярилцана.	

Багшид зөвлөмж:

Аливаа юмсын байршил, орон зайг төсөөлөн бодох, дүрслэх, чадвар нь удаан хугацааны үйл ажиллагаа, үг хэллэгийг байнга ашиглах нь энэхүү ойлголтыг ялган танихад дэмжлэг болно. Хүүхэд баруун, зүүн зэрэг орон зайн байрлалд заримдаа будилдаг. Тиймээс хөдөлгөөнт тоглоом нь байршил, орон зайн баримжаатай болоход тусалж болох аргын нэг учраас хичээлийн агуулгатай холбоотой тоглоомоор баяжуулан сургалтаа зохион байгуулах боломжтой.

Дараах үнэлгээний шалгуурын хүрээнд даалгавар боловсруулж, нэгж хичээлийн үнэлгээг хийнэ.

Түвшин-I	Орон зай, чиглэл хөдөлгөөнтэй холбоотой үг хэллэгийг өгсөн зааврыг ойлгож, биелүүлдэг.
Түвшин-II	Орон зай, чиглэл, хөдөлгөөнтэй холбоотой үг хэллэг хэрэглэн гэр, сургууль, орчны юмсын болон аюулгүй тоглох, зорчих замын байршлыг тайлбарладаг.

АРАВ ХҮРТЭЛХ ТОО

Суралцахуйн зорилт: 1.1а. Зуу хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах


Зорилго: Нэгээс 10, 10-аас 0 хүртэл тоолох, 10 хүртэлх тоог таних, тооны бүтцийг мэддэг болох

Мэдлэг	Чадвар	Хандлага
10 хүртэлх тоо 10 хүртэлх тоог уншиж, бичиж, жишиж, эрэмбэлнэ - Дэс дугаар - Дараалал 10 хүртэлх тооны бүтэц	10 хүртэлх тооны юмсыг тоолох 10 хүртэлх тооны юмсыг дүрсээр загварчлах, тоон шулуун дээр тэмдэглэх - Их, бага гэсэн үгсийг хэрэглэн хоёр тоог жиших, тэдгээрийн хооронд орших тоог хэлж нэрлэх - Тоонуудыг эрэмбэлэх, бүтэн аравтаар тэмдэглэсэн тоон шулуун дээр байрлуулах, дэс дугаарыг таних, юмсыг дугаарлахад хэрэглэх 10 хүртэлх тооны бүтцийг хэрэглэн нийлүүлэх, нэгтгэх гэсэн үг хэллэгийг ойлгох утга санааг мэдэх 10 тооны бүтцийг цээжээр хэлнэ.	- Математикийн мэдлэгээ өдөр тутмын ахуй амьдралдаа хэрэглэх, өөртөө итгэх итгэлтэй болох - Математикийг судлах сонирхолтой болох
Агуулгын залгамж холбоо		
Өмнөх	Одоо	Дараах
СӨБ: Цифр таньдаг. 10 хүртэл тоолох	- Арав хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах 10 хүртэлх тооны бүтцийг мэдэх	- Арав дотор нэмэх, хасах - Хорь хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах, 20 хүртэлх тооны бүтцийг мэдэх

Тоо таниулах

Тоог таниулахдаа юмсыг тоолуулах, дармал, бичмэл цифр таниулах, агаарт бичүүлэх, дэвтэрт дуурайж бичих, нүдлүүлэх гэх мэтээр таниулж ирсэн.

Тухайлбал: 5-ыг таниулахын тулд өчнөөн арга хэрэглэсэн байгааг дээрх зургаас харж болно.



Загварчилсан, багцалсан, тоон шулуун дээр тэмдэглэсэн, бодит хэрэглэдэхүүнийг тоолсон гээд энэ олон аргаас хэдийг нь та хэрэглэдэг вэ. Өөрөө бусдад санаа болгох ямар арга танд байгаа вэ? Ганцхан зураг үзүүлээд орших нь хангалтгүй шүү дээ. Тиймээс өөрсдөөр нь бариулж, будуулж, зуруулж хийлгэвэл тэдгээр үйл нь үнэн бат мэдлэг болж үлдэнэ. Тиймээс бидэнд элбэг олдох ундааны савны бөглөө, зайрмагны иш мод зэргийг ашиглаад хүүхдэд илүү хялбархан ойлгуулах ямар боломж байгааг багш та эрж хайх л чухал.

Иймд танд дэмжлэг болохуйц арга зүйн болон хэрэглэгдэхүүний санааг тусган орууллаа. Багш та олон аргаар оновчтой хэрэглэдэхүүнээр дэмжих хэрэгтэй.

Орчин тойрны объектуудыг ашиглах арга

Танд хүүхдэд математик заахад шаардлагатай бүх зүйл байна. Товчнууд, аяга шаазан, ном, жимс, жимсгэнэ, өрөөний цонх, мод, машин гээд орчин тойронд бэлэн байгаа зүйлсийг тоолж болно. Бодит юмсын тоо ширхгийг тоолох, амьдралд байдаг зүйлсийг жишээ татан ярилцах, түүнийгээ загварчлах, цифрээр тэмдэглэх зэргээр суралцана.

Жишээ нь. 10-ийн цифр таниулахад “Амьдрал дээр 10 ширхэг байдаг зүйлсийг нэрлээрэй” гэсэн даалгавар дасгал хийлгэж болно. Гарын арван хуруу, хөлийн арван хуруу гэдгээс эхлээд л 10ш өндөг авлаа, 10 давхар байшинд амьдардаг гээд орчин тойрноосоо суралцах боломж хязгааргүй.




Орчин тойрны объектуудыг ашиглаж суралцах явцдаа математикийн хувьд чухал ач холбогдолтой ч бүх зүйл ижил төстэй байх албагүй гэдгийг заахад тань тусална. Алим, жүрж, тарвас зэргийг тоолохдоо 1, 2, 3-ийн тогтмол тоонуудыг ашиглахаас гадна янз бүрийн бусад зүйлтэй холбож, математик хэл, сэтгэлгээнд сургаж болно. Тухайлбал: Гурван аяга угаалаа. Түүнтэй тэнцүү тооны халбага хэрэглэсэн үү. Сандал ширээний аль нь олон бэ? гэх мэт.

Юмсын тоо хэмжээг аль болох амьдралд ойр жишээн дээр нь мэдрүүлэх чухал.









1-10 тооны бүтцийг таниулах

Амьдралд ойр жишээгээр тооны дугаарлалыг сайн мэдэж авсан бол одоо тооны бүтцийг сайн мэддэг байхад туслах аргыг санал болгоё.

Эдгээр дасгал нь тооны бүтцийг тогтоох, харааны ойг хөгжүүлэх, тоглох явцдаа математик харилцаанд суралцах боломжтой юм.



Жишээ нь. Есөн нүд бүхий хүснэгтийг өөр өөрөө будаарай. Энд буй есөн нүдийг будахдаа л есийн тооны бүтцийг давтана. (1 нь цагаан, 8 нь цэнхэр гэх мэт)



Дараах дасгалуудыг хийлгэж бүтцээ нүдлүүлэх, цээжлүүлэхэд ашиглаарай.

Дасгал. “Арав”-ын уулзалт зохион байгуулна. Хүснэгтийн дээд тоо, доод тоо нийлээд 10 болох ёстой. Тиймээс “Арав”-ын уулзалт зохион байгуулахыг санал болгож байна. Энэ хүснэгтийг нөхөхдөө яагаад арван ширхэгтэй өндөгний сав ашиглаж болох юм.


10	1	2	3	4	5	6	7	8	9	10



Дүрс зургаар, хавчаараар, эвлүүлдэг тоглоомоор хэрэглэгдэхүүн бэлтгэж тооны бүтэц цээжлэх, нүдлүүлэх боломжтой.

Математикийг тоглоом тоглох аргаар сурга

Амьдрал дээр математик заахад тус болох олон тоглоом бий. Бидний өвөг дээдэс тоглож байсан “Хуруу гаргах”, “Чулуу таалцах” тоглоом бол тооны бүтэц таниулах, тооны нийлбэр олох зэрэгт одоо ч үнэ цэнээ алдаагүй тоглоом шүү. Үүнтэй нэг адил “Тоон карт”, “Шоо”, “Эвлүүлдэг тоглоом”, орчин үеийн дэвшилтэт технологи ашигласан тоглоомууд ч 1-ээс 100 хүртэлх тоог таниулах, нэмэх, хасах үйлдэлд гүйцэтгэх, жиших гээд математикийг хэрэглээ болгох боломжийг олгоно. **Жишээ нь. “Хуруу гаргах”** тоглоом тоглохдоо их багыг жишнэ үү.



АРАВ ДОТОР НЭМЭХ, ХАСАХ

Зорилго: Нэмэх, хасах үйлдлийн утгыг ойлгон, үйлдлийг гүйцэтгэх 1.1в. 1.1е. 1.1з. суралцахуйн зорилтыг хэрэгжүүлнэ.

Мэдлэг, ойлголт	Чадвар	Хандлага
А1. Нэмэгдүүлэх, нийлүүлэх, ялгах, хорогдуулах, зөрөө, А2. Байр сэлгэн нэмэх, 0-ийг нэмэх, хасах	Б1. Нэмэх, хасах үйлдлийн мэдлэг, ойлголтоо танил ба танил бус үйлдлээ гүйцэтгэх Б2. Юмсыг тохирох зураглал, дүрслэлээр илэрхийлэх Б3. Оновчтой аргыг сонгох, төлөвлөх Б4. Тооцооллыг зөв гүйцэтгэх, тайлбарлах	В1. Сонирхол, идэвх оролцоо В2. Бүтээлчээр хандах байдал В3. Зааврын дагуу нягт нямбай гүйцэтгэх
Агуулгын залгамж холбоо		
Өмнөх	Одоо	Дараах
- Арав хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах 10 хүртэлх тооны бүтцийг мэдэх	- Арав дотор нэмэх, хасах - Тоон илэрхийлэл бичиж, утгыг олох - Нэмэх үйлдлийн байр солих, 0-ийн чанар хэрэглэх - Үйлдлийн мэдэгдэхгүй байгаа гишүүний утгыг олох - Математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдэг бичих - Энгийн бодлогыг загварчлах, бодох	20 хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах 20 хүртэлх тооны бүтэц, нэмэх, хасах үйлдлийг гүйцэтгэх

Агуулгын интеграц хийх боломж :

Өгөгдөлтэй ажиллах	Хэмжигдэхүүн	Геометр
Юмсыг нэг, хоёр шинжээр ангилах	Юмсын уртыг стандарт бус нэгж хэрэглэн жиших	Дөрвөлжин, дугуй, гурвалжин дүрсээр загварчлах

Хоёр буюу хэд хэдэн хэсэг юмсыг нийлүүлж нэг багц болгоод тоолохыг нэмэх үйлдэл гэж хэлж болно. Хоёр буюу хэд хэдэн хэсэг юмсыг эхлээд нэг хэсгийг нь тоолоод дараачийн хэсгийг үргэлжлүүлэн тоолох гэх мэтээр тоолохыг нэмэх үйлдэл гэж бас үзэж болно. Харин хасах үйлдэл бол нэмэх үйлдлийн эсрэг үйлдэл юм. 10 доторх тооны нэмэх, хасах үйлдэл гүйцэтгэхэд дугаарлалын мэдлэг, тооны бүтэц ашиглан үйлдэл гүйцэтгэж сургахад анхаар.

Интерактив хичээлийн арга зүйн санаа: 10 дотор нэмэх, хасах

Хичээлийн зорилго: Нэмэх, хасах үйлдлийн утгыг ойлгох

Алхам 1: Сэдэлжүүлэлт

Хүүхдэд танин мэдэхүйн хувьд сонирхолтой, сэдэл төрүүлэхүйц асуудлыг дэвшүүлнэ.

Хүнс хөвсөн түүх

Хязгааргүй уудам огторгуйг чимэн Иоп гарагийн хөлөг сансарт хөвнө. Тэнд Айдо, Мидо, Кидо нэртэй бяцхан цахим аялагчид эх дэлхийг зорин, эрдэм мэдлэгт суралцахаар зорчиж явна. Гэтэл гэнэт аялагчдын хөлөг онгоц дайвалзаж, хөргөгчинд байсан хүнснүүд агаарт жингүйдэн хөвж байна. Найзууд хүнсээ хурдан цуглуулж, цэгцлэх хэрэгтэй болно.

Алхам 2: 10 хүртэл тооны бүтцийг давтах

Хүүхдүүд хөргөгчний тавиур бүрт байх жимс, ногоог тохируулан өрөх хэрэгтэй болно.

Хүүхэд бүр хүнсээ өрөх явцдаа 10 хүртэл тооны бүтцийг бататган дасгал хийнэ.

Алхам 3: Нэмэх, хасах үйлдэлтэй танилцах

Найзууд хамтран ажиллах явцдаа нэмэгдүүлэх, нийлүүлэх үед нэмэх үйлдлийг, хорогдуулах, ялгах, зөрөөг олоход хасах үйлдлээр илэрхийлж тооцоолох аргад суралцаар байх болно.

Нэмэгдүүлэх	Хорогдуулах
Нийлүүлэх	Ялгах, зөрөөг олох

Бие даан ажиллах интерактив дасгалууд:

Хэрэглэгдэхүүн: Аравтын загвар, 10 ш алим, туслагч Бидо, дахин давтан сонсох боломжтой аудио, 0 – 10 тоонууд

№	Зорилго	Даалгавар	Тайлбар, үнэлгээ
1.	Нэмэх, хасах үйлдлийн байр солих, 0-ийн чанар	Илэрхийллийн утгыг олоорой. $10 - 5 =$ $4 + 3 =$ $0 + 6 =$	Энд арав хүртэлх тооны нэмэх, хасах үйлдэл сурагчдын ажиллах бүрт солигдож бодогдохоор төлөвлөсөн.
2.	Математик бичвэрийг үнэн байлгах тоог бичих	Мэдэгдэхгүй байгаа тоог олоорой. $? + 5 = 10$ $6 + ? = 6$ $8 - ? = 6$	Үнэлгээ: Дасгалыг зөв гүйцэтгэх бүрт Бидо урамшуулж, алдсан тохиолдолд дахин оролдох боломж олгосноор сурагчид бүх оролдлогыг хийж алдаагаа залруулахад суралцана.
3.	Бодлогын өгүүлбэрийн утгыг ойлгох, загварчлах, цээжээр тооцоолох аргад суралцана.	Бодлого бодоорой. Модон дээр 8 шувуу байна. 5 шувуу нисэж явлаа. Хэдэн шувуу үлдсэн бэ	

Нэмэлт дасгалууд:

1. Тоон картыг сонгож, бүтцийг блокоор харуулаарай. Тооны бүтцэд тохирох нэмэх үйлдлүүдийг бичиж, утгыг олоорой

7			
$6 + 1 = 7$	$3 + 4 = 7$		

ДАРААЛАН НЭМЭХ, ХАСАХ

Зорилго: 10 дотор хэд хэдэн тоог дараалуулан нэмэх, хасах үйлдлийг гүйцэтгэх 1.1в. 1.1е. 1.1з. суралцахуйн зорилтыг хэрэгжүүлнэ.

Мэдлэг, ойлголт	Чадвар	Хандлага
А1. Нэмэгдүүлэх, нийлүүлэх, ялгах, хорогдуулах, зөрөө, А2. Байр сэлгэн нэмэх, 0-ийг нэмэх, хасах	Б1. Дараалан нэмэх, хасах үйлдлийн мэдлэг, ойлголтоо танил ба танил бус үйлдлээ гүйцэтгэх Б2. Юмсыг тохирох зураглал, дүрслэлээр илэрхийлэх Б3. Цээжээр болон бичгээр тооцоолох тохиромжтой аргыг сонгох Б4. Тооцооллыг зөв гүйцэтгэх, тайлбарлах	В1. Сонирхол, идэвх оролцоо В2. Бүтээлчээр хандах байдал В3. Зааврын дагуу нягт нямбай гүйцэтгэх
Агуулгын залгамж холбоо		
Өмнөх	Одоо	Дараах
- Нэмэх болон хасах үйлдэл - Нэмэхийн байр солих чанар - Нэмэх болон хасах үйлдлийг бичгээр болон цээжээр гүйцэтгэх чадвар 10 хүртэлх тооны бүтэц	- Арав дотор нэмэх, хасах - Тоон илэрхийлэл бичиж, утгыг олох - Нэмэх үйлдлийн байр солих, 0-ийн чанар хэрэглэх - Математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдэг бичих - Энгийн бодлогыг загварчлах, бодох, зохиох	20 хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах 20 хүртэлх тооны бүтэц, нэмэх, хасах үйлдлийг гүйцэтгэх

Агуулгын интеграц хийх боломж :


Өгөгдөлтэй ажиллах	Хэмжигдэхүүн	Геометр
Юмсыг нэг, хоёр шинжээр ангилах	Юмсын уртыг стандарт бус нэгж хэрэглэн жиших	Дөрвөлжин, дугуй, гурвалжин дүрсээр загварчлах

Ээлжит хичээлийн арга зүйн санаа: Дараалан нэмэх


Зорилго: Суралцагчид хэд, хэдэн нэмэгдэхүүний нийлбэрийг бодит үйлдэлд тулгуурлан, загварчилж бодох, цээжээр бодох чадвараа хөгжүүлнэ.

Алхам	Сурагчийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг	Анхаарах зүйл Үнэлгээ
Хичээлийн зорилгыг ойлгох	Зургийн үйлдэл дарааллыг ажиглана. Сайтар ажигласны дараа бодлого зохиож ярилцана. Хүү хэдэн тоглоомоор тоглож байсан бэ? ... Хүүгийн тоглоом дээр хоёр найзын тоглоомыг нэмбэл нийт хэдэн тоглоомтой вэ? Мөн сурагчид олон төрлийн бодлого нээлттэй зохиож болно.	Багш сурагчдын өмнөх мэдлэг, чадварыг оношилсон байна. Суралцагчдын оролцоонд тулгуурлан зохион байгуулах Сурагчдын анхаарлыг төвлөрүүлэхүйц хэрэглэгдэхүүнийг бэлтгэх
Сурагчид бие даан эсвэл хамтран ажиллаж бодлогоо өөрийнхөөрөө бодох	Тодорхой түвшин: Тоглож байгаа хүүхдүүд Дүрслэлийн түвшин: Бодит юмсыг дөрвөлжин дүрсээр загварчилж буйг хүүхдэд илүү дэмжлэг болохуйц хөдөлгөөнт хэлбэрээр харуулж, хамтран ажиллана.  Үүний дараа сурагчдад өөрийнхөөрөө бодолтыг гүйцэтгэнэ.	Сурагчид үйлдэл дутуу орхигдуулж буйд анхаарах Зөвхөн нэг сурагч л зөв хариулт түрүүлж хэлээд, яриад байх үед сурагчдад хүлээх цаг гаргах, ээлжээр ярих, өөрийн санаагаа бусадтай хуваалцаач гэж хүснэ.



Хэрхэн бодсоноо хэлэлцэх (ялгаатай бодолтуудыг авч үзэх)	Багш зөвхөн асуулт тавихаас илүү хүүхдүүд хоорондоо асууж ярилцах боломж олгоно. Багш тулгуур асуултуудыг бэлтгэсэн ч болно. Энд хүүхдүүдийн гүйцэтгэлийг дараалан нэмэгдүүлэх дүрслэлтэйгээ холбоотой тайлбарлуулах хэрэгтэй. Асуултын жишээ: Миний бодолт энэ загварт тохирч байна уу? Чи яаж бодсон бэ? Би энэ аргыг сайн ойлгож байна. Чиний бодолт минийхтэй ижил байна. Хэн арай өөрөөр бодсон байна вэ?	Үнэлэх шалгуур: •Бодит юмсаар илэрхийлэх, үйлдлийг ойлгох •Загварчилж, дүрслэх •Үйлдэл гүйцэтгэх •Цээжээр бодох •Тайлбарлах зэрэгт анхаарч судлан, дараагийн хичээл төлөвлөлтөд уялдуулна.
Бататгах, дүгнэлт хийх	Нээлттэй бодлогыг бодуулна. /Сурах бичгийн хуудас 65/  Дүгнэлт хэсэгт: Нийлбэр 9 байх тоонуудыг хэлээрэй. Нийлбэр нь 9 гарах хэдэн боломж байна вэ? Ямар дарааллаар нэмбэл хялбар байна вэ? Хэд хэдэн тоог дараалан нэмсний дараа дахин сайн шалгах хэрэгтэйг анхааруулна.	Сурах бичгийн бодлого, дасгалыг сурагчдын ялгаатай байдалд тохируулж ажиллуулна. Хүүхэд бүрийн чадвар өөр өөр тул гэрийн даалгаврыг төлөвлөж өгөхдөө тоглоомын аргаар бататгах, цээжээр бодох чадварыг хөгжүүлэх байдлаар төлөвлөнө. Бодолтыг бичихэд цагаан самбарын аргыг хэрэглэх нь сурагчид чөлөөтэй сэтгэх, бодсоноо илэрхийлэхэд дэмжлэг болно.
Багшид зөвлөмж: Энэ хичээлийн үр дүн нь сурагчид нийлмэл бодлого бодох суурь болох юм. Сурагчид бодлогыг дутуу ойлгох, үйлдэл дутуу орхих зэрэг алдаа гаргадаг. Иймд бодит үйлийг загварчлахдаа өгөгдлийг дутуу орхигдуулахгүй дүрслэх, дараа нь тохирох үйлдлээр илэрхийлэх, хийснээ шалгаж ажиллана. Сурагчдыг ойлгоогүй үед багш давтан тайлбарлахаас илүү хамтран ажиллах боломжтой сонирхолтой дасгалуудыг ажиллуулах нь үр дүнтэй юм.		

Ямар нэгэн тоог 1-ээр нэмэгдүүлэхэд дараагийн тоо болно. 1-ээр хорогдуулахад өмнөх тоо болно. Нэмэх хасах үйлдэл оролцсон тооцоо хийхэд тоон шулуун дээр тайлбарлан ярилцаж, тэмдэглэж болно. 20-ийн доторх тоонууд дээр нэмэх (хасах) үйлдэл хийхэд тоон шулуун найдвартай туслагч болж чадна.



ХОРЬ ХҮРТЭЛХ ТОО

Суралцахуйн зорилт: 1.1а. 1.1б.

Зорилго: Нэмэх, хасах үйлдлийн утгыг ойлгох, үйлдлийг гүйцэтгэх аргад суралцана.

Мэдлэг	Чадвар	Хандлага
• 20 хүртэлх тоог • Хоёр оронтой тооны утга • Их, бага тоо • Хөрш тоо • Дэс дугаар • Бүтэн аравтаар баримжаална.	• 20 хүртэлх тоог унших, бичих •Юмсыг харгалзуулан жиших •Тоог тоон шулуун дээр тэмдэглэх •Өгсөн тооны хөрш тоог хэлэх, тэмдэглэх •Тоог тоон шулуун дээр тэмдэглэх, эрэмбэлэх •Юмсын дарааллыг тогтоон хэлэх, тайлбарлах •Тоог аравт, нэгжээр илэрхийлэх	• Бусдыг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх • Бие даан бодоход суралцах • Гүйцэтгэлд нягт нямбай хандах



Агуулгын залгамж холбоо		
Өмнөх	Одоо	Дараах
- Арав хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах 10 хүртэлх тооны бүтэц, нэмэх, хасах үйлдэл	- Хорь хүртэлх юмсыг тоолох, тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах 20 хүртэлх тооны бүтцийг мэдэх - Юмсын тоо, хэмжээг аравтаар баримжаалан хэлж, түүнийгээ тоолж шалгах	- Зуу хүртэлх юмсыг тоолох, тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах 100 хүртэлх тооны бүтцийг мэдэх - Юмсын тоо, хэмжээг аравтаар баримжаалан хэлж, түүнийгээ тоолж шалгах

Агуулгын интеграц хийх боломж :

Өгөгдөлтэй ажиллах	Хэмжигдэхүүн	Геометр
Юмсыг нэг, хоёр шинжээр ангилах, асуулт асууж хүснэгтэд бүртгэх, зурган диаграмм унших	Юмсын уртыг стандарт бус нэгж хэрэглэн жиших	Дөрвөлжин, дугуй, гурвалжин дүрсээр загварчлах

Хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүйн санаа:

Математикийн сургалтаар сурагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, бие даан суралцах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж, сурагчдын нас сэтгэхүй болон судлагдахууны онцлог, сургалтын орчныг харгалзан тодорхойгоос загварчлах, загварчлахаас хийсвэрлэх зарчмыг зүй зохистой хэрэглэх явдал юм. Хүүхдийн суралцах үйл явц нь үйл ажиллагаанд оролцож байж, өөрөө өгөгдөл, мэдээлэлтэй ажиллан, мэдлэгийг бүтээх нь илүү үр дүнтэй болохыг сэтгэл зүйчид тогтоосон. Сурагч өөрөө өгөгдөл мэдээлэлтэй ажиллаж, суралцах үйл ажиллагаанд оролцох нь мэдлэг бүтээхэд илүү үр дүнтэй. Иймд багш хэрэглэгдэхүүнийг хүрч мэдэрч, зурж дүрсэлж, тооцоолох, мөн хувирган өөрчилж бусад агуулгатай интеграцчилан хэрэглэж болохуйц бэлтгэх шаардлагатай юм. Тухайлбал 20 хүртэлх тоотой танилцах хичээлийн явцад сурагчид тоог аравт нэгжээр задлан, тооны орны утгыг ойлгосноор нэмэх, хасах үйлдлийг гүйцэтгэх, цээжээр тооцоолох суурь чадварыг эзэмшдэг. Дараах хэрэглэгдэхүүнийг хичээлийн агуулгатай уялдуулан хэрэглэх боломжийг өргөжүүлж, сурагчдад сонирхолтой хэрэглэгдэхүүн боловсруулах туршлагаа солилцон ажиллаарай.

Хэрэглэгдэхүүн-1.

Заавар: Аравт, нэгжийн 2 шоог хаяна. Буусан шооны нүдэнд тохирох аравт нэгжийн загварыг хүснэгтэд өрж, тохирох тоог дугуйлна. Аравт -2ш, нэгж -10ш, маркер

10	15	3	9	17	2
1	Аравт		Нэгж		13
18					19
6					14
16					20
8	11	4	12	7	5

Багаар хамтарч ажиллана.Өөрийгөө болон бусдыг хянахдаа загвараа тоолж шалгана.

Хэрэглэгдэхүүн-2. Сурагчдад ойлгоход дэмжлэг үзүүлэх, хүндэвтэр агуулгыг судлах явцад цахим хэрэглэгдэхүүний сонгох нь сурагчдад сонирхолтой, илүү өргөн боломжтой, цагийг хэмнэх үр дүнтэй.

Багаар хамтарч ажиллана.Өөрийгөө болон бусдыг хянахдаа загвараа тоолж шалгана.

Хэрэглэгдэхүүн-2. Сурагчдад ойлгоход дэмжлэг үзүүлэх, хүндэвтэр агуулгыг судлах явцад цахим хэрэглэгдэхүүний сонгох нь сурагчдад сонирхолтой, илүү өргөн боломжтой, цагийг хэмнэх үр дүнтэй.

Программын линк: https://phet.colorado.edu/sims/html/number-play/latest/number-play_en.html


<https://apps.mathlearningcenter.org/number-frames/>

Цахим хэрэглэгдэхүүний талбар дээр тоо болон бүтцийг загварчлах, жиших зэрэг олон хэлбэрийн дасгалыг гүйцэтгэх боломжтой. Юмсын тоог дүрс, загварчлалын өргөн сонголттой, хүүхдэд



ажиллахад хялбар, үйлдлээ хянах боломжтой байхаар төлөвлөгдсөн онцлогтой байна. Дээрх линкээр орж цахим хэрэглэгдэхүүнийг хэрэглэх боломжтой.

Нэмэгдэхүүн, нийлбэр, хасагдагч, хасагч, ялгавар гээд үйлдлийн гишүүдийн нэр, үйлдлийн дүн, гишүүдийн хоорондын хамаарал, нэмэхийн байр солих чанарыг ойлгуулах зэрэгт загварчлах, зураглал, схем ашиглах байдлаар мэдлэг, ойлголтыг бататгана.



ХОРЬ ХҮРТЭЛХ ТООНЫ НЭМЭХ, ХАСАХ ҮЙЛДЭЛ

Зорилго: 20 дотор аравт хэтрүүлэн нэмж, аравт задлан хасах аргад суралцах 1.1в. 1.1е. 1.1з суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэх.

Мэдлэг, ойлголт	Чадвар	Хандлага
А1. 20 дотор аравт гүйцээн нэмэх, аравт задлан хасах үйлдэл А2. Байр сэлгэн нэмэх, 0- ийг нэмэх, хасах	Б1. Хорь хүртэлх тооны нэмэх, хасах үйлдлийн мэдлэг, ойлголтоо танил ба танил бус нөхцөлд хэрэглэх Б2. Асуудлыг тохирох товч бичиглэл, зураглал, дүрслэл, хүснэгтээр илэрхийлэх Б3. Цээжээр болон бичгээр тооцоолох тохиромжтой аргыг сонгох Б4. Тооцооллыг зөв гүйцэтгэх Б5. Үр дүнг шалган, үндэслэлтэй тайлбарлах	- Бусдыг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх - Бие даан бодоход суралцах - Гүйцэтгэлд нягт нямбай хандах
Агуулгын залгамж холбоо		
Өмнөх	Одоо	Дараах
10 хүртэлх тооны нэмэх хасах үйлдэл хийх чадвар 10 хүртэлх тооны бүтэц, түүнийг ашиглах чадвар 20 хүртэлх тоо	1.1в. Хорь дотор аравт хэтрүүлэн нэмэх, аравт задлан хасах; 10, 20-ийн бүтцийг цээжээр хэлэх 1.1е. Тоон илэрхийлэл бичиж утгыг олох; нэмэх үйлдлийн байр солих, 0-ийн чанар хэрэглэх; үйлдлийн мэдэгдэхгүй байгаа (дүрсээр тэмдэглэсэн) гишүүний утгыг олох, математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдэг бичих 1.1з. Энгийн бодлогыг загварчлах, бодох, хариуг шалгах, өгсөн загвар, зураг дүрслэлд тохирох энгийн бодлого зохиох	-100 хүртэлх тооны нэмэх, хасах үйлдэл



Агуулгын интеграц хийх боломж :

Өгөгдөлтэй ажиллах	Хэмжигдэхүүн	Геометр
Юмсыг нэг, хоёр шинжээр ангилах, асуулт асууж хүснэгтэд бүртгэх, зурган диаграмм унших	Юмсын уртыг стандарт бус нэгж хэрэглэн жиших	Дөрвөлжин, дугуй, гурвалжин дүрсээр загварчлах

Ээлжит хичээлийн арга зүйн санаа: Хорь хүртэлх тооны нэмэх үйлдэл

Зорилго: 20 дотор аравт гүйцээн нэмэх аргад суралцана.

Алхам	Сурагчийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг	Анхаарах зүйл Үнэлгээ
Хичээлийн зорилгыг ойлгох	-Зургийг ажиглаж, ойлгох -Юмсыг дүрсээр загварчлан тайлбарлаж, нэмэх үйлдлийг бодох хялбар аргад суралцана. - Бусадтай хамтран ажиллаж, ярилцаж хичээлдээ амжилттай оролцох хэрэгтэй.	Багш сурагчдын өмнөх мэдлэг, чадварыг оношилсон байна. Суралцагчдын оролцоонд тулгуурлан зохион байгуулах

Сурагчид бие даан эсвэл хамтран ажиллаж бодлогоо өөрийнхөөрөө бодох	-Бодит юмсыг дүрсээр илэрхийлж, нэмэх үйлдлийн утгыг ойлгох үйлийг дахин давтан гүйцэтгэх. - Ширээ бүрт 2x5 хүснэгт, нэгжийн хавтан загварыг тарааж өгсөн байна. -Хүүхдүүд багшийн үзүүлсэн зургийг ажиглан тохирох тооны хавтан загварыг өрж, нэмэгдүүлэх үйлдлийг дүрсээр загварчилна. -Багш нэмэгдэж байгаа шувууны тоог 2, 3, 4, 5, 6-өөрчилнө. Сурагчид тохирох үйлдлийг дүрсээр үзүүлнэ. 9 дүрсийг арав болгон гүйцээхийн тулд хэдэн дүрс нэмэх вэ? асуултаар ярилцана. 	Хэрэглэгдэхүүнийг олон хувилбартай, өгөгдлийг сольж болохуйц байдлаар бэлтгэнэ. Хэд гарсан бэ? гэж асуухын оронд Яаж? Яагаад? гэсэн асуух нь сурагчдын бүтээлч, оролдлогыг нэмэгдүүлнэ. -Хүүхдүүдээр өөрийгөө болон найзыгаа үнэлэхэд тулгуур дохионы аргыг хэрэглэнэ. Үнэлэх шалгуур: •Зургийг ажиглах ойлгох •Загварчилж, дүрслэх •Аравт гүйцээн нэмэх •Цээжээр бодох
Хэрхэн бодсоноо хэлэлцэх (ялгаатай бодолтуудыг авч үзэх)	Багш хүүхдүүдийн бүтээсэн загваруудыг самбарт байршуулсан байна. Загварт тохирох үйлдлийг бодуулж, тайлбарлуулна. Яагаад нийлбэрийн утга 14 болсон бэ? 9 дээр 5-ийг яаж нэмсэн бэ?	•Тайлбарлах зэрэгт анхаарч судлан, дараагийн хичээл төлөвлөлтөд уялдуулна. Сурах бичгийн бодлого, дасгалыг сурагчдын ялгаатай байдалд тохируулж ажиллуулна.
Дүгнэлт хийх Самбарт байршуулсан аравт гүйцээж буй загвар дээр ярилцаж, ес дээр ? нэмэхдээ, эхлээд нэгийг нэмж арав болгож гүйцээж, нэмнэ.		Хүүхэд бүрийн чадвар өөр өөр тул гэрийн даалгаврыг төлөвлөж өгөхдөө тоглоомын аргаар бататгах, цээжээр бодох чадварыг хөгжүүлэх байдлаар төлөвлөнө. Бодолтыг бичихэд цагаан самбарын аргыг хэрэглэх нь сурагчид чөлөөтэй сэтгэх, бодсоноо илэрхийлэхэд дэмжлэг болно.
Багшид зөвлөмж: Хорь дотор нэмэх, хасах үйлдэл нь цаашид олон оронтой тооны үйлдэл гүйцэтгэхэд чухал суурь болж байдаг. Иймд багш бодит юмс, дүрслэл, хийсвэрлэлийг нягт уялдаатай гүйцэтгэхэд анхаарах хэрэгтэй. Бодит юмсыг дүрсээр илэрхийлэх чадваргүй бол нэмэх, хасах үйлдлийг гүйцэтгэхэд бэрхшээл гарах нь тодорхой. Иймд шууд тоогоор илэрхийлж бодоход яаралгүй, бодох аргын утгыг ойлгоход дүрслэх, загварчлах үйлийг давтаж гүйцэтгэх чухал юм.		

ЗУУ ХҮРТЭЛХ ТОО

Зорилго: Хоёр оронтой тоог уншиж, бичиж, орны нэмэгдэхүүний нийлбэрт задлан, тоонуудыг жишиж, эрэмбэлж, аравтаар баримжаалах 1.1а. 1.1б. 1.2б. суралцахуйн зорилтыг хэрэгжүүлнэ.

Мэдлэг, ойлголт	Чадвар	Хандлага
A1. Зуу хүртэлх тоо, их, бага, эрэмбэ, баримжаа A2. Зуу хүртэлх тооны утга	B1.100 хүртэлх тооны мэдлэг ойлголтоо танил болон танил бус нөхцөлд хэрэглэх B2.Тоог дүрс, тооллын хэрэгсэл, тоон картаар илэрхийлэх, тоон шулуун дээр тэмдэглэх B3.Юмсын дарааллыг тогтоон хэлэх, тайлбарлах B4.Тоог аравт, нэгжээр илэрхийлэх, бүтэн аравтаар баримжаалах	B1.Сонирхол, идэвх оролцоо B2. Бүтээлчээр хандах байдал B3.Гүйцэтгэлд нягт нямбай хандах B4.Байгаль экологид ээлтэй, хэмнэлттэй хэрэглээг эрхэмлэх байдал B5.Өөрийн болон бусдын шийдлийн талаар эргэцүүлэн дүгнэх байдал
Агуулгын залгамж холбоо		
Өмнөх	Одоо	Дараах



• 20 хүртэлх тоог таних • Тоог нэгээр нэмэгдүүлэн хорогдуулан тоолох • 20 хүртэлх тоог жиших, эрэмбэлэх, баримжаалах	1.1а. Зуу хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах 1.1б. Юмсын тоо, хэмжээг аравтаар баримжаалан хэлж, түүнийгээ тоолж шалгах 1.2б. Мөнгөн дэвсгэртийг таних, задлах, бүхэлдэх	1.1г. Зуу дотор аравт хэтрүүлэхгүй нэмэх, аравт задлахгүй хасах
--	--	--

Агуулгын интеграц хийх боломж :

Өгөгдөлтэй ажиллах	Хэмжигдэхүүн	Геометр
Юмсыг нэг, хоёр шинжээр ангилах, асуулт асууж хүснэгтэд бүртгэх, зурган диаграмм унших	Юмсын уртыг стандарт болон стандар бус нэгж хэрэглэн жиших, хэмжээг аравтаар баримжаалах	Дөрвөлжин, дугуй, гурвалжин дүрсээр загварчлах, цэг, хэрчмээр тэмдэглэх

Ээлжит хичээлийн арга зүйн санаа: Хэд орчим, хэд гаруй байна вэ?

Зорилго: Юмсын тоо хэмжээг аравтаар баримжаалах

Алхам	Сурагчийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг	Үнэлгээ, дэмжлэг
Хичээлийн зорилгыг ойлгох	-Бүтэн аравтуудыг унших, бичих, тоон шулуун дээр тэмдэглэх дасгал хийнэ -Багш гартаа савх эсвэл харандаа атгасан байна. -Багш нь гартаа хэдэн савх барьсан байна вэ? Яг хэд байгааг мэдэхгүй үед бид нар тоог хэрхэн хэлж болох вэ? асуудал дэвшүүлэн хичээлийн зорилгыг танилцуулна.	Гаруй, шахам, орчим, ойр зэрэг үг хэрэглэж баримжаалж хэлүүлэх. 1-р ангид ахуй амьдралд өдөр тутам хэрэглэгддэг үг хэллэгээр ойлгуулна.
Сурагчид бие даан эсвэл хамтран ажиллаж бодлогоо өөрийнхөөрөө бодох	-Хүүхдүүд хариултыг тодорхой гаргаж ирээгүй тохиолдолд: Дээрх гаруй, шахам, орчим үгүүдийг хэрэглээд тоог хэлж болох уу? Ингээд хүүхдүүдийн хариултыг сонсож, хамтдаа шалгаж үзье. Хүүхэд бүрт тоон шулууны загвар тарааж, хамтарч ажиллана. Ингээд гарт барьсан юмсыг тоолж, тоон шулуун дээр тэмдэглэе. 12 нь 10 ба 20 гэсэн аравтын хооронд орших учраас хуваарийг 10-аас 20хүртэл бичээрэй. -12ыг тоон шулуун дээр цэгээр тэмдэглэе. -12-оос 10 хүртэл хэдэн нэгж зайтай байна вэ? -12-оос 20 хүртэл хэдэн нэгж зайтай байна вэ? - 12 нь 10, 20-ын алинд нь илүү ойр байна вэ?	Хэрэглэгдэхүүнийг олон хувилбартай, өгөгдлийг сольж болохуйц байдлаар бэлтгэнэ. Тоон шулуун дээр тоог цэгээр тэмдэглэхдээ алдаа гаргадаг тул зөв тэмдэглүүлэхэд анхаарах. -Хүүхдүүд өөрийгөө болон найзыгаа үнэлэхэд тулгуур дохионы аргыг хэрэглэнэ. Үнэлэх шалгуур: •Үг хэллэг хэрэглэн баримжаалан хэлэх •Хэлснээ шалгах
Хэрхэн бодсоноо хэлэлцэх (ялгаатай бодолтуудыг авч үзэх)	Баримжаалан хэлэх дасгал хийх. -10д ойр 11, 12, 13, 14-ыг яагаад 10 гаруй гэсэн бэ? -20д ойр 16, 17, 18, 19-ыг яагаад 20 орчим гэсэн гэдгийг тайлбарлуулж ярилцана. 15-нь ижил зайд байдаг тул их тоогоор нь баримжаална.	• Аль аравтуудын дунд оршиж байна вэ? тэмдэглэх •Нэгж хэмжээг харьцуулах зэрэгт анхаарч судлан, дараагийн хичээл төлөвлөлтөд уялдуулна.
Бататгах дүгнэлт хийх	Багш 20 ба 30ын хооронд орших тоог сурагчдаар хэлүүлэн тоон шулуун дээр тэмдэглэнэ. Аль аравтад ойр байгааг баримжаалан хэлүүлнэ. Тухайлбал: 26 нь 30д ойр байгаа учир юу гэж хэлж болох вэ? Амьдрал дээр савны багтаамж, юмны уртын хэмжээ, мөнгөний хэмжээг зэргийг баримжаална.	Сурах бичгийн бодлого, дасгалыг сурагчдын ялгаатай байдалд тохируулж ажиллуулна. Хүүхэд бүрийн чадвар өөр өөр тул гэрийн даалгаврыг төлөвлөж өгөхдөө тоглоомын аргаар бататгах, цээжээр бодох чадварыг хөгжүүлэх

Багшид зөвлөмж:

Амьдрал дээр савны багтаамж, юмны уртын хэмжээ, мөнгөний хэмжээг зэргийг баримжаалан хэлэх шаардлага гардаг тул эдгээр дасгал даалгавраар баяжуулан төлөвлөх боломжтой.



ЗУУ ХҮРТЭЛХ ТООНЫ НЭМЭХ, ХАСАХ ҮЙЛДЭЛ

Зорилго: Зуу дотор аравт хэтрүүлэхгүй нэмэх, аравт задлахгүй хасах үйлдлийг гүйцэтгэх 1.1г. 1.1е. 1.1ж. 1.1з. 1.2б. суралцахуйн зорилтыг хэрэгжүүлнэ.

Мэдлэг, ойлголт	Чадвар	Хандлага
А1. Орны нэмэгдэхүүний нийлбэрт задлан нэмэх, хасах, зуу дотор аравт хэтрүүлэхгүй нэмэх, аравт задлахгүй хасах А2. -Нэмэх үйлдлийн чанар -0-ийн чанар -Тоо, дүрс, юмсын зүй тогтол	Б1. Зуу хүртэлх тооны нэмэх, хасах үйлдлийн мэдлэг, ойлголтоо танил ба танил бус нөхцөлд хэрэглэх Б2. Асуудлыг тохирох товч бичиглэл, зураглал, дүрслэл, хүснэгтээр илэрхийлэх Б3. Цээжээр болон бичгээр тооцоолох тохиромжтой аргыг сонгох Б4. Тооцооллыг зөв гүйцэтгэх Б5. Үр дүнг шалган, үндэслэлтэй тайлбарлах	В1. Сонирхол, хүсэл эрмэлзэлтэй В2. Бүтээлчээр хандах байдал В3. Гүйцэтгэлд нягт нямбай хандах В4. Байгаль экологид ээлтэй, хэмнэлттэй хэрэглээг эрхэмлэх байдал В5. Өөрийн болон бусдын шийдлийн талаар эргэцүүлэн дүгнэх байдал
Агуулгын залгамж холбоо		
Өмнөх	Одоо	Дараах
• 10 дотор нэмэх, хасах • 20 дотор нэмэх, хасах • Нэмэх үйлдлийн чанар, 0-ийн чанар хэрэглэх • Тоог 1, 2, 5, 10-аар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох • Орны нэмэгдэхүүний нийлбэрт задлах, оронгийн утгыг тайлбарлах • Мөнгөн дэвсгэртийг ялгах, задлах, бүхэлдэх	1.1г. Зуу дотор аравт хэтрүүлэхгүй нэмэх, аравт задлахгүй хасах 1.1е. Тоон илэрхийлэл бичиж утгыг олох; нэмэх үйлдлийн байр солих, 0-ийн чанар хэрэглэх; үйлдлийн мэдэгдэхгүй байгаа (дүрсээр тэмдэглэсэн) гишүүний утгыг олох, математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдэг бичих 1.1ж. Тоог 1, 2, 5, 10-аар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, дараалуулан байрлуулсан тоо, дүрс, юмсын зүй тогтлыг олох 1.1з. Энгийн бодлогыг загварчлах, бодох, хариуг шалгах, өгсөн загвар, зураг дүрслэлд тохирох энгийн бодлого зохиох 1.2б. Мөнгөн дэвсгэртийг таних, задлах, бүхэлдэх	2.1г. Мянга дотор тоог орны нэмэгдэхүүний нийлбэрт задлаж болон задлахгүйгээр нэмэх, хасах


100-ын дотор нэмэх (хасах) үйлдэл хийхийн тулд тоон тор буюу 100 буудалтай хөлөг ашиглаж, мөр багана руу шилжүүлэн нэмэгдэж, хорогдож буйг тооцох боломжтой. Олон оронтой тооны нэмэх, хасах үйлдлийг төвөггүй гүйцэтгэхэд 1-р ангид эзэмшсэн 100 дотор нэмэх хасах чадвар чухал суурь болно. Тиймээс хөзөр, зурган болон тоон карт, савх мод, шоо ашиглан төрөл бүрийн дасгал хийлгэх нь багш таны бүтээлч үйлээс хамаарна.

Ээлжит хичээлийн арга зүйн санаа: Хоёр оронтой тоон дээр хоёр оронтой тоог нэмэх

Зорилго: Зуу дотор аравт хэтрүүлэхгүйгээр нэмэх, цээжээр бодох аргад суралцана.

Алхам	Сурагчийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг	Үнэлгээ, дэмжлэг
Хичээлийн зорилгыг ойлгох	-Дүүд 36 төгрөг байв. Ээж 11 төгрөг нэмж өглөө. Дүү нийт хэдэн төгрөгтэй болсон бэ? -Дүү 25 төгрөгөөр наадаг зураг авлаа. Бид үүнийг яаж бодох вэ?	Хүүхэд бүрийн анхаарал төвлөрөлт, хэрхэн сонирхож байгааг хянана.




Сурагчид бие даан эсвэл хамтран ажиллаж бодлогоо өөрийнхөөрөө бодох	Ширээ бүрт аравт нэгжийн дүрсэн загварыг тараасан байна. Эхний бодлогыг хүүхдүүдээр уншуулна. Ялгаатай байдлыг харгалзан зураглалыг хамт харуулна. 56 төгрөгийг аравт, нэгжээр задлан харуулна. 11 төгрөгийг аравт нэгжээр задлан харуулна. Бодлогын эхний асуултыг уншина. Хүүхдүүд нэгж, аравтын загвараар бодох үйлийг гүйцэтгэнэ.	Хоёр оронтой тоог оронгийн нэмэгдэхүүнээр задалж чадаж байна уу? Хосоор ажиллаж бие биедээ тусална. Багш дэмжлэг хэрэгтэй хүүхдэд чиглүүлж өгнө. Дүрсээр загварчлах, зуутын хүснэгт, тоон шулуун ашиглах чадварыг ажиглаж судална.
Хэрхэн бодсоноо хэлэлцэх (ялгаатай бодолтуудыг авч үзэх)	•https://apps.mathlearningcenter.org/number-pieces/?28131duv  Эдгээр загварууд болон зуутын хүснэгт ашиглан бодож, цээжээр тооцоолох дасгал хийнэ. Бодсон аргаа тайлбарлана.	Бодолтыг нэмэх үйлдлээр илэрхийлэн бичих, тэмдэглэх Хэрхэн бодсоноо тайлбарлах
Бататгах дүгнэлт хийх	Бататгах хэсэгт сурах бичиг, бие даан ажиллах дасгал ажлын хуудсуудыг сурагчдын ялгаатай байдалд тохируулан хэрэглэнэ. Дүгнэлт: Зуу дотор нэмэх үйлдлийг бодож болох өөр өөр аргачлалууд дээр ярилцаж, цээжээр тооцоолох дасгал, хялбар программ дээр ажиллах аргачлалыг эцэг эх, асран хамгаалагчдад хүргэж, хамтарч ажиллах нь үр дүнтэй	

Багшид зөвлөмж:


Нэгдүгээр ангид баганаан бичлэгээр яаран бодсоноор сурагчдад бэрхшээлтэй, эцэг эх, багш нарт ажиллахад хүндрэлтэй асуудлууд их гардаг. Хүүхдүүд өөртөө итгэх итгэлгүй болох тал ажиглагддаг. Тоо болон үйлдлийн утгыг ойлгуулах, олон аргаар бодох, сэтгэхүй хөгжүүлэх, цээжээр тооцоолох аргуудыг эзэмшүүлэхийн тулд хүүхдийн идэвхтэй үйл ажиллагааг өрнүүлэх хэрэглэгдэхүүнийг олон хувилбартай төлөвлөж ашиглах хэрэгтэй..

Нэмэх, хасах үйлдлийг гүйцэтгэх, сурагчдыг дэмжин ажиллах, хичээлийг сонирхолтой төлөвлөж зохион байгуулах олон боломж нээлттэй байдаг. Багшийн цагийг хэмнэсэн математикийн хичээлийн программуудыг ашиглаж, интернэт боломжгүй үед зураг, бичлэг хэлбэрээр бэлтгэн ашиглах боломжтой юм.

Зуу хүртэлх тоо нэгж хичээлийн үнэлгээний даалгавар





1. Орхисон тоог нөхөж бичээрэй.



2. Загварт тохирох тоог бичээрэй.

Бичсэн тоогоо орны нэмэгдэхүүний нийлбэрээр задлан бичээрэй.





$26 + 43 =$
$$58 - 37 =$$

A horizontal number line is shown with tick marks at every integer from 0 to 10. The segment between the tick marks for 4 and 5 is shaded gray.

	—		=	
--	---	--	---	--

Хүүг өвөл, зуны хувцсаар
ээлжилж хувцаслаж болно.




Тэнгэрт нар сар, одод ээлжлэн
түгэх үзэгдлийг үзүүлж болно.

УРТЫГ ХЭМЖИХ



1-р ангид бэлтгэл хөтөлбөр эхлэх үеэс урт богино зүйлийг аль нь урт, аль богино болохыг харьцуулж ярилцах, цаашид урт богиныг харьцуулан эсвэл стандарт бус хэмжих нэгж хэрэглэн жишиж, хэмжээг унших, бичих, жиших, хэмжих хэрэгслийн хуваарийн утгыг тайлбарлах зэргээр агуулгыг өргөжүүлэн судална. Тиймээс уртыг хэмжих тухай ойлголтыг төлөвшүүлэхдээ уртыг хэмжих багаж буюу шугамаа зөв сонгох, хэмжих нэгжээ зөв сонгох хаанаас хаа хүртэл хэмжилт хийж буй эхлэх цэгээ зөв тодорхойлох зэрэгт анхаарах шаардлагатай. Жишээ нь. Зурагт өгөгдсөн А, В туузын аль нь урт вэ гэдгийг хэрхэн мэдэх вэ, яг ямар



аргаар мэдэхийг сурагчдаар өөрсдөөр нь санаа гаргуулах, хэмжих хэрэгслээ зөв сонгох боломжийг бүрдүүлээрэй.

Туузыг зэрэгцүүлээд хэмжихээс гадна дэвтрийн шугам дагуу байршуулах, нэгж хэмжигдэхүүн болгож баллvvр эсвэл бичгийн хавчаараар хэмжье гэх мэт олон санаа vралдvvлах чvхал.



ДҮРСИЙГ ТАНИХ, НЭРЛЭХ

Зорилго: Цэг, хэрчим, квадрат, тэгш өнцөгт, гурвалжин, дугуй зэрэг дүрсийг дурын

байрлалд таних, нэрлэх, дүрслэх, зурах, тэгш хэмтэй нугалах, дүрсээр бүтээл

хийхэд суралцаж, 1.3а суралцахуйн зорилтыг хэрэгжүүлнэ.

Геометрийн агуулгыг таниулахдаа тухайн шинжлэх ухааны тогтсон нэр, томъёо тодорхойлолтыг анхнаас нь зөв тогтоолгож, математик хэл сэтгэлгээнд сургах хэрэгтэй. Юмсын бодит дүрслэлийг практик хэрэглээтэй холбон сэдэлжүүлж, зурж, тэмдэглэх, бүтээл хийх зэрэг дадлага туршилт хийх чухал. Хүүхдүүд бага насандаа бөмбөг, шоо, машины дугуй, дөрвөлжин хайрцаг гээд юмсыг ялгадаг боловч эдгээрийг нэгтгэн дүгнэх чадвар сул. Хэлбэрийг нь төсөөлөх боловч нэрлэж чадахгүй, зурж чадах боловч ерөнхий шинж чанаруудыг илрүүлж, дүгнэж чаддаггүй байна. Иймд хүүхдийг дүрсийн тухай сэтгэлгээг нь цэгцэлж өгөх нь багш бидний үүрэг болоод байна.


Мэдлэг	Чадвар	Хандлага
Дүрс, нэршил, зохиомж, тэгш хэм	Дүрсүүдийг дурын байрлалд таних, нэрлэх, ангилах, дүрслэх, зурах, зохиомж бүтээх, дүрсийг тэнцүү хуваах	Хамтран суралцах Бүтээлчээр хандах
Агуулгын залгамж холбоо		
Өмнөх	Одоо	Дараах
Эд зүйлсийг хэмжээ, хэлбэр, дүрсээр нь ангилах, ижилсүүлэх	- Цэг, хэрчим, тахир шугам, гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг таньж нэрлэх, зурах, бүтээх - Биет болон хэвийг хэрэглэн дүрс зурах, бүтээл хийх - Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг Хоёр тэнцүү хэсэг болгон нугалах аргаар тэгшхэмтэй эсэхийг таних	- Цацраг, өнцөг, тэгш өнцөг, дөрвөн өнцөгт, таван өнцөгт, зургаан өнцөгтийг нэрлэх, дүрсээр бүтээл хийх - Биет хэрэглэн бүтээл хийх - Хоёр тэнцүү хэсэг болгон нугалах аргаар тэгшхэмтэй дүрсийг таних

Дүрслэх урлаг, технологийн хичээлтэй интеграцчилах боломжтой. Хүүхдийн сонирхлыг татахуйц өнгө хэлбэр бүхий эвлүүлдэг тоглоомыг ашиглан бүтээх даалгавар хийлгэж болно.

Ээлжит хичээл: Гурвалжин дүрсийг таних, бүтээх

Зорилго: Гурвалжин дүрсийг таньдаг болох, нэрлэх, биет болон хэв ашиглан гурвалжин зурах, зохиомж бүтээх



Алхам	Сурагчийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг	Үнэлгээ, дэмжлэг
Хичээлийн зорилгыг ойлгох	Төрөл бүрийн биет хайрцаг, савыг хэв болгон ашиглаж, дүрс зурна. Хүүхдүүд дүрсийг ялгаж, нэрлэж ярилцана.	Биетийн талсыг ямар хэлбэртэй харагдаж байгааг асууж ярилцах
Гурвалжин дүрсийг таньж нэрлэх	Орчиндоо байгаа юмсаас гурвалжин дүрсээс бүтсэнийг олж нэрлэнэ. Дэвтэртээ цэг тэмдэглэж, шугам хэрэглэн гурвалжин дүрс зурна.	Дасгал даалгавар бүр дээр хүүхдүүдийн буруу төсөөлөл, гаргаж байгаа алдааг хүснэгтээр хянах боломжтой.
Биет болон хэвийг хэрэглэн дүрс зурах, бүтээл хийх	https://apps.mathlearningcenter.org/pattern-shapes/ программ ашиглан дүрсээр зохиомж, бүтээл хийнэ. 	Учир нь сурагчид геометрийн үг хэллэгийг ойлгоогүйн улмаас алдаа гаргахаас урьдчилан 1-р ангиас эхлэн хянаж, дэмжлэг үзүүлэх, дараагийн хичээл төлөвлөлтийг сайжруулах юм.
Анги нийтийн хэлэлцүүлэг	 Гурвалжин дүрс хэдэн хэрчим, талаас бүтэж байгааг ярилцана. https://apps.mathlearningcenter.org/geoboard/?43wvjtwy	
Бататгах, дүгнэлт хийх	Бие даан суралцах ажлын дэвтрийн дасгалаас сурагчдын түвшинд тохируулан сонгож хийлгэнэ. «file:///C:/Users/BMDI/Downloads/G11_Durs.pdf»	

Багшид зөвлөмж:

Бага ангийн сурагчдын хувьд эхлээд Тодорхой түвшинд мэдэрдэг учраас дүрсээс илүү биетийг илүү ойр хүлээж авдаг. Учир нь тэдний ойр орчин, гэр, ахуй, тоглоомд биет илүү тааралддаг билээ.

Ихэнх сурагч дүрсийн талаар хэвшсэн төсөөлөлтэй болсон байдаг. Тухайлбал, адил хажуут гурвалжин бүр суурь нь доороо байна гэх мэт. Иймд уг төсөөллөөр нь дүрсүүдийг ангилуулах нь математикийн хувьд хангалтгүй юм. Сурагчид дүрс, түүний шинж чанарын талаар бүхэлд нь төсөөлж, сэтгэхүйгээ хөгжүүлж байх шаардлагатай.

Хичээлийн явцад хэрэглэж болох хянах хүснэгтэд багш хялбар тэмдэглэгээ хэрэглэн ашиглах боломжтой.

	Цэг	Хэрчим	Тахир шугам	Гурвалжин	Дөрвөлжин	Дугуй
Нэрлэх						
Зурах, бүтээх						
Тэгш хэм						
Бүтээл хийх						

Нэгж хичээлийн үнэлгээний жишиг даалгавар

1. **Тахир шугамыг олж сонгоорой.** (Цэгийг, хэрчмийг сонгох хувиргаж болно)



2. Гурвалжин дүрсийг сонгоорой. (Дөрвөлжин, дугуй дүрсийг сонгох хувиргаж болно)



3. Энэ хайрцгийг хэв болгон ямар дүрсийг зурж болохгүй вэ?



а.




б.







в.



4. Дөрвөлжин дүрсийг 2 тэнцүү хэсэгт тэгш хэмтэй хуваагаарай.




5. Гурвалжин, дугуй дүрсийн байрлалыг өөрчлөн наагаарай.



ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ


Зорилго: Юмсыг тодорхой зорилготойгоор нэг, хоёр шинжээр ангилах 1.4а. 1.4б. суралцахуйн зорилтыг хэрэгжүүлнэ.

Мэдлэг ойлголт	Мэдлэг хэрэглэх	Хандлага
A1. Өгөгдөл, ангилал, бүртгэл, юмсын шинж, зурган диаграмм, Карролын диаграмм	Б1. Математикийн мэдлэг ойлголтоо танил бус нөхцөлд хэрэглэх • Карролын диаграмм хэрэглэн дүрс юмсыг өнгө, хэлбэр, хэмжээ гэх мэт нэг, хоёр шинжээр ангилах, • Тодорхой зорилгоор асуулт асууж, хариултыг хүснэгтэд бүртгэх, хүснэгт, диаграммыг унших, илэрхийлэх	В1. Сонирхол, хүсэл эрмэлзэлтэй байдал В2. Бүтээлчээр хандах байдал В3. Гүйцэтгэлд нягт нямбай хандах
Агуулгын залгамж холбоо		
• Дүрс, юмсын хэлбэр, өнгө, хэмжээг ялган таних • Цээжээр болон бичгээр тооцоолох чадвар	1.4а. Юмсыг (өнгө, хэлбэр, хэмжээ) нэг, хоёр шинжээр Карролын диаграмм хэрэглэн ангилах 1.4б. Асуулт асууж, хариултыг хүснэгтэд бүртгэх, зурган диаграммыг (пиктограмм) унших, илэрхийлэх	2.4а. Юмсыг нэг, хоёр шинжээр Карролын диаграмм хэрэглэн ангилах, тайлбарлах 2.4б. Өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган диаграммаар илэрхийлэх, тайлбарлах



Боломж болон статистикийн ойлголтыг сурагчдын өөрсдийнх нь мэдлэг мэдээлэл, хэрэглээн дээр нь суурилан олгоно. Жишээ нь. Харандаа, баллуурны тоо хэмжээг гаргах, ижил шинжээр ангилах, цаашлаад загварчилж үнийн дүнг харуулсан зураглал хийх, тус бүрийн үнийг олох гэх мэт хувирган хэрэглэнэ.

Эвлүүлдэг тоглоомоор тоглонгоо зүй тогтлыг илрүүлэх, мэдээлэл цуглуулах, бүртгэх гэх мэт




Жишээ нь. Сурагчид товч, ном, шугам, харандаа зэргийг цуглуулан тэднийгээ өнгө, хэлбэр, хэмжээгээр нь ангилна. Өөр ямар шинжээр ангилж болох тухай ярилцаж, сурагчдын сонирхсон шинжээр ангилж болно. Ангилал болгоны нэрийг бичсэн цаасыг бичгийн хадаасаар тогтоогоод, тухайн ангилалд байгаа юмсын тоогоор бичгийн хавчаар өлгөнө.

Чацарганатай								
Нэрстэй								
Шоколадтай								

Сурагчдаас асуулга судалгаа авч мэдээлэлд боловсруулалт хийх тул тэдэнд асуулт асуух, асуултын дагуу мэдээллээ бүртгэх, түүнийг ангилах аргад сургах боломжтой.

Өгөгдөл цуглуулах явцад нэг сурагч нэг л удаа санал өгнө. Бүх сурагч хамрагдах ёстой. Яагаад гэдгийг ярилцаарай.

Хүүхдүүд ямар амьтанд хайртай вэ? өгсөн саналыг нэгтгэж, графикаар илэрхийлсэн байдлыг ажиглаарай.



КАРРОЛЛЫН ДИАГРАММ

1.4а. Юмсыг (өнгө, хэмжээ, хэлбэр) нэг, хоёр шинжээр Карроллын диаграмм хэрэглэн ангилах

Дүрсийг нэг шинжээр ангилах	Өнгө
Ногоон өнгөтэй	Ногоон өнгөтэй биш
Өгсөн шинжийг хангах дүрс	Өгсөн шинжийг хангахгүй дүрс

Дүрсийг хоёр шинжээр ангилах (өнгө, хэлбэр)	Өнгө	Хэлбэр
Ногоон өнгөтэй	Ногоон өнгөтэй биш	
Дөрвөлжин		
Дөрвөлжин биш		



Ашигласан материал

1. Б.Балдулмаа, Ц.Нямжав, Д.Энхцэцэг ба бусад “Бага боловсролын математикийн онол, дидактик УБ, 2010 он
2. Г.Батболд, Ж.Чогмаа, Н.Ганзаяа ба бусад “Бага боловсролын математикийн онол, арга зүйн асуудалд УБ, 2018 он
3. Питер Кларк, Каролайн Клисолд, Черри Мозли “Математикт хэрхэн сайн болгох вэ?” DK, www.dk.com
4. Ц.Нарантуяа, А.Гантуул, Ж.Буянт, Т.Батчимэг “Бага боловсролын математикийн сургалтын арга зүй” УБ, 2020 он
5. Бага боловсролын сургалтын хөтөлбөр, 2019 он
6. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж Математик I-V анги, УБ, 2019 он

2.4. ХҮН БА ОРЧИН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Хүн ба Орчин хичээл нь сурагч хүрээлэн буй орчноо танин мэдэх явцад өөрийгөө нээх, сурах арга барил эзэмших, эрүүл аж төрөх дадал, зан үйлд сургах зорилготой.

Сургууль, анги, хамт олон нийгмийн гишүүн болж өөрийгөө нээх, илэрхийлэх, орчиндоо дасан зохицох, өөрсдийн мэдрэмжээ ашиглан эргэн тойрноо ажиглаж судлах, сурах арга барил эзэмшин эрүүл аж төрөх энгийн дадал хэвшилд суралцана. **Тухайлбал:**

Өөрийгөө таних, нээх	- Байгаль болон нийгэмтэй харилцах явцдаа өөрийнхөө байр суурийг мэдэх, үзэл бодлоо илэрхийлэх - Өөрийн сайн тал, авьяасыг мэдэх, хөгжүүлэх - Биеэ даах, шийдвэр гаргахад суралцах
Хүмүүс болон байгаль, нийгэмтэй харилцах	- Харилцаа нь хүмүүс болон өөрт чухал болохыг тайлбарлах - Бусадтай зөв харилцах, мэндлэх, хүндлэх зэрэг дадал хэвшилд суралцах - Эргэн тойрныг шинжлэх судлах хүсэлтэй болох
Эрүүл аж төрөх энгийн дадал хэвшилтэй болох	- Эрүүл мэнд болон аюулгүй байдлаа хамгаалах, биеэ зөв авч явах - Эрүүл орчин бүрдүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах - Дүрэм журмыг мөрдөх

БСШУ-ны сайдын 2007 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 286 дугаар тушаалын дагуу “Хүн ба байгаль”, “Хүн нийгэм”, “Эрүүл мэнд” хичээлүүдийг нэгдмэл хичээл болгон 1-3 дугаар ангид судлахаар оруулж, 2008 оноос Хүн-Орчин сургалтын үндэсний хөтөлбөр, 2014 оноос “Хүн ба Орчин” сургалтын цөм хөтөлбөр, 2019 оноос “Хүн ба Орчин” сургалтын сайжруулсан хөтөлбөр батлагдаж, сурах бичиг боловсруулагдан хичээллэж байна.

Иймд “Хүн ба Орчин” хичээлээр байгалийн ухаан, нийгмийн ухаан, эрүүл мэндийн агуулгыг интеграци байдлаар судална.



Сургалтын төлөвлөгөөнд 1-р ангийн “Хүн ба Орчин” хичээлийг бэлтгэл хөтөлбөрийн дараа 29 долоо хоног тус бүр 2 цагаар нийт 58 цаг орохоор төлөвлөгдсөн. Би, Миний гэр бүл, Манай сургууль, Миний нутаг, Манай дэлхий¹ гэсэн 5 бүлэг сэдвийг 1-3 дугаар ангид агуулгын залгамж холбоотойгоор судална.

1-р ангийн бүлэг сэдэв бүрийн харгалзах суралцахуйн зорилтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1. Жишиг цагчилсан төлөвлөлт

Улирал	I улирал																II улирал									III улирал						
7 хоног	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7
Бүлэг сэдэв	Би																Манай сургууль									Манай дэлхий						
Нэгж сэдэв	Бэлтгэл хөтөлбөр																Миний нутаг									Эх орон, эх дэлхий						
С.З	1.1б, 1.1в																1.3а									1.5а, 1.5б, 1.5в						

Тайлбар: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай” 2020 оны А/244 дүгээр тушаалыг баримтлан жишиг төлөвлөлтийг оруулав.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Гэр бүлийн орчноос гарч шинэ хамт олон дотор орж байгаа энэ насны хүүхдийн орчноо таньж мэдэх хүсэл сонирхол их байдаг. “Хүн ба орчин” хичээлийн агуулга нь байгаль, нийгмийн юмс үзэгдэл, түүний учрыг мэдэх сонирхол төрүүлэх, сорил туршилт хийх, хэм хэмжээ дэг дэглэм мөрдөх, эрүүл зан үйлийг хэвшүүлэхэд чиглэгдэнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид дараах чадварыг эзэмшинэ.

Орчин тойрноо сонирхон судлах	✓Хүрээлэн буй орчноо ажиглах, танилцах ✓Сонирхсон зүйлийн талаар асуулт асуух ✓Юу болохыг баримжаалах ✓Асуултад хариулт авч, мэдээлэл цуглуулах ✓Хичээлийн хэрэглэлээ бэлтгэх, сонгох, зориулалтын дагуу хэрэглэх, зааварчилгааг сахих ✓Болсон зүйлийг таамаглалтай харьцуулах ✓Шинэ санааг дүрс зургаар илэрхийлэх, тайлбарлах
Хэм хэмжээ дэгийг сахих	✓Хэм хэмжээг зохицуулсан дохио тэмдгийг ялган таних ✓Сургуулийн орчинд дасан зохицох, анги хичээлийн дэг мөрдөх ✓Өдрийн дэглэм сахих ✓Аюулгүй, цэвэр орчин бүрдүүлэх санаа гаргах
Бусадтай харилцах, үнэт зүйлийг эрхэмлэх	✓Санал бодлоо илэрхийлэх, тайлбарлах ✓Байгаль, хүрээлэн буй орчинд эерэг хандах ✓Үнэт зүйлийг таних мэдэх (хувийн, гэр бүлийн, найз нөхдийн)

Анги танхим, сургуулийн орчинтой танилцах, ангид байгаа эд юмс, хичээлийн хэрэгслийг нэрлэх, зориулалтыг мэдэх, зөв хэрэглэх, сургуулийн дэгтэй танилцах, ойлгох, ангид мөрдөх дэг зохиоход оролцох, түүнийгээ дагаж мөрдөх, тоглоом, үйл ажиллагаанд дүрэм заавар баримтлан оролцох, тоглох, бусадтай хамтран ажиллах гэсэн үйлийг бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс эхлээд сурагчдад дадал хэвшил бий болгох зорилгоор хэрэгжүүлнэ. Бэлтгэл хөтөлбөр, Хүн ба Орчин хичээлээр олгогдох агуулгууд давхцалтай харагдах тал ажиглагдах хэдий ч залгамж холбоо, арга зүйн онцлогоороо хэрхэн хүргэхийг багш та өөрөө урьдчилан төлөвлөөрэй. **Тухайлбал:** Бэлтгэл хөтөлбөрт хичээлийн хэрэгслийг нэрлэх, зориулалтыг мэдэх, зөв хэрэглэх тухай “Миний цүнх” сэдвийн хүрээнд сурагчийн цүнх нь багш, эмчийн барих цүнхнээс юугаар ялгаатай байх, юу, юу байх талаар ярилцах бол “Хүн ба Орчин” хичээл дээр **1.1а.** (Өөрийн хичээлийн хэрэглэлээ нэрлэж, үүрэг зориулалтаар нь ялган таних) суралцахуйн зорилтын хүрээнд нэг хичээлээр жишээ болгон зургийн хичээлд хэрэглэх хэрэглэгдэхүүн, биеийн тамирын хичээлээр хэрэглэгдэх зүйлс ялгаатай бөгөөд өөр өөрийн үүрэг зориулалттай болохыг өөрсдөөр мэдрүүлэх, ангилж, ялган таньж, зөв хэрэглэх дадалд сургахыг чухалчилна. Суралцахуйн удирдамжид дөрвөлжин, тууш, ноотны дэвтрийн үүрэг зориулалт ялгаатай болохыг өөрсдөөр нь төрөл бүрийн дүрс зурахыг санал болгож, аль нь амархан байсныг мэдрүүлэх туршилт оруулсан байгааг багш өөрөө урьдчилан судалж, хэрэгжүүлээрэй.

Багшид санамж: Сурагч бүрийн хичээлд оролцох, өөрийгөө илэрхийлэх түвшин харилцан адилгүй байх тул тэдэнд урмын үг хэлж, залхаахгүй байхад анхааран сурагчдын өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах чадварыг дэмжихийн тулд асуултаа оновчтой тавих, дөхүүлэх, дэмжих асуултыг оновчтой бэлтгэх хэрэгтэй.

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ

- Сурагчдыг нийгмийн орчин (гэр бүл, найз нөхөд, багш, хамт олон)-той танилцуулах
- Байгалийн орчин (сав, шим ертөнц)-ийг сонирхон судлах сэдэл төрүүлэх
- Эрүүл мэндээ хамгаалах, бусадтай зөв харилцах зан үйлд суралцах, хэвшүүлэхийг дэмжихэд чиглэгдэх болно.

Эдгээрийг хэвшүүлэхийн тулд судлах агуулгын хүрээнд ажиглах, таамаглах, турших, үр дүнг танилцуулах замаар сонирхон судлах арга барил эзэмших, хичээлийн хэрэглэлээ нэрлэж,



зориулалтаар нь ялган таних, зөв ариг гамтай хэрэглэх, хадгалах, мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар хүрээлэн байгаа юмс үзэгдлийг ажиглаж, хоорондоо хэрхэн зохицдогийг танин мэдэхэд чиглэгдсэн тэдний нас сэтгэхүйн онцлогт тохирсон сурагч төвтэй арга зүйг хэрэглээрэй. Өөрөөр хэлбэл сурагчийн бүтээлч сэтгэлгээ, идэвх оролцоо, өөрийн бодит туршлагад тулгуурласан өөрийгөө нээн илэрхийлэх, бие даасан байдлыг хүндэтгэсэн шинжлэн судлах эрэл хайгуул хийх сурагч төвтэй сургалтын арга технологид суурилсан үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх чухал. Анхлан сурагч болж буй сурагчдын сонирхол хэрэгцээнд нийцсэн сорил, туршилт төлөвлөн хэрэгжүүлэх нь тэдний шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх тул багш өөрөө шинжлэх ухаанч арга барилд зайлшгүй суралцсан байх шаардлагатай.

Мөн энэ насны хүүхдэд тоглох, тоглоомоор дамжуулан аливааг хүлээн авах чадвар нь давамгайлсан байдаг тул тухайн насны онцлогт тохирсон тоглоомын арга зүйг голчлон ашиглаарай. Ингэхдээ тоглоомын дүрмээ ярилцаж, дүрмийн дагуу тоглох явцдаа дэг дэглэм мөрдөх, юмсын шинж чанарыг ялган таних чадварт суралцахад анхаарч нийгэмшихүйн чадварыг илүү дэмжиж өгөх хэрэгтэй.

Сургалтын хөтөлбөрт тусгасан зарим агуулгыг орон нутаг, сургууль, улирлын онцлогт тохируулан өөрчилж, тухайн өөрчлөлтийн дагуу арга зүйгээ тохируулан заах боломжтой.

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

Сургалтын агуулга, хөтөлбөр, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор судлагдахуун тус бүрийн суралцахуйн удирдамж боловсруулагдсан. Суралцахуйн удирдамжид суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх сурагчдын сурах үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэглэгдэхүүнийг санал болгосон. **Тухайлбал:**

Танхимын сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн	- “Хүн ба Орчин I” сурах бичиг, 2020 он (www.medle.mn) - Бага боловсролын сургалтын хөтөлбөр, 2019 он (www.meds.gov.mn/curriculum-baga) - “Хүн ба Орчин” хичээлийн зөвлөмж ба суралцахуйн удирдамж, 2019 он (www.mier.mn)
Цахим сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн	- “Хүн ба Орчин I”-ийн 29 теле хичээл (www.medle.mn) - “Хүн ба Орчин I”-ийн 6 интерактив хичээл (www.medle.mn) - Үлгэр, бяцхан түүхүүд” 44 нэмэлт контент (www.medle.mn)
Бусад	Энгийн гарын доорх туршилтын багаж, тасалгааны ургамал, хичээлийн хэрэглэл гэх мэт хичээл бүрийн онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн бэлтгэсэн байна.

ҮНЭЛГЭЭ:

Суралцахуйн үр дүн гэдэг нь хичээл сургалтын явцад тухайн нэг хичээлээр суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, ойлголт, хандлага юм. Үнэлгээг суралцахуйн үр дүнд тулгуурлан хийнэ. Бага боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур (www.ebook.eec.mn), шалгуурыг хэрэглэх зөвлөмжийг сургалт үйл ажиллагаандаа ашиглаарай. Мөн явцын үнэлгээг тогтмол ашиглах чухал. Бүлэг сэдвийн ээлжит хичээл бүрийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлгээний шалгуурт нийцүүлэн задалж орууллаа.

БИ

Зорилго: “Би” бүлэг сэдвээр өөрийн бие эрхтнийг таньж мэдэн тэдгээрийн тусламжтайгаар амт, үнэр, бат бөх чанарыг ялган таних, хичээлийн хэрэглэлээ ялган нэрлэж, өдрийн дэглэм мөрдөх, эрүүл ахуйн дэглэм сахих зөв дадал хэвшилд суралцана.

Нэгж агуулга ба суралцахуйн зорилт:

Миний бие		Миний хичээлийн хэрэгсэл
1.16. Мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар биетийн өнгө, хэлбэр, хэмжээ, хөдөлгөөн, амт, үнэр, дуу чимээ, бат бөх чанарыг мэдэрч ялган таних	1.1в. Өдөр тутам хийдэг ажлуудаа дарааллаар нь танилцуулж, өдрийн дэглэмээ зургаар илэрхийлэх	1.1а. Өөрийн хичээлийн хэрэглэлээ нэрлэж, үүрэг зориулалтаар нь ялган таних



Эзэмших мэдлэг, чадвар хандлага:

“Би” бүлэг сэдвээр дараах мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлнэ.

Нэгж сэдэв	Мэдлэг	Чадвар	Хандлага
Миний бие (7 цаг)	A2.Мэдрэхүйн эрхтнүүдээ нэрлэх	B2.Зурган мэдээлэл, өөрийн бие дээр болон тоглоом, биет үзүүлэнг ашиглан, ялгааг ажиглах, нэрлэх, тоолох, тайлбарлах зэрэг дасгалуудыг хийх B3.Сурагчид дуу, шүлэг сонсож ямар мэдрэмж төрснөө илэрхийлэх	B5. Мэдрэхүйн эрхтнээ хамгаалах, хэт ойр ба холоос ном, зурагт үзэхгүй байх, хэт чанга дуу авиа сонсохгүй байх, чихэвч, гар утсыг зөв зохистой хэрэглэх
	A1. Өглөө, өдөр, орой тогтмол хийдэг зүйлийг өдрийн дэглэмийн хуваарь гэж нэрлэдэг болохыг тайлбарлах	B3. Хичээл хийх, амрах цагаа зөв зохицуулах, дасгал хөдөлгөөн хийх зэрэг үйлийг нэрлэх B4.Өдрийн дэглэмийн хуваарь хийж, мөрдөх	B2. Идэвх оролцоотой хандаж өөрийн хуваарьтай болох B5. Хэм хэмжээ, дэгийг баримтлах
Миний хичээлийн хэрэглэл (3 цаг)	A2.хичээлийн хэрэглэл, дүрэмт хувцас, биеийн тамирын хувцас, чөлөөт хувцас	B4. Өөрт байгаа хичээлийн хэрэглэлүүдээ нэрлэх, хэрэглэх зориулалтаар нь ялгаж ангилж ямар хичээлд, хэрхэн, яаж хэрэглэх. B3. Дүрэмт хувцас, биеийн тамирын хувцас, чөлөөт хувцсыг хэзээ, хаана өмсдөг ялгааг таних	B3. Хичээлийн хэрэглэл, хувцсаа цэвэр нямбай, гамтай хэрэглэх

Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ “Би” бүлгийн жишиг ээлжит хичээлийн төлөвлөлтийг, тухайн ээлжит хичээлийн зорилгод нийцүүлэн харгалзах түлхүүр ухагдахууныг олгох юм. Иймд түлхүүр ухагдахууныг аль шинжлэх ухааны суурь чадварыг илүү түлхүүр олгох боломжтойг дараах хүснэгтээс анхаарч үйл ажиллагаагаа төлөвлөнө.

Ээлжит хичээл	Ээлжит хичээлийн зорилго	Түлхүүр ухагдахуун		
		Хүн ба байгаль	Хүн ба нийгэм	Эрүүл мэнд
Юу мэдрсэн бэ?	Өнгө, хэлбэр, хэмжээ, хөдөлгөөнийг мэдрэх	мэдрэхүйн эрхтэн (нүд, чих, хамар, ам, гар)		
Нүдээ хамгаалъя	Нүдээ хамгаалахын тулд зөв дадал зуршилтай болох	нүд-нүдний эрүүл ахуй	нүдээ хамгаалах, зөв ба буруу үйл	
Ямар амттай вэ?	Чихэрлэг, гашуун, исгэлэн, давслаг амтыг яаж мэдрсэнээ хэлэх	амт, амтлах эрхтэн (ам, хэл)		
Ямар үнэртэй вэ?	Анхилуун, сэнгэнэсэн, гоё үнэрийг ямар эрхтний тусламжтай ялган таньснаа хэлэх	үнэр, үнэрлэх эрхтэн -хамар		
Юу сонссон бэ?	Чих сонсох үүрэгтэйг мэдэж, янз бүрийн дуу чимээг ялган таних	дуу чимээ, сонсох эрхтэн-чих		
Юугаар хийсэн бэ?	Гар, хуруугаар тэмтэрч өөрийн хэрэглэдэг зүйлсийг хатуу, зөөлөн, бат бөхийг мэдэрч таних	мэдрэх эрхтэн-гар	Хувийн эрүүл ахуй, гар угаах дараалал	
Гар, шүдээ зөв угааж хэвшье	Гар, шүдээ зөв дарааллаар угааж сурах	шүдний эрүүл ахуй		
Мөрдөж суръя	Өдрийн дэглэмээ дарааллаар нь танилцуулж, зургаар илэрхийлэх		дэг дэглэм	
Чөлөөт цагаа зөв ашиглая	Чөлөөт цагаа зөв өнгөрөөж, юу юу хийж чаддагаа хэлэх		чөлөөт цаг, сонирхол, дуртай зүйл	



Өдрийн дэглэмийн ач тус	Гэр бүлийн гишүүдтэйгээ ярилцаж, өдрийн дэглэм баримталснаар ямар ашиг тустайг мэдэх		өдрийн дэглэм	
Сурагчийн цүнх	Цүнхэнд юу юу байх ёстой вэ? Цүнхээ цэвэрхэн, эмх цэгцтэй байлгаж сурах		эмх цэгц	хүүхдийн цүнхний жин
Хичээлийн хэрэглэлээ зөв хэрэглэж сурцгаая	Хичээлийн хэрэглэлийг зориулалтаар ялган таних, зөв хэрэглэж сурах		хичээлийн хэрэглэл, зориулалт, аюулгүй хэрэглээ	
Дүрэмт хувцсаа зөв хэрэглэх	Сурагч дүрэмт хувцсаа зөв, цэвэр, дүрэм журмаар нь өмсөж сурах		зөв, цэвэр хэрэглээ	
Бид юу сурсан бэ?	Сурагч өөрийн хичээлийн хэрэглэлээ үүрэг зориулалтаар ялган таньж чаддаг болсноо дүгнэх			

“Миний бие” нэгж хичээлээр биеийн бүтцийг нэрлэж, хүрээлэн буй орчны юмсыг мэдрэхүйн эрхтнээр дамжуулан ам, хэл-амталж, хамар-үнэрлэж, чих-сонсож, нүд харж, өнгө ялгаж, гар-тэмтэрч, барьж мэдэрдэг гэсэн үүргийг нь мэдүүлэх чухал. Жишээ нь. Хайрцагт хийсэн зүйлийг харахгүйгээр гараар тэмтэрч юу байгааг таах (<https://youtu.be/Ax7ujAm5Gr8>), дуу авиа сонсоод таалгах гэх мэт суралцахуйн удирдамжид зөвлөмжилсний дагуу хэрэгжүүлэх боломжтой. Тиймээс тохирох арга, оновчтой хэрэглэгдэхүүн бэлтгэж, 5 мэдрэхүйн үүргийг таниулахаас гадна хамгаалах үүргийг ойлгуулахад багш танд хэрэг болох зарим нэмэлт цахим холбоосыг орууллаа.



Эдгээр бичлэгийг хөрвүүлж орчуулах, хэсэгчилж ажиглуулах зэргээр хувирган ашиглах боломжтой. 5 мэдрэхүйн үүрэг: <https://youtu.be/XUMiPK6LZBI>

www.medle.mn Нэмэлт контент “Онцгой нүдний шил” аудио бичлэг

Амтлах буюу хэлний мэдрэх онцлогийг таниулах туршилт хийхдээ гашуун, исгэлэн эсэхийг амтлуулан таниулахаас болгоомжлох хэрэгтэй.

Хичээлийн арга зүйн санаа: **Ямар амттан вэ? /туршилттай хичээл/**

Хичээлийн үе шат	Сурагчийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг
Сэдэлжүүлэлт	Бичлэгийн 0:18 – 0:52 секундын хоорондох хэсгийг үзүүлнэ. Бяцхан хүүхдүүдийн нүүрний хувирлыг харсан уу? Яагаад тэд ярвайсан бэ? Юу амсуулсан бэ? Ямар амттай бол...гэсэн асуултаар эхлүүлнэ.
Багшийн анхаарах зүйл: https://youtu.be/UjjOG_TJ2Jc бичлэгт жаахан хүүхдүүдэд нимбэг амсуулаад илэрч буй хариу үйлдлийг харуулсан бөгөөд бичлэгийг үзэж байх явцдаа сурагчдын нүүрэнд хувирал илэрч буй эсэхийг давхар ажиглаж, илүү мэдрэмжээ илэрхийлж буй сурагчдаас асуугаарай.	
Таамаглал дэвшүүлэх	“Сайн найзын төрсөн өдөр” сэдвийг багш унших явцад найзууд юу ууж, идэж буйг таамаглана. Эхийг аудио хэлбэрээр сонсож болно.
Багшийн анхаарах зүйл: Тэр юу уусан бэ? Тэр юу идсэн бэ? гэсэн асуултад сурагчдаас ирэх хариултыг багш самбарт зурж тэмдэглэнэ. Сурагчид таамаглалыг зурж тэмдэглэнэ. Өнгө ялгахгүй	
Туршилт хийх	Туршилтын хэрэглэгдэхүүн:а/ улаан лооль, улаан алим, б/ тараг, сүүтэй цай, в/ төмсний жигнэмэг, цайны жигнэмэг (чипс, орайз, сахаргүй жигнэмэг зэргийг орлуулж болно) Туршилт хийх дараалал: 1. Гурван хэсэг амттан тус бүрийг урьдчилж, багш жижиглэн бэлтгэнэ. 2. Сурагчид хосоор эсвэл багаар хамтарч нэг нэгэндээ жижиглэсэн зүйлээс амсуулна. 3. Амталж буй оролцогч нүдээ аньж, хамраа чимхэн амсуулсан зүйлийг юу болохыг зажилж, хэлээрээ мэдэрч хэлнэ. 4. Мэдэрсэн зүйлээ ажлын хуудсанд тэмдэглэнэ.



Туршилтын үр дүнгээ танилцуулах	Багийн ажлын үр дүнг амталсан зүйлээ зөв таньсан эсэхийг нэгтгэнэ. Амталсан зүйлээ зөв мэдэрсэн, буруу хариулсан сурагчдын төлөөллөөс хэрхэн мэдэрсэн, зааврын дагуу ажиллах чадсан эсэхийг асууж ярилцан хэл, шүд, хамрын аль нь илүү үүрэгтэй болохыг мэдэрч чадсан эсэхийг тодруулах асуултаар дэмжиж өгөөрэй. Жишээ нь. Алим, улаан лооль хоёрын амтны ялгааг л чухалчлах хэрэгтэй. Сурагчид үр дүнг өөрөө шууд илтгэх боломжгүй багш дэмжиж өгнө.
Багийн анхаарах зүйл: Туршилт зөв хийж эсэхийг нягталж, анхааруулна. Жижиглэж хэрчсэн зүйлээс 1-2 хэсгийг л амсах, Амсах явцад харахгүй, үнэрлэхгүй зажилж, тамшаалж идэх гэдгийг багш эхэлж харуулбал зүгээр. Мөн гэртээ багш болон том хүний зааваргүйгээр өөр зүйлсийн хамаагүй амталж, туршиж үзэхгүй байхыг анхааруулна. Туршилтын үр дүнг танилцуулж байгаа нь туршилтын эцсийн үр дүнг биш бөгөөд багш эцсийн үр дүн болон туршилтаас хүлээгдсэн үр дүн, түүнд үндэслэн гарах дүгнэлт анхаарах зүйлсийг дүгнэлт хэсэгт хэлж өгнө.	
Дүгнэлт	Таамаглал хэсэгт таавар таахдаа харах болон сонсох үйлээр дамжуулан ямар амттай вэ, энэ юу вэ гэж таамагласан. Харин туршилтын үед амтлах буюу хэлний мэдрэмжээ ашиглан ямар амттай болохыг мэдэж чадсан. Бидний хэрэглэдэг хүнсний зүйлс гашуун, чихэрлэг гээд төрөл бүрийн амттай бөгөөд бас эдгээрийн амт чанар нь таарах таарахгүй гэж байх бөгөөд хэтрүүлэн хэрэглэж болгохгүй. Жишээ нь. Чихэрлэг зүйл байнга идэх, хэтрүүлэн идэх нь эрүүл мэндэд муу. Бас гаднаас нь хараад юу нь мэдэхгүй учир тааралдсан бүхнээ таамагар идэж, амсаж болохгүй гэх мэт Бидний биеийн эрхтэн бүхэн өөр өөрийн онцлог ялгаатай, бас чухал үүрэгтэй
Үнэлгээ	Багийн анхаарах зүйл: Өмнөх таамаглалтай холбож, зөвхөн чихэрлэг гашуун зүйлийг мэдрэх гэхээс илүүтэй шингэн, хатуу мөн халуун хүйтэнтэй холбож үдийн цайны халуун ус ундаа уухдаа болгоомжлох, том томоор балгах гэхээс илүү оочилж амсах гэдгийг бас анхааруулж болно. Энэхүү нэгж хичээлээ улирлын эхээр эхний агуулга болж судлахаар төлөвлөгдсөн байгаа тул мэдрэхүйн эрхтний бусад хичээлийн хаана нь оруулахаа багш та зохицуулах боломжтой.
	Хичээлд холбоотой хэрэглэгдэхүүнийг цахим болон цаасан хэлбэрээр бэлтгээд хавсралтад орууллаа. Ажлын хуудасны дасгал даалгавраар, сурагчдын идэвх оролцоогоор үнэлэх боломжтой. http://ebook.eec.mn/books/107/#p=25 -ээс гүйцэтгэлийн түвшнийг судлаарай.

МИНИЙ ГЭР БҮЛ

Зорилго: “Миний гэр бүл” бүлэг сэдвээр гэр бүлийнхээ гишүүдийг танилцуулах, тэдний утасны дугаар, гэрийн хаяг байршлыг шаардлагатай тохиолдолд хэлж мэддэг байх, гэрийн эргэн тойронд болон гэрт байдаг зарим цахилгаан хэрэгсэл болон ахуйн эд хэрэгслийг аюулгүй эсэхийг анзаарч шаардлагатай үед зөв ашиглах аргад суралцана.

Нэгж агуулга ба суралцахуйн зорилт:

Манай гэрийнхэн	Миний гэр орон		
1.2а. Гэр бүлийнхнээ танилцуулах, шаардлагатай үед утсаар холбоо тогтоож чаддагаа харуулах	1.2б. Орчин тойрны зүйлстэй харьцуулж, гэр байраа хаана оршдогийг тодорхойлох	1.2в. Гэр, байрны орчин (тухайлбал, гал тогоо) тойронд хаана, юу байдгийг ажиглаж, зураглах	1.2г. Гэрийнхээ цахилгаан хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааг тодорхойлох

Эзэмших мэдлэг, чадвар хандлага:

“Миний гэр бүл” бүлэг сэдвээр дараах мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлнэ.

Нэгж сэдэв	Мэдлэг	Чадвар	Хандлага
Манай гэр орон (6 цаг)	A1. Гэртээ хамт амьдардаг хүмүүсээ нэрлэх	B3. Өөрийн гэр бүлээ танилцуулах, зурган цомог бүтээх B4. Шаардлагатай үед яах гэж, хэн рүү, ямар дугаар руу залгаж болохыг тайлбарлах, нүдлүүлж тогтоолгох	B2. Идэвх оролцоотой хандаж өөрийн хуваарьтай болох B5. Хэм хэмжээ, дэгийг баримтлах



Миний гэр орон (6 цаг)	А3. Байшин болон гэрийн дотор байгаа зүйлийг зүг чиг, байрлалаар танилцуулах	Б3. Гэрийн хаана, юу байгааг харьцуулж, гэрийнхээ байрлалыг үндсэн 4 зүг чигээр тодорхойлох дасгал даалгавар гүйцэтгэх	В1. Сонирхол Гэрийнхээ хаана юу байгааг мэдэж, гэрийнхэндээ туслах хүсэл, сонирхолтой байх В2. Идэвх оролцоо, өөрийгөө хамгаалах
		Б1. Гэрийнхээ унтлагын болон зочны, гал тогооны өрөөнд хаана, юу байгааг нэрлэж тойм зураг гаргах Б4. Тэдгээрийг ямар зориулалтаар, яаж хэрэглэдгийг тайлбарлах Б5. Нэрлэсэн зүйлээ хэрхэн аюулгүй хэрэглэх талаар ярилцах	В3. Нягт нямбай,эрүүл мэнд В5. Хэм хэмжээ, дэгийг баримтлах байдал
	А2. Гэртээ байдаг цахилгаан хэрэгслүүдийг нэрлэнэ.	Б1.Цахилгаан хэрэгсэлтэй аюулгүй ажиллах дүрмийг харуулсан зурагт тайлбар хийнэ. (хориглосон тэмдэг тэмдэглэгээг зургаар илэрхийлэх)	В3.Цахилгаан хэрэгсэл болон амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй зүйлтэй болгоомжтой харьцах, урьдчилан сэргийлэх дадал хэвшилд сурах


Энэхүү бүлэгт өөрийнхөө гэр бүлийн тухай танилцуулах нь сурагчдад ойр сонирхолтой агуулга байх хэдий ч гэр бүл, хүүхдийн ялгаатай байдал, онцлогийг багш өөрөө сайн судалж, сурагчдыг эмзэглүүлэхгүй байхад анхаарч, өөртөө итгэлтэйгээр бусдад гэр бүлийн тухай танилцуулах, найзынхаа яриаг анхааралтай сонсож, тэдэнд хүндэтгэлтэй хандах зэргээр харилцах, хамтрах, үнэт зүйлийг эрхэмлэхэд сургаарай. Танилцуулгыг төрөл бүрийн ном хэлбэрээр хийж болно. Гэхдээ тухайн хичээлээр олгох гол зүйл юу вэ гэдгийг л чухалчил.



Ээлжит хичээл	Ээлжит хичээлийн зорилго	Түлхүүр ухагдахуун		
		Хүн ба байгаль	Хүн ба нийгэм	Эрүүл мэнд
Гэрийнхнээ танилцуулъя	Өөрийнхөө гэр бүлийн цомгийг хийх		Гэрийнхэн, ам бүл, гэрийнхний тухай, ажил мэргэжил	
Гэрийнхэндээ тусалъя	Гэрийнхэндээ тус болох ажлаа танилцуулах		Өөрийн хийж чадах зүйл, бусдад туслах	
Дээр ба доор Урд ба ард	Үлгэрийн санааг ойлгож, эв нэгдэл, хүндлэл, ач тусыг ойлгох ба байршлыг мэдэх	Байрлал, дараалал (дээр, доор, урд,ард)	Эв нэгдэл Хамтын хүч	
Шаардлагатай үеийн утасны дугаар	Гэрийнхнийхээ утасны дугаарыг цээжлэх, шаардлагатай үед залгаж чаддаг болох		Аав ээж болон гэрийнхнийхээ утасны дугаар,	
Бид юу сурсан бэ?	Гэр бүлийнхнээ танилцуулах, шаардлагатай үед утсаар холбоо тогтоож чаддагаа харуулах		Шаардлагатай тохиолдолд холбоо тогтоох чадвар	
Танайх хаана байдаг вэ?	Өөрийн амьдардаг гэр, байрныхаа байршлыг хэлэхдээ баруун зүүн, урд ард гэсэн үгийг зөв хэрэглэж сурах	зүг чиг-хойд, өмнө, баруун,зүүн		
Өөрийн гэрээ танилцуулаарай	Өөрийн гэрийн хаяг, байршлаа зөв хэлж чаддаг болох		тавилга эд юмсаа зөв нэрлэх	
Болгоомжтой харьцаарай	Гэрийн орчин тойронд байгаа зам талбай, эд материалтай болгоомжтой харьцах		Зам талбайгаар зөв зорчих	
Танайд цахилгаан хэрэгсэл байгаа юу?	Гэртээ байгаа цахилгаан хэрэгслэлүүдээс нэрлэх, зориулалтыг мэдэх	Цахилгаан хэрэгсэл	аюулгүй ажиллагааны дүрэм сануулга мэдэх	
Гэрийн цахилгаан хэрэгсэлтэй ажиллах	Гэр ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгслийг зөв, аюулгүй хэрэглэх энгийн аргуудаас суралцах	Залгуур салгуур унраалга	аюулгүй ажиллагааны дүрэм сануулга мэдэх	



“Миний гэр орон” сэдвээр хаана юу байгаа, хаяг байршлаа зөв нэрлэхээс гадна гэрийн орчин тойронд болон гэрт буй эд материалтай болгоомжтой харьцах, аюулгүй ажиллагаа хэрэгтэй гэдгийг тухайн нас сэтгэхүйн онцлогт тохируулан эзэмшүүлэх чухал. Болгоомж, сэрэмж хэзээ ч илүүдэхгүй. Бие даан суралцахад дэмжлэг үзүүлэх “Зүг чиг” (1.26), “Хэмнээрэй, болгоомжлоорой” (1.2г) интерактив хичээлүүдийг <https://medle.mn/interactivelesson> талбараас үзэх боломжтой.



МАНАЙ СУРГУУЛЬ

Зорилго: “Манай сургууль” бүлэг сэдвээр сургууль орчмын дуу чимээ, тэдгээрийн үйлчлэлийн хэмжээг ялган таньж, эрүүл мэндээ хамгаалах, ангид ургаж буй ургамлыг бүрдүүлж буй хэсгүүдийг зөв ялган нэрлэж, тарьж, ургуулах мэдрэмжийг хөгжүүлнэ.

Нэгж агуулга ба суралцахуйн зорилт:

Сургуулийн гадаад орчин	Сургуулийн дотоод орчин
1.3а Сургууль орчмын дуу чимээг сонсоод ялган таних	1.3б Ангид ургаж буй ургамлын бүтцийн хэсгүүдийг ялган таньж, нэрлэх

Эзэмших мэдлэг, чадвар хандлага:

“Манай сургууль” бүлэг сэдвээр дараах мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлнэ.

Нэгж сэдэв	Мэдлэг	Чадвар	Хандлага
Сургуулийн гадаад орчин (4 цаг)	А1. сургуулийн орчинд хаана, ямар дуу чимээ сонсогдож байгааг сонсож тэмдэглэх	Б1. Сургуулийн орчинд хаана, ямар дуу чимээ сонсогдож байгааг сонсож тэмдэглэх Б4. Өөрийн сонссон, мэдсэн зүйлээ бусдадаа тайлбарлаж, дуу бүхэн ялгаатай сонсогдож байгаа талаар санал бодлоо солилцох Б5. Дуу чимээ эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж болох талаар ярилцах.	В1. Сонирхол Сургуулийн орчимд ялгаатай байдлыг сонирхох В2. Идэвх оролцоо В3. Нягт нямбай байдал В5. Хэм хэмжээ, дэгийг баримтлах Сургууль дээрээ дэг мөрдөж, бусдад саад болохгүй байх
Сургуулийн дотоод орчин (5 цаг)	А1. Ангид ургаж буй тасалгааны ургамлууд аас сонгон, бүтцийн хэсгүүдийг (үндэс, иш, навч, цэцэг) нэрлэх	Б1. Навчис ялгаатай болохыг ангид буй цэцгүүдийг харж тэмдэглэх Б4. Ургамлын цэцгийн өнгө, дэлбийн тоо ширхэг өөр өөр ялгаатай байдлыг харьцуулах, ялгах	В1. Сонирхол Цэцэг ургамлыг таньж мэдэж, тарьж ургуулах сонирхолтой байх В2. Идэвх оролцоо В3. Нягт нямбай байдал В6. Бусадтай харилцах хамтрах

I-III ангид сургууль орчмын дуу, чимээ, дуу хэрхэн үүсдэг болохыг агуулгын залгамж холбоотойгоор судлах бөгөөд 1-р ангид өндөр, нам, чанга сул сонсогдож буйг судлах туршилтыг зөв төлөвлөж, оновчтой хэрэгжүүлбэл уншиж сурах үеэс авиагаа зөв тод дуудахад суралцана. Цаашаа гүнзгийрүүлэн судалж, хүмүүсийн сурч, ажиллаж, амрахад хэрэггүй дуу чимээ саад болдог төдийгүй чимээ шуугианы бохирдол нь хүний сонсголыг муутгаж, эрүүл мэндэд ч нөлөөлдөг болохыг ойлгуулах боломжтой. Иймд сургуулийн хонгил, цайны газар, номын сангаар аялал хийсний дараа чанга, сул дууг мэдрүүлэх туршилт хийгээрэй. www.medle.mn -д интерактив хичээл бий.

Туршилтын санаа: Ямар чимээ тааламжтай сонсогдсон бэ?

Хэрэглэх зүйлс: 00 цаасны гол, том жижиг хэмжээтэй төрөл бүрийн цаасан аяга, төмөр лааз, олсон утас, хатуу цаас гэх мэт

Туршилт хийх аргачлал:

Багш урьдчилан төрөл бүрийн дуу авиа гаргах хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ. Жишээ нь. Савх мод, том, жижиг лааз, цаасан аяга <https://youtu.be/ivSS0Q8J5LY>





Багш чимээ гаргахад сурагчид 00 цаасны гол ашиглан сонсож, чимээг таах, хол ойр буйг таах, чанга сул болохыг эрхий хуруугаараа дохио өгөх зэргээр олон янзаар туршаарай.

Ярилцах асуулт: 1. Ямар чимээ тааламжтай сонсогдсон бэ?

2. Яагаад хөгжмийг чанга сонсож болохгүй вэ? Найзуудтайгаа ярилцаарай.

3. Чи чихээ хэрхэн хамгаалах вэ? гэх мэт

/Хэтэрхий чанга дуу агаараас чих рүү орох үед чих гэмтэж болзошгүй/

Ээлжит хичээл	Ээлжит хичээлийн зорилго	Түлхүүр ухагдахуун		
		Хүн ба байгаль	Хүн ба нийгэм	Эрүүл мэнд
Сургуулийн хаягийг мэдэцгээе	Сургуулийнхаа хаягийг бүтнээр хэлж чаддаг болох		өөрийн сургуулийн хаяг-аймаг, хот, сум, дүүрэг, сургууль	
Сургуулийн орчин дахь дуу чимээг судалцаа	Сургуулийнхаа орчин дахь олон дуу чимээг ялгах	олон төрлийн дуу чимээ түүний хэмжээ	Номын сан, ангид дэг мөрдөх	
Дуу чимээ эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх вэ?	Сонсох эрхтнээ хэрхэн хамгаалах тухай мэдэх, дасгал хийх			чих сонсголоо хамгаалах дасгал хийх
Ангид ургасан ургамлыг ажиглах	Ургамлуудаас сонгон, бүтцийн хэсгүүдийг нэрлэх	үндэс, иш, навч, цэцэг		
Навч урлацгаая	Навчууд ялгаатай болохыг мэдэх	навчны ялгаа-хэлбэр, хэмжээ, өнгө цэцгийн ялгаа	Навчаар бүтээл хийх	
Ургамлын цэцгийг ажиглая	Цэцгийн өнгө, дэлбээний тоо ялгаатай байдгийг харьцуулах, ялгах	цэцгийнхэлбэр, хэмжээ, өнгө, дэлбээний тоо		
Цэцэг урлая	Ургамлын бүтцийн хэсгүүдийг харуулсан бүтээл хийж урлах, зурж дүрслэх			
Ургамлын бүтэц	Урласан цэцэг, навчаа нэрлэж ургамлын хэсгүүдийг ялган таних	ургамлын бүтэц үндэс, иш, навч, цэцэг		

Ангид ургаж байгаа ургамлыг ажиглаж, тэдгээрийн цэцэг, навч, иш үндсийг харьцуулан ажиглахад хэрэглэдэгдэхүүн буюу ургамлаа багш урьдчилан бэлтгэж, туршилттай хичээл явуулах боломжтой. Гэхдээ анги танхимын ялгаатай байдал, орчин хэрэглэдэгдэхүүний хүртээмжийг харгалзан энэхүү зурагт хуудсыг ашиглан нэг, нэг багана эсвэл мөрөөр нь ажиглуулж, илүүц зургийг олох тоглоом тоглуулах, ялгааг нэрлүүлэх зэргээр цэцэгтэй эсэхийг мэдүүлэх боломжтой.

Навч нь бариул илтэс гэсэн хоёр хэсэгтэй бөгөөд зарим навч бариулгүй байдаг учир тийм ялгаатай навч болон дэлбээний тоо, үндэс зэргийг багш өөрөө урьдчилан бэлтгээд сурагчдад үзүүлэх нь зөв байх. Тунгалаг шилэн саванд үрсүүлсэн ургамал, дэлбээний тоо ялгаатай ургамлуудыг харж мэдэрч байж л ойлголт мэдлэг нь гүн бат болно. **Жишээ нь.** Бүтээл хийх, цэцэг урлахад зохиомжлон сэтгэж хийх явцдаа дэлбээний тоог тоолох, навчийг судалтай будуулах боломжтой. 1-р ангийн сурагчдад зориулсан дасгал ажлын дэвтрийн 43-р хуудсыг судалж үзээд, санаа авч хичээлдээ хэрэглээрэй. <https://www.unicef.org/mongolia/media/3001/file/1st%20class.pdf>



Мөн ургамлын зургийг хэсэглээд эвлүүлэх тоглоом болгон бататгах дасгал хийлгэж болно.

Хичээлийн арга зүйн санаа²: **Ургамлыг ажиглая.**



Хичээлийн үе шат	Сурагчийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг			
Ангид ургаж буй ургамлын аль нэгийг сонгон ажиглах	Ангид байгаа ургамлуудыг ажиглаарай. Тэдгээр ургамлаас нэгийг сонгон, харж, барьж, үнэрлэж, хэмжиж үзээд найзтайгаа ярилцаарай. Ажиглахдаа дараах зүйлүүдийг анхааран ажиглаарай.			
	✓ Тасалгааны ургамлын нэр нь юу вэ?			
	✓ Иш нь ямар байна?			
	✓ Навч нь ямар байна?			
	✓ Навчинд бариул байна уу?			
	✓ Ургамлын үндэс харагдаж байна уу? Үндэс нь ямар байгаа бол?			
	✓ Ургамлын цэцгийн өнгө болон дэлбийн тоо хэд байна вэ?			
✓ Ургамал хир өндөртэй байна вэ?				
Багшийн анхаарах зүйл: Ангид байгаа ургамлуудаас сурагчдаас өөрсдөөр нь сонгуулаарай. Учир нь сурагчдад цэцэгт ургамлыг сонгох боломжийг бүрдүүлнэ. Сурагч өөрийн сонгосон ургамлаа ажиглаж судлаад, бусад ургамалтай харьцуулж бүтцийн хэсгүүд болох цэцэг, иш, навч, үндэс зэргийг таньж ялгах нь чухал .				
Дасгалын хуудас дээр ажиллах, зурах, тэмдэглэх	✓ Хүснэгтийг ажиглаарай.	Ургамлын бүтцийн хэсэг 1.  2.  3.  4. 	Ажигласан ургамлын эдгээр хэсгүүдийг зураарай.	
	✓ Эхний багананд ургамлын			
	✓ бүтцийн хэсгүүдийг дүрсэлсэн. Дараагийн			
	✓ багананд өөрийн сонгон ажигласан ургамлын			
	✓ хэсгүүдийг зураарай.			
	✓ Зурсан зургаа бодит өнгөөр нь ялган будаарай.			
	✓ Зурахдаа нэг ижил ургамал ажиглаж			
✓ байгаа найзтайгаа ярилцаж зураарай.				
Багшийн анхаарах зүйл: Сурагчдад ойлгомжтой байх зорилгоор дасгалын хуудсанд ургамлын бүтцийг зургаар илэрхийллээ. Арын баганад өөрийн ажигласан ургамлын хэсгүүд ямар хэлбэртэй, ямар өнгөтэй байгааг харгалзах нүдэнд зурахад нь анхаарч чиглүүлээрэй. <i>Үндсийг төсөөллөөрөө зурах, боломжтой бол багш үндсийг хөрснөөс салган харуулж болно. Эсвэл теле хичээлийн хэсгээс харуулах боломжтой.</i>				
Өөр сурагчийн ажлын хуудастай танилцаж өөрийн ажигласан ургамалтай харьцуулан хэлэлцэх	✓ Хананд байрлуулсан найзынхаа ажлын хуудастай танилцаарай.			
	✓ Өөрийн зурагтай харьцуулан найзтайгаа ярилцаарай.			
	Сурагчид хоорондоо ярилцах үед дараах асуултаар чиглүүлж болно.			
	– Цэцэгтэй байсан уу?			
	– Иш, навч, үндэс байна уу?			
	– Навч нь ялгаатай байна уу?			
	– Өндрөөрөө ялгаатай байна уу?			
– Навчнууд нь бариултай эсэх?				
– Өнгөөрөө ялгаатай байна уу?				
✓ Бататгах дасгал: Үзүүлэн өгөөд бүтцийг дугаарлуулна.				
Багшийн анхаарах зүйл: Сурагчдын ажлын хуудсыг ханын самбарт байрлуулаарай. Сурагчид өөрсдөө сонирхсон зургаа найзаасаа асууж ярилцах боломжийг гаргаарай. Энэхүү хичээлээр сурагч ургамлын бүтцийн хэсгүүдийг ялган таньж нэрлэх нь гол юм. Ургамлууд ялгаатай байдаг тухай 2 дугаар ангид судлах болно.				

Хэрэглэгдэхүүн:

Багшийн бэлтгэх зүйлс:	Сурагчийн бэлтгэх зүйлс:
Ангид ургаж байгаа цэцэгт ургамал /2-оос дээш/, ургамал бүрийн нэрийг бичиж хажууд байрлуулсан байх, ургамлын үндсийг бодитоор эсвэл зургаар харуулах зурган карт, сурагч бүрт дасгалын хуудас, цагаан самбар	үзэг, балын харандаа, өнгийн харандаа, хэмжих зүйл /бал, үзэг, харандаа, шугам, гар, хуруугаа ...гэх мэт.

МИНИЙ НУТАГ

Зорилго: “Миний нутаг” бүлэг сэдвээр хүрээлэн буй орчноо сонирхон судалж, өөрийн орон нутгийн үйлчилгээний газрын байршил, хаягийг нэрлэж, тэдгээрийн үйл ажиллагааны талаар хэлэлцэх, орон нутагт ургадаг ургамлыг ажиглах явцдаа тэжээмэл амьтдын ашиг шимийг ойлгож, үнэт зүйлийг хүндэтгэх хандлага төлөвшинө.

Нэгж агуулга ба суралцахуйн зорилт:

Орон нутаг ба хүмүүс		Орон нутаг ба байгаль	
1.4а Гэр, сургуулийнхаа болон аймаг, сум, хот дүүргийнхээ нэр, хаяг, байршлыг зөв хэлж чаддагаа харуулах	1.4б Орон нутгийнхаа үйлчилгээний газруудыг нэрлэж, тэдгээрийн үйл ажиллагааны талаар хэлэлцэх	1.4в Орон нутагтаа ургадаг хүнсний ногоо болон жимс, жимсгэнийг ялган таних	1.4г Орон нутагтаа амьдардаг гэрийн тэжээмэл амьтдыг нэрлэж, хайрлан хамгаалах арга, ашиг шимийг жишээгээр тайлбарлах

Эзэмших мэдлэг, чадвар хандлага:

“Миний нутаг” бүлэг сэдвээр дараах мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлнэ.

Нэгж сэдэв	Мэдлэг	Чадвар	Хандлага
Орон нутаг ба хүмүүс (4 цаг)	A3. Аймаг, сум, сургууль, гэрийн хаягаа нэрлэх	B1. Гэр, сургуулийнхаа хаягийг цээжлэн тогтоож, бусдад танилцуулах. B3. Аль хот, аймаг, дүүргийн харьяа болохыг хэлж чаддаг болох	B2. Идэвх оролцоо Албан газрын хаяг унших гэж оролдох B3. Нягт нямбай байдал
	A1. Өөрийнхөө болон гэр бүлийнхнийхээ хамгийн их очиж үйлчлүүлдэг газар, байгууллагуудыг нэрлэж, хэрхэн үйлчлүүлдэг тухайгаа жишээгээр тайлбарлах.	B1.Орон нутгийнхаа үйлчилгээний газруудыг нэрлэж, танилцах аялал хийх. B4. Аяллын үед зурж тэмдэглэх, зарим үйлчилгээний ажилтнуудаас хийж буй үйл ажиллагааных нь талаар сонирхсон асуулт асууж, харилцан ярилцах.	B2. Бусадтай хамтран ажиллахыг эрмэлздэг бусдын асуултад хариулах анхааралтай хандахыг эрмэлзэх B3. Туршилтыг зааврын дагуу гүйцэтгэх
Орон нутаг ба байгаль (5 цаг)	A2. Хүнсний ногоо (төмс, лууван, байцаа, сонгино, сармис), жимс жимсгэнэ (алим, улаан лооль, өргөст хэмх) таниж, нэрлэх	B3.Нутгийнхаа таримал болон зэрлэг ургамлын орчны ялгаатай байдлыг ажиглаж харьцуулах B4. Ургамлыг хоол хүнсэнд хэрэглэхээс гадна гоёл чимэглэлийн, бэлэг дурсгалын гэх мэт зориулалтаар нь ангилдаг болохыг танин мэдэх дасгал ажиллах	B1. Цэцэрлэгт хүрээлэн, талбайд очиж ургамал ажиглуулах B4. Асууж, ярилцаж мэдээлэл солилцох
	A2.Өөрийн мэддэг гэрийн тэжээмэл амьтдыг нэрлэж, хайрлан хамгаалах арга, ашиг шимийг ярилцах	B3.Гэрийн тэжээвэр амьтад болон зэрлэг амьтдын амьдрах орчны ялгааг харьцуулах. B4. Амьтдыг хайрлах, өсгөж үржүүлэхэд өөрийн оруулж чадах хувь нэмрээ тодорхойлох	B1. Сонирхол Амьтдыг харйлах, арчлах сонирхол төрөх B2. Идэвх оролцоо, Амьтныг хайрлах, хамгаалах



Орон нутгийн нийтийн үйлчилгээний газруудтай танилцах аялал зохион байгуулах, мэргэжлийн хүмүүстэй уулзалт зохион байгуулах нь тухайн агуулгыг эзэмшихэд илүү үр дүнтэй. Эко сургууль хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдсан “Байгаль хамгаалагчтай аялсан нь” сэдвийн боловсруулалт гарын авлагыг судлаарай.

Ээлжит хичээл	Ээлжит хичээлийн зорилго	Түлхүүр ухагдахуун		
		Хүн ба байгаль	Хүн ба нийгэм	Эрүүл мэнд
Гэрийн хаягаа хэлж өгөөч	Өөрийн гэрийн хаяг, байршлаа зөв хэлж чаддаг болох	Байршил Хаяг	өөрийн гэрийн хаяг	
Миний төрсөн нутаг	Өөрийн сургууль, амьдардаг газрынхаа байршил, хаягийг бусдад хэлж чаддаг болох		өөрийн төрсөн нутгийн бахархалт зүйл	
Миний нутаг	Байгалийн үзэсгэлэнт ба дурсгалт газар, ан амьтны зураг мэдээлэл цуглуулах	Үзэсгэлэнт газар дурсгалт газар		



Нутгийн үйлчилгээний газрууд	Өөрийнхөө болон гэр бүлийнхээ хамгийн их очиж үйлчлүүлдэг газар, байгууллагуудыг нэрлэх		үйлчилгээний газрууд (номын сан, дэлгүүр, театр, эмнэлэг)	Дэглэм мөрдөж үйлчлүүлэх
Бусдыг хүндэтгэх	Үйлчилгээний газруудаар хэрхэн үйлчлүүлдэг болох, бусдад “Баярлалаа” талархлын үг хэлж сурах		мэндчилгээ болон талархлын үг хэрэглэх	
Чи үүнийг мэдэх үү?	Таримал болон зэрлэг ургамлын ялгааг харьцуулан нэрлэх	амьд биеийг ялгах, (амьтан, ургамал)		
Манай нутагт ургадаг жимс, хүнсний ногоонууд	Өөрийн орон нутагт ургадаг хүнсний ногоо, жимсийг ялган таних, нэрлэх	Таримал зэрлэг ургамал		Хүнсний ногоо, жимсний ашиг тус
Жимс, хүнсний ногооны ашиг тус	Жимс, хүнсний ногооны ашиг тусыг мэдэх	ургамлын хэрэглээ, (хүнсний, жимс жимсгэний, тасалгааны, үр тарианы)		
Тэжээмэл амьтан	Тэжээмэл амьтдыг мэдэх, нэрлэх	үнээний сүү, тахианы өндөг, зөгийн бал, тэмээний ноос	Амьтдыг хайрлах, хамгаалах	
Гэрийн тэжээвэр амьтдын ашиг шим	Тэжээвэр амьтдын ашиг шим юу болохыг мэдэх			
Амьтдыг хайрлан хамгаалахад яаж туслах вэ?	Тэжээмэл амьтдыг хэрхэн хамгаалах, яагаад хамгаалах ёстойг мэдэх	зөгийн үүр, малын хашаа, шувууны үүр, загасны хорго		

Хэрэглэгдэхүүний санаа: Орон нутгийн таримал болон зэрлэг ургамлын ялгааг ажиглаж, харьцуулахад зурагт үзүүлэнгээс илүү бодит үзүүлэн чухал. Гэвч бодитоор очиж судлах боломж бүрдэхгүй тохиолдолд багшид урьдчилан ургамлын хатаамал, эсвэл бичлэг аудио бэлтгэж болно. Жишээ нь. www.medle.mn -ний нэмэлт контент хэсгээс “Үлгэр бяцхан түүхүүд” дээрх “Зугаалга” аудио (<https://econtent.edu.mn/additional/261/200002440516624>) бичлэгийг хэрэглэж, аялал зугаалгын үед баримтлах дэг, бусдын үгийг сонсож, хүндэтгэлтэй хандах, байгалиа хайрлах, үнэт зүйлийг эрхэмлэх чадварт дэмжлэг үзүүлэх төдийгүй, жамъянмядаг төмсний улаан цэцгүүд дурдагдаж байгаа нь түүгээр дамжуулан таримал болон зэрлэг цэцгийн ялгаатай байдлыг ярилцах боломжтой. “Соотон”, “Зүүдэндээ ухаарсан нь” гээд олон нэмэлт аудио бичлэгээр дамжуулан сурагчдын сонсох, ярих, харьцуулан дүгнэх чадварыг нэмэгдүүлээрэй. Мөн www.medle.mn -дээрх “Зөгийхөн” (1.4г) интерактив хичээл нь тэжээмэл амьтдын хайрлан хамгаалах, ашиг шимийн талаар ойлголт мэдлэг өгөх тул ялгаатай түвшний сурагчдад бие даан суралцах чадварыг нэмэгдүүлээрэй. Теле хичээлүүдээс хэрэглэгдэхүүний санаа аварай.

МАНАЙ ДЭЛХИЙ

Зорилго: “Манай дэлхий” бүлэг сэдвээр өдөр, шөнө солигдохоос шалтгаалан байгаль эргэн тойрны юмс үзэгдэл, хүмүүсийн амьдрал үйл ажиллагаа өөрчлөгдөж буйг сонирхон судалж, хэм хэмжээ, дэглэм сахих, амьдралын зөв дадал хэвшилд суралцана.

Нэгж агуулга ба суралцахуйн зорилт:

Эх орон, эх дэлхий		
1.5а. Өдөр (гэрэлтэй, дулаан), шөнө (харанхуй, хүйтэн) -ийн ялгааг харьцуулах	1.5б. Байгалийн юмс үзэгдэл нар мандах, жаргахаас хамаарч өөрчлөгддөгийн учрыг жишээгээр тайлбарлах	1.5в Хүний амьдрал, үйл ажиллагаа өдөр, шөнийн урт богино болон улирлаас хамаарч өөрчлөгддөгийг тодорхойлох

Эзэмших мэдлэг, чадвар хандлага:

“Манай дэлхий” бүлэг сэдвээр дараах мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлнэ.

Нэгж сэдэв	Мэдлэг	Чадвар	Хандлага
------------	--------	--------	----------



Эх орон, эх дэлхий (12 цаг)	А2.Өдөр ,гэрэл, дулаан, шөнө, харанхуй, хүйтэн, сар,одыг ялган нэрлэх	Б2. Нар бол гэрэл гаргадаг, дулаан өгдөг гэдгийг ширээний чийдэн ашиглаж, загварчилж харуулах. Б1. Од гэрэл гаргадаг ч, асар хол зайд байгаа тул дулаан өгдөггүй талаар ярилцах. Б2.Сар өөрөөсөө гэрэл гаргахгүй, нарны гэрэл туссанаас бидэнд гэрэлтэж харагддаг гэдгийг таниулах дадлага ажил хийх	В1. Туршилтыг бодитоор хийх В3. Туршилтыг зааврын дагуу гүйцэтгэх В5. Бусадтай хамтарч туршилт хийх өөрийн туршилтыг батлах нотлох
	А2.Нарны мандах ба жаргах зүйгийг ялган тодорхойлох	Б2.Нар мандахад дулаан болж, шөнө нь өдрөөсөө сэрүүн болдгийг нар мандах, хөөрөх, жаргахтай холбон тайлбарлах дасгал ажиллах Б3. Нартай үед ургамал ямар байдаг, наргүй үед яаж өөрчлөгддөгийг бичлэгээс харж тайлбарлах	В1.сонирхон судлах арга барилд суралцуулах В5.Термометр,Халуун ба хүйтнийг харьцуулах хамтарч ажиллах
	А1.өглөө, өдөр, орой юу хийдэг болохоо бусдад танилцуулах.	Б3.Хүний амьдрал, үйл ажиллагаа өдөр, шөнийн алинд нь илүү идэвхтэй байдгийг дүгнэн хэлэлц эх. Б2.Улирлаас хамаарч хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэлт өөрчлөгддөг болохыг ярилцах	В2. Идэвх оролцоо Яагаад өдөр шөнө ээлжилдгийг мэдэх сонирхолтой байх. В3. Нягт нямбай байдал

Энэхүү бүлэг сэдвийн өдөр (гэрэлтэй, дулаан), шөнө (харанхуй, хүйтэн)-ийн ялгааг харьцуулах, байгалийн юмс үзэгдэл нар мандах, жаргахаас хамаарч өөрчлөгддөгийн учрыг жишээгээр тайлбарлах гэсэн агуулга 1-5 дугаар ангид залгамж холбоотой судлах тул 1-р ангиас нь сорил, туршилттай хичээл зохион байгуулж, шинжлэх ухаанч арга барилыг үнэн зөв олгох хэрэгтэй.


Ээлжит хичээл	Ээлжит хичээлийн зорилго	Түлхүүр ухагдахуун		
		Хүн ба байгаль	Хүн ба нийгэм	Эрүүл мэнд
Өглөө, өдөр, орой	Нар мандах, хөөрөх, жаргахад өглөө, өдөр, орой болохыг цаг хугацаагаар баримжаалан тайлбарлах	хоног (нар мандах, хөөрөх, жаргах)	хүмүүсийн өглөө, өдөр, орой хийдэг үйл	
Өдөр яагаад дулаахан байдаг вэ?	Өдөр юунаас болоод дулаахан байдаг, юу дулаан гаргадгийг мэдэх	өдөр- нар мандах, гэрэл дулаан ялгаруулах		
Шөнө, шөнө яагаад сэрүүхэн байдаг вэ?	Нар мандах үед дулаан, нар жаргах үед сэрүүн болдгийг ажиглан мэдэх	шөнө-нар жаргах,сар гарах, одод түгэх		
Нар мандах жаргах үед дэх байгалийн өөрчлөлт	Нартай болон наргүй үеийн өөрчлөлтийг ажиглаж, эргэцүүлэн бодож тайлбарлах			
Ямар улирал вэ?	Жилийн хэдэн улирал байдаг, байгальд ямар өөрчлөлт гардаг талаар мэдэх	байгальд гарах өөрчлөлт		
Улирлын онцлог	Байгальд ямар өөрчлөлт гарч, хүмүүс улирал бүрд юу хийдэг талаар танилцуулах	хавар цас хайлах, зун уул тал ногоорох, намар өвс шарлах, өвөл цас орж хүйтрэх	хүмүүсийн амьдралын онцлог	
Хүмүүсийн амьдрал	Улирлаас шалтгаалж хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэлт өөрчлөгддөг болохыг мэдэх			
Ургамлын нууцыг олъё	Улирлын өөрчлөлтүүд ургамалд хэрхэн нөлөөлдөг, ургамал яаж өөрчлөгддөгийг ажиглан тайлбарлах	мөнх ногоон ургамал	ургац хураах,	
Ургац хураах	“Ургац хураах” гэж юуг хэлдэг, хэзээ ургац хураадаг, түүгээр ямар бүтээгдэхүүн хийж болдог талаар мэдэх	үр тариа, жимс, хүнсний ногоо хураах	бүтээгдэхүүн	

Ээлжит хичээлүүдээр олгогдох түлхүүр ухагдахуунууд “Хүн байгаль”-тай илүүл холбоотой байгааг дээрх хүснэгтээс ажиглаж болно. Иймд сорил, туршилтыг зөв, оновчтой төлөвлөж хэрэгжүүлээрэй.







Видео бичлэг ашигласан туршилтат хичээлийн арга зүйн санаа³

Хичээлийг хосоор ажиллахаар зохион байгуулна. Хичээлд ашиглах видео (хүүхэлдэйн кино)—г https://www.youtube.com/watch?v=dJz_noKP-Bw линкээр татан авч гацалтгүйгээр гарч байхаар бэлтгээрэй. / Youtube – ийн хайх хэсэгт Day and night гэж бичвэл хичээлд ашиглагдах хүүхэлдэйн кино гарч ирнэ. / Видео бичлэг ашиглан туршилтат хичээл зохион байгуулах арга зүйн санааг санал болгож байна.



Хэрэглэгдэхүүн:

Хэвлэж бэлтгэх зураг					Туршилтад хэрэглэх
Хүүхэлдэйн киноны бичлэгээс дараах хэсгүүдийн зургийг өнгөтөөр хэвлэж бэлтгээрэй.					Ширээний чийдэн, теннисний бөмбөг
					
1 дүгээр зураг	2 дугаар зураг	3 дугаар зураг	4 дүгээр зураг		
					
5 дугаар зураг	6 дугаар зураг	7 дугаар зураг	8 дугаар зураг	9 дүгээр зураг	
					Ширээний чийдэнг нар, од болгож ашиглана. Теннисний бөмбөгийг сар болгож ашиглана.

Хичээлийн арга зүйн санаа: Өдөр, шөнийн ялгаа /туршилтат хичээл/

Хичээлийн алхам	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн дэмжлэг
Видео үзэх	Видеог анхааралтай үзэж өдөр, шөнийн ялгааг харьцуулан ажиглана.	Видеог тоглуулахын өмнө юуны тухай гарч байгааг, ямар ямар ялгааг байгааг анхааралтай ажиглахыг сурагчдад сануулна.
Багшийн анхаарах зүйл: Видео нь гацалтгүй гарах бэлтгэлийг сайтар хангаарай.		
Хэлэлцэх	Ажигласан зүйлээ хосоор ярилцахдаа нэг нь өдөр, нөгөө нь шөнө болж өөрийн онцлогуудыг найздаа хэлнэ. Багшийн чиглүүлэх асуултын дагуу ангиараа өдөр, шөнийн тухай хэлэлцэнэ.	Хэвлэж бэлтгэсэн зургуудыг самбарт дарааллын дагуу байрлуулж дараах асуултаар хэлэлцүүлгийг удирдан чиглүүлнэ. - Юуны тухай гарч байна вэ? - Өдөр, шөнө нь ямар ялгаатай байна вэ? - Яагаад өдөр дулаахан байдаг юм бол? - Яагаад шөнө хүйтэн, сэрүүн байдаг юм бол? - Сар дулаан өгдөг үү? - Одноос яагаад дулаан ирэхгүй байгаа вэ? - Нар аль зүгээс мандаж, аль зүгт жаргадаг вэ?
Багшийн анхаарах зүйл: Нар мандах, жаргах зүгийн талаар хэлэлцэхдээ “Өдөр ба шөнө” теле хичээлийн самбарын санааг хараарай. Нар мандахаас жаргах хүртэл өдөр, харин нар жаргахаас мандах хүртэл шөнө үргэлжилдэг гэдгийг аль болох сурагчдаар өөрсдөөр нь хэлүүлээрэй. Мөн нар мандах, жаргахаас хамаарч ургамалд ямар өөрчлөлт гардаг талаар нэмэлт видео үзүүлж хэлэлцүүлж болно.		



Тайлбарлах	Туршилтаас яагаад өдөр дулаан, шөнө хүйтэн байдгийн учрыг ажиглаж тайлбарлана. 1 дүгээр туршилтыг багшийн хэлсэн зааварчилгааны дагуу хийж гүйцэтгэнэ. 2 дугаар туршилтыг ажиглана.	Туршилтын зааварчилгаа Туршилт 1: 4,4-өөр багшийн хэлсэн зааварчилгааны дагуу хийж гүйцэтгээрэй. Нар бол бидэнд хамгийн ойрхон оршдог од юм. Ширээний чийдэнг нар гэж үзье. Чийдэнгээ асаагаарай. Гараа чийдэнгийн гэрэлд ойртуулаад үзээрэй. Одоо гараа холдуулаад үзээрэй. Юу мэдрэгдэж байна вэ? Туршилт 2: Энэ туршилтыг багш хийж үзүүлнэ. Теннисний бөмбөгийг сар гэж үзье. Цонхны хөшгийг хааж ангийн гэрлээ унтраана. Ширээний чийдэнгийн гэрэлд теннисний бөмбөгөө тавьж ажиглуулна. Сар өөрөөсөө гэрэл гаргаж байна уу? Яагаад сар харагдаж байгаа юм бол? гэсэн асуултыг асууж чиглүүлнэ
Багшийн анхаарах зүйл: Зэрэгцээ 4 сурагчийн дунд 1 ширхэг ширээний гэрэл (эсвэл сайн тусгалтай гар чийдэн) байхаар тооцож урьдчилан бэлтгээрэй. Чийдэнгээр тоглож болохгүй, хэн нэгний болон өөрийнхөө нүд рүү тусгаж болохгүй гэдгийг заавал сануулах хэрэгтэй. 1 дүгээр туршилтаас Нар бол гэрэл гаргадаг, дулаан өгдөг, од гэрэл гаргадаг ч, асар хол зайд байгаа тул дулаан өгдөггүй талаар ажиглуулж сурагчдаар тайлбарлуулна. 2 дугаар туршилтаас сар өөрөөсөө гэрэл гаргахгүй, нарны гэрэл туссанаас бидэнд гэрэлтэж харагддаг гэсэн дүгнэлт хийлгэж тайлбарлуулна.		

Үнэлгээний даалгаврын санаа:

_____ Багшийн хэлснийг анхааралтай сонссон.

_____ Найзтайгаа хамт туршилтаа хийж чадсан.



Нөхөх, холбох, хоосон зайд смайл зурах, интерактив дасгалууд байж болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Бага боловсролын сургалтын хөтөлбөр, 2019он, 39,40-р тал
2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж, 2020он, 10-р тал
3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж, 2020он, 11, 12-р тал



2.5. ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн зорилго нь хүнлэг энэрэнгүй, цэвэр ариун сэтгэлтэй, билиг оюун төгөлдөр, монгол үндэстнийхээ хэл, соёлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, хүндэлж хамгаалдаг, эх орноо эрхэмлэн дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан, хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулах ирээдүйн монгол иргэнийг өсгөх, хүмүүжүүлэх, бэлтгэхэд оршино.


Бага боловсролын агуулгаар сурагчид өөрийгөө танин мэдэх, дотоод сэтгэл, мэдрэмж, өөрийн үзэл бодлоо илэрхийлж чаддаг болох, үүн дээр суурилан сэтгэлээ зөв залж, магтаал, сайшаал, зэмлэлийг зөв хүлээн авч сурах улмаар өөрийгөө үнэлж чаддаг болно. Түүнчлэн шинэ мэдлэгийг өмнөх мэдлэгтэйгээ холбож ойлгох, цэгцлэх чадвартай болно

Сургалтын төлөвлөгөөнд 1-р ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг долоо хоног тус бүр 2 цагаар орохоор төлөвлөгдсөн. \БСШУС-ын сайдын 491-р тушаал\

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ

Иргэний ёс зүйн боловсрол хичээл нь сурагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг өдөр тутмын амьдралдаа дадуулан хэвшүүлэхийг шаарддаг онцлогтой.


Хөтөлбөрийн агуулга нь бүхэлдээ өөрийг бус бусдыг эрхэмлэдэг, бусдыг бус өөрийгөө судалж танин мэддэг монголын уламжлалт өв соёлд тулгуурлаж буй юм. Нэгдүгээр ангид ерөнхий агуулга тус бүр хоёр бүлэг сэдвийн хүрээнд судална. (Зураг 1)



Тухайн ангийн сурагчид өөр өөрийн хөгжлийн онцлогоороо ялгаатай бөгөөд тус тусын онцлогтоо тулгуурлан ёс суртахууны үйлийн шинжийг тасралтгүй дагасаар ёс суртахуунтай болдог. Иймд агуулгыг олон талаас нь давтан тайлбарлаж, утга учрыг нь ойлгуулах, тэднээр дүгнэлт, шийдвэрийг нь гаргуулах, улмаар үйлийг дадуулан хэвшүүлэх арга зүйг баримталдаг.

Хичээлийн арга зүйн боловсруулалтын төлөвлөлт

Хичээлийн арга зүйн боловсруулалтын төлөвлөлтийг үзүүлэв. (Зураг 2)



Багш ээлжит хичээл бүрийн зорилгоо тодорхойлохдоо оновчтой тодорхойлох хэрэгтэй. Энэ талаар www.medle.mn-д байгаа цахим контент шалгаруулалтын төлөвлөлттэй танилцахыг зөвлөж байна.

Жишээлбэл: Хичээлийн зорилгыг хэрхэн тодорхойлсныг хэсэгчлэн харуулав.

(Нэгдүгээр хүснэгт)

Нэгдүгээр хүснэгт. 1дүгээр ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн төлөвлөлт

Бүлэг сэдэв	Нэгж хичээл	Суралцахуйн зорилт	Д/д	Ээлжит хичээлийн сэдэв	Хичээлийн зорилго
1.Өөрийгөө таньж хөгжүүлэх	Мэндлэх ёс	1.1.Мэндлэх ёсны төрөл, ялгааг мэдэж, зөв мэндэлж хэвших	1	Мэндлэх ёс \теле хичээл \	Мэнд мэдэх нь хүнийг хүндлэх, эвсэг найрсаг харилцааны үндэс болохыг мэдэх,
			2	Амар сайн байна уу? \теле хичээл \	Өдөр тутмын ба цаг улирлын мэндчилгээний үг хэллэгээс танин мэдэж, зөв хэрэглэхэд сурах
			3	Ахмадаа хүндэлье\теле хичээл \	Ахмад хүнтэй мэндлэх үг, үйлийн онцлогийг таньж мэдэх, хэрэгжүүлэх
			4	Бусадтай хэрхэн мэндлэх вэ?	Дүүмэд хүнтэй болон найзуудтайгаа, нийгмийн орчинд зөв мэндэхэд суралцах
			5	Зочноо угтах ёс	Зочин гийчнээ хүндэтгэн угтах харилцаанд суралцах
			6	Эелдэг мэндлэх ёс	Буруу мэндэлдэг үг, үйлдлээ хянаж засахад суралцах
			7	Биеэр хүндэтгэл илэрхийлэх	Мэндлэхдээ чин сэтгэлээсээ хандах, биеэр хүндэтгэл үзүүлэхэд суралцах
			8	Мэндлэх хүндлэх үйлд дадах \теле хичээл \	Эелдэг зөв мэндэлж, биеэр хүндэтгэл үзүүлэхэд дадах
			9	Бататгал дүгнэлт	Мэндлэх ёсны төрөл ялгаа, хэрхэн зөв мэндэлж дадсанаа бататган дүгнэх



Сурагчдаар эргэцүүлэн бодуулахаас гадна шаардлагатай үйлдлийг бусад хичээл болон сургалтаас гадуурх үйл ажиллагаанд ч хэрэгжүүлж дадал хэвшил болгох нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Тухайлбал нэгдүгээр ангийн иргэний ёс зүйн боловсрол хичээлийн **3.1.1 Таван хошуу малыг ялган нэрлэх** суралцахуйн зорилтыг зурагт үзүүлснээр монгол хэл, дүрслэх урлагийн хичээлтэй интеграц хийж зааж болохоор байна. (Зураг 3)Сурагчдад ёс зүйн боловсрол эзэмшихэд нөлөөлөх хүчин зүйлийн нэг нь эцэг эх, асран хамгаалагчид тул тэдэнд ёс зүйн боловсрол олгох сургалтыг багш зохион байгуулна. Үүнд дараах санаануудыг ашиглаж болно. Тухайлбал:

- ✓ Танхимын бус хэлбэрээр эцэг эхийг түшиглэн зохион байгуулах
- ✓ Хичээлд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх
- ✓ Сайн үйлсийн аян өрнүүлж хүмүүнлэгийн үйлд эцэг эхтэйгээ хамт оролцох
- ✓ Хичээлд зочин эцэг эх, өвөө, эмээг урин оролцуулах
- ✓ Эцэг эхтэй хамтран , чадвар,хандлагын ахиц, амжилтыг үнэлэх гэх мэт эцэг эхийг иргэний ёс зүйн боловсрол хичээлд татан оролцуулж тэдний ёс зүйн боловсрол олгох ажлыг хийж болно.

Өнгөц харахад сургалтын хөтөлбөр ба сурах бичгийн зарим сэдэв агуулга зөрж байгаа мэт боловч **ёс зүйн үнэт зүйлээрээ холбоотой** бөгөөд бага боловсролын сургалтын хөтөлбөр ба сурах бичиг, ээлжит хичээлийн цахим контентын төлөвлөлт, хоорондын уялдаа холбоог нэгж хичээл болон ээлжит хичээл тус бүрээр задлан ангилсныг хүснэгтэд үзүүлсэн байна. (Хоёрдугаар хүснэгт)

Хоёрдугаар хүснэгт. Нэгдүгээр ангийн иргэний ёс зүйн боловсрол хичээлийн хөтөлбөр ба сурах бичгийн агуулгын уялдаа

Нэгж хичээлээр		Ээлжит хичээлээр		Нэмэлт агуулга
Хөтөлбөрт	Сурах бичигт	Сурах бичигт	Ээлжит хичээлийн цахим контент	
Мэндлэх ёс	Мэндлэх ёс	“Мэндийн үг” “Гэгээн өглөө” “Амархан сайн байна уу?”	“Мэндийн үг” - “Мэндлэх ёс”, “Гэгээн өглөө” – “Амар сайн байна уу?”, “Амархан сайн байна уу?” - “Ахмадаа хүндэлье”, “Бусадтай хэрхэн мэндлэх вэ?”, “Зочноо угтах ёс”, “Эелдэг зөв мэндлэхийн учир”, “Биеэр хүндлэл илэрхийлэх”, “Мэндлэх хүндлэх үйлд тусалъя”	
Эрдэм номд хичээнгүйлэн сурах ёс	Хичээлээ анхааралтай сонсож сурах	“Зөв сууж сурцгаая”, “Анхаарай”, “Азтай мөндөл”, “Авхаалж самбаагаа сориорой”, “Сайн сурахад юу хэрэг тэй вэ?”	“Аль нь зөв бэ?”, “Зөв сууж сурцгаая”, “Анхаараарай” – “Анхаарал”, Анхааралтай сонсох арга”, “Авхаалж самбаагаа сориорой”, Анхааралтай сонсохын ач тус”, “Азтай мөндөл” – “Анхааралтай зөв сууцгаая” “Зөв сэтгэлээр сонсох арга”	“Ангийн найзууд”, “Эвийн хүч их”, “Зөвсэг найзууд”, “Ангийн дүрэм”, “Баярлалаа”, “Уучлалт гуйх”, “Ажилсаг хүүхдүүд”
	Хичээлээ өөрийн болгон эзэмшиж сурах		“Бодлоо удирдаж суръя”, “Миний хичээл”, “Хичээлээ хэзээ давтах вэ?”, “Сайн сурахад юу хэрэгтэй вэ?” “Чармайн сурахын ач тус”, “Би чадах болов уу?”, “Би чадна”	

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

Танхимын сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн	- “Монгол ёс зүйн хүмүүжил” сурах бичиг, 2020 он (www.medle.mn) - Бага боловсролын сургалтын хөтөлбөр, 2019 он (www.meds.gov.mn/curriculum-baga) - “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн зөвлөмж ба суралцахуйн удирдамж, 2019 он (www.mier.mn) - А.Оюунтунгалаг, Г.Ариунцэцэг Нийгмийн ухааны сургалт “Иргэний ёс зүйн боловсрол, заах арга зүй”, 2021 он
Цахим сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн	- “Иргэний ёс зүйн боловсрол”-ийн 15 теле хичээл (www.medle.mn) - Үлгэр, бяцхан түүхүүд” нэмэлт контент (www.medle.mn)
Бусад	Ёс суртахуун, хэм хэмжээ, өв уламжлалын тухай хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт тохирсон контент, аудио болон видео бичлэг, цуврал зураг, интерактив даалгаварууд, тухайн ангийн сурагчдын эцэг эхтэйгээ хамтран хийсэн богино хэмжээний бичлэг, багш эцэг эх, сурагчийн үнэлгээний хуудас гэх мэт

ҮНЭЛГЭЭ:

Үнэлгээ нь сурагчдаар ёс суртахууны хэм хэмжээ болон төлөвших үйл түүний шинжийн өөрчлөлтийг үнэлэх бөгөөд өөрчлөлт нь ахиц амжилтыг агуулна. Аль ч үнэлгээний үр дүнг сурагчдад ёс зүйн боловсрол эзэмшүүлэх болон эцэг эхэд зөвлөн туслах үндсэн мэдээлэл болгон ашиглана. Жишээлбэл: Багш, эцэг, эх болон сурагчийн өөрийн үнэлгээний санааг жишээ болгон орууллаа. Сурагчийн нас сэтгэхүйн онцлог болон хичээлийн агуулгад тохируулан баяжуулан хэрэглээрэй.

- Багш ЗАН-ээрээ нэгж бүлэг сэдвээр гаргасан үнэлгээний шалгуураар үнэлж шаардлагатай сурагчдад зөвлөгөө өгч чиглүүлж байх
- Сурагч өөрийгөө, эцэг эх хүүхдээ улирлын эхэнд үнэлээд ахиц буюу дадал хэвшлийн үр дүнг тодорхой хугацааны дараа дахин үнэлж болох юм. Үүнийгээ “Эцэг эхийн үнэлгээний ном” гэж гарган жилийн турш хэрэглэж болно. (Дөрөвдүгээр хүснэгт)

Дөрөвдүгээр хүснэгт

Зөв дадал хэвшил	Өөрийн үнэлгээ			Эцэг эхийн үнэлгээ		
	тогтмол	хааяа	үгүй	тогтмол	хааяа	үгүй
Бусадтай өдөр тутамд мэндэлдэг						
Хичээлээ хийхдээ зөв суудаг						
Гэрийн даалгавраа тогтмол цагт хийдэг						
...						

- Ангид “Жимсний сагс” үнэлгээний самбар ажиллуулж, шинээр өөртөө хэвшүүлж чадсан чадвар бүртээ жимсний зураг нэмж нааж үр дүнг тооцож, сурагчдаар өөрийн үнэлгээ хийлгэж болно.

- Бусдын зөв хандлага нь ямар байгаад ангиараа харилцан ярилцаж байна. Энэ нь 1-р ангиасаа магтаал, сайшаал, зэмлэлийг зөв хүлээн авч сурах, нэгнийгээ шударга үнэлэх эерэг аргад суралцана гэсэн үг. Гэхдээ багш үнэлгээнээс үүдэн эрсдэл гаргахгүй байхад анхаарч ажиллах хэрэгтэй.



Бусдыг анхааралтай сонсдог

Багшийгаа дээдэлдэг

Бусдыг анхааралтай сонсдог



ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН САНАА:

Иргэний боловсрол хичээлийн “Өөрийгөө таньж хөгжүүлье”, “Бусдыг хүндэлж баярлуулъя”, “Монгол ёс уламжлалаас суралцъя” гэсэн 3 үндсэн агуулгаас дараах ээлжит хичээлийн арга зүйн санааг санал болгож байгааг сурагчдынхаа онцлогт тохируулан баяжуулан хэрэглэж болох юм.

Хөтөлбөрийн агуулгын ерөнхий ангилалд	Сурах бичигт	Ээлжит хичээлийн сэдэв
Өөрийгөө таньж хөгжүүлье	Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье	Дуулгаваргүй дэгдээхэй
Бусдыг хүндэлж баярлуулъя	Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс	Багшийг дээдлэх
Уламжлалт өв соёлоосоо суралцъя	Уламжлалт аж төрөх ёс, зан үйл	

Эхийг уншихын зэрэгцээ эхийн утга санаагаар дамжуулан юуг ойлгуулан, судлан шинжилж, танин мэдүүлж, амьдралд дадуулан хэвшүүлэх гэж байгаа вэ? гэдэг зорилгоо тодорхой төлөвлөх хэрэгтэй. Жишээ болгон “Багшийг дээдлэх” сэдэвтэй ээлжит хичээлийн арга зүйн санааг орууллаа.

Хичээлийн арга зүйн санаа 1.

Бүлэг сэдэв: Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье \ Сурах бичгийн бүлэг сэдвээр\

Нэгж хичээлийн сэдэв: Сайн сурагч

Дэд сэдэв: Багш, эцэг эх, асран хамгаалагч, ахмад настны үг, сургаалыг сонсож сурах

Ээлжит хичээлийн сэдэв: Дуулгаваргүй дэгдээхэйнүүд \сурах бичгийн эх\

Зорилго: Үг сургаал үл сонсохын гэмийг танин мэдэх


Зорилт:

- ✓ Эхийн утга санаанаас гэм хийвэл, өөрийгөө шинжих хэрэгтэйг санана
- ✓ Гэм алдаа юунаас үүсдэг болохыг тодорхойлно
- ✓ Тохиолдлыг шинжилж, өөрийн гэмээ таних мэдэхэд суралцана

Хүрэх үр дүн:

МЭДЛЭГ	ЧАДВАР	ХАНДЛАГА
Өөрийн гэмийг мэднэ	Гэм алдаа юунаас үүсдэг болохыг ухаарч ойлгоно	Өөрийн бие, хэл, сэтгэлийг ажиглан гэмээ танин мэдэхэд суралцана

Аргачлал

Үе шат	Багшийн чиглүүлэг	Сурагчийн	Хэрэглэгдэхүүн
Сэргээн санах Алхам 1	Чи аав ээж, эмээ өвөө, багш нарынхаа үг, захиасыг хэр биелүүлдэг вэ? Бодож байгаад, тохирох бөмбөгийг будаарай	- Ургэлж, хааяа, огт биелүүлдэггүй хариултаас сонгоод бөмбөгийг будна 	Ажлын хуудас: Даалгавар 1 Холбоос: https://qrco.de/bdDFQS
Танин мэдэх Алхам 2	Дуулгавартай дэгдээхэй эхийг хэсэгчилж болон бүхлээр нь унших	Дуулгаваргүй дэгдээхэйнүүд Бор бялзуухай голын хажуугийн хайлаас модонд үүр барин өндөглөжээ. Бялзуухай хэдэн дэгдээхэйгээ цаг үргэлж хайрлаж өсгөн, тэжээж байв. Эх бялзуухай "Гэрээсээ битгий гараарай. Усанд унах аюултай шүү" гэж дэгдээхэйнүүддээ байнга захиана. Нэг өдөр царцаа тэдэн дээр нисэн ирж гэнэ. Тэгээд "Та нарын хэн нь над шиг нисэж чадах вэ? Би өндөрт дүүлж чадна. Ямар сайхан гээч" хэмээн сайрхжээ. Үүнийг сонссон дэгдээхэйнүүд "Бид чамаас ч өндөрт нисэж чадна" гээд үүрнээсээ дэрвэн гарлаа. Гэвч усанд унаад "Амь авар" хэмээн хаширалдав. Энэ үед усанд шумбаж байсан галуу тэднийг аварлаа. Яагаад унасныг нь асууж мэдсэн галуу "Онгирич, дураараа ашилбал аюул учирна. Ахмадын үгийг дагавал та нар хэзээ ч буруудахгүй" гэлээ. Галуу дэгдээхэйнүүдийг ээжид нь эсэн мэнд хүргэж өгөв. Түүнээс хойш дэгдээхэйнүүд ээжийнхээ болон ахмадын үгийг сонсдог болжээ.	Сурах бичиг 23-р хуудас https://medle.mn/textbook/4?-type=pdf
Алхам 3	Үйл явдлын дарааллыг олуулах даалгавар гүйцэтгүүлнэ	 Дуулгаваргүй дэгдээхэй эхийн үйл явдлын дарааллыг тунгаан бодож зургийг дугаартай нь холбоно	Ажлын хуудас: Даалгавар 2 Холбоос: https://app.wizer.me/pre-view/5T9FQQ?f-bclid=IwAR1p-FyZQ33IXVjaHI-oRbjJDYSj1K-pfguEz_yr6EK-sT4fc4abwAKc-GTySvtU
Ухаарч ойлгох Алхам 4	Дуулгаваргүй дэгдээхэйнүүд үг сонсохдоо ямар байсан талаар ярилцаж даалгавар 3-ын тохирох хариултыг сонгуулна	Дэгдээхэйнүүдийн гэмийг шинжилж, үг сонсохгүй дуулгаваргүй байсан гэм нь муу үр дагавартай болохыг ухаарч хариултыг сонгож тэмдэглэнэ Үг сонсдоггүй, дуулгаваргүй Үг сонсдог, дуулгавартай	Ажлын хуудас: Даалгавар 3
Багшид зөвлөмж: \Үг сонсдог, үгэнд ордог гэсэн хоёр хувилбараас аль нэгийг сонгож дуулгаваргүй гэдэг үгийн утгыг ойлгуулна.			
Алхам 5	Дэгдээхэйнүүд ээжийнхээ үгэнд ороогүйн улмаас тэдэнд юу тохиолдсон бэ? гэж асууж хосоор нь ярилцуулна	Хамт суудаг найзтайгаа "Дэгдээхэйнүүд ээжийнхээ үгэнд ороогүйн улмаас усанд унаж амиа алдах шахсан тухай ярилцаж муу үр дагаврыг ойлгож авна	Сурах бичиг хуудас 24
Дадан хэв-шүүлэх Алхам 6	Яавал сайн сурагч болох талаар харилцан ярилцаж өгүүлбэрт тохирох үгийг сонгож бичүүлж дүгнэлт хийлгэнэ	<i>Багш, эцэг эх, асран хамгаалагч, ахмад настны үг сургаамыг дуулгавартай сонсож дагавал сайн хүүхэд болно</i> Өөрийн бие, хэл, сэтгэлийг ажиглан гэмээ танин мэдэхэд суралцана	Ажлын хуудас: Даалгавар 4



Алхам 7	Зүйр цэцэн үгийг хичээлтэйгээ холбон дүгнэлт хийлгэнэ	Дуслыг хураавал далай Дуулсныг хураавал эрдэм Зүйр цэцэн үгийн утгыг өнөөдрийн хичээлтэйгээ холбон тунгаан бодож ойлгоод, цээжилж чадсан эсэхдээ үнэлгээ өгнө	Ажлын хуудас: Даалгавар 5 Зүйр цэцэн үг
Анхаарах зүйлс		Багшид өгөх зөвлөмж	
-Энэ хичээлээр Томчуудын үгийг үг дуугүй сонсож,дагаж мөрд хэмээн сургахаас илүү багш, эцэг эх, ахмад хүний үгийг яагаад сонсох хэрэгтэй вэ гэдгийг ойлгуулах нь чухал - Иргэний ёс зүйн боловсрол хичээлээр аль болох буруу зөвийг ялган сураад, зөв дадал хэвшилтэй болох нь чухал гэдгийг ойлгуулахад, хийлгэж байгаа дасгал даалгавар нь, уншиж бичих үйлээс гадна олон хувилбартай байх нь чухал юм.		“Дуулгаваргүй дэгдээхэйнүүд “ эхийг уншиж, ярилцахын зэрэгцээ, харилцан ярилцан , эргэцүүлэн бодсон зүйлээ богино хугацаанд ажлын хуудас дээр будах , холбох, сонгох, нөхөх зэрэг үйлүүд хийх ажлын хуудас бэлдсэн. Мөн ажлын хуудсыг танхим, цахим, хосолсон сургалтаар ашиглах боломжтойгоор интерактив даалгаврыг бэлтгэн холбоосыг оруулж өгсөн .	
Энэ хичээлийн суралцахуйн зорилготой холбоотой теле хичээлээс арга зүйн санаа авахад ашиглахыг санал болгож байна. Теле хичээл: https://medle.mn/telelesson/1/245/830			

Хичээлийн арга зүйн санаа 2.

Бүлэг сэдэв: Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс\ Сурах бичгийн бүлэг сэдвээр\

Дэд сэдэв: Багшийг дээдлэх

Нэгж хичээлийн сэдэв: Багшийг дээдлэх ёс

Ээлжит хичээлийн сэдэв: Багшийг дээдлэх \ бататгах хичээл \

Зорилго: Багшийг дээдлэх учир шалтгааныг ухаарч, ямагт үг, үйлдэл,сэтгэлээрээ дээдлэх

Зорилт:

- ✓ Багшийн эрдмийг санах
- ✓ Багшийн ачийг санах
- ✓ Багш хэзээ ямагт ачтайг санах
- ✓ Багшийг ямагт үг, үйлдэл, чин сэтгэлээрээ дээдлэх



Хүрэх үр дүн:

мэдлэг	ЧАДВАР	ХАНДЛАГА
Багшийг дээдлэх	Багшийг дээдлэх учир шалтгаан, ач тусыг танин мэдэх	Багшийг ямагт үг, үйлдэл, чин сэтгэлээрээ дээдлэх

Арга зүй:

Үе шат	Багшийн чиглүүлэг	Сурагчийн	Хэрэглэгдэхүүн
Алхам1. Сэргээн санах	- Багш ямар ямар үйл хийдэг вэ? Сонгоорой - Интерактив даалгавар ажиллуулж өмнөх хичээлээ сэргээн сануулж, сурагчдаас хариулт авна	-Сургуулийн орчинтой танилцуулсан. -Сурагч хүн ямар байдаг тухай заасан. -Бичих, зурах, бодохыг зааж өгдөг -Өдөр бүр угтан авч, хичээлээ заагаад тарахад аав ээжид нь хүлээлгэн өгдөг гэх мэт өдөр бүр хийдэг үйлийг нь дурдаад зургуудаас сонгоно	



Алхам 2 Танин мэдэх	- “Багш та” эхийг хэсэгчлэн сонсоно  Багш та ☆☆☆☆ 00:00-03:30 хүртэл	- Эхийг анхааралтай сайн сонсоно 	Medle.mn нэмэлт контент Хэсэгчилж авна https://medle.mn/additional/261/200002440538275
Багшийн анхаарах зүйл: www.medle.mn нэмэлт контентын “Багш та” аудио бүхлээр нь ашиглахад агуулга нь их томдох учраас 00:00-03:30 хүртэл хэсэгчилж ашиглахыг санал болгож байна			
Алхам 3 Ухаарч ойлгох	Сонссон эхээ эхнээс нь тунгаан бодоод үйл явдлын дарааллыг санан 4 зургийг зөв байрлуулан дэвтэртээ хэрхэн наах талаар заавар өгч ярилцана	 -Эхийг зургийн дагуу ярилцана -Үйл явдлын зөв дарааллаар байрлуулна -Дараалал зөв эсэхийг нягтлана -Хичээлийн сэдвээ бичнэ - 4 зургаа наана -1-4 хүртэл дугаарлана	“Багш та” эхийн үйл явдлын зурагт үзүүлэн 
	Эхийн утгыг ухаарч ойлгоход чиглүүлэх асуултын дагуу ярилцана	- Эмээ болон эцэг эхчүүд багшийг хэн гэж дуудаж байсан бэ? - Чи Анхаагийн оронд байсан бол “Манай багш эмээгийн багш биш байхад, эмээ яагаад “Та” гэж хайрлаж хүндлээд байгаа юм бол? Гэж бодох байсан уу? - Эмээд багш нарынхаа тухай юу гэж дурссан бэ? - Анхаа багшийгаа дотночлон хүндэлдэг болсон уу?	Асуултад хариулна
	Чиний хувьд багштайгаа харилцахдаа “ТА” гэдэг үгийг хэрхэн яриандаа ашиглах вэ?	- “Багшаа та сайхан амарсан уу? - “Багшаа та миний хийсэн бүтээлийг үзэх үү? - Багшаа та гэж чин сэтгэлээсээ дээдэлнэ	
Алхам 4 Дадан хэвшүүлэх	Багшийг дээдлэн хүндлэх “Та” гэж хүндэтгэн, үг, үйлдлээрээ хэрхэн дадал хэвшил болгохыг ойлгож авсан талаар “Багш та” эхтэйгээ холбон багшийг дээдлэх нь өөрөөс илүүд авч үзэж хүндэтгэнэ гэсэн утга гэж ойлгуулах	Анхаагийн эмээ бүх багш нараа байнга хайрлан дээдлэн дурсан санадаг, аль ч багшийг хүндэтгэн харилцдаг сайхан зан чанарыг ойлгож авч, дадал хэвшил болгоход хичээнэ Хичээл номоо сайн сурах, сайн хүн болж хүмүүжихийн тулд багшийг дээдлэх, чин сэтгэлээсээ хүндэтгэх ёстойг ухаарна	Эцэг эх, багш нарынхаа хэлж захиж, зааж сургаж буй үгийг анхааралтай сонсож, өөрийн төлөө хэлсэн үгэнд нь талархаж, хэрэгжүүлж биелүүлэхийг чармайдаг болно. Харин тэдний хэлсэн үг, сургаалын эсрэг бодол, үг, үйлдлээс зайлсхийдэг болно.
Алхам 5	Үнэлгээний хуудас хэрхэн ажиллах заавар өгнө	Өнөөдрийн хичээлээр багшийг бие, хэл, сэтгэлээр хэрхэн дээдлэх талаарх ойлголтоо нэгтгэн ухаарна	Үнэлгээний хуудас
Алхам 6 Гэрийн даалгавар	Багшийг хэрхэн дээдэлдэг, талаар мэдэж ирэх даалгавар өгнө.	Аав, ээжтэйгээ багшийгаа хэрхэн дээдэлдэг талаар асууж ярилцана	
Багшид өгөх зөвлөмж. Багшийг бие, хэл, сэтгэлээрээ дээдлэнэ, хүндэтгэнэ. Багшид биеэр хүндэтгэсэн үйлдэл үзүүлэх, хүндэтгэлтэй үгээр харилцах, багшийн эрдэм ач тус, багш хэзээд ачтайг сэтгэлдээ санахыг бие, хэл, сэтгэлээр хүндэлж дээдлэх гэнэ.			
Энэ хичээлтэй холбоотой теле хичээлээс арга зүйн санаа авахад ашиглахыг санал болгож байна.			
Теле хичээл: https://medle.mn/telelesson/1/245/830			



Үнэлгээ:

Сурагчид багшийгаа дээдлэж сурахад өөртөө хэвшүүлэх зүйлийг ✓ тэмдэглээрэй.

Хэдийг ч тэмдэглэж болно.

д/д	Бие, хэл, сэтгэлээр хийх үйл	Сонгож тэмдэглэх
1	Анх багштайгаа учирсан тэр өдрөө дурсан бодох	
2	Багшийгаа “Та” гэж хүндэлж харьцах	
3	Багшийн заасан эрдэм, ачийг ангидаа ирэх бүрдээ санах	
4	Багштайгаа инээмсэглэл дүүрэн ярьж байх	
5	Багшдаа биеэр хүндэтгэл үзүүлэх	
6	Багшийнхаа дуу хоолойг үе үе бодож байх	

Ашигласан материал

1. Энхбат.Р, Оюунтунгалаг,А, “Иргэний ёс зүйн боловсрол сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж”, УБ, 2019 он
2. “Монгол ёс хүмүүжил I” сурах бичиг, УБ, 2020 он
3. Оюунтунгалаг,А, Ариунцэцэг,Г, Нийгмийн ухааны сургалт “Иргэний ёс зүйн боловсрол, заах арга зүй”, УБ, 2021 он



2.6. ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Нэгдүгээр ангид сурагчид дүрслэх урлагийн нэр томъёо, зургийн багаж хэрэгслийн ялгааг таньж хэрэглэх түүгээр ажиллах арга барилыг эзэмшихийн зэрэгцээ зураасны төрөл, цэг, толбо, үндсэн дүрс болон нэг ба олон өнгөөр зохиомжлох, эвхээс, нугалаас хийх, баримал барих, зургийн гол ба туслах дүрийг илэрхийлэх арга барилд суралцана.

Зорилго. Сурагч нь хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг танин мэдэх арга барилтай, гоо сайхны мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх, хөгжүүлэх, соёлын өв, уламжлалаа хүндэтгэх хүсэл эрмэлзэлтэй иргэн болж төлөвшинө

Сургалтын хөтөлбөр нь

- “Дүрслэлийн хэрэглэгдэхүүн” багаж хэрэгслийг ашиглах хэрэглээг тодорхойлох
- “Дүрслэлийн хэл” зураас болон өнгө ашиглан зурж дүрслэх
- “Дүрслэн урлахуй” сэдэвт зураг зурах
- “Цаасан урлал” дүрс ашиглан наамал хийх
- “Цаасаар техникийн загвар бүтээх” биет дүрсээр тоглоом бүтээх
- “Урлан бүтээхүй” дүрсийг нугалах, хайчлах аргаар бүтээх
- “Баримлын шавран урлал” барих аргуудыг ашиглан эд зүйл, амьтан бүтээх гэсэн долоон агуулгаас бүрдэнэ.

Зургаан настай хүүхдийн дүрслэн урлах үйлийн онцлог: Хүүхдийн ерөнхий мэдлэгийн хүрээ өргөжиж, юмсын өнгө, хэлбэр дүрс, орон зайг хооронд нь харьцуулан юмсын төсөөтэй болон ялгаатай шинжийг ажигладаг болно. Зурах сэдвийн хүрээ өргөжиж хүн амьтан, байгалийг дүрслэн зурж эхэлнэ. Өөрт таалагдсан үлгэр, хүүхэлдэйн киноны баатар, хүрээлэн буй орчныг өөрийн санаачилга бодол төсөөллөөр зурж дүрсэлнэ. Зурсан зургийн бүтсэн хэсгүүд нь тодорхой хэмжээ, харьцаатай болно. Зургийн сэдэв, дүрслэлд нийцүүлэн өнгө, будгийг сонгож зурна. Багш хүүхдийн эдгээр онцлогуудад тулгуурлаж тэдний хэрэгцээ сонирхолд нийцүүлэн дүрслэх урлаг, технологийн сургалт үйл ажиллагааг оновчтой зохион байгуулна.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫН ХЭРЭГЖИЛТ

Сэдэв 1: Хөгжилтэй найзууд

Тухайн сэдэвт зохиомж нь дараах суралцахуйн зорилтуудыг нэгтгэж цогц бүтээл болгоно.

- 1.1а. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг таньж хэрэглээг тодорхойлох
- 1.1б. Тосон харандаагаар ажиллах арга барилыг зураг дүрслэлд хэрэглэх
- 1.2а. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэх, өрөх аргаар бүтээх
- 1.2б. Үндсэн дүрсийг зохиомжлон наах аргаар бүтээл хийх

Тухайн хөтөлбөрөөр дараах мэдлэг чадвар, хандлагыг эзэмшинэ.

Суралцагчийн эзэмших мэдлэг:

- Харандааны төрлүүд, бийрийн зөв хэрэглээг мэддэг болно
- Наамлын багаж хэрэгслийн төрөл хэрэглээг мэднэ
- Үндсэн дүрсүүдийг нэрлэдэг, ялгааг мэддэг байна

Чадвар:

- Тосон харандаа, өнгийн харандааг зураг бүтээлдээ ашиглаж чаддаг байна
- Бийрийн төрлүүдээр ажиллах арга барилд суралцана
- Хайчийг зөв барьж зураас, хэлбэр дүрсийн дагуу хайчилж чаддаг болно
- Үндсэн дүрсүүдийг өрж, эвлүүлж зохиомжлон нааж чадна

Хандлага:

- Дүрслэн урлах хүсэл сонирхолтой байна





- Дүрслэх урлагийн багаж, хэрэгслийг зориулалтын дагуу ашиглаж аюулгүй ажилладаг болно
- Зурж дууссаны дараа бийр, будгийн нийлүүрээ угааж цэвэр нямбай ашигладаг болно
- Хайчийг бариул хэсгээр нь бусдад дамжуулдаг болно


Анхаарах зүйлс	Багшид өгөх зөвлөмж
• Балын харандаагаар тогшихгүй байх. Учир нь харандааны бал дотроо хугарах эрсдэлтэй тул хүүхдэд сануулна • Будагтай бийрийг амандаа хүргэхгүй байхыг анхааруулна • Харандаа, бийр, хайчаар юм заах, чичлэхгүй байхыг анхааруулна • Хайчны ирийг ангайлгаж тавьж болохгүй гэхчлэн аюулгүй ажиллагааны зааврыг тайлбарлаж өгнө	• Хүүхдэд дүрслэх урлагийн багаж хэрэгсэлтэй аюулгүй ажиллах зөвлөгөө өгөх • Дүрслэх урлагийн багаж хэрэгсэлтэй ажиллах арга барилыг биечлэн үзүүлэх • Хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан тэгш оролцох нөхцөлийг хангах • Бүтээл хийх явцын өнгийн сонголт, зохицолд зөвлөгөө өгөх • Хичээлийн явцад хүүхдийн хэрэгцээ сонирхол, сонголт хийх, шийдвэр гаргахад хүндэтгэлтэй хандах

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН: Сурах бичиг, суралцахуйн удирдамж, балын харандаа, өнгийн харандаа,

Дүрслэх урлаг	Технолги
• Балын харандаа, тосон харандааг зөв барих, зурааслах, будах дасгал • Бодит зүйлсийн үндсэн хэлбэр, бүтэц, харьцааг тодорхой дүрсэлж сурах • Тосон харандаа, өнгийн харандаа, бийрээр хэлбэрийн дагуу будах	• Хайчийг зөв барьж хайчлах дасгал • Цавууг хэлбэрийн дагуу түрхэж наана • Өнгийн цаасаар хавтгайд хэлбэршүүлж зохиомжлон наах

- тосон харандаа, усан будаг, бийр, зургийн дэвтэр, баллуур, будгийн нийлүүр, усны сав, хайч, цавуу, өнгийн цаас гэж бүгдийг
- Цахим сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн Теле хичээл, Интерактив хичээл

Алхам 1 Дүрслэх урлагийн багаж хэрэглэгдэхүүнтэй танилцъя



Зөвлөмж:

- Харандаагаар зурааслахдаа хэт чанга дарахгүй байх.
- Харандаагаар чичлэхгүй байх.
- Бийрийг урд хэсгээс барьж будна.
- Бийрийг будагтай сайтар нийлж босоо чиглэлд барьж будна.
- Өнгө солихдоо сайтар угааж дараагийн будалт хийнэ.
- Будаг дуусаад бийрээ угааж хэлбэршүүлж хатаана.



Будаг найруулах



Хэв ашиглан зурах



Зөв Буруу

Зөв Буруу




Хичээлийн хэрэгслээ хэрхэн зөв сонгох вэ? Холбоосоор ороод үзээрэй.

<http://old.econtent.edu.mn/interactiveAll>

- Харандаагаар ажиллахдаа өөрт хамгийн тохиромжтой барилтаа сонгоорой.
- Тосон харандаа, лааны тосон харандааг хөнгөн дарж будахад бүдэг, чанга дарж будахад тод өнгө гарна.
- Бийрээр будахдаа бийрийнхээ ишнээс өөрт хамгийн тохиромжтой барилтаар барьж хөнгөн дарж хэлбэрийн дагуу будна.
- Зураасыг арилгахдаа баллуураа хөнгөн дарж үрнэ.

Алхам 2 Наамлын багаж хэрэглэгдэхүүн.



Манай улсад хүүхэд хэрэглэхэд зөвшөөрөгддөг худалдаанд зарагдаж байгаа олон янзын цавуу байдаг. Үүнээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг цаасны цавууг танилцуулж байна. Эдгээр нь зөвхөн цаас болон хөнгөн чанарын эд зүйл түүн дотроо цавууг өөртөө шингээх эд материалыг наахад зориулагдсан байдаг.

Цавуугаар наах гэдэг нь хийх, бүтээх зүйлд оролцож байгаа хоёр салангид эд зүйлийн хоёр өөр гадаргууг нэгтгэхийн тулд холбогч эд нь цавуу байх тул эд зүйлийн гадаргууд бага хэмжээгээр шингээнэ гэсэн үг юм. Цавуугаар наахдаа.



Наах хэсгүүдийнхээ гадаргууд бага зэрэг нимгэн түрхээд тасалгааны температурт 20 орчим секунд байлгаад наах зүйл дээрээ нийлүүлэн дээр нь цэвэр цаасаар арчиж гадаргууг жигд нийлүүлж өгөөрэй.

Цаасны цагаан цавуу нь шингэн байдаг тул гадаргуугийн наах хэсэгт түрхээд түрхсэн хэсгээрээ жигд тараахын тулд цэвэрхэн цаас болон наалдац багатай зүйлээр хөнгөхөн арчиж цавуугаа наах гадаргуу дээр тарааж өгнө. Жишээ зураг



Цавуугаа нимгэн түрхээд хатхаас нь өмнө гадаргуугаа нийлүүлэн хөдөлгөөнгүйгээр хаттал байлгаарай. Цаасыг өөр материалтай наахаар бол цагаан цавуугаа хоёр гадаргуу дээрээ түрхээд хэсэг хугацаа өнгөрсний дараа хуруугаа хүргэж мэдэрч үзээрэй энэ үед цавуу гарт чинь наалдахгүй болсон бол цавуугаа ахиж нэг удаа нимгэхэн


түрхээд наагаарай.

Хүүхдүүд та нар цавуугаар ажиллаж байхдаа цавуу түрхэж болохгүй хэсгээ өөр цаасаар хамгаалахаа мартав.

Цавууны төрөл зүйл. Анхаарах зүйл. Цавуу нь маш олон төрлийн эд зүйлийг наах, нэгтгэх тогтоох зориулалттай байдаг тул зориулалтаас хамааран янз бүрийн үнэртэй байдаг юм. Хүүхдүүд та нар янз бүрийн үнэртэй цавуугаар ажиллаж болохгүйг анхаараарай.




Алхам 3 Үндсэн гурван дүрсийг хэлбэрийн дагуу будах, зураасаар чимэглэх.



Зөвлөмж:

- Хүрээнээс гаргахгүй хэлбэрийн дагуу будах.
- Харандаан будгаар будах, зурааслахдаа хэт чанга дарахгүй байх.
- Тосон харандааны урд хэсгээс барьж зөөлөн дарж жигд будна.



Тосон харандаагаар ажилаах арга. Дараах холбоосоор орж үзээрэй <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/dursleh/3073>

Алхам 4 Үндсэн дүрсийг хэлбэрийн дагуу хайчилж зохиомжлон наах дасгал ажил



Зөвлөмж:

- Дүрсийг хэлбэрийн дагуу хайчлахад багш дэмжлэг үзүүлнэ.
- Цавууг цаасны ирмэг хөвөөгөөр жигд түрхэнэ.
- Цавууг хатахаас сэргийлж мөн асгарахаас сэргийлж таглаж тавина.

- Цаасны өнгө, дүрсийн хэлбэрүүдийг нэрлэнэ.
- Дүрсээ дулаан болон хүйтэн өнгөөр ялгана.
- Дүрсүүдийг наахаас өмнө өрж байрлуулж зохимжтой хэлбэрийг сонгоход багш дэмжлэг үзүүлнэ.
- Цавууг хэлбэрийн дагуу түрхэж наана
- Үндсэн өнгийг нэрлэнэ.
- Улаан, шар, хөх өнгүүдийг сонгож будуулна.
- Тосон харандааны өнгийг хөвөнгөөр үрж жигд уусгана.
- Үндсэн дүрсүүдийг хэлбэрийн дагуу дан болон олон өнгөөр дагнаасалж чимэглэнэ.



Сэдэв 2: Халуун орны амьтад

Бүлэг сэдвийн дараа хүүхэд бүр дараах суралцахуйн зорилтуудыг нэгтгэж нэг цогц бүтээл хийнэ.

1.1в. Энгийн хэлбэр дүрс зурахдаа цэглэх, толболох, цэгүүдийг холбох аргыг ашиглах

1.1г. Энгийн дүрсээс бүтсэн эд юмсыг дүрслэхдээ шулуун, долгион, нуман, тахир зураасыг хэрэглэх

1.2д Цаасыг нугалах аргаар бүтээл хийх

Тухайн хөтөлбөрөөр дараах мэдлэг чадвар, хандлагыг эзэмшинэ.

Суралцагчийн эзэмших мэдлэг:

- Цэглэх, толболох аргыг мэддэг болно
- Зураасны төрөл, хэлбэр, нэршлийг мэднэ
- Цаасыг нугалах, ялгааг мэддэг байна

Чадвар:

- Цэглэх, толболон будах арга барилд суралцана
- Шулуун, долгион, нуман, тахир зураасыг зураг бүтээлдээ ашиглаж чаддаг байна
- Цаасыг нугалах, хайчлах аргаар зохиомжлон нааж чадна

Хандлага:

- Цэглэх, толболон будах арга барилаар зураг бүтээл чимэглэх сонирхолтой байна
- Дүрсээр амьтны загвар болон эд юмсыг нугалан хийж гүйцэтгэнэ
- Өөрийн бүтээлээ бусдад тайлбарлана

Анхаарах зүйлс	Багшид өгөх зөвлөмж
• Цэглэх аргыг зураг бүтээл чимэглэхэд балыг харандаа өнгийн харандааг ашиглахгүй байх • Толболон будах аргуудаас сурагчдын харилцан адилгүй байдлыг харж сонголтоо хийх • Хэрэглэгдэхүүнийг долоо хонгийн өмнөөс бэлдүүлэх • Орчноо сайтар бэлдэх /Усны сав, бийрний алчуур, нойтон алчуур, хормогч, ханцуйвч гм/	• Цэглэх аргыг хэрэглэхдээ эсгий бал болон тосон харандааг ашиглуулах • Толболон будахдаа хурууны өндөг, хөвөнтэй саваа, бийр, дардаслах арга барилаас сонгон биечлэн үзүүлэх • Хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан тэгш оролцох нөхцөлийг хангах • Цаасыг тэгш хэмтэй нугалж хэлбэр дүрсэнд оруулахад дэмжлэг үзүүлэх • Хичээлийн явцад хүүхдийн хэрэгцээ сонирхол, сонголт хийх, шийдвэр гаргахад хүндэтгэлтэй хандах


Дүрслэх урлаг	Технологи
• Балын харандаа, бийрийг зөв барих, цэглэх, толболон будах дасгал • Тосон харандаа, өнгийн харандаа ашиглан зураасны төрлүүдээр зохиомжлох дасгал • Зураасаар хэмнэл, давтамж үүсгэх	• Цаас нугалах аргаар амьтдын үндсэн хэлбэр, бүтэц, харьцааг тодорхой дүрсэлж нугалж сурах • Хайчийг зөв барьж хайчлах дасгал • Цавууг хэлбэрийн дагуу түрхэж наана • Өнгийн цаасаар хавтгайд хэлбэршүүлж зохиомжлон наах

Хэрэглэгдэхүүн: Сурах бичиг, суралцахуйн удирдамж, балын харандаа, өнгийн харандаа, тосон харандаа, усан будаг, бийр, сойз, зургийн дэвтэр, баллуур, будгийн нийлүүр, усны сав, шүршигч, хайч, цавуу

- Цахим сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн. Теле хичээл. Интерактив хичээл, Нэмэлт контент

Алхам 1 Цэглэх, толболох, цэгүүдийг холбох





Зөвлөмж:

- Цэглэх арга ашиглахдаа тухайн амьтны загвар дүрсийг урьдчилан бэлдэх.
- Толболох арга ашиглахдаа будгаа урьдчилан бэлдэж ашиглах.
- Гарын хуруугаар толболон будсан тохиолдолд хурууг нойтон алчуураар цэвэрлүүлэх.
- Бийрийг будагтай сайтар нийлж босоо чиглэлд барьж толболон будна.

- Амьтны дүрсээ ямар амьтан болохыг ярилцан тохирох өнгөөр нь будна.
- Цоохор амьтдыг цэглэж, алаг амьтдыг толболох аргаар чимэглэнэ.
- Цэглэхдээ харандаа болон эсгий балаа эрхий, долоовор, дунд хуруугаар тулж үзгэн барилтаар барина.
- Бийр, хөвөнтэй саваагаар толболон будахдаа хөнгөн дарж будна.

Алхам 2 Шулуун, долгион, нуман, тахир зураас.



Зөвлөмж:

- Зураасны төрлүүдийг ажиглуулж нэрлүүлнэ.
- Байгалийн зургийг ажиглуулан ямар зураас байгааг нэрлүүлнэ.
- Зураасууд хэвтээ, босоо, эсвэл ташуу байж болно.
- Гэртээ зураасны төрлөөс бүтсэн ургамал болон мод зурах даалгавар өгнө.

Зураас ашиглан бүтээл хийх арга. Холбоосоор орж үзээрэй

<http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/dursleh/3473>


Алхам 3 Цаасыг нугалах

Цаас нугалаж бүтээл хийх арга.



Цаас нугалж нугалбар хийхдээ ширээгээ сайн цэвэрлэж гадаргууд ямар нэг өөгүй байхыг анхаараарай.



Цаас нугалах хэсэгтээ хэмжээ тавьж шугамаа байрлуулна. Харандаа буюу балаар зөөлөн зурж тэмдэглэнэ.



Шугамаа хөдөлгөхгүйгээр цаасаа хагас нугална дараагаар нь шугамаа авч нугалаасаа улам тодруулна. Мөн өөрөөр нугалах хэсэг нь өнцөг таарсан бол зөвхөн өнцгөө сайтар нийлүүлээд зогсохгүй нугалаасны эсрэг талын ирмэгээ ч сайн тааруулах хэрэгтэй.



Дасгал ажил.





Цаас нугалж бүтээл хийх талаарх аргыг дараах холбоосоор орж үзээрэй

<http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/dursleh/276>

Алхам 4 Халуун орны амьтад сэдэвт наамал

- Тахир зураас ашиглан цаасны дээд хэсэгт уул зурна.
- Доод хэсэгт нь шулуун зураасаар газрыг зурна.
- Нуман зураас ашиглан үүл, дов толгод, нуур, усан хээг зурж болно.
- Долгион зураас ашиглан усны долгио, гол зэргийг зурж буд.



Зөвлөмж:

- Ам дөрвөлжин цаасыг нугалахдаа хоёр үзүүрийг нийлүүлэн үзүүрийг нь хуруугаараа хөдөлгөхгүй дарж бусад хуруугаа ашиглан нугална.
- Тасархай зураас нь нугалах тэмдэглэгээг заана.
- Сумтай нуман зураас нь хавсрах тэмдэглэгээг заана.



- Ам дөрвөлжин цаасыг хошуулдан нугалж зурган зааврын дагуу цэцэг хийхэд багш дэмжлэг үзүүлнэ.
- Дугуй дүрсийг нугалж цэцэг, эрвээхэй, амьтны дүрс үүсгэн нугалж болох бөгөөд сурагчид сурах бичигт дүрслэгдсэнээс өөр дүрсийг сэтгэж хийх боломжоор хангах.
- Нугалаасаас үүссэн дүрсүүдийг эсгий бал, өнгийн цаас ашиглан баяжуулан чимэглэнэ.



Зөвлөмж:

- Дүрсийг хэлбэрийн дагуу хайчлахад багш дэмжлэг үзүүлнэ.
- Урьд нь хийсэн ажлуудаа авч ирэх эсвэл ангидаа хадгалсан байна.
- Дүрсүүдийг өрж байрлуулах наах явцад зөвлөн тусалж дэмжлэг үзүүлэх.

- Халуун орны талаар ярилцах, зураг, дүрс бичлэг үзүүлж сэдэлжүүлж сэдвээ өгнө
- Зураасны төрлөөр зурж бэлдсэн хавтгай дээр ургамал, моддыг байрлуулан наахад багш дэмжлэг үзүүлэх буюу санаа өгөх /бэлдсэн зураг болон наамал байж болно/
- Дүрсүүдийг наахаас өмнө амьтан болон цэцэг хаана байрлавал зохистойг өрж байрлуулан өөрт таалагдаж байвал нааж бэхэлнэ

Сэдэв 3: Дүрс

1.1д. Үндсэн 5 дүрсийн нийлэмжийг эд юмсыг дүрслэхдээ ашиглах

1.2в. Үндсэн дүрсийг эвлүүлж наах аргыг техникийн загвар бүтээхэд хэрэглэх

1.2г. Амьтны ба техникийн загвар бүтээхэд цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж хайчлах аргыг ашиглах

Тухайн хөтөлбөрөөр дараах мэдлэг чадвар, хандлагыг эзэмшинэ.

Суралцагчийн эзэмших мэдлэг:

- Дүрсийн төрөл, онцлогийг мэддэг болно.
- Дүрсээр зохиомжлон эд зүйл, техникийн загвар бүтээх аргыг мэднэ.
- Цаасыг тэгш хэмтэйгээр нугалж хайчлах аргаар амьтны ба техникийн загвар бүтээх аргыг мэднэ.

Чадвар:

- Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэх, өрөх аргаар бүтээж чаддаг болно.
- Дүрсээр зохиомжлон эд зүйл, техникийн загвар бүтээх чадвартай болно.
- Цаасыг тэгш хэмтэйгээр нугалж хайчлах аргаар зохиомжлох чадвар эзэмшинэ.

Хандлага:


- Дүрс ашиглан эд юмс, техникийн загвар бүтээх хүсэл сонирхолтой байна.
- Дүрсээр техникийн болон амьтны загварыг оновчтой хийж гүйцэтгэнэ.
- Өөрийн бүтээлээ бусдад тайлбарлана.



Анхаарах зүйлс	Багшид өгөх зөвлөмж
- Дүрсээр зохиомжлохдоо бодит зүйлийн өнгө бүтэц, хэлбэр хэмжээг сайтар ажиглуулж оновчтой бүтээхэд анхаарна - Загварын дагуу тэнцүү хэсэг болгон нугалж хайчлахдаа тэгш хэмийн зарчмыг баримтлахад анхаарна.	- Дүрсээр зохиомжлох арга барилыг багш биечлэн үзүүлэх - Бодит зүйлийн өнгө бүтэц, хэлбэр хэмжээг сайтар ажиглуулна - Хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан тэгш оролцох нөхцөлийг хангана - Хичээлийн явцад хүүхдийн хэрэгцээ сонирхол, сонголт хийх, шийдвэр гаргахад хүндэтгэлтэй хандана
Дүрслэх урлаг	Технологи
- Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэх, өрөх дасгал - Техникийн болон амьтны загвар бүтээх дасгал	- Дүрсийн онцлог шинж чанар ялгаатай байдлыг өөрийн бүтээлдээ тохируулан сонгож сурна - Цаасыг тэгш хэмтэйгээр нугалж хайчлах аргаар зохиомжлох дасгал

- **ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:** Өнгийн цаас, үндсэн 5 дүрс, харандаа, шугам, хайч, цавуу
- Цахим сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн -Теле хичээл , Интерактив хичээл, Нэмэлт контент

Алхам 1. Үндсэн дүрсийн нийлэмжийг эд юмсыг дүрслэхдээ ашиглах.



Зөвлөмж:

- Эд зүйлийн онцлог, хэлбэр дүрсийн талаар харилцан ярилцаж ажиглалт хийнэ.
- Домбыг дүрслэхэд тохирох дүрсийг сонгоход багш дэмжлэг үзүүлнэ.
- Хүүхдийн бүтээлийг бусдад таниулж магтан сайшаах зэргээр урамшуулна.

Дүрсийн загварчлал

Домбо

- Домбыг дүрслэхэд тохирох дүрсийг сонгож зохиомжилж наана.
- Домбыг өнгийн цаасаар чимэглэж наана.

Үндсэн 5 дүрсийн нийлэмжээр эд юмсыг дүрслэхдээ энэ холбоосоор орж үзээрэй.

<http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/dursleh/3556>

Алхам 2. Үндсэн дүрсийг эвлүүлж наах аргыг техникийн загвар бүтээхэд хэрэглэх

Сургуулийн автобус



Зөвлөмж:

- Автобусны хэлбэр дүрсийн талаар харилцан ярилцана.
- Тохирох дүрсийг нэрлэж сонгоно.
- Цавууг ирмэгийн дагуу түрхэж наахыг сануулна.
- Хүний дүрс бүхий цаасыг жигд давтамжтай наахыг зөвлөнө.

Алхам 3. Амьтны ба техникийн загвар бүтээхэд цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж хайчлах аргыг ашиглах.

- Тэгш өнцөгт цаасыг сонгож автобусны их биеийг хийнэ.
- Автобусанд дугуй наана.
- Багш, сурагчдыг цагаан цаасан дээр зурж цонхны хэсэгт наана.

Суудлын машин



Зөвлөмж:

- Тохирох өнгийн цаасыг сонгож дээрх машины дүрс зурахыг зөвлөнө
- Машины дүрсийг зураасны дагуу хайчлахыг сануулна
- Цавууг хатахаас сэргийлж таглаж тавина

- Ам дөрвөлжин цаасыг тэгш хэмтэй нугалана
- Нугалсан цаасан дээрээ суудлын авто машины дүрсийг зурна
- Зураасны дагуу хайчилна
- Цонхны хэсэгт хөх өнгийн тэгш өнцөгт хэлбэртэй цаас наана

Сэдэв 4: Усан доорх ертөнц

Тухайн сэдэвт зохиомж нь дараах суралцахуйн зорилтуудыг нэгтгэж цогц бүтээл болгоно.

- 1.1е. Усан будгаар ажиллах арга барилыг зураг бүтээлдээ хэрэглэх
- 1.1ж. Нэг ба олон өнгөөр зурсан зургийн ялгааг харьцуулах, зураг дүрслэлдээ ашиглах
- 1.1з. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас гол ба туслах дүрийг таньж тодорхойлох
- 1.2е. Навч өрж наах аргаар амьтны дүрс бүтээх

Тухайн хөтөлбөрөөр дараах мэдлэг чадвар, хандлагыг эзэмшинэ.

Суралцагчийн эзэмших мэдлэг:

- Өнгөний уусалт, санамсаргүй дүрс үүсгэх аргыг мэддэг болно.
- Олон өнгийг зөв хэрэглэх арга, дулаан хүйтэн өнгийн зохицлыг мэднэ.
- Байгалын материалыг нэрлэдэг, ялгааг мэддэг байна.

Чадвар:

- Уусгах, шүрших, үлээх аргыг зураг бүтээлдээ ашиглаж чаддаг байна.
- Бийр, сойз, зэрэг төрөл бүрийн хэрэглэгдэхүүнээр ажиллах арга барилд суралцана.
- Хавтгай дээр байгалийн материал, санамсаргүй үүссэн дүрсүүдийг өрж, эвлүүлж зохиомжлон нааж чадна.

Хандлага:

- Усан будгаар уусгаж будах хүсэл сонирхолтой байна
- Олон өнгөнөөс сонгон өөрийн бүтээлдээ ашигладаг болно
- Навч түүх, хатаах, ангилах, өнгө, хэлбэр дүрсээр ангилан хадгална

Анхаарах зүйлс	Багшид өгөх зөвлөмж
• Усан будгаар ажиллах орчныг сайтар бүрдүүлэх, бийрээр ажиллах явцыг анхаарах, зааварчилга, дэмжлэг үзүүлнэ • Байгалийн материалыг бэлдэх даалгварыг томчуудын дэмжлэг тусламжтайгаар бэлдэх даалгаврыг өгөх	• Хүүхдэд будгаар будах, үлээх, шүршиж будах үед үүсэж болох аюулгүй ажиллах зөвлөгөө өгөх • Усан будгаар уусгаж ажиллах арга барилыг биечлэн үзүүлэх • Хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан тэгш оролцох нөхцөлийг хангах • Бүтээл хийх явцын өнгийн сонголт, зохицолд зөвлөгөө өгөх • Хичээлийн явцад хүүхдийн хэрэгцээ сонирхол, сонголт хийх, шийдвэр гаргахад хүндэтгэлтэй хандах

Дүрслэх урлаг	Технологи
• Бараан өнгөөр уусгаж будах дасгал ажил • Үлээх аргаар санамсаргүй дүрс үүсгэх дасгал • Шүршиж будах дасгал ажил	• Навч өрж наах аргаар амьтны дүрс бүтээх дасгал ажил • Цавууг хэлбэрийн дагуу түрхэж наана • Санамсаргүй үүссэн дүрсийг хавтгайд зохиомжлон нааж дасгал

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН: Сурах бичиг, суралцахуйн удирдамж, балын харандаа, өнгийн харандаа, тосон харандаа, усан будаг, бийр, сойз, зургийн дэвтэр, баллуур, будгийн нийлүүр, усны сав, шүршигч, хайч, цавуу

Цахим сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн - Теле хичээл , интерактив хичээл, нэмэлт контент

Алхам 1 Уусгах аргаар хавтгайг будах



Зөвлөмж:

- Ширээн дээр зургийн хавтан эсвэл будаг болохоос хамгаалсан дэвсгэр тавих.
- Цаасыг норгохдоо шүршигч ашиглах.
- Будахдаа бийрний урд хэсгээс барьж будна.
- Бийрийг будагтай сайтар нийлж босоо чиглэлд барьж будна.
- Өнгө солихдоо сайтар угааж.
- Будаг дуусаад бийрээ угааж хэлбэршүүлж хатаана.

- Уусгаж будахдаа цаасыг шүршигчээр сайтар норгож бийрийг эрхий, долоовор, дунд хуруугаар тулж үзгэн барилтаар барин усан будгийн бараан өнгөнөөс өөрт таалагдсан өнгөө сонгон бүхэлд нь уусгаж будна
- Бийрээр будахдаа бийрний урд хэсгээс барьж хөнгөн дарж хэлбэрийн дагуу будна
- Уусгах явцад цаас хатсан тохиолдолд шүршигчээр нэмж норгон цаасыг босоо чиглэлд байршуулан усыг урсган уусгана.

Алхам 2 Үлээх аргаар санамсаргүй дүрс үүсгэх



Зөвлөмж:

- Үлээх өнгийг будгийн нийлүүрт урьдчилан найруулан бэлдэх
- Үлээхдээ амьсгалаа зөв хуваарилах буюу ойр ойрхон хурдан үлээхгүй байх, амьсгалаа хуримтлуулж хүчтэй үлээх
- Санамсаргүй үүссэн дүрсийг юутай төстэй байгаа талаарх санаа өгч туслан дэмжих

- Будгаа шингэн найруулж дэвтэр дээрээ бийрээр үлээх зүйлээсээ хамааран хэмжээг тааруулан зургийн дэвтэр дээрээ дусаана.
- Үлээхдээ гуурс, хэрэглэж дуусан балны гэр ашиглан дусаасан будгийг хүчтэй, сул зэргээр үлээж туршина.
- Санамсаргүй үүссэн дүрсийг эргүүлж тойруулан юутай төстэй байгааг ажиглан нэрлэж тухайн дүрсийг зураас, цэг, толбо ашиглан тодотгож болно. Жишээ нь нүд, ам, хамар гм.

Алхам 3 Навч ашиглан загасны дүрс бүтээх.





Зөвлөмж:

- Навч түүж хатааж бэлэн болгох хугацаа тооцож урьдчилан бэлтгэх даалгавар өгөх.
- Навч түүхдээ том, жижиг, хэлбэр дүрс, өнгө зэргийг ажиглан төрөлжүүлэн цуглуулах.
- Хатаахдаа тасалгаанд нарны тусгал шууд тусахгүй газар 2-3 хоног байлгаж номын завсар хадгалах.
- Хийж дуусаад дэвтэрт наахгүй хадгалах.

- Өөрийн мэддэг загасны тухай ярилцаж ямар загас хийхээ төлөвлөнө
- Цуглуулсан навчнаас тухайн хийх гэж буй загасанд тохирсон хэлбэр, дүрс өнгөнөөс сонгон тохирч буй эсэхийг өрж байрлуулна
- Бүтээж байгаа загасны нүдийг цагаан цаасан дээр зурж сэлүүр, сүүлийг нааж бэлэн болгож өнгийн будаг, эсгий бал ашиглан өөрийн санаагаар баяжуулан чимэглэж болно

Алхам 4 Хавтгай дээр санамсаргүй дүрс, байгалийн материалаар зохиомжлон наах дасгал ажил



Зөвлөмж:

- Урьд нь хийсэн ажлуудаа авч ирэх эсвэл ангидаа хадгалсан байна.
- Санамсаргүй үүссэн дүрсийг хэлбэрийн дагуу хайчлахад багш дэмжлэг үзүүлнэ.
- Дүрсүүдийг өрж байрлуулах наах явцад зөвлөн тусалж дэмжлэг үзүүлэх.
- Навчтай харьцахдаа үүрэх, хугарах зэрэг эрсдэл үүсэж болзошгүй тул болгоомжтой цавуудах.

- Далай тэнгис, нуур цөөрмийн талаар ярилцах, зураг, дүрс бичлэг үзүүлж сэдэлжүүлж сэдвээ өгнө
- Уусгаж бэлдсэн хавтгайг сойз ашиглан цагаан өнгөөр шүрших арга ашиглан чимэглэнэ
- Дүрсүүдийг наахаас өмнө санамсаргүй үүссэн дүрсээр ургамал шавж, навчин загасаа хаана байрлавал зохистойг өрж байрлуулан өөрт таалагдаж байвал нааж бэхэлнэ

БАРИМАЛ

1.2ж. Баримлын шавартай ажиллах хэрэглэгдэхүүнийг таньж зориулалтыг тодорхойлох.

1.2з. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх аргаар хагас товгор дүрс бүтээх.

1.2и. Баримлын шаврыг цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох, мушгих аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийх.

Тухайн хөтөлбөрөөр дараах мэдлэг чадвар, хандлагыг эзэмшинэ.

Суралцагчийн эзэмших мэдлэг:

- Баримлын төрөл, урлах арга ажиллагааг мэддэг болно.
- Баримлын шаврын төрөл, шинж чанартай танилцана.
- Баримлын багаж хэрэгслийн төрөл хэрэглээг мэднэ.

Чадвар:

- Баримлын шавраар бүтэн болон ингэмэл баримал барих чадвартай болсон байна.
- Баримлын багаж хэрэгслүүдээр ажиллах чадвартай болно.
- Баримлын шаврыг байгалийн материалтай хослуулан барьж чаддаг болно.

Хандлага:



- Баримал барих хүсэл сонирхолтой байна.
- Баримлын бүтээлээ цэвэр нямбай хийж гүйцэтгэнэ.

Анхаарах зүйлс	Багшид өгөх зөвлөмж
• Хүүхдийн хийж буй бүтээл бодит зүйлийн бүтэц, хэлбэр хэмжээ, өнгө зүстэй төстэй болж байгаа эсэхийг анхаарах, зааварчилга, дэмжлэг үзүүлнэ. • Хүүхэд баримлын шаврыг хэлбэржүүлэхэд үүсэх үндсэн хөдөлгөөнийг хийх үед гарын хүчийг тохируулж байгаа эсэхийг анхаарна. • Баримлын багаж хэрэгсэл, засуур модыг зөв зааврын дагуу ашиглаж байгаа эсэхийг анхаарах давтан зааварчилга өгнө.	• Хүүхдэд баримлын багаж хэрэгсэлтэй аюулгүй ажиллах зөвлөгөө өгнө. • Баримал барих, багаж хэрэгсэлтэй ажиллах арга барилыг биечлэн үзүүлэх. • Хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан тэгш оролцох нөхцөлийг хангана. • Баримлын шаврыг холих, өнгө үүсгэх, зохиомжлох үйлд зөвлөгөө өгнө. • Хичээлийн явцад хүүхдийн хэрэгцээ сонирхол, сонголт хийх, шийдвэр гаргахад хүндэтгэлтэй хандана • Хүүхдийн бүтээлийг бусдад таниулах, магтан сайшаах зэргээр урамшуулна.

Дүрслэх урлаг	Технологи
• Баримлын шаврыг таслах, зөөллөх, бөөрөнхийлөх, хавтгайлах, хуйлах, цувих, холбох, өнгө үүсгэх дасгал. • Ерөнхий хэсгээс бусад жижиг хэсгийг илэх, сунгах байдлаар дүрслэх аргуудыг бүтээлчээр ашиглана • Бодит зүйлсийн үндсэн хэлбэр, бүтэц, харьцааг тодорхой дүрсэлж сурна.	• Баримлын багаж хэрэгслүүдийг ашиглах дасгал • Нэмэх, хасах аргаар баримлын эх загвар бүтээх дасгал. • Байгалийн мод, чулуу, дахин ашиглах материалыг баримлын шавартай хослуулан бүтээл урлана. • Төмөр утсан каркасыг баримлын шавраар шавж хүн, амьтны хөдөлгөөнийг дүрслэнэ.

- **ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:** Баримлын шавар (Пластелин – 3D Баримлын шавар), баримлын засуур мод, баримлын хавтан, суурь, төмөр утас, байгалийн материал, дахин ашиглах материал, савх мод, алчуур

- Цахим сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн, теле хичээл, интерактив хичээл

Алхам 1. Баримлын шавартай ажиллах хэрэглэгдэхүүнийг таньж зориулалтыг тодорхойлох



Баримлын шавар

Засуур мод

Зөвлөмж:

- Баримлын шаврыг хэлбэржүүлэх үндсэн хөдөлгөөнийг багш биечлэн хийж үзүүлнэ
- Баримлын шаврыг холбох, бэхлэх, шавах, хасах аргуудыг багш тайлбарлаж хамтран гүйцэтгэнэ
- Баримлын шаврыг хольж өнгө үүсгэх үйл явцыг биечлэн үзүүлнэ
- Баримлын засуур модтой ажиллах арга барилыг багш биечлэн хийж үзүүлж хамтран гүйцэтгэнэ

- Баримлын шаврыг таслах, зөөллөх, бөөрөнхийлөх, хавтгайлах, хуйлах, цувих, шавах, хасах болон хэсгүүдийг хооронд нь холбох үйлдлийг дарааллын дагуу хийлгэнэ.
- Баримлын ерөнхий болон жижиг хэсгүүдийг засуур модоор хэлбэржүүлж дүрсэлнэ.
- 3D Баримлын шаврыг хольж өнгө үүсгэнэ.
- Байгалийн материал, дахин ашиглах материалыг баримлын шавартай хослуулан бүтээл урлана.

Баримлын шавраар ажиллах дараалал:



Хуйлах



Хавтгайлах



Цувих



Мушгих



Бөөрөнхийлөх

Алхам 2. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх аргаар хагас товгор дүрс бүтээх

Тал товгор ингэмэл баримал.



Зөвлөмж:

- Хавтгайлсан шаврыг засуур модоор өөлж хэлбэршүүлнэ.
- Засуур модоор ажиллах арга барилыг багш биечлэн үзүүлнэ.
- Хэвлэж дардаслахдаа хуруугаа гэмтээхгүй байх аюулгүй ажиллагааны зөвлөгөө өгнө.

- 3D баримлын шаврыг дэвсгэрт дээр жигд түрхэж наана.
- Эрвээхийний далавчийг тэгш хэмтэйгээр хавтгайлж шавна.
- Төрөл бүрийн өнгийн шавраар чимэглэнэ.
- Үүл, цэцэгний дүрсийг хэв ашиглаж бүтээнэ.

Алхам 3. Баримлын шаврыг цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох, мушгих аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийх.

Тал товгор ингэмэл баримал



Зөвлөмж:

- Баримлын шаврыг зохист харьцаатайгаар таслан авч гарын алганд бөөрөнхийлж дугуй хэлбэртэй хайвтгайлахыг зөвлөнө
- Баримлын шаврыг зууван хэлбэртэй цувихдаа гарын хүчийг хэрхэн тохируулахыг тайлбарлана
- Засуур модоор ажиллах арга барилыг багш биечлэн үзүүлнэ

- Баримлын шаврыг бөөрөнхийлөх, хавтгайлах, цувих, товойлгон нааж дүрс бүтээх үйлдлийг дарааллын дагуу хийлгэнэ.
- Жимсийг ишэн дээр зохиомжилж наана.
- Навчыг засуур модоор чимэглэнэ.

Баримлын шавраар хавтгайлах аргаар - хагас товгор бүтээл хийхдээ

<http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/dursleh/1616>

Баримлын шавраар жимс хийх арга.

<http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/dursleh/2492>

Ашигласан материал

1. Баярмагнай.З нар, Бага боловсролын, дүрслэх урлаг арга зүй, УБ, 2018 он
2. Нэргүй.А, Жаргал.Б, “Бага боловсролын технологи арга зүй”, УБ, 2021 он
3. Хөхөө.Д, “Багшийн ном” Технологийн бага боловсрол, УБ, 2007 он
4. Батчулуун.С нар, “Дүрслэх Урлагийн боловсрол”, УБ, 2010 он
5. Баярмагнай.З, Сурагчдын зохиомжлох үйлийн баримжааг хөгжүүлэх арга зүй, УБ, 2013
6. Цэдэн-Иш.Д, “Дүрслэх урлаг” багшийн ном УБ, 2012 он
7. Нэргүй.А, Жаргал.Б, “Цаасны ертөнцөөр аялахуй” УБ, 2012 он
8. Маюми.М, Нэргүй.А, “Бага ангийн дүрслэх урлаг, технологи” УБ, 2012 он
9. Жаргал.Б, “Зүймэл даавуун урлал” УБ, 2010 он



2.7. ХӨГЖМИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Бага боловсролын урлагийн сургалтын хөтөлбөрийн зорилгыг¹ “Сурагч нь хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг танин мэдэх арга барилтай, гоо сайхны мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх, хөгжүүлэх, соёлын өв, уламжлалаа хүндэтгэх хүсэл эрмэлзэлтэй иргэн болж төлөвшинө” гэж тодорхойлсон байна. Бага ангийн сургалтын төлөвлөгөөнд нэгдүгээр ангид хөгжмийн хичээлийг 29 долоо хоногт долоо хоногт тус бүр 2 цаг, нийт 58 цаг судлахаар төлөвлөсөн байдаг. Жилийн нийт цагийг бүлэг сэдэвт хуваарилсан жишиг төлөвлөлтийг дараах хүснэгтэд харуулж байна.

Хүснэгт 1. Судлах агуулгыг цагт хуваарилсан жишээ

Бүлэг сэдэв	Судлах цаг
Байгалийн дуу чимээ	14
Хэм, хэмжээ	15
Энгийн хэмнэл	14
Аялгууны хэм, хэмнэл	15
Нийт цаг	58

Хөгжмийн хичээл бол хүүхдэд хөгжмийн мэдлэг чадвар олгох, хөгжүүлэх төлөвшүүлэх зорилго чиглэлтэй багш сурагчдын хамтарсан бүтээлч үйл ажиллагааны нэг хэлбэр юм. Хөгжмийн хичээлийн онцлог бол:

- Багш сурагчид гэсэн 2 субъект байнга харилцан бие биендээ нөлөөлдөг үйл явц;
- Хөгжмийн хичээл бүр нь сурагчдыг хөгжмийн нэр томъёотой танилцуулан дуулах, хөгжим сонсох болон хөгжмийн бусад үйл ажиллагаанд оролцох арга барил эзэмшүүлж тэдэнд бие хүний чанаруудыг төлөвшүүлэх;
- Хөгжмийн хичээл бүр хөгжмийн онол, урлагийн зүй тогтлын тухай шинжлэх ухааны ухагдахуун эзэмшүүлэх тодорхой агуулгыг хэрэгжүүлэх;
- Хөгжмийн хичээл зориулалтын техник хэрэгслээр тоноглогдсон анги танхимд явагддаг онцлогтой.

Бага боловсролын түвшинд сурагчид сонсох, дуулах, хөгжимдөх, хөгжимт хөдөлгөөн, зохион найруулах үйлийн явцад эгшгийн уртааш, хэмнэл, эгшгийн өндөр, эгшиг тэмдэглэгээтэй танилцаж, хөгжмийн хэлэнд суралцах юм.

Нэгдүгээр ангиас эхлээд алгуураар, маш энгийнээр тухайлбал, үе, үг, хэлц үг, зүйр цэцэн үгээр хэмнэлийн дасгал хийх, цаашлаад ноотны дүрс, тэмдэглэгээтэй танилцуулж, хөгжмийн энгийн зэмсэг ашиглан хэмнэлээр хөгжимдөх арга ажиллагааг хэрэгжүүлэхээр сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

Нэгдүгээр ангид хөгжмийн хичээлээр сурагчид хөгжим сонсох, дуулах, энгийн хөгжмийн зэмсгээр хөгжимдөх хөгжмийн аялгуунд хөдөлгөөн хийх, өөрсдөө чөлөөтэй зохиомжлох, хөгжмийн тухай санал бодлоо чөлөөтэй ярилцах, мэдэхгүй зүйлээ бусдаас асуух, хамтран суралцах гэх мэтээр үйл ажиллагааны явцад авьяас чадвараа нээн хөгжүүлэх, сэтгэл хөдлөлөө удирдах, өөрийгөө хөгжүүлэх боломжтой юм.

Хүснэгт 2. Жилийн жишиг төлөвлөлт

Энэхүү гарын авлагыг боловсруулахдаа



Улирал		Нэгдүгээр улирал													Хоёрдугаар улирал							Гуравдугаар улирал							
Долоо хоног		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	1	2	3	4	5	6	7	1	2	3	4	5	6	7	8
Нэгж сэдэв		1.1. Байгалийн дуу чимээ							1.2. Хэм, хэмжээ						1.3. Энгийн хэмнэл							1.4. Аялгууны хэм, хэмнэл							
Суралцахуйн зорилт		1.1а., 1.1б., 1.1в., 1.1г.							1.2а., 1. 2б., 1. 2в., 1. 2г., 1. 2д						1.3а., 1.3б., 1. 3в., 1. 3г., 1. 3д							1.4а., 1. 4б., 1. 4в., 1. 4г.							
Судлах цаг		29 цаг													14 цаг							15 цаг							
Үнэлгээ	Явцын																												
	Бичиг																												
	Аман																												
	Хөндлөнг ийн																												
	Бүлэг сэдвийн																												

- Хөгжмийн ойлголт мэдлэг чадварыг хүүхэд өөрөө бий болгож бүтээх арга зүйг түлхүү оруулахыг эрхэмлэсэн.
- Агуулгыг эзэмшүүлэх явцыг хүүхдийн амьдралын туршлагад тулгуурлан, аливаа юмс үзэгдлийн хөдөлгөөн янз бүрийн хэмнэл, эгшиг аялгуу, хүч, хурдтай байдаг гэсэн санааг илэрхийлж, тэдний өөрсдийнх нь идэвхтэй үйл ажиллагааг өрнүүлэх, арга зүйг сонгосон.
- Хөгжмийн дүрслэл илэрхийллийг мэдрүүлэхдээ хөгжмийн хэлийг ардын дуу хөгжим, аман зохиол /оньсого түргэн хэллэг, сургаал үг, жороо үг, дайралцаа үг/ шүлэг яруу найраг уран зурагтай холбох арга зарчмыг баримталсан.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Ерөнхий боловсролын сургуулийн практикт хөгжмийн хичээл нь сургалт-хүмүүжлийн ажлын үндсэн хэлбэр бөгөөд хөтөлбөрийн агуулгыг олон талт үйлийн явцад буюу сурагчдын дуулах, сонсох, хөгжимдөх, бүжиглэх, бүтээлчээр сэтгэх бодит чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлнэ. I ангид 7 хоногт 2 цаг орох хэдий ч дараах байдлаар агуулгыг багцалж хэрэгжүүлэх боломжтой ба “econtent” дээр байршуулсан теле хичээлийг ч ашиглах боломжтой юм.

Хүснэгт 3. I ангийн агуулга буюу суралцахуйн зорилтыг багцалсан байдал

	Хөгжим сонсох	Дуулах	Хөгжимдөх	Хөгжимт хөдөлгөөн	Зохион найруулах
Агуулга буюу суралцахуйн зорилт	1.3.а, 1.4.а Дуу, бүжиг, маршийн төрөл зүйлийг сонсох, сэтгэгдлээ илэрхийлэх, айзам хэмжээ, хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлох	1.3.б, 1.4.б Сонсголын тогтоолт дээр тулгуурлан 2 ба 3 хувьт хэмд дууны утга агуулгыг ойлгож, сэтгэл хөдлөлөө илэрхийлэн, гоцлол болон найрлаар дуулж чадахаа харуулах	1.3.в, 1.4 Хоёр ба гурван хувьт хэмд хэмнэлээр хөгжимдөх, хялбар дуу аялгуунд хамсраа хийж, гоцлол болон найрлаар хөгжимдөж чадахаа харуулах	1.3.г, 1.4.г Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг тодорхойлж, тохирох дүрийг (цэцэг, амьтад...) хөдөлгөөнөөр илэрхийлэх, айзам хэмжээ, хурд хүчийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулах, өөрийнхөөрөө баяжуулах	1.3.д, 1.4.д Янз бүрийн хэмнэлээр тодорхой дүр бүтээх, сэдэвт тоглоом зохиож хамтран тоглох /морьд, бороо, марш, бүүвэй.../

Агуулгыг багцалж хэрэгжүүлэхээс гадна видео бичлэг болон цахим эх сурвалжид тулгуурлан хэрэгжүүлж болно. Хөгжмийн хичээлийн зарим агуулгыг сурагчдад ойлгомжтой видео хэлбэрээр цахим хуудсуудад тавьсан байдаг. Эдгээр эх сурвалжаас багш судлах агуулгад тохирсон бичлэгийг сонгон хичээлдээ хэрэглэвэл сурагчдын мэдлэг, гүйцэтгэх чадвар сайжрах боломж их бий. Хичээлийг видео бичлэгт тулгуурлан явуулахдаа дараах арга зүйд анхаарахыг зөвлөж байна.Үүнд:

- Хичээл дээр үзүүлж буй бичлэгийн хэмжээнээс хамааран сурагчдын анхаарлын төвлөрөл сулрах, залхах зэрэг байдал ажиглагддаг учир бичлэг сонгохдоо түүний үргэлжлэх хугацаанд анхаарах хэрэгтэй.
- Сурагчдад бичлэг үзэх явцдаа янз бүрийн аргаар тухайлбал, тэмдэглэл хөтлөх, зураглах, дагаж хөгжимдөх зэргийг санал болгох нь идэвхтэй үзэх боломж үүсгэдэг. Сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан анги нийтээр нэг арга санал болгох,

эсвэл өөр өөр арга санал болгохыг багш шийдвэрлэнэ. Жишээ нь: салаагаар, хосоор, эрэгтэй, эмэгтэй сурагчдаар гүйцэтгэх гэх мэт.

- Бичлэгийг шаардлагатай хэсэг дээр зогсоож, багш тайлбар хийх, ярилцлага хийх зэргээр тохируулах боломжтой. Жишээ нь:

Суралцахуйн зорилт: 1.4в. Хоёр ба гурван хувьт хэмтэй дуу аялгуунд хэмнэлийн хамсраа хийж, хэмнэл хэмжээ нийлүүлэн хамтран хөгжимдөж чадахаа харуулах

Сэдэв: Би дуучин (2020.12.16 - ны теле хичээл)

Энэ хичээлд 2 видео бичлэг үзүүлсэн. Үүнд:

1. Хэмнэлийн дасгал (https://www.youtube.com/watch?v=cflEhnYQulA&list=PL1_s1haH2_UnuqVSKKIBZWmrBi5SWaGib&index=11)
2. “Би дуучин” дуу (<https://www.youtube.com/watch?v=fnuS0RJLtC8>)


Эхний бичлэг нь шинэ мэдлэг эзэмшүүлэхийн өмнө түүнтэй холбоотой хэмнэлийн бичлэг үзүүлж, сурагчдын анхаарлыг татах, сонирхлыг төрүүлэх, сэдэлжүүлэх зорилготой байсан.

Дараах бичлэг нь хэмнэлийн дасгалтай холбоо бүхий дууны бичлэг бөгөөд сурагчдад энгийн хэмнэлийг таниулахад чиглэгдсэн болно.

Видео бичлэгт тулгуурлан хичээлийг зохион байгуулах нь сурагчдын сонирхлыг татах, хүүхэд бүрт хүрч ажиллах, өмнөх хичээлийг сэргээн сануулах, бататгах, шинэ мэдлэг эзэмшүүлэх зэрэгт хугацаа алдахгүй байх зэрэг олон давуу талтай байдаг. Бататгал хичээлийг 2 хэлбэрээр явуулж болох юм. Үүнд:

а. Сурагчдаар хөгжмийн энгийн зэмсэг ашиглан энгийн хэмнэл бүхий хэмнэлийн дасгал ажиллуулах боломжтой. Тухайлбал, бичлэгтэй холбоотой дараах даалгаврыг ажиллуулан, сурагчдын гүйцэтгэлийг рубрик, болон өөрийн үнэлгээний хуудсаар үнэлэн, суралцахуйн зорилтын агуулгыг хэрэгжүүлэх боломжтой юм. Жишээ нь:

- Амьтдын зургийг анхааралтай ажиглаарай. Том - 1, жижиг - 2 удаа алга ташин хэмнэлээр тоглоорой.



- Хэмнэлийн зураглалыг ажиглаарай. Хэдэн хувь байна вэ? хэмнэлээр тоглоорой.



б. Сурагчдаар өгөгдсөн хэмд хэмнэл зохиолгох ба ингэхдээ хэлц үг, хэл зүгшрүүлэх дасгал, оньсого таавар, өөрсдийн дуртай жимс жимсгэнийг нэрлүүлж, үеэр таслуулан хэмнэл зохиолгож болно. Жишээ нь:

- Үеэр тасалсан үгийг ажиглаад алга ташаад, дүрсээр хэмнэл зохиолгож болно.


Энэ дасгалыг олон хувилбартайгаар хийлгэнэ.

Сайн морь э – зэн – тэй

Сайн хүн нө – хөр - тэй



- Хөгжмийн энгийн зэмсэг ашиглан гоцлол, цөөхүүл, найрлаар нэгэн зэрэг хөгжимдөөрэй.



Багшид санамж

Хэмнэл бол айзмын хүчтэй ба сул хувийн ээлжлэлтэд тулгуурлан урт богино эгшгүүд зохион байгуулалтад орох дараалал. Гэтэл сурагчид хүчдэлийн тухай ойлголтыг айзам дахь хүчтэй, сул хувь хоорондын хамааралд тулгуурлан ойлгосон, гүйцэтгэх магадлал өндөр байдаг. Иймд багш хөгжмийн хэлний хэрэглүүр, түүний тухай ойлголт, нэр томъёог таниулахдаа тэдгээрийн холбоо хамаарал цогц нийлэмж, ялгаатай байдалд анхаарлаа хандуулах шаардлага байна.

7 настай хүүхдийн хоолой сул эцэж цуцах нь амархан байдаг бөгөөд тасралтгүйгээр дуулах хугацаа 4-5 минут байна. Энэ насний хүүхдийн хоолойд эрэгтэй эмэгтэй гэсэн ялгаа байхгүй. 1 ангийн хүүхдийн хоолойн диапозон с1-с2 толгойн резенаторт дуулна. Энэ насний хүүхдийг хэт удаан дуулуулсанаас дуу хоолойн аппарат өвчилдөг. Ардын аман зохиолоос түргэн хэллэг зүйр үг болон сургаал үг ашиглан амьсгааны багтаамжийг тэлэх, хэллэг зүгшрүүлэх, дикц сайжруулах, ритмийн сонсголыг хөгжүүлэх, улмаар аялгуунд хадаж транспозицтай дуулсанаар хоолойн диапозон өргөтгөх, амьсгааны багтаамжаа тэлэх ач холбогдолтой.

Хүүхдэд бэлэн мэдлэгийг их хэмжээгээр олгох юм шиг ойлгодог нь өрөөсгөл бөгөөд хүүхдэд хүндээр тусдаг Тиймээс хөгжим сонсох үйл ажиллагаагаар уран зураг, уран зохиол, шүлэг яруу найраг кино, үлгэртэй холбон дүр бүтээх байдлаас хийсвэрлэх, улмаар санаа бодлоо ярилцах бие биенээ сонсох, ажиглах, харьцуулах, өөртөө үнэлгээ өгөх зэрэг логик сэтгэхүйн олон талт үйлийг хийж байгаа юм. Хөгжмийн зохиолыг эхнээс нь дуустал анхаарлаа төвлөрүүлж тэвчээртэй сонсож сургах. Сонсохдоо Яагаад? гэсэн асуултыг тавьж түүнд хариулах эрэл хайлтыг хийж сурах ба улмаар түүнд хариулахын тулд бодож сэтгэх шаардлагатай болно. Ийм учраас хөгжим сонсоно гэдэг бол **“сонсголын ажиглалт хийнэ”** гэсэн үг бөгөөд сонсголын ажиглалтаар хөгжмийг хүртэж мэдэрнэ.

6-7 настай хүүхдүүд дуу болон дан хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг тодорхойлох, түүнд тулгуурлан хөгжмийн зарим нэг онцлогийг бие дааж илрүүлэх чадвартай байдаг.

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ

Бага боловсролын түвшинд тусгайгаас ерөнхийд буюу аливааг хийж гүйцэтгэх явцдаа сурах арга барил (суралцахуйн зорилтоор томъёологдсон) эзэмшихэд арга зүйгээ чиглүүлнэ.

1. Сонсох чадварыг хөгжүүлэх:

Сэдэв: Хөгжмийн төрөл зүйл /дуу, бүжиг, марш/-ийг сонсож хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлох

МЭДЛЭГ:	ЧАДВАР:	ХАНДЛАГА:
Хөгжмийн төрөл зүйл /дуу, бүжиг, марш/-ийг сонсож	Хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлох	бие биенээ сонсох

Үндсэн ойлголт:

- Дуу, бүжиг, марш

Хэрэглэгдэхүүн:

а. Цахим нөөц хэрэглэгдэхүүн:



- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/9>
- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/3161>
- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/480>

б. Хэвлэмэл нөөц хэрэглэгдэхүүн: Оюунбилэг, Ч. ба бус., (2013) ХӨГЖИМ 1, УБ

Үйл ажиллагааны дараалал:

Хөгжмийн зохиолыг анхлан эзэмшүүлэхэд хөгжмийн төрөл зүйлтэй танилцуулах нь чухал. Иймээс хөгжим сонсох үйл ажиллагаагаар бид дуу бүжиг маршийг сонсгож “Тулгын гурван чулуу”- тай танилцуулна. Марш сэдвийн хүрээнд Жагсаалын марш, Амьтдын марш гэсэн хоёр зохиол сонсгож болно.

Алхам 1. Багш жагсаалын марш, сонгодог хөгжим эсвэл вальсыг сонгон авч харьцуулан сонсоно.

Алхам 2. Үүний дараа аялгууны шинж төрхийг тодорхойлно (баяр баясгалан, урам зориг, эрч хүч)

Алхам 3. Аялгуунд тохирох өнгө будгийн сонголт хийлгэх (хурц тод гэрэл гэгээ)

Алхам 4. Хөгжмийн хэмнэлд тохирох хөдөлгөөн хийлгэнэ. Ингэхдээ нэг хөгжим сонсгоод тохирох хөдөлгөөн хийлгэх, дараагийн хөгжим сонсгоод тохирох хөдөлгөөн хийлгэх буюу нэг дор бүх хөгжмөө сонсгоод дараа нь хөдөлгөөнөө хийж болохгүй юм.



Алхам 5. Зургийг ажиглан хөгжмөө сонсоод хэмнэлд тохируулан хурууны өндөгөөр зөөлөн тогшоорой. Хурууны өндөгөөр тогшихдоо эхний хувийг чанга, тод тогшино / > /



Бие даан гүйцэтгэх жишиг дасгал даалгавар “Амьтдын марш”

1. Хөгжмөө сонсоод дуу, бүжиг, маршийн аль нь болохыг тодорхойлно уу.

а. бүжиг

б. марш

в. дуу

2. Хөгжмийн зохиолын утга санааг тайлбарлаарай.

.....

3. Энэ зохиолыг ямар хөгжмийн зэмсэгээр тоглож байна вэ?

а.Хийл

б. Гитар

Зөвлөмж:

Сонсох үйл ажиллагаагаар сурагчдыг аль болох анхааралтай сонсох, хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийг сонсож таних, тодорхойлох, агуулга дүрслэлтэй холбож ойлгох чадварт хөтөлсөн байхад анхаарах хэрэгтэй. Жишээ нь: Өгөгдсөн хурдаар (хурдан, аажмаар хурдсах гэх мэт) ямар агуулга, дүр дүрслэлийг илэрхийлж болох энэ нь ямар хүчээр илрэх, аялгууны шинж төрх ямар байж болох гэх мэтээр хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийн тухай ойлголтыг саланги бус хоорондын уялдаа холбоо, хамааралд нь авч үзэх байдлаар даалгавар боловсруулах, даалгаварт суурилсан арга зүйг чухалчлах нь оновчтой.

Хөгжмийн зохиолуудыг сонсгохдоо юуны өмнө сурагчдаар аялгууны шинж төрх, хэмнэлийг анхааралтай сонсож тодорхойлох оролдлого хийлгэнэ.

Арга зүйн санаа

- Зөвхөн алга ташилт төдийгүй хөлийн товшилттой хамсран хэмнэлийг хөгжимдүүлж сурагчдын хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлнэ.
- Хэмнэлийн дасгалыг 2 дэвсгэрт өгөхдөө дээд дэвсгэрийг гарт, доод хэсгийг хөлд зориулж өгнө.
- 2 дэвсгэр шугамд өгөгдсөн хэмнэлийн зураглалыг алга таших, өсгий өлмий товших байдлаар унших дасгал хийнэ. Үүний дараа уншиж тогтоосон хэмнэлийн дасгалаа хөдөлгөөнтэй холбон, явдал дундаа гүйцэтгэнэ.
- Хөгжим сонсох үйл ажиллагааг зөвхөн ангид хийх биш гэр бүлийн дэмжлэгтэйгээр гэртэй гүйцэтгэж болно.
- Хөгжмийн шинж төрхийг тодорхойлон гэр бүлийн гишүүдтэй хамтран хэмнэлийн хамсраа хийх, хөдөлгөөн зохиомжлох зэрэг үйлийг хийж болно.

2. Дуулах чадварыг хөгжүүлэх

Сэдэв: Сонсголын тогтоолт дээр тулгуурлан 2 ба 3 хувьт хэмд хэмжээ хэмнэлээ нийлүүлэн нэгэн зэрэг дуулж чадахаа харуулах

МЭДЛЭГ:	ЧАДВАР:	ХАНДЛАГА:
2 ба 3 хувьт хэм, хэмжээ	Хэмжээ хэмнэлээ нийлүүлэн нэгэн зэрэг дуулах	багаар хамтрах

Үндсэн ойлголт:

- 2 ба 3 хувь
- хэм хэмжээ

Хэрэглэгдэхүүн:

а. Цахим нөөц хэрэглэгдэхүүн:

- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/9>
- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/3161>
- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/2139>

б. Хэвлэмэл нөөц хэрэглэгдэхүүн: Оюунбилэг, Ч. ба бус., (2013) ХӨГЖИМ 1, УБ

Дууг заахад учрах бэрхшээлүүд

1. Үг хэллэг
2. Аялгуу
3. Хэмнэл
4. Регистр
5. Амьсгаа
6. Хурд

7. Царааны гэх мэт байж болно. Эдгээр хүндрэл бэрхшээл нь уран бүтээлийг хүүхдийн боломж, нас сэтгэхүйн онцлогт тохируулан сонсгоогүйгээс учирна. Гэхдээ зарим нэг хүндрэлтэй дуу ч бий.

1. Хэллэгийн хүндрэлийг давахын тулд түргэн хэллэгийн дасгал (хэл зүгшрүүлэх үг) хийлгэх хэрэгтэй. Ингэхдээ ритмийн хамсраатай байх нь илүү их ач холбогдолтой. Түргэн хэллэг бол зөвхөн хэл зүгшрүүлэх төдий биш амьсгаа задлах, ритмийн сонсголыг хөгжүүлэх чухал ач холбогдолтой. Хэллэг зүгшрүүлж, диц сайжруулах, амьсгааны багтаамж тэлэхэд ардын аман зохиолоос хэлц үг, зүйр үг, түргэн хэллэг, оньсого тааврыг аялгуунд хадаж хөг шилжүүлж транспозицтой дуулснаар хоолойн диапозон өргөтгөх ач холбогдолтой ба агуулгын хувьд ч арга зүйн хувьд ч тохиромжтой байдаг. Жишээ нь:

Арын тэр нуур Авдрын тэр нүүр
Аргагүй том нуур Алаггүй хүрэн нүүр

2. Аялгуун дахь интервалын холын үсрэлт, нэг өнгөн дээр удаан давтах давталт, лад хөгийн өөрчлөлт зэрэг нь сурагчдад хүндрэл учруулдаг. Иймээс аялгууны хүндрэлтэй хэсгийг хэсэгчилж зааж болно.
3. Хэмнэлийн хүндрэлтэй хэсгийг схемчлэн зураглалаар харуулж болно. Мөн хэмнэлийг цохиж сонсох, өөрсдөөр нь хэмнэлийг цохиулах, хөдөлгөөн хийх амьсгаа авах, тоолох гэх зэргээр хэмнэлийн хүндрэлийг давж болно.
4. Регистрийн хүндрэлтэй хэсгийг заах үедээ тоналност (хөг) солих, октав (наймц) шилжүүлэх гэх мэт аргаар шийдвэрлэнэ.
5. Хоолой болон амьсгалын замын өвчтэй хүүхдийг анхаарах.
6. Хэт хурдан эсвэл удаан дууны хурдыг заах үедээ дундаж хэмжээнд оруулж заана. Дууг бүрэн сурсан үед нь үндсэн хурдад оруулах хэрэгтэй.
7. Дуу бүхэн хүүхдэд тодорхой нэг шинэ зүйлийг нээж өгдөг. Жишээ нь: Тухайн дуу хүүхдийн хувьд шинэ хөг аялгуу, утга агуулга, өргөн цараа, дуулах арга барилыг эзэмшүүлж байдаг.

Эдгээрийг анхаарч дуу заах үйл ажиллагааг эхлүүлээрэй.

Үйл ажиллагааны дараалал:

Алхам 1: Аялгууны шинж төрхийг ярилцана.





Алхам 2. Хоолойн дасгалыг до ре ми фа соль ноотоор дуулна.

Алхам 3: Дууны аяыг Хэсэгчлэн хөгжимдөж сонсгох ба тусгайлан тэмдэглэсэн хэсгийг анхаарч сонсоно.

Алхам 4: Дууны үгийг мөр мөрөөр нь хэлж цээжлүүлэх ба сүүлийн хоёр такт дахь эгшгийн үсрэлт дээр анхаарч, хөгжимтэй хамтран дуулуулна. Ялангуяа дээд эгшгээс доод эгшиг рүү шилжих шилжилтийг дахин давтан гүйцэтгүүлнэ.

Алхам 5: Сурагчид өөрийнхөө хоолойн өнгийг сонсож, бусадтай нийцүүлэн нийтээрээ болон хэсэг хэсгээр нь дуулна.

Алхам 6: Багшийн дохиог анхаарч дуулна.

Хөгжилтэй

Аа - ваа ха - раа - рай Ээ - жээ сон - соо - рой Ал - тан но-мын

үс - гийг би Ах шиг сайн сур - сан - даа аа - ваа а - хаа

Али - маа гэ - хэд А ор - дог тийм ээ аан тий - мээ тийм

Зөвлөмж:

Орчин үед хүүхдүүд өөрсдийн сонирхолын дагуу хүссэн дуугаа хаанаас ч, хэнээс ч сурч дуулдаг болсон. Дуулах үйл ажиллагаатай холбоотой багшийн анхаарах гол зүйл бол амьсгаа, амьсгааг фраз бүрийн эхэнд авах, амьсгаан дээр тулгуурлаж аялгууг цэвэр өнгө хөгөөр дуулах, үг хэллэг, дуудлага тод байх, тухайн дууны утга агуулгад тохируулан нюанс тавих буюу уран илэрхийлэл дээр ажиллах нь зүйтэй.

Дууны уран бүтээл дээр ажиллахдаа дууг сонсож тайлбар, мэдээлэл хийсний дараа заах үйл ажиллагаанд орно. Заахдаа сурагчдын хараа, сонсгол, хөдөлгөөний сэрлүүдийг нэгтгэсэн үйлийг хийх бөгөөд багшийн гарын дохио нь өндөрлөг, хэмнэл, хэллэг, амьсгаа, дуулахуйн ур дүйг мэдрүүлэх ёстой.

I ангийн хүүхдийн хэл яриа гүйцэд хөгжөөгүй байдаг нь дуулалтад шууд нөлөөлдөг. Ийм учраас ярианы болон дуу авианы өндөрлөгийн ялгааг ойлгуулж мэдрүүлэх зорилгоор унисон дуулалтыг эзэмшүүлнэ. Унисон дуулалтыг I октавын ми-гээс ля ноотны багтаамжинд жигд зөөлөн дуулж, өөрөө өөрийнхөө дууны өнгийг сонсож мэдрэх зорилтыг тавьж ажиллана. Цэвэр унисон дуулалтыг эзэмшүүлэх явцдаа дуулах техник ажиллагааг хослуулж ажиллана. Үүнд:

- Эгшгийн өндөрлөг (интонаци)
- Үг хэллэг (гийгүүлэгч тод, эгшиг задгай бус)
- Амьсгаа
- Хүч (эхлэх өнгийг зөөлөн дуулна)

Дуу заах үйл ажиллагаагаар дамжуулан хэмжээ хэмнэлийг зөв мэдэрч дуулах, зогсоц (пауз)-ыг зөв илэрхийлж дуулах, өргөлт (акцент)-ийг зөв мэдэрч дуулах зэрэг чадварыг хөгжүүлэх бөгөөд дууны үг, шүлэг, яруу найргийг утга илэрхийлж зөв уншуулах нь хэмнэлийн сонсголыг хөгжүүлэхэд чухал түлхэц болно. Үүнд: хүчтэй доль, угтвар такт (затакт), зогсоц (пауз), цочир өргөлт \синкопа ритм\ бүгд агуулагдаж байгаа юм.

I ангийн дуулах дасгалын зорилго нь: цэвэр өнгөтэй, дуу хоолойн багтаамжийг өргөтгөх, дуулалтын техник ажиллагааг хөгжүүлэх, хөгжмийн сонсголыг хөгжүүлэх зэрэг болно.

Бие даан гүйцэтгэх жишиг дасгал даалгавар

1. Эдгээр дууг ямар хурдтай дуулах вэ? Хурдыг тодорхойлж бичээрэй.


а. “Есөн сарын нэгэн”.....

б. “Байгаль эхийн хүүхдүүд”.....

в. “Туулай”.....


2. Эгшгийн өндрийн зураглалыг зааж дуулаарай. Ямар нэртэй дуу вэ?





3 .

Эгшгийн цувааг өгөгдсөн хэмжээгээр дуулж, зураглал хийгээрэй. 1и



3. Хөгжимдөх чадварыг хөгжүүлэх нь

Сэдэв: Хоёр хувиар хэмнэл зохиосноо хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимдөж харуулах

МЭДЛЭГ:	ЧАДВАР:	ХАНДЛАГА:
Хоёр хувьт хэмнэл	Хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимдөж харуулах	бусдыг сонсож хөгжимдөх

Үндсэн ойлголт:

- 2 хувьт хэм

Хэрэглэгдэхүүн:

а. Цахим нөөц хэрэглэгдэхүүн:

- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/3728>
- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/2207>

б. Хэвлэмэл нөөц хэрэглэгдэхүүн: Оюунбилэг, Ч. ба бус., (2013) ХӨГЖИМ 1, УБ

Өгүүлэн ярих, тоочих, нэрлэх, яриан дунд амьсгаа авах, түр зогсох энэ бүгд тодорхой хэмнэлтэй. Хөгжимд янз бүрийн урттай эгшгүүдийн зохион байгуулалттай дарааллыг хэмнэл гэдэг. Эгшгүүд нь өөр хоорондоо 2/1-ийн харьцаатай байдаг. Иймээс 2/1 харьцаа бүхий урт богино дуугаралтаар дамжуулан хэмнэлийг мэдрүүлэх хэрэгтэй.

Үйл ажиллагааны дараалал

Алхам 1.Сурагчдаар жимснүүдийг нэрлүүлж, үгийн дуудлагыг зураастай холбон ажиглуулаарай.


Лийр, тоор, аньс, нэрс гэх мэтчилэн нэг үетэй жимсний нэрээр дамжуулж, дөрөвт ноотны жигд хэмнэлийг мэдрүүлэхэд анхаарна.



Алхам 2. Хоёр үетэй хүнсний ногоонуудын нэрийг бичүүлнэ. Багш хоёр үеэр дамжуулан дөрөвт ноотноос богино наймт ноотыг хөгжимдүүлж сургахад анхаарна.



Алхам 3. Үүний дараа дэвсгэр шугам дээрх ноотны хэмжээг тоолж хэмнэлийн дасгал хийнэ. Хөгжимдөхдөө энгийн зэмсэг ашиглаж болно.



Алхам 4. Дасгалыг эхнээс нь сурагчдаар ганцаарчлан болон багаар ажиллуулах бөгөөд багш хөгжмийн хамсраа хийж болно.

Алхам 5. Эгшгийн урт богино, хувь, хэмнэл гэсэн эхний ойлголтуудыг монгол хэлний урт богино эгшиг, математикийн тоо тоололтой холбож, дүрс болон тоогоор ойлгуулах нь хүүхдэд илүү хялбар байх болно. Жишээ нь:



Зөвлөмж:

Хэмнэл бол дүрслэл илэрхийллийн маш чухал хэрэглүүр. Тиймээс хэмнэлийг сонсож мэдрэх, ойлгох, тогтоох, хэмнэлийн зураглалыг унших үйлд хөтлөх нь чухал байдаг. Сурагчдын сонсголын ойг хөгжүүлэх, ноот уншиж хэмнэлээр хөгжимдөх чадварыг хөгжүүлэхийн тулд хэмнэлийн дүрсийг харах, ялгааг таних, үүргийг мэдэх, тайлж унших, гүйцэтгэж харуулах зэрэг хөтөлбөрийн зорилтод чиглэсэн даалгавруудаар хөтлөн ажиллах хэрэгтэй.

Хэмнэлээр тогшоод өгөгдсөн хэмжээгээр айзамын зураас татах даалгаврыг олон хувилбараар хийлгэж болно. Тухайлбал, өгөгдсөн хэмнэлийг сурагчдаар ажиглуулж ямар алдаа байгааг олуулах, өгөгдсөн айзам хэмжээнд тохируулан өөрийнхөөрөө хэмнэлийг гүйцээж зохиох, мөн тодорхой зураглал бүхий үйл явдалд тулгуурлан түүнийг хэмнэлжүүлэх нь бэлэн өгөгдлийн дагуу хийж гүйцэтгэхээс илүү хүүхдийн хувьд шинээр сэтгэх, бүтээлч арга барилд суралцах боломжийг бүрдүүлнэ.

Сурагчид багшийн тоглолтыг сонсоод дагах биш, харин өөрсдөө ноотоо хараад тоглох нь чухал гэдгийг анхаараарай. Үүний тулд сурагчид:

- Ноот бичлэгийг эхлээд сайтар ажиглана,
- Дараа нь ноотыг уншина,
- Уншихдаа хэмжээгээ алдахгүйн тулд тоолж хөгжимдөнө гэсэн ойлголтыг маш сайн өгөх хэрэгтэй.

Ноотоор тоглохын өмнө багш заавал тоолж хэмжээ өгнө. Ингээгүйгээс сурагчид өөр өөрсдийн хэмжээгээр эхэлж улмаар ангид замбараагүй байдал үүссэнээр сурагчдын анхаарал сарнидаг.

Нэгдүгээр ангийн сурагчдад ноотны задаргаа (алим хуваах, шугам ашиглах, хүснэгтээр ажиллах гэх мэт) яагаад дөрөвт ноот гэж нэрлэсэн (дөрөвт ноот нь бүтэн ноотонд дөрөв багтдаг болохоор дөрөвт гэж нэрлэсэн) тухай тайлбар огт шаардлагагүй. Харин ноотны дүрсийг тогтоолгож хөгжимдөх үйлд хөтлөх хэрэгтэй.

Бие даан гүйцэтгэх жишиг дасгал даалгавар

1. Бүүвэйн дууны хэмнэлээр хөгжимдье. Хүүхэд бүр өөрсдийн хийсэн хөгжмийн энгийн зэмсгээр өгөгдсөн хэмнэлээр хөгжимдөн, дагаж дуулаарай.





2. Үеэр тэмдэглэсэн ноотыг нэрлээд, хэмнэлээр хөгжимдөөрэй. Тухайлбал,

- хувилбар 1-ийг хагас ноотны хэмжээгээр;
- хувилбар 2-ыг дөрөвт ноотны хэмжээгээр;
- хувилбар 3-ыг наймт ноотны хэмжээгээр;

Хувилбар 1

До, ре, ми, фа, соль, ля, си, до² си, ля, соль, фа, ми, ре, до

Хувилбар 2

До, ре, ми, фа, соль, ля, си, до² си, ля, соль, фа, ми, ре, до

Хувилбар 3

Соль ми соль ми соль ми ми до ми до

3. Бүжиглэх чадварыг хөгжүүлэх

Сэдэв: Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг тодорхойлж, тохирох дүрийг (цэцэг, амьтад...) хөдөлгөөнөөр илэрхийлэх

МЭДЛЭГ:	ЧАДВАР:	ХАНДЛАГА:
Аялгууны шинж төрхийн талаар	янз бүрийн сэдвээр хөдөлгөөн зохиомжлох	Аялгууны шинж төрхөд тохируулан сэтгэл хөдлөлөө илэрхийлэх

Үндсэн ойлголт:

- Шинж төрх

Хэрэглэгдэхүүн:

а.Цахим нөөц хэрэглэгдэхүүн:


- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/3119>
- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/1703>

б. Хэвлэмэл нөөц хэрэглэгдэхүүн: Оюунбилэг, Ч. ба бус., (2013) ХӨГЖИМ 1, УБ Үйл ажиллагааны дараалал:

I ангид хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх зорилгоор хөгжимт хөдөлгөөн бүхий хэмнэлийн олон хувилбарт дасгалыг гүйцэтгүүлж болно. Зөвхөн алга ташилт төдийгүй хөлийн товшилттой хамсран хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх боломжтой.

Алхам 1. Дээд дэвсгэрийг гарт, доод дэвсгэрийг хөлд зориулсан болно.

- Алга таших, өлмий товших, алга таших, өлмий товших гэсэн дарааллаар нэгэн хэмээр жигд гүйцэтгэнэ.



Алхам 2. “Бөмбөрчин” хөгжмөө анхааралтай сонсоод юун тухай илэрхийлж байгааг ярилцана.



Алхам 3. Хөгжимт хөдөлгөөнийг хийхдээ дууны ая, хэмнэлд тохируулан 1-8 тоонд хөдөлгөөн хийнэ.

Алхам 4. Сурагчид хөгжмөө сонсоод ганцаараа болон найзтайгаа хамтран хөдөлгөөнөө хийж гүйцэтгэнэ.

Бие даан гүйцэтгэх жишиг дасгал даалгавар

1. Нүүрний хувирал болон биеийн хөдөлгөөнөөр аялгууны шинж төрхийг илэрхийлэн бүжиглэх. Сурагчдад үгийг зургаар, дүрс бичлэгээр, хөгжмөөр, оньсого, таавраар гэх мэт олон янзаар өгнө.

Хувилбар 1. Эрвээхий. Зөөлөн уян налархай, хөнгөн дэвэх хөдөлгөөнийг хийлгэнэ.



2. Хөгжмөө сонсоод аялгууны шинж төрхийг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлээрэй.

а. Эрвээхий/...../



б. Цэцэг /...../



в. Шувуухай /...../



3. Хөгжмийг сонсоод аялгууны шинж төрхийг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлж өөрийгөө болон найзыгаа үнэлээрэй.

а. Хүнд нүсэр /...../

б. Сэргэлэн, цовоо /...../

в. Уянгалаг, намуухан /...../

5. Зохиох буюу бүтээлч чадварыг хөгжүүлэх

Зөвлөмж:

Хүүхдийн хөгжмийн сонсгол хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэхэд хөгжимт хөдөлгөөн чухал үүрэгтэй. Хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон хөгжимт хөдөлгөөнүүд нь тэдний дотоод сэтгэлийг нээх, бүтээлч чадварыг хөгжүүлэх, төсөөлөл, уран сэтгэмж, гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг.

Хөгжимт хөдөлгөөнийг хүүхдэд заахдаа нэг удаагийн хичээлээр нэг л заагаад өнгөрөх биш хичээл орох бүрт энгийн хялбар хөдөлгөөнөөс эхлэн 1-2 хөдөлгөөнийг нь сонгон бие халаах дасгал хэлбэрээр өгч, хүүхэд бүр хөдөлгөөнөө сайн ойлгож, сурсны дараа хөгжимт хөдөлгөөнийг бүрэн эхээр нь хийлгэх боломжтой.

Хөгжимт хөдөлгөөн, тоглоомыг тэдний юу сонирхож, мэдэхийг хүсэж байгаа болон тэдний эргэн тойронд нь гарч буй дуу чимээ дүрслэлээс сэдэвчилж болно.

Сэдэв: Янз бүрийн хэмнэлээр тодорхой сэдэвт зохиомж хийж/морьд, бороо, марш, бүүвэй.../ үзүүлэх

МЭДЛЭГ:	ЧАДВАР:	ХАНДЛАГА:
Хэмнэл	танил болон танил бус орчинд тодорхой сэдвээр зохиомж хийх	өгөгдсөн хэмнэлийг өөрийнхөөрөө баяжуулах, бүтээлчээр сэтгэх



Үндсэн ойлголт:

- Хэмнэл

Хэрэглэгдэхүүн:

а. Цахим нөөц хэрэглэгдэхүүн:

- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/3728>
- <http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/2207>

б. Хэвлэмэл нөөц хэрэглэгдэхүүн: Оюунбилэг, Ч. ба бус., (2013) ХӨГЖИМ 1, УБ
Үйл ажиллагааны дараалал:

Зөөлөн шиврэх бороон дуслууд болон аянга цахилгаантай хүчтэй аадар борооны хэмнэлийг хөгжимдүүлнэ. Сурагчдад өөрсдийн сонголтоор хөгжмийн энгийн зэмсгээ сонгох боломжийг олгоход багш анхаарна. Учир нь сурагч бүрийн дүрслэн зохион бодох арга нь харилцан адилгүй байдаг.



Алхам 1. Багш сурагчдын хэмнэлээр хөгжимдөх үйл ажиллагааг удирдан чиглүүлж өгнө.
Тухайлбал: Бороон дуслууд зөөлөн зөөлөн шивэрлээ

Бороон дуслууд ширүүслээ, бүр ширүүслээ

Аадар бороо асгарлаа

Аянга цахилгаан цахиллаа гэх мэт

Алхам 2. Дүрсийг ажиглаад сурагчид өөрсдийн сонгосон хөгжмийн энгийн зэмсгийг ашиглан хэмнэлээр илэрхийлэн тоглоно. Тод өнгийн дүрс хүчтэй, бүдэг өнгийн дүрс сул хувийг илэрхийлнэ.



Алхам 3. Дүрсэн тэмдэглэлээр хэмнэлийн дасгал гүйцэтгэсний дараа ноотны хэмжээнд шилжүүлэн хэмнэлийн дасгал гүйцэтгэнэ. Жишээ нь: Хэмнэлийн зураглалыг ажиглаж хэдэн хувь байгааг тодорхойлно, хэмнэлээр тоглоно.



Бие даан гүйцэтгэх жишиг дасгал даалгавар

Хэмнэлийн янз бүрийн зураглалуудыг бие даан болон бусадтай хамтран уншиж, хэмнэлээр хөгжимдөөрэй.

Хувилбар 1





Зөвлөмж:

Хөгжмийн хичээлийн зохион найруулъя бүлэг сэдвийн зорилго сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд оршдог.

Зохион найруулах даалгавар нь сурагчдын ноот унших чадварыг сайжруулахаас гадна, хэмнэл болон ноотыг цээжлүүлж, шинэ хувилбаруудыг өөрөө зохиож дуулах чадварыг нь хөгжүүлнэ. Тухайлбал: зөгийн үүрнээс гадна төөлүүр хорхой, могой, төмөр замын болон автобусны буудал, гарын таван хуруу, шат гэх мэтээр дэс дараалал бүхий, сонирхолтой, олон янзын хувилбартай байж болох ертөнцийн юмс үзэгдэлтэй хөгжмийн нэр томьёо, ойлголтыг холбон тайлбарлаж, сурагчдад энгийн байдлаар хүргэх аргыг эрж хайх замаар бүтээлч байдлаар хандаарай.

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Хэвлэмэл нөөц хэрэглэгдэхүүн	1. Оюунбилэг, Ч. ба бус., (2013). ХӨГЖИМ 1 сурах бичиг, УБ 2. Оюунбилэг, Ч. ба бус., (2013). ХӨГЖИМ 1 багшийн ном, УБ 3. Боловсролын хүрээлэн, (2019). Бага боловсролын сургалтын хөтөлбөр 4. Боловсролын хүрээлэн, (2019). Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж
Цахим нөөц хэрэглэгдэхүүн	Теле хичээл - http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/3728 - http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/3161 - http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/2207 - http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/3119 - http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/9 - http://old.econtent.edu.mn/lessons/EBS/1rangi/hugjim/480 Интерактив хичээл - https://medle.mn/interactivelessonAll/1/10005# Нэмэлт контент - https://medle.mn/additional

ҮНЭЛГЭЭ

Хөгжмийн хичээлийн суралцахуйн үр дүнг үнэлэх шалгуур, шалгуурын зөвлөмжийг 2020 онд боловсруулсан. Энэхүү зөвлөмжид судлагдахууны хувьд нэгж, СҮД, үнэлгээний шалгуур болон гүйцэтгэлийн 4 түвшинд боловсруулахдаа баримталсан зарчмын талаар тодорхой тайлбарласан. Мөн үнэлгээний шалгуурыг жилийн, нэгжийн, ээлжит хичээлийн хувьд хэрхэн ашиглаж болох, оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээнд гол харгалзах шаардлагатай зүйлсийн талаар тайлбарлан арга зүйн зөвлөмжийг боловсруулсан. Түүнчлэн СҮД болон шалгуурт нийцүүлэн нэгжийн үнэлгээ хийх арга, аргачлалын талаар тайлбарлаж, жишиг даалгаврыг сонгох болон задгай хэлбэрээр боловсруулан дагалдах хариултын мэдээллийг боловсруулах, оноожуулах аргачлалыг цогцоор нь оруулсан.

Оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний явцад цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргачлалыг хялбар, ойлгомжтой байдлаар тайлбарласан. Нотолгоонд үндэслэн суралцагчдын сурах арга барил болон мэдлэг, чадвар, хандлагыг хэрхэн дэмжиж болох талаар тусгасан бөгөөд эдгээр шалгуур, шалгуурын зөвлөмжийг хэрэглэх бүрэн боломжтой юм.

Гүйцэтгэлийн үр дүнг тооцохдоо сурагчдыг сайн, муу гэхээс илүү суралцахуйн зорилтдоо

чиглүүлж чухам юун дээр алдаж байгааг олж илрүүлэн цаашид ажиллах арга зүйгээ сонгох хэрэгтэй.

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхдээ өөрийн үнэлгээний хуудас ашиглаж болно.

Хэн үнэлэх	Үйл ажиллагаа - даалгаврууд			
	1	2	3	4
Өөрөө				
Ангийн найз				
Багш				



Өөртөө итгэлтэй
маш сайн гүйцэтгэсэн



Өөртөө итгэлгүй
дутуу гүйцэтгэсэн



Илүү сайн хийх
хийх хэрэгтэй

Сурагчдын гүйцэтгэлийг дараах рубрикээр үнэлэх боломжтой

Чадвар	Маш сайн	Хангалттай	Сайжирч байгаа	Анхаарах шаардлагатай
Сонсох чадвар	Хөгжмийн бүтээлийг сонсоод хэмнэл, хурд, хүч, аялгууны шинж төрхийг бүрэн тодорхойлж, ойлгосноо тэмдэглэнэ, Сэтгэл хөдлөлөө үг яриа, хөдөлгөөн, зураглалаар илэрхийлнэ. Сэдэв аяыг маш сайн тогтооно, аялна.	Хөгжмийн бүтээлийг сонсоод хэмнэл, хурд, хүч, аялгууны шинж төрхийг тодорхойлж, ойлгосноо тэмдэглэнэ, Сэтгэл хөдлөлөө үг яриа, хөдөлгөөн, зураглалаар илэрхийлнэ. Сэдэв аяыг тогтооно, аялна. Өөртөө бүрэн итгэлтэй биш.	Хөгжмийн бүтээлийг сонсоод хэмнэл, хурд, хүч, аялгууны шинж төрхийг тодорхойлохыг хичээнэ, ойлгосноо тэмдэглэнэ, Сэтгэл хөдлөл, ойлголтоо илэрхийлэхийг оролдоно, өөртөө итгэлгүй, илэрхийлэх чадвар сул.	Хөгжмийн бүтээлийг сонсоод хэмнэл, хурд, хүч, аялгууны шинж төрхийг тодорхойлох чадвар сул, ойлгосноо тэмдэглэнэ, Бүрэг ичимхий, өөрийгөө илэрхийлэх чадвар сул. өөртөө
Дуулах чадвар	Дууны айзам хэмжээ, хурд, аялгууны шинж төрхийг бүрэн илэрхийлж дуулна, утга агуулгад тохируулж сэтгэл хөдлөлөө илэрхийлнэ, хөгжмөө сонсож бусадтай нийцэж, өнгө болон хэмжээ алдалгүй дуулна	Дууны айзам хэмжээ, хурд, аялгууны шинж төрхийг илэрхийлж дуулна, утга агуулгад тохируулж сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг, хөгжмөө сонсож, бусадтай нийцэж дуулна, заримдаа өнгө алдана.	Дууны айзам хэмжээ, хурд, аялгууны шинж төрхийг илэрхийлж дуулахыг оролдоно, хөгжмөөс хоцрох буюу түрүүлж дуулах ба зарим өнгөнд хүрэхгүй өнгө алдаж дуулна.	Дууны айзам хэмжээ, хурд, аялгууны шинж төрхийг мэдэрч илэрхийлэх чадвар сул, хөгжмөө болон бусдыг сонсож нийцүүлэх чадвар сул, өнгө тогтворгүй, хэмжээ алдаж дуулна.
Хөгжимдөх чадвар	Ноотны дүрсүүдийг таньж, хэмнэлийг уншиж, айзам хэмжээ, хүчтэй сул хувийг бүрэн илэрхийлж өөртөө итгэлтэй хөгжимдөнө	Ноотны дүрсүүдийг таньж, хэмнэлийг уншиж, айзам хэмжээ, хүчтэй сул хувийг илэрхийлж хөгжимддөг хэдий ч өөртөө итгэлгүй	Ноотны дүрсийг бүрэн танихгүй, хэмнэлээр ноот харж хөгжимдөхийг оролдоно, уншихдаа алддаг, бусдыгаа сонсож нийцэх чадвар сул	Ноотны дүрсийг бүрэн танихгүй, хэмнэлээр хөгжимдөх, өөрийгөө илэрхийлэх чадвар сул алдаатай уншиж, дахин давтаж тоглоно.
Бүжиглэх чадвар	Хэмнэлийн мэдрэмж, хөдөлгөөний эвсэл сайн. Аялгууны шинж төрх, айзам хэмжээ, хурд, хүчийг мэдэрч, хөдөлгөөнөө бүрэн дүүрэн илэрхийлэл сайтай гүйцэтгэнэ.	Хэмнэлийн мэдрэмж, хөдөлгөөний эвсэл сайн. Аялгууны шинж төрх, айзам хэмжээ, хурд хүчийг мэдэрч хөдөлгөөнөө гүйцэтгэх ч өөртөө итгэлгүй	Хэмнэлийн мэдрэмж, хөдөлгөөний эвсэл дунд зэрэг. Айзам хэмжээг мэдэрч хөдөлгөөнөө гүйцэтгэхийг оролдоно. Өөртөө итгэлгүй, хөдөлгөөн нь оновтой бус, эвсэл сул	Хэмнэлийн мэдрэмж, хөдөлгөөний эвсэл сул, бүрэг ичэмхий, өөртөө итгэлгүй. Айзам хэмжээг мэдэрч хөдөлгөөнөө гүйцэтгэхийг оролдоно, хөдөлгөөний эвсэл сул

Ашигласан материал

1. Бага боловсролын сургалтын хөтөлбөр, 2019, 66-р тал
2. Оюунбилэг, Ч. (2000). Хөгжмийн боловсрол олгох арга зүй, Содпресс ХХК, УБ.
3. Оюунбилэг, Ч. ба бус., (2013). ХӨГЖИМ 1 сурах бичиг, УБ.
4. Оюунбилэг, Ч. ба бус., (2013). ХӨГЖИМ 1 багшийн ном, УБ.
5. Боловсролын хүрээлэн (2021) ТВ контент





2.8. БИЕЙН ТАМИРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын сургалтын зорилго нь суралцагч бие бялдраа хөгжүүлэн, эрүүл мэндээ хамгаалах арга барил эзэмшиж, спортын авьяасаа нээн хөгжүүлж, эрүүл бөгөөд идэвхтэй амьдрах суурь мэдлэг, чадвар, хандлагатай иргэн болж төлөвшихөд оршино.

Манай оронд биеийн тамирын хичээлийг мэргэжлийн багш нар зааж байгаа боловч зарим тохиолдолд бага ангид анги даасан багш биеийн тамирын хичээл орж байгаа тохиолдол байсаар байгаа билээ. Тиймээс биеийн тамирын хичээлийг орж байгаа багш бүр тус хичээлээр хүүхдийн бие бялдрыг өсөлт хөгжилтийг дэмжин, зөв дадал хэвшилтэй болгон хөгжүүлэх хэрэгтэй. Тиймээс биеийн тамирын хичээл орж буй багш та:

- Тэдний нас, сэтгэхүй биеийн хөгжлийн онцлогт тохирсон аргаар биеийн тамирын мэдлэг, чадвар эзэмшүүлэх
- Биеийн тамирын хичээлээр олж авсан мэдлэгээ өдөр тутмын амьдралдаа ашиглаж, сурах арга барилыг эзэмшүүлэх БАГШ таны гол зорилго юм.

Биеийн тамирын хичээлээр сурагчид өөрийн бие бялдраа хөгжүүлэн, эрүүл мэндээ хамгаалах арга барилд суралцах төдийгүй багаар ажиллах, өөрийгөө илэрхийлэх, бусдыг хүндэлдэг, тэдэнд санаа тавьдаг, илүү хүчтэй, илүү зоригтой өөртөө итгэлтэй болж, баг хамт олноо хүндэтгэх, хариуцлагатай, зорилготой байх зэрэг хувь хүний бүхий л сайн сайхан чанар төлөвшдөг.

Биеийн тамирын дасгал, хөдөлгөөн нь бие бялдрыг хөгжүүлэх гол хэрэгслэл ба дасгалаар хичээллэн /төрөл бүрийн бөрийн дасгал хөдөлгөөн, бүх төрлийн спорт/, байгалийн хүчин зүйлийн /нар, ус, агаар/ тусламжтай бие махбодыг чийрэгжүүлэн, эрүүл амьдралын хэв маягийг /хувийн эрүүл ахуйг сахих, өдрийн дэглэмийг мөрдөх, нойрсолт, чанартай хоол тэжээл, хорт зуршилгүй/ цогцлоон сайн сайхан амьдралыг бий болгодог. Иймээс биеийн тамираар хичээллэлснээр амьдралын чанарт томоохон өөрчлөлт гардаг гэдэг ойлголтыг хүүхэд бүрд багаас нь суулгах нь нэн чухал.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Монголын хүүхэд бүрийг эрүүл чийрэг иргэн болгож төлөвшүүлэхэд биеийн тамирын сургалт маш их үүрэгтэй. Зах зээлийн нийгэмд хүний эрүүл мэнд бол тухайн хүний болон нийгмийн гол баялаг, үнэт зүйл гэдгийг суралцагч бүрд ойлгуулж, түүнийгээ хайрлан хамгаалах, өөрийн бие бялдрыг чийрэгжүүлэн хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал, хэвшилтэй болох нөхцөлийг бүрдүүлэн, тусалж дэмжих нь биеийн тамирын сургалтын гол үүрэг байна.

Бага боловсролын биеийн тамирын хичээлийн агуулга нь:

Хүний төрөлхийн хөдөлгөөн (алхах, гүйх, үсрэх, шидэх)-д тулгуурлан хүүхдийн өдөр тутмын амьдралын хөдөлгөөний хэрэгцээг хангаж, тэдний бие махбодыг эрүүлжүүлэн чийрэгжүүлэхэд чиглэсэн байдаг. Харин биеийн тамирын багш бүхнийг зааж сургагч, дагуулан дуурайлгагч биш харин:

- Сэдэлжүүлэгч
- Хөтлөгч, чиглүүлэгч
- Дэмжигч
- Хамтран

суралцагч байхуйц арга зүйгээр хичээлээ удиран зохион байгуулах шаардлагатай юм.

Биеийн тамирын хичээлээр хийж буй дасгал хөдөлгөөн нь бие бялдраа хөгжүүлж чийрэгжүүлэх, эрүүл байх үндэс гэдгийг эхнээс нь зөв ойлгуулан суралцагч бүрийн бие бялдрын хөгжил, сэтгэл зүйн онцлог, хөдөлгөөний чадварын түвшинд тохирсон ачааллаар хүүхдийг хөгжүүлэх аргыг хичээл бүрээр оновчтой, үр дүнтэй хэрэглэснээр

- Хүүхэд бүрийн хувийн онцлогийг олж харж
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх боломжийг байнга эрэлхийлэх



- Хүүхдийн өөртөө итгэх итгэлийг дээшлүүлэх
- Дасгалыг бүтээлчээр гүйцэтгэх сонирхлыг нэмэгдүүлэх зэрэг давуу талтай болно.

Тийм учраас биеийн тамираар анхлан хичээллэх гэж буй шавь нартаа биеийн тамираар хичээллэхийн сайн сайхныг мэдрүүлэн, эрүүл чийрэг зөв монгол иргэн төлөвшихөд хувь нэмэр оруулах багш та сургалтын хөтөлбөрөө баримжаалан төлөвлөлтөө хийж, ээлжит хичээл бүрээ чанартай явуулах нь таны үүрэг билээ. Тиймээс танд - 1-р ангийн биеийн тамирын хичээлийн жилийн төлөвлөгөө, ээлжит хичээлийн төлөвлөлтийг хүргэж байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах гол зүйл нь хичээлийн сайн төлөвлөлт юм.

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн үйл ажиллагаа нь тухайн ангийн биеийн тамирын хичээлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахаас эхэлнэ.

Анги тус бүрд тухайн хичээлийн жилийн туршид биеийн тамирын хичээлийг судлах жилийн төлөвлөгөөг биеийн тамирын багш нартайгаа хамтарч боловсруулах хэрэгтэй. Яагаад хамтарч гэж хэлж байна гэвэл:

- Заал талбай хэрэглэгдэхүүний хэрэгцээг тооцно.
- Агуулгын залгамж холбоог оновчтой тооцно.
- Багш ажлын байрандаа суралцах, хамтран хөгжихөд дэмжлэг болно.

Жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа:

Тухайн ангийн сургалтын төлөвлөгөө /нэг хичээлийн жилд ямар хичээлийг анги тус бүрд хэдэн цаг судлахыг тогтоосон баримт бичиг/

- Тухайн жилийн хичээлийн бүтэц /БШУС-ын сайдын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/244 тушаалаар батлагдсан хичээлийн жилийн бүтцийг баримталж байна.
- Биеийн тамирын сургалтын хөтөлбөрт үндэслэн боловсруулна.

Жилийн төлөвлөгөөг боловсруулах дараалал:

-Тухайн хичээлийн жилийн бүтцэд тохируулан анги бүрт биеийн тамирын хичээлийг судлах цагийг тогтооно. /1-р анги эхний 4 долоо хоног нь бэлтгэл хөтөлбөр байх тул 56 цагийн хичээл/

-Тухайн ангийн биеийн тамирын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, суралцахуйн удирдамжийг сайтар судална.

- Тухайн ангийн биеийн тамирын сургалтын хөтөлбөр дэх бүлэг сэдэв бүрийг судлах цагийг тооцоолно. /Хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудыг уншаад уг суралцахуйн зорилтуудыг хэдэн цагийн хичээлээр эзэмших боломжтойг тооцно. - Суралцахуйн зорилтыг хэдэн цагийн хичээлээр эзэмших боломжтойг багш тооцдог тул шинэ залуу багш нарт жаахан хүндрэлтэй байх талтай тул жилийн төлөвлөлт, нэгж болон ээлжит хичээлийн жишиг төлөвлөлтийг санал болгож байна/

Жилийн төлөвлөгөөг боловсруулахад анхаарах зүйлс:

- Бүлэг сэдвийг биеийн тамирын сургалтын хөтөлбөрт том үсгээр тухайн ангийн дугаарын ард тоогоор тэмдэглэсэн байгаа

- Нэгж хичээл гэдэг нь тодорхой нэг чиглэлийн томоохон суралцахуйн зорилтыг шийдвэрлэх дунджаар 5 цагийн хичээлийг ойлгоно. Тиймээс нэгж хичээлийг 3-8 цаг байхаар төлөвлөж болно. /Биеийн тамирын хичээлийн төлөвлөлтийн талаар дараах линкээс татаж үзээрэй/

<https://drive.google.com/file/d/1umWe11YOC05UU5ja9m8Pe8R4TJcRDJqH/view>

-Ээлжит хичээлийг суралцахуйн зорилтод нийцүүлэн ээлжит хичээлийн сэдвийг багш боловсруулна. /Биеийн тамирын ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл дараах линкээс татаж авч үзээрэй/

<https://drive.google.com/file/d/10mkLgib31w17D3sUTLqrrcBGK68JfxUm/view>



Нэгдүгээр ангийн жишиг жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа нэг улиралд зөвхөн ганц бүлэг сэдвийг судлах нь бага насны хүүхдийн сонирхлыг бууруулж, тэдний бүх талын хөгжилд таатай бус байдаг тул нэг улиралд 2-4 бүлэг сэдвийг судлахаар төлөвлөсөн. Та бүхэнд санал болгож байгаа энэ төлөвлөлт зөвхөн жишиг төлөвлөлт учраас багш та өөрийн сургууль, сургалтын орчинд тохируулан өөрчлөн өөрчлөн болон шууд ашиглаж болох ба ээлжит хичээлийн төлөвлөлтөө хүүхүүдийнхээ бие бялдрын онцлогт тохируулан боловсруулах хэрэгтэй.

Бага ангийн тэр дундаа 1-р ангид биеийн тамирын хичээлийг анги удирдсан багш, шинэ залуу багш нар орох магадлал өндөр байдаг тул бүлэг сэдэв тус бүрээр гурван ээлжит хичээлийн жишиг төлөвлөлтийг алхамчлан боловсруулан орууллаа. Энэ нь багш танд ээлжит хичээлийн төлөвлөлт хийхэд дэмжлэг болно гэж бодож байна.

Ээлжит хичээлийн төлөвлөлтийг бүлэг сэдэв бүрээр 2-3 төлөвлөлт хийсэн нь багш танд арга зүйн санаа хангалттай өгнө гэж бодож байгаа бөгөөд та загварт оруулан илүү сайжруулан хэрэглэх боломжтой.

Хүснэгт 1. Жишиг жилийн төлөвлөгөө: 1-р анги 58 цаг

Улирал	I улирал																II улирал								III улирал																	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16										
Бүлэг сэдэв, цаг	Ахуйн хэрэгцээт дасгал 6 цаг						Алхалт, гүйлт 8 цаг						Усрах харайх 12 цаг						Шархт дайнуулант 12 цаг						Усрахт харайхт 4 цаг						Ахуйн хэрэгцээт дасгал 8 цаг						Алхалт гүйлт 6 цаг					
Нэгж сэдэв	Жагсаал, жагсаалын хувиргалт, өсөлт хөгжилт тодорхойлох												Алхалт, гүйлт				Усрахт буюу тэгшлэм Ургад харайх, харайлт буюу тэгшлэм				Бөмбөгтэй харьцах сурах 6 цаг Бай өмнө хэрэг хэрэгтэй буюу үйл хийх 6 цаг				Хөлийн хүч хөгжүүлэх				Харгалсгүй ба харгалсат дасгал багасгах хөгжүүлэх 5 цагаар тусламжтай бөгөөд				Гүйлт, алхалт хөгжүүлэх									
Эмнэлт хөгжүүлэх буюу сэдэв	Сургууль 9 дугаар анги																																									
	Бөмбөг тэжүүлч илгээл болж, доройтуулж уцах ажил Эмнэл, хуучин амьтан, амьтлын тэжүүлч уцах ажил Хүснэгт дасгалууд ажил, амьтлын хөгжүүлэх Хүснэгт дасгалууд ажил, амьтлын																																									

Хөгжлийн ялгаатай хүүхэдтэй ажиллах санамж:

Биеийн тамирын хичээл бусад хичээлээс ялгагдах онцлог нь хичээлд оролцож буй бүх хүүхдүүд хөдөлгөөний үйлдлүүдийг байнга хийдэгт оршино. Тиймээс багшаас асар их анхаарал, сонор сэрэмж, мэдрэмж, хичээлийн сайн төлөвлөлт, бэлтгэлийг шаарддаг.

Суралцагч бүрийн байгалиас заяасан авьяас чадвар, мэдээллийг хүртэх байдал, орчин, сонирхол, өмнөх туршлага бүгд өөр өөр болохоор тэдний амжилттай сурах арга нь харилцан адилгүй байдаг.

Суралцагч бүрийн ялгаатай байдлыг мэдснээр багш арга зүйдээ суралцагч бүрд тохирсон хувилбарыг бодож боловсруулан хэрэглэх, тэдний хөгжлийг дэмжих туршлагатай болж байдаг. Суралцагч бүрийн ялгаатай байдалд тохирсон зөв арга зүйг суралцах орчин, үнэлгээ, даалгавартай хослуулан хэрэгжүүлснээр багш суралцагч бүрийг амжилттай сургах нөхцөл бүрдэнэ.

Биеийн тамирын хичээл бусад хичээлээс ялгагдах онцлог нь тэнд оролцож буй бүх хүүхдүүд хөдөлгөөний үйлдлүүдийг байнга хийдэгт оршино. Тиймээс хүүхэд бүрийг маш анхааралтай ажигласны үндсэн дээр тухайн хүүхдийн хөдөлгөөний чадварыг мэдэхээс гадна Хэнд ямар тусламж хэрэгтэй вэ? Ямар арга зүйг ашиглавал илүү үр дүнтэй болох вэ? гэдгийг тодорхойлон хичээлээс хичээлд туршлагажин багшлах арга зүйгээ олж авна. Энэ талаар гадаад улс орны голлох эрдэмтдийн судалгааг авч үзвэл:

Эрдэмтэн Willis & Mann, (2000) “Сургалтын үйл ажиллагааг багш төлөвлөнө гэдэг нь ялгаатай (өвөрмөц) хүүхэд бүрд ижил ойлгогдох жишээ, баримт хичээлд ашиглахыг хэлнэ”.

Mitchell & Hobson, (2005) “Ялгааг (өвөрмөц) харгалзсан сургалт, багшийн үйл ажиллагаа сургалт эхлэхээс өмнөх суралцагчийн мэдлэг, чадварын ялгаатай байдлыг илрүүлэхээс эхэлдэг. Koutsellini (2008) “Ялгааг (өвөрмөц) харгалзана гэдэг нь багш сургалтаас гадуур суралцагчид ямар мэдлэг, туршлага харилцан адилгүйгээр олж авч байна вэ гэдгийг бодолцоно, анхаарна гэсэн үг”. Valiandes (2010) “Сургалтын хөтөлбөр, багшийн хичээлд ашиглах материалаас ялгааг харгалзсан сургалтын багшийн үйл ажиллагааны зарчим, гол үнэт зүйлсийг харж болдог. Ялгааг (өвөрмөц) харгалзсан сургалт бол зөвхөн олон янзын арга биш” гэсэн байгаагаас дүгнэхэд

багш суралцагчдын өвөрмөц байдлыг хичээлийн хөтөлбөртэй заавал тусгах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Судлаачдын үр дүнгээс АНУ-ын судлаач Томлинсоны загварын дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад суралцагчийн тухай сургалтын агуулгыг хүлээн авахад бэлэн байдал, сонирхол, суралцах онцлог гэсэн дараах гурван зүйл нь суралцагчдад ялгаатай заавар өгөхөд хөтөлдөг гэж үзсэн байна.

Түүнчлэн багш нар суралцагчдыг яагаад ялгаатайгаар сургалтын үйл ажиллагаагаа зохион байгуулах хэрэгтэй вэ? (Томлинсон 1999) гэдгийг доорх байдлаар тодорхойлсон байна.

Учир нь:

- Суралцагч бүр өөр өөр соёлтой.
- Суралцагч бүр харилцан адилгүй нийгэм эдийн засгийн боломжтой.
- Суралцагч бүр өөр өөр сурахуйн онцлог шинж төрхтэй.
- Суралцагч бүр өөр өөр хэлний болон бусад чадвартай.
- Суралцагч бүр өөр өөрөөр сэдэлждэг.
- Суралцагч бүр өөр өөр сонирхолтой
- Суралцагч бүр өөр өөр мэдээлэлтэй, бас мэдлэгтэй.

Иймээс сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа суралцагчийн бэлэн байдал, сонирхол, сурах онцлогийг харгалзах нь зүйтэй гэсэн байдаг. Ийнхүү суралцагчийн сурах онцлог, хэв маягийг харгалзсан сургалтыг зохион байгуулахын тулд тэдний сурах онцлог, хэв маягийг урьдчилан тодорхойлох нь чухал байдаг. Тиймээс шинэ бүлэг сэдэв орох бүрдээ хүүхдүүдээ оношилж өөрийн арга зүйгээ баримжаалах нь чухал. Мөн танай ангид ямар нэгэн хөгжлийн ялгаатай суралцагч байвал тэр сурагчдад зориулан тохирох хөгжүүлэх үйл ажиллагаа бүхий дасгал хөдөлгөөн, тоглоомыг санаачлан оруулах хэрэгтэй.

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ

Биеийн тамирын сургалтын хөтөлбөрийн агуулга танхимын болон цахим орчинд хичээлийг зохион байгуулах чиглэлүүдийг тодорхой тусгасан байна. Үүнд:

- Мэдээлэл харилцааны технологи ашигласан дасгалыг сурагчид илүү сонирхож байгаа учраас видео бичлэг, сургалтын DVD-гээр дасгалыг үзүүлж, дуурайн хийх
- Аль болох олон төрлийн хэрэглэгдэхүүн ашигласан дасгалуудыг сонгон оруулах
- Хэрэгсэлгүй БЕХД-ыг хүүхэд хийх сонирхолгүй болсон тул тэдгээр дасгалыг алчуур, цацаг, саваа гэх зэрэг хэрэгсэлтэй хийх
- Сурагчдыг өөрсдийн чадварт тохируулан хэрэглэл материалаа сонгох, байрлуулах байдлыг дэмжих
- Багшийг дуурайж хийх биш, сурагчид өөрсдөө бодох, зохиох, туршиж үзэх, бие даан гүйцэтгэх агуулгыг өргөжүүлэх зэрэг юм.

Хувьсан өөрчлөгдөж цахимжиж буй энэ үед сургалтын хөтөлбөрийн агуулгыг орхихгүй залгамж холбоог алдуулахгүй явуулах нь багшаас суралцагчдын бие бялдрын хөгжлийг дэмжих, ажлын байран дээрээ хөгжих, олон ур чадварыг өөртөө бий болгох, бүтээлч эрэл хайгуул, мэдээлэл харилцааны өргөн чадварыг шаардаж байгаа билээ.

Хөтөлбөрийн дагуу хичээлээ удирдан явуулахдаа багш бүр өөр өөрийн арга барил, технологийн ур чадвартаа тохируулан явуулах боловч биеийн тамирын хичээлийн арга зүйн дараах онцлогуудад заавал нийцүүлсэн байна. Үүнд:

- Хүүхэд бүрийн хувийн онцлогийг тодруулна
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх боломж олгоно
- Хүүхдийн өөртөө итгэх итгэлийг дээшлүүлнэ
- Дасгалыг бүтээлчээр гүйцэтгэх сонирхол дээшилнэ.

Биеийн тамирын хичээлийн сургалтад сурагчдыг идэвхжүүлэх зорилгоор ашиглаж ирсэн уламжлалт аргуудыг насны онцлогт тохируулан хэрэглэх юм бол хичээл илүү сонирхолтой





болоод зогсохгүй оролцогчдын идэвхийг сэргээх сайн талтай. Сургалтын аргуудыг нэрлэвэл:

- Тоглоомын арга
- Тэмцээний арга
- Урамшуулах арга
- Шийтгэх арга
- Баримжаалах зүйлүүдийг ашиглах арга
- Дуут дохиог ашиглах арга
- Итгэлцэх арга
- Хэрэглэгдэхүүн хувирган ашиглах арга
- Үгэн тоглоомын арга
- Мэргэжлийн багаж, төхөөрөмж ашиглах

Эдгээр аргуудыг ашиглан хичээлээ илүү сонирхолтой болгох боломжтой. Бага насны хүүхдүүд амархан уйддаг, ядардаг, сонирхол нь буурдаг тул хичээл бүр дээр шинэ арга, шинэ хэрэглэл, материал зэргийг оруулж санаачлагатай ажиллах нь чухал юм.

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

Сургалтын агуулга, хөтөлбөр, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор биеийн тамирын хичээлийн суралцахуйн удирдамж боловсруулагдсан. Суралцахуйн удирдамжид суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх сурагчдын сурах үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэглэгдэхүүнийг санал болгосон. Тухайлбал:

Танхимын сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн	- Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж, Биеийн тамир 1-5-р анги, 2019 он (meds.gov.mn/curriculum-baga), https://www.mier.mn/images/product_images/48a0f-biyiin_tamir_baga.pdf) - “Суурь, бүрэн дунд боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур” Биеийн тамир, 2021 он - “Биеийн тамирын багшийн ном– I”, 2014
Цахим сургалтад дэмжлэг үзүүлэх нөөц хэрэглэгдэхүүн	- “Биеийн тамир”-ийн 10 теле хичээл (medle.mn) - “Биеийн тамир”-ийн 2 интерактив хичээл (medle.mn) - “Эрүүл биед саруул ухаан - Дасгал, хөдөлгөөний ач тус” нэмэлт контент (https://econtent.edu.mn/additional/261/100001345534375) • “Өвчнөөс хамгаалах-Ханиаднаас урьдчилан сэргийлэх” нэмэлт контент (https://econtent.edu.mn/additional/261/100001345534374) • “Онцгой нүдний шил-Хараа хамгаалах, ялгаатай байдал” нэмэлт контент (https://econtent.edu.mn/additional/261/200002440538279)
Бусад	Төрөл бүрийн дасгал хөдөлгөөнийг харуулсан зурагт үзүүлэн, дасгалд тохирох ая бүхий CD, DVD бичлэг, төрөл бүрийн хэрэглэл гэх мэт ээлжит хичээл бүрийн онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн бэлтгэсэн байна.

ҮНЭЛГЭЭ:

1-р ангид биеийн тамирын хичээлийн үнэлгээ нь хүүхдийн бие бялдрын түвшинг тодорхойлж, тэдэнд тохирсон арга зүйгээр, тохирсон хэрэглэгдэхүүн, дасгал хөдөлгөөн хэрэглэж хүүхдийн хөгжлийг дэмжинэ. Хичээлийн явцад багш ажиглалтын арга, тэмдэглэл хөтлөх арга, - баримтжуулах арга, ярилцах аргыг ашиглан хүүхдийн бие бялдрын бэлтгэлжилтийг хянах нь чухал. Тиймээс бага ангид явцын үнэлгээг ашиглах нь зохимжтой. Явцын үнэлгээнээс 2 дүгнэлт хийж чадаж юм бол хичээл үр дүнтэй болдог.

Нэг талаас багш “Миний төлөвлөлт, арга зүй хүүхдэд тохирч байна уу? Ямар хэрэглэгдэхүүн хэрэглэвэл илүү үр дүнтэй вэ? Цаашид..... гэх мэт асуудлыг олж харж хичээлийн хөгжүүлэлтийг байнга хийж сайжруулан ажиллах, нөгөө талаас сурагч “Би яагаад үүнийг хийж чадахгүй байна. Яавал дээр вэ? Би ингээд хийсэн чинь болж байна. Цаашид яаж илүү сайжрах вэ? гэж өөрийн хөдөлгөөний үйлдлийг мэдэрч, дүгнэдэг болоход явцын үнэлгээ туслах бөгөөд ингэж үйл ажиллагаагаа нэгтгэж чадвал биеийн тамирын хичээлийн гол зорилго хангагдах юм. Та бүхэнд 1-р ангийн хүүхдийг ингэж дүгнэх хэрэгтэй гэхээс илүүтэйгээр бүлэг сэдэв бүрээр хүүхдээ хэрхэн ажиглах, ажигласан тэмдэглэлээ ашиглах хүрээнд тэмдэглэх хөтлөх хүснэгтийн санааг та бүхэнд санал болгож байна. Мөн биеийн тамирын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур (ebook.eec.mn), шалгуурыг хэрэглэх зөвлөмжийг сургалт үйл ажиллагаандаа ашиглаарай.



1. Ахуйн хэрэгцээт дасгалын хүрээнд: Биеийн жинг тодорхойлох

Сурагчдын гутлыг тайлуулан, цуваагаар зогсоож, ээлжлэн жинлүүр дээр гаргаж биеийн жинг хэмжээд, үзүүлэлтийг өөрт нь хэлж өгнө. Үүнийг намар ,хавар 2 удаа хийнэ.

- Багш сурагч бүрийн жинг тэмдэглэж авах

 Олон тооны сурагчийн биеийн жинг хэмжиж тэмдэглэхдээ жингийн ялгаатай байдлыг богино хугацаанд тодорхойлохын тулд доорх хүснэгтийг бэлтгээд сурагчдын нэрийг бичсэн байвал зохино. 2 багана нь намар хаврын үзүүлэлт бичигдэх бөгөөд жилийн турш биеийн тамырын хичээлээр хичээллэлсний үр дүн харагдах юм. Биеийн өндөр болон бусад үзүүлэлтүүдийг энэ хүснэгт ашиглан бичих боломжтой.

I ангийн 7 настай сурагчдын биеийн жингийн үзүүлэлт**Хүснэгт 1**

№	Сурагчийн нэр	хүйс	жин багатай		хэвийн жинтэй		жин бага зэрэг илүү		жин ихтэй	
			20- доош кг		21-23 кг		24-26 кг		27-дээш	
1	Алтан	эр			23.4					
2	Ариун	эр							28.2	
3	Болор	эм					24.1			
4	Буян	эм	17.8							

2. Шидэх дамжуулах бүлэг сэдвийн хүрээнд: Сурагчдын бөмбөг шидэх, барьж авах чадварыг оношлох

- Сурагчдад жижиг бөмбөг тарааж өгөх
- Бөмбөгийг хоёр гараар дээш шидээд хоёр гараар барьж авах дасгалыг хүүхдүүд биеэ даан давтах. Бөмбөгийг толгойноос дээш өндөрт шидээд, биедээ хүргэлгүйгээр хоёр гараар барьж авахыг багш үзүүлж, сануулна.
- 5 удаа бөмбөгөө газарт унагалгүй барьж авсан сурагчид бөмбөгөө өргөөрэй гэнэ.

 Багш сурагчдын гүйцэтгэлийг ажиглан, оношилгооны хуудас дээр сурагч бүрийн гүйцэтгэлийн үр дүнг тэмдэглэнэ. Богино хугацаанд оношлохын тулд сурагчдыг багшийн журнал дээрх нэрсийн дарааллаар жагсаавал тэмдэглэл хийхэд хялбар болно.

I ангийн сурагчдын бөмбөг шидэх, барих чадварын үзүүлэлт**Хүснэгт 2**

№	Сурагчийн нэр	Бөмбөгөө дээш шидээд 5 удаа биедээ хүргэлгүй барьж авсан	Бөмбөгөө дээш шидээд 3-4 удаа биедээ хүргэлгүй барьж авсан	Бөмбөгөө дээш шидээд 4-5 удаа биедээ наан барьж авсан	Бөмбөгөө дээш шидээд 2-оос олон удаа газарт унагасан
1	Ариугүн		+		
2	Асралт	+			
3	Болд	+			
4	Бадам			+	
5	Гүнээ				+

 Сурагчдын чадварт дүн шинжилгээ хийж, бөмбөгийг шидээд барьж авч чадахгүй байгаа болон биедээ наан барьж авч буй сурагчдыг анхааралдаа авна. Гэртээ энэ дасгалыг давтаж байгаад бөмбөгөө биедээ хүргэлгүй барьж авч чаддаг болсон үедээ багшдаа хэлээрэй гэсэн даалгавар өгч болно.

3. Үсрэх харайх бүлэг сэдвийн хүрээнд: Сурагчдын нэг ба хоёр хөлөөр үсрэх чадварыг оношлох

- Хооронд нь 50-60 см зайтай 4 ш дугуй дүрсийг сөөлжүүлэн байрлуулах
- Сурагчид цувран, хоёр хөлөөр түлхэн үсэрч дугуй дотор буугаад үргэлжлүүлэн үсрэх. Багш сурагч бүрийг ажиглан анхаарах шаардлагатай сурагчдын нэрийг тэмдэглэнэ.
- Сурагчид цувран баруун хөл дээр дэгдэн урагш үсэрч явах – 10 м



- Дараа нь зүүн хөл дээр дэгдэн урагш үсэрч явах – 10 м



Хүүхдийн хоёр хөл багтах хэмжээний жижиг цагаригийг ашиглаж болно. Эсвэл шалан дээр өнгийн скочоор дугуй дүрс наагаарай. Энэ дасгал нь хүндрэл багатай учраас ихэнх сурагч чадна гэж найдаж байна. Мөн баруун, зүүн хөл дээр үсрэх чадварт ялгаа байгаа эсэхийг анзаарна. Хэрэв ялгаа ажиглагдвал хүүхдийн бие бялдрыг өв тэгш хөгжүүлэх үүднээс хоёр хөлд ижил ачаалал өгч байхыг хойшид анхаарна.

I ангийн сурагчдын үсрэх чадварын үзүүлэлт

Хүснэгт 3

№	Сурагчийн нэр	Хоёр хөлөөр оновчтой үсрэх			Нэг хөлөөр 10 м дэгдэж үсрэх				Онош
		5 удаа оновч-той буусан	3-4 удаа оновч-той буусан	1-2 удаа оновч-той буусан	баруун		зүүн		
					10 м тасралтгүй үсэрсэн	заримдаа зогсоод үсэрсэн	10 м тасралтгүй үсэрсэн	заримдаа зогсоод үсэрсэн	
1	А	*			*		*		Маш сайн
2	Г		*		*			*	сайн
3	Л		*			*		*	дунд
4	У			*	*			*	тааруу

Сурагчид өөрийгөө үнэлэх болон найз нараа үнэлэж болно. Жишээлбэл:

- Сурагч бүр хоёр хөлөөр түлхэн үсрэхдээ 5 дугуйгаас хэдэн дугуй дотор нь онож буусан тоогоор өөртөө оноо өгнө.
- Дахин үсрэхдээ бие биенийхээ гүйцэтгэлийг ажиглан, 5 онооноос үнэлнэ.
- Энэ дасгалыг хоёр удаа гүйцэтгэхдээ нийт хэдэн оноо авсныг багшдаа хэлнэ. Багш үгэн үнэлгээгээр урамшуулна.

Үнэлгээ хийх явцад хүүхдийн өөрийн нь үнэлсэн үндэслэл, цаашид яаж сайжрах, яаж зөв хийх, найздаа хэрхэн туслах, өөрт нь ямар дэмжлэг хэрэгтэй байгааг заавал яриулж байх хэрэгтэй. Биеийн тамирын хичээл бол зөвхөн даган дуурайн хийх хичээл биш хүүхэд өөрийн үйлдлийг мэдрэн, үнэлэлт өгөх, асуудал шийдлээ зөв гаргахад туслах юм.

Биеийн тамирын хичээлээр сурагчдад бие бялдар, хөдөлгөөний чадвар суулгахаас гадна өөрийн хөгжил, чадвартаа үнэлэлт дүгнэлт хийх арга барилыг багаас нь суулгахын тулд хичээл бүр дээр ярилцах боломжийг бий болгох нь чухал юм.

Хичээлийн арга зүйн санаа:

Хичээл №1. Биеийн тамирын хичээл бэлдэх, зориулалтын хувцас өмсөх

Зорилго:

1. Биеийн тамирын хичээлд зориулалтын хувцас өмсөх, өмссөний ач холбогдлыг ойлгуулах
2. Биеийн тамирын хувцсаа тээвэрлэх, өмсөх, хадгалах талаар анхны мэдэгдэхүүн олгох

Алхам 1. Заал болон талбайдаа хүүхдүүдээ суулган ярилцана.

- Багш сурагчдыг суулгах буюу жагсааж зогсоогоод биеийн тамирын хичээлд ямар хувцас өмсдөг вэ? гэсэн асуултаар хичээлээ эхлэх бөгөөд мэдэж байгаа хүүхдүүд гараа өргөөрэй гэнэ. Мэдэж буй сурагчид, мэдэхгүй байгаа сурагчдын аль нь олон байгааг ажиглана.
- Биеийн тамирын хичээлд яагаад бэлтгэлийн хувцас, кет өмсдөг талаар гар өргөсөн 2-3 хүүхдүүдээр яриулна.
- Энд гараа өргөсөн хүүхэд бүр биеийн тамирын хувцасны талаар бүрэн дүүрэн ойлголтгүй боловч нэгдүгээр ангийн сурагч биеийн тамирын хичээлийг бусад хичээлээс ялгаж байна уу? гэдгийг харж болно.

Алхам 2. Биеийн тамирын хичээлд өмсөж болох хувцас, хэрэглэлийг үзүүлэх



- Багш өөрийн өмссөн хувцас хэрэгсэл дээр тайлбар хийх
- Тухайн үед бэлтгэлийн хувцсаа бүрэн өмсөж ирсэн 2-3 хүүхдийг зогсоож тайлбар хийх
- Өмссөн хувцас хэрэглэл дээр ярилцаж байгаа нь хүүхэд өөрийн харж байгаа бодит зүйлдээ илүү анхаарал хандуулдаг тул багш тайлбарыг илүү энгийн сонирхолтой ойлгомжтой хийх хэрэгтэй. Үүнд:
- Бэлтгэлийн өмд цамц, подволк, шорт биед эвтэй байх, хөдөлгөөнд саад учруулахгүй байх, гэмтэл бэртлээс хамгаалах, ямар материал байвал сайн, өнгөний талаар
- Кет, пүүз, оймс хөлд эвтэйхэн байх, томдсон буюу багадаагүй байх, хальтрахгүй байх, даавуун материал оймс сонговол сайн талаар

Хүснэгт 1. Үзүүлэн хийх буюу цахим болон танхимын хичээлийн үед хэрэглэж болно,

			
Бэлтгэлийн хувцас, шорт подволк	Хүүхдийн бэлтгэлийн бүрэн хувцас	Кет, пүүз	Хувцас тээвэрлэх уут

Алхам 3. Биеийн тамирын хувцасны хадгалалт, арчилгаа, тээвэрлэлт

- Биеийн тамирын хувцсаа хэрхэн арчлах, угааж цэвэрлэх, тээвэрлэх /хичээлээ авч ирэх/ талаар багш тайлбарлах ба Medle.mn.-д байршуулсан 1-р ангийн интерактив хичээлийг үзүүлэх: Линк /<http://old.econtent.edu.mn/interactives/EBS/>

 Биеийн тамирын хувцсыг зориулалтын дагуу иж бүрэн өмсөж, эцэг эх, асран хамгаалагчдын тусламжийг аван цэвэрлэн өмсөх дадал хэвшил тогтоохын тулд нэг цагийн хичээл багадаа билээ. Энэ хичээлээр мэдлэгүүдийг хүүхдийн оролцоотой, сонирхолтой хэлбэрээр, харилцан ярилцах, хийж гүйцэтгэх, шийдлийг хүүхдэд өөрт нь үлдээх, зөв цагт нь засч залруулах хэрэгтэй.

Багшид санамж: Биеийн тамирын хувцас хэрэглэлийг зориулалтын дагуу өмсөж сурах дадал хэвшлийг анхнаас нь зөв суулгах нь чухал. Тиймээс 1-р улрлын хичээл дуустал багш хичээл бүр дээр хүүхдүүдийн биеийн тамирын хувцсаа хэрэглэж байгаа байдал, угааж цэвэрлэж байгаа байдал, сургуульдаа хэрхэн авчирч байгаа байдал /тээвэрлэн авч ирж байгаа/ зэрэгт байнга хяналт тавьж, зөвлөх ба 7 хоногт нэг хүүхдийг онцлон хувцас хэрэглэлээ хэрхэн угааж, цэвэрлэж хичээлдээ өмсөж байгаа талаар хувийн туршлагыг нь яриулж болно. Ингэснээр бүх хүүхдүүд хувцаслалтаа хариуцлагатай хандаж, биеийн тамирын хувцас зөв хэрэглэх дадал хэвшил амархан төлөвшинө. Medle.mn. байршуулсан 1-р ангийн интерактив хичээлийг өөрсдөө ажлуулан үзэж, бодит хэрэглээ болгох даалгавар өгнө.
Линк /<http://old.econtent.edu.mn/interactives/EBS/>

Хичээл №2. Эгнээ, цуваа жагсаал, жагсаалын хувиргалт

Зорилго: Эгнээ цуваа жагсаалаар жагсаж сурах, жагсаалын ялгааг таних, нэрлэж сурах

Алхам 1. Бие халаалт. Багш сурагчдыг удирдана.

- Дэлгэц, проектор ашиглана. Хүүхдүүд эгнээ ба цуваа жагсаалаар жагсаж буй бичлэг
- Эгнээ цуваа жагсаалыг харуулсан үзүүлэн
- Багш хичээл эхлэхийн өмнө “Хүүхдүүдийн хувцаслалт”-ын талаар ярилцана.

 Хувцаслалтыг хичээл бүрийн эхэнд заавал ярилцана. Багш ийм тийм гэж дүгнэхээс илүүтэй хүүхдүүд өөрсдийн хувцаслалтаа дүгнэх, эсвэл хичээлийн бэлтгэлээ сайн хангаж




ирсэн хүүхдүүд энд зогсоорой! гэх мэт аргуудыг хэрэглээд байвал дадал болох талтай.

Алхам 2. “Шугам даган зөв зогсоцгооё” тоглоом

- Хооронд нь 2-3 м зайтай 3 ш шулуун, 2 эгнээ 3 ш шулуун байрлуулах
- Багш сурагчдыг 5-6-аар бүлэг болгон зогсооно Багш сурагч бүрийг анхааралтай сонсохыг хүснэ.
- Багийг нэгээс эхлэн дугаарлана. Багаараа багшийн хэлсэн зураасан дээр зогсоно. Зогсохдоо 1ш шулуун зураасан дээр эгнээ, 2 ш шулуун зураасан дээр цуваа жагсаалаар жагсана. Эхний 3 удаа тоглоомоо давтаад 4 дэхээс эхлэн тоглоно.
- Багш зураасуудаа дугаарлана. Тоглоомоо эхлэхдээ 1-р баг 4 номерын зураас дээр, 2-р баг 1 номерын зураас дээр гэх мэт хэлж дуусаад гүйгээд гэж хэлнэ. Хүүхдүүд гар гараасаа хөтлөлцөн яваад зураасан дээрээ зогсоно. Буруу зогссон баг ялагдаад суух ба хамгийн сүүлд нэг баг үлдтэл тоглоно.
- Тоглоомыг дүгнэхдээ яагаад буруу хийсэн, юу нөлөөлсөн, зөв хийхэд юу нөлөөлсөн талаар ярилцана.



Хүүхдийн анхаарал болон багийн ажиллагаанд хяналт тавина. Биеийн тамирын хичээлээр багаар ажиллах, бие биеэ удирдах, сонсох, ярилцах зэрэг аргуудыг түлхүү хэрэглэнэ.



Цахим болон танхим хосолсон

Багшид зөвлөмж: Эгнээ, цуваа жагсаал нь жагсаал зохион байгуулалтын суурь тул эхний ойлголтыг сайн өгөх хэрэгтэй. Гэхдээ эхний хэдэн хичээлээр өндөр намаар нь жагсаах гэж хүчлэх буруу. Учир нь хүүхдүүд бие биеэ танихгүй тул хүчээр зогсоох гэж оролдвол биеэ барих, тухайн орчиндоо дасахгүй байх, хичээлд сонирхохоо болих зэрэг сөрөг тал ихтэй тул эхний хичээлүүд дээр өөрсдийн саналаар зогсоох бөгөөд аажмаар өндрөөс нам, намаас өндөр лүү жагсаах хэрэгтэй. Харин камондыг заавал зөв гүйцэтгэх зүйл гэдгийг илүү сайн тайлбарлан ойлгуулах хэрэгтэй. Мөн эхний хэдэн хичээлүүдээр хатуу, чанга камондлахгүй байх шаардлагатай. Цахим сургалт явуулах бол ээлжит хичээлийн төлөвлөлтийн дагуу түүнд байгаа зургуудыг ашиглан бэлтгэж ороорой. Medle.mn сайтад байршуулсан теле хичээлийг татан авч ашиглаж болно. Лунк: <https://medle.mn/telelesson/1/23/3208>

Хичээл №6. Гар, хөл, их биеийн хөдөлгөөнийг нэрлэх, танин ялгах, дасгал хийх

Зорилго: Сурагчдын гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг нэрлэх, таних, гүйцэтгэх чадварыг дэмжих, хөгжүүлэх

Алхам 1. Хичээлийн эхний хэсэгт:

- Цуваагаар алхах – 1 тойрог
- Хоёр цуваа болж хөтлөлцөн алхах – 1 тойрог
- Хөтлөлцөн зөөлөн гүйх-2 тойрог
- Тойрч зогссон байдлаас хөлөө жийн сууж, босох – 6-8 удаа
- Өлмий дээрээ хөнгөн үсрэх – 10 удаа



Багш сурагчдын хийх үйлдлийг үгээр ойлгомжтой хэлнэ. Заримыг нь үзүүлж болно. Цуваан дахь хүүхдүүдийн хооронд хоёр алхам зайтай байхыг анхааруулж хэлээрэй. Хичээл бүр дээр өмнөх үзсэн зүйлээ давтах нь сурагчдын мэдлэг чадварыг баталгаажуулах тул багш төвөгшөөлгүй давтан ярьж байх шаардлага бий.



Алхам 2. Гарын үндсэн хөдөлгөөнт дасгалыг нэрлэж, гүйцэтгэх

- Бэлтгэх байдал: үндсэн зогсолт

Дас 1. 1- гараа урагш өргөнө. 2- алдална. 3-дээш өргөнө. 4-буулгана.

Дас 2. 1- гараа алдална. 2-арагш өргөнө. 3-урагш өргөнө. 4-ташаанд авна.

Дас 3. 1- гараа арагш өргөнө. 2-дээш өргөнө. 3-толгойн ард авна. 4-алдална.



Ангийг 4 эгнээ болгож зогсооно. Гарын хөдөлгөөнийг юу гэж нэрлэдгийг санаж байгааг асууж болно. Дасгал бүрийг багш үзүүлээд 1-2 удаа дагуулж хийнэ. Дараа нь багш тоолж, сурагчид бие даан гүйцэтгэнэ. Дасгалыг үзүүлэхдээ хөдөлгөөн бүрийг багш нэрлэвэл сурагчид гарын үндсэн хөдөлгөөнүүдийн нэршлийг мэддэг болоход тусална.

Алхам 3. Хөлийн үндсэн хөдөлгөөнт дасгалыг нэрлэж, гүйцэтгэх

- Бэлтгэх байдал: үндсэн зогсолт

Дас 1. 1-зүүн хөлөө урагш өргөнө. 2-буулгана. 3-баруун хөлөө урагш өргөнө. 4-буулгана. 5-зүүн хөлөө хажуу тийш өргөнө. 6-буулгана. 7-баруун хөлөө хажуу тийш өргөнө. 8-буулгана.

Дас 2. 1-зүүн хөлөө урагш өргөнө. 2-буулгана. 3-зүүн хөлөө хажуу тийш өргөнө. 4-буулгана. 5-зүүн хөлөө арагш өргөнө. 6-буулгана. 7-зүүн хөлөө урагш-дээш өргөнө. 8-буулгана. Дараагийн 8 тоонд баруун хөлөөр дасгалыг гүйцэтгэнэ.



Дасгалыг дуурайж хийхээс өмнө багш сурагчдаас баруун хөлөө өргөхийг хүснэ. Баруун, зүүн гар хөлөө ялгаж байгаа эсэхийг тодруулаад, мэдэхгүй байвал үзэг барьдаг гараар зүйрлүүлж ойлгуулна. 2-ын аргыг хэрэглэж болно.

Алхам 4. Их биеийн үндсэн хөдөлгөөнт дасгалыг нэрлэж, гүйцэтгэх

- Бэлтгэх байдал: үндсэн зогсолт

Дас 1. 1-бөхийнө. 2-эгцэрнэ. 3-гэдийнэ. 4-эгцэрнэ. 5-зүүн тийш хазайна. 6-эгцэрнэ. 7-баруун тийш хазайна. 8-эгцэрнэ.

Дас 2. 1-гараа ташаанд авч баруун тийш хазайна. 2-эгцэрнэ. 3-зүүн тийш хазайна. 4-эгцэрнэ. 5-гараа толгойн ард авч бөхийнө. 6-эгцэрнэ. 7-гэдийнэ. 8-эгцэрч гараа буулгана.



Дасгал бүрийг багш нэрлэж, үзүүлээд 1-2 удаа дагуулж хийнэ. Дараа нь багш тоолж, сурагчид бие даан гүйцэтгэнэ.

Алхам 5. Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн хосолсон дасгалыг гүйцэтгэх

- Бэлтгэх байдал: үндсэн зогсолт


Дас 1. 1-гараа алдлан бөхийнө. 2-гараа буулган эгцэрнэ. 3-гараа өргөн гэдийнэ. 4-гараа буулган эгцэрнэ. 5-баруун гараа өргөн зүүн тийш хазайна. 6-гараа буулган эгцэрнэ. 7-зүүн гараа өргөн баруун тийш хазайна. 8-гараа буулган эгцэрнэ.

Дас 2. 1- гараа дээш, зүүн хөлөө урагш өргөнө. 2-гараа алдлан хөлөө буулгана. 7-гараа урагш, баруун хөлөө урагш өргөнө. 8-гар, хөлөө буулгана.

Дас 3. 1-зүүн хөл, хоёр гараа урагш өргөнө. 2-буулгана. 3-баруун хөлөө хажуу тийш өргөн, гараа алдална. 4-буулгана. 5-зүүн хөлөө арагш өргөн, гараа толгойн ард авна. 6-буулгана. 7-баруун хөлөө урагш-дээш өргөн, гараа ташаанд авна. 8-буулгана.



Багш тоолж, алга ташиж, хөдөлгөөнийг нэрлэж сурагчдыг удирдана. Гар, хөл, их биеийн хөдөлгөөн хосолсон дасгалыг удаавтар тоолж хийлгээрэй. Сурагчид багшийгаа даган хөдөлгөөнийг нэрлэх, зарим хөдөлгөөнийг нэг сурагч нэрлэн хийх аргыг хэрэглээрэй.

Гар хөлийн үндсэн хөдөлгөөн	Цахим хичээлд хэрэглэх хичээлийн холбоосууд
Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн бүхий 8-32 тоот цогц дасгал 	https://medle.mn/interactivelessonAll/1/10007 Контент https://medle.mn/telelesson/1/23/216 Теле хичээл https://medle.mn/telelesson/1/23/2418 Теле хичээл
Багшид зөвлөмж: Гар, хөл, их биеийн хөдөлгөөнийг нэрлэх, таних, хийх нь хамгийн чухал бөгөөд гар, их биеийн дасгал хөдөлгөөнийг дасгалуудыг эхлэн хийлгэхдээ заавал дасгалын нэрийг хэлж давтан гүйцэтгүүлнэ. Гарын хөдөлгөөнийг хийх үед гараа тохойгоор нугалахгүй, гарын сарвууг нийлүүлэн чангалах, дасгалыг гүйцэтгэхдээ гарын үзүүрийг харж нуруу цэх хийх, хөлийн дасгалыг хийхдээ биеийн тэнцвэрээ хадгалах, хөлөө урагш, хойш, хажуу тийш өргөн дасгал хийхдээ хөлийн өлмийг жийлгэн хийлгэж сургах хэрэгтэй. Анх зааж буй энэ үед л тухайн дасгалуудыг зөв хийлгэж сургавал насан туршдаа дасгал хөдөлгөөн хийх зөв дадалд суралцах тул анхлан заахдаа л дасгалыг буруу заах гэсэн ойлголтгүйгээр чадварт суралцуулах хэрэгтэй.	

Хичээл №3. Янз бүрээр мөлхөх, авирах аргыг хэрэглэх

Зорилго: Мөлхөх, авирах хөдөлгөөнийг гүйцэтгэж бие бялдраа хөгжүүлнэ.

Алхам 1. Бие халаалт. Гарын үндсэн хөдөлгөөнийг хийж цуваагаар алхах, зөөлөн гүйх.

Амьтдын хөдөлгөөнийг сурагчид биеэр дүрсэлж үзүүлэн бие халаалт хийнэ

- Муур, нохой, могой, тогоруу зэрэг амьтдын хөдөлгөөнийг дүрсэлж үзүүлэх
- Хөгжмийн аянд амьтдын хөдөлгөөнөөр явж үзүүлэх

 Багш амьтдын нэрийг нэрлэхэд сурагч өөрийн сэтгэмжээр уг амьтныг дүрсэлж үзүүлнэ. Тэр үйлдлээ 2-4 удаа давтана. Хөдөлгөөнөө гүйцэтгэхдээ амьтдын дуу авиаг гаргаж үзүүлээрэй гэнэ. Багш хүүхдүүдийг зөв хийвэл даган хийж явах бөгөөд буруу хийвэл жаахан бодоорой гэж бодох хугацаа өгөх ба

Алхам 3. Дөрвөн хөллөн мөлхөх буухиа

	Буухиа тоглоом хэлбэрээр явуулна. Багт 5 хүүхэд байна. Гараа, бариаг тэмдэглэсэн байна. - Зиг заг-аар тавьсан тоглоомыг сүлжүүлэн мөлхөх - Мөлхөхдөө гартаа туг барих ба өөрийн багийн хүүхэддээ тугаа дамжуулах - Хамгийн сүүлийн хүүхэд байранд орсноор багш дүгнэнэ. Дүгнэхдээ энэ баг түрүүллээ. Баяр хүргэе! гэх мэт зүйлсийг хэлэхгүй. Харин мөлхөхөд хэцүү байсан эсэх, хэрхэн мөлхөх нь зөв бэ? Хэн хамгийн сайн мөлхөх вэ? Хэн хамгийн сайн мөлхсөн вэ? зэрэг асуултаар чиглүүлнэ.
Багшид зөвлөмж: Мөлхөхдөө гарын алгаар бүтэн дарж өвдөг дээр ширээ хэлбэрт орж мөлхөх ба нуруугаар хотойлгохгүй, толгой өргөн харц урагш харсан байна. Тогтоосон зайд мөлхүүлээд заавал босгон гар хөлийн булчинг амраан алхуулна. Хөлийн өвдөг цоорохоос хамгаалах зорилгоор биеийн жинг голчлон гар дээр төвлөрүүлэн мөлхөхөд анхаарах хэрэгтэй. Ижил нэрийн хөдөлгөөн болон эсрэг хэрийг хөдөлгөөнөөр мөлхөх аргачлалыг дараах линкээс татаж үзээрэй. https://medle.mn/telelesson/1/23/3685	

Алхам 4. Буухиа тоглоом тоглох


 Нэг багт 5 хүүхэд байна.	- Тогоруу шиг өлмий дээрээ алхъя. - Цагираг доогуур "Нохой" мэт мөлхье. - Өлмий дээрээ "Өд" мэт хөнгөн гүйе. Багшид зөвлөмж: Буухиа тоглоомын дүрмийг сайтар тайлбарлан өгнө. Буухиад оролцож буй бүх хүүхдүүд хийх зүйлээ хийж чадахгүй гэж орхих биш заавал хийж дуусгахыг анхаарна. Бага наснаас уралдах биш сайн гүйцэтгэх чадвар дээр анхаарах хэрэгтэй. Дасгал хөдөлгөөн хийсний дараа заавал дүгнэн яриулж сургах хэрэгтэй.
---	--

Хичээл №7. Янз бүрээр алхах чадвараа сайжруулан алхаж харуулах**Зорилго:** Сурагчдын зөв бөгөөд янз бүрээр алхах гүйх чадварыг дэмжин, хөгжүүлэх**Алхам 1.** Хичээлийн эхний хэсэгт: Хүүхдүүдээ нэг зүгт харуулан зогсооно.

- Найзынхаа биед хүрэхгүйгээр алхаарай
- Болжмор болон нисээрэй!
- Дороо гүйгээрэй гэж хэлээд багш өөрөө дагуулан хийж хүүхдүүдийн биеийг халаана. Алхам 2. Зөв алхах аргыг таниулах
- Багш зөв алхах үйлдлийг үзүүлж тайлбарлана.
- Сурагчид байрандаа багшийг дуурайн алхана.
- Хөлийн өлмий дээр хөнгөн алхах



Алхахдаа гараа тохойгоор бага зэрэг нугалан, урагш хойш чөлөөтэй саван хөдөлгөн өлмий дээрээ хөнгөн алхахыг сануулна. Хөлийн өлмий хэсгийг тодотгон харуулсан үзүүлэн ашиглана. Алхалт бүр жагсаалын алхаа байдаггүйн хэлнэ.



Конус болон төрөл бүрийн бартаа ашиглан алхаж сурах

Хөлийн өлмийгөө заагаарай. Аль вэ?

- Өлмий дээрээ зогсоорой!
- Өндөр болж байна уу гэх мэт сонирхол татсан асуулт асууж өөрөө дагуулан хийлгэнэ.
- Өлмий дээрээ алхаарай, гүйгээрээ гэж багш нь хэлбэл яах вэ? гэж өөрсдөөр нь хийлгэнэ.

Алдааг нь засч зөв хийлгэнэ

Конус дагуулан гараа ташаа, болон толгой дээрээ авч алхуулж, гүйлгэнэ.



Хөлийн улан дээр алхуулж гүйлгэхдээ биеийн тэнцвэрээ хадгалах талаар сануулна.

Дасгалыг олон удаа хол зайд хийлгэх нь хүүхдэд ачаалал их өгөх тул аль болох бага ачаалалаар “ЗӨВ” хийлгэх нь чухал. Мөн хөлийн өсгий, хоёр хажуу тал, огцом эргэж болон дороо эргэж алхах алхаануудыг зааж алхуулах ба алхах явцад хөгжмийн аянд нь алхуулж болно.

Багшид зөвлөмж: Хүүхдүүд дороо алхах алхалтыг эзэмшихдээ бүтэн улаар алхаад сураад үүнийгээ засаж чадахгүй байх тохиолдол байдаг. Тиймээс дороо алхахдаа эхлээд хөлийн өлмий дээр, улмаар өсгий дээр алхаж сургах нь чухал байдаг. Мөн жагсаалын, энгийн алхалтуудыг янз бүрийн чиглэлд, янз бүрийн темпээр хийх нь хүүхдийн хөдөлгөөний чадварт илүү нөлөөлдөг гэдгийг санах хэрэгтэй

Хичээл №9. Зөв гүйж сурахдаа янз бүрийн дасгалыг ашиглах**Зорилго:** Сурагчдын зөв бөгөөд хурдан гүйх чадварыг дэмжин, хөгжүүлэх**Бататгах хичээлийн агуулга:****Алхам 1.** Хичээлийн эхний хэсэгт:

- Цуваагаар алхах, зөөлөн гүйх
- Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон 4-6 дасгалыг багш дагуулж хийнэ

Алхам 2. Зөв гүйх аргыг таниулах

- Багш зөв гүйх үйлдлийг үзүүлж тайлбарлана.
- Сурагчид байрандаа багшийг дуурайн хөнгөн гүйнэ.
- Урагшаа 10 м хөнгөн гүйнэ.
- Шүглийн дуугаар 15 м гүйнэ



Гүйхдээ гараа тохойгоор нугалан, урагш хойш хөдөлгөн өлмий дээрээ хөнгөн гүйхийг сануулж, үзүүлнэ. Хөлөө газарт чанга дэвсэж тавихгүйг бодитоор харуулж болно. Барианы





шугамыг тод харагдахуйц татах ба хоёр хажууд нь том тэмдэг тавих хэрэгтэй. Урагш гүйхдээ аль болох хурдан гүйхийг сануулна. Марш гэж дохио өгөхийн оронд шүгэл хэрэглэвэл энэ насанд тохиромжтой.

Алхам 3. “Туулайгаа уралдуулъя” тоглоом

- Сурагчдыг 3-4 баг болгоно. Багийн гишүүд хоёр хуваагдан 15 м зайд өөд өөдөөс харан цуварч зогсоно.
- Баг бүрийн эхний тоглогч тоглоомон туулай барьсан байна.
- Шүглийн дуугаар баг бүрийн эхний тоглогч гүйж эсрэг талд байгаа өөрийн багийн тоглогчид туулайгаа дамжуулж өгөөд өөрөө цувааны ард зогсоно. Туулайг авсан тоглогч гүйж, мөн эсрэг талын цуваанд туулайгаа дамжуулах байдлаар үргэлжлүүлнэ.
- Туулайгаа бүх тоглогч дамжуулж дууссан баг туулайгаа өргөнө.
- Багш аль багийн туулай гүйлтийн уралдаанд түрүүлснийг хэлж, баяр хүргэнэ.



Туулайны оронд өөр тоглоом байж болох нь мэдээж. Тэгвэл тоглоомын нэрийг өөрчлөөрэй. Тоглох явцад багш хэний баг түрүүлж байгааг чанга хэлж, идэвхжүүлнэ.

Багшид зөвлөмж: Хүүхдүүдэд зөв гүйх техникийг эзэмшүүлэхдээ гарыг тохойгоор нугалан, гарын сарвууг хагас атган урагш хойш чөлөөтэй хөдөлгөн өлмий дээрээ чөлөөтэй гүйж сургах нь чухал байдаг. Ядарч байсан ч яарч байсанч энэ техникийн өөртөө тогтоож чадвал дараагийн ангиудад эзэмших үндсэн техникүүдийг эзэмшихэд хэрэгтэй тул энэ ангиас нь сайтар анхаарах хэрэгтэй. Тиймээс тоглож байхдаа, уралдаж байхдаа ч таны шавь нар гүйлтийн техникийг мөрдөж байх хэрэгтэй тул та бүхэн гүйх явцад нь сануулан хэлж байвал илүү үр дүнтэй.

Хичээл12: Янз бүрийн дохиогоор гүйж сурах

Зорилго: Хөдөлгөөний хариу үйлдэлд бэлэн байх, хурд чадавхыг сайжруулах

Алхам 1. Бие халаалт. Тэмдэгтийг тойрч ба сүлжин гүйх, БЕХ-ийн 3-4 дасгалыг багшийн заавраар гүйцэтгэнэ.

Алхам 2. “Болжмор” тоглоом тоглох. Энэ тоглоом нь хүүхдийн авхаалж самбааг дээшлүүлэхээс гадна өөрийн хяналттай байхад сургана. 6 настай хүүхдүүдийн хувьд анхны дүрэмтэй тоглоом учир маш сайн тайлбарлаад тоглуулах ба тоглоом эхэлсэн үед зогсоож болохгүй бөгөөд дууссаны дараа ярилцах хэрэгтэй.



Тоглоомын дүрэм:

- Гараа болжморын далавч мэт байнга дэвнэ.
- Өлмий дээр зөөлөн алхах ба гүйнэ
- Найзуудтайгаа мөргөлдөхгүй байхыг хичээнэ
- Багшийн хаясан цагирагт орохгүй байхыг хичээнэ.

Хэрэв багшийн хаясан цагирагт орсон бол заалны буланд хөдлөхгүй сууна.

- Хамгийн сүүлд 3 хүүхэд үлдвэл тоглоом шинээр эхлэнэ.

 Хичээл бүрийн эхэнд бие халаалтын дасгалыг яагаад заавал хийдэг талаар хичээл бүрээрээ дасгал хийх бүрдээ багш хэлж байх хэрэгтэй. Ингэснээр хүүхдүүдийн биеийн тамирын хичээлийн боловсрол дээшилнэ.

Алхам 3. Биеийн тамирын хичээлд хэрэглэгддэг дохиотой танилцах

- Хүүхдүүийг дуртай газраа зогсохыг хүснэ.
- Дохио дуугарангуут бие биедээ саад болохгүй гүйх заавар өгнө. Гүйх хязгаарыг зааж өгөх ба эргэн өөрийн байрандаа ирнэ гэдгийг тайлбарлан
- Багш “Гарын алгыг таших” эсвэл Марш! гэсэн дохио өгнө.

Багшид зөвлөмж: Багш нар дохиогоор гарч гүйх гэдэгт зайн гүйлтэд нам болон босоо гараанаас гарч гүйлгэх гэдгийг ойлгож 2 янзаар гараанаас гаргаж гүйлгэсээр ирсэн. Тэгвэл энэ сэдвийн хүрээнд сурагчдыг дохиогоор зогсоо, суугаа, эргэж харж гүйхээр байрлуулан авхаалж самбаа, хурд хүч болон аливаад хариу үйлдэл хурдан үзүүлэх чадварыг дэмжих, хөгжүүлэх илүү анхаарах шаардлагатай.



Хичээл №16. Нэг ба 2 хөл дээр үсрэх чадварыг хөгжүүлэх тоглоом

Зорилго: Сурагчдын нэг ба хоёр хөлөөр түлхэн үсрэх, зөв буух чадварыг дэмжин, хөгжүүлэх


Алхам 1. Хичээлийн эхний хэсэгт:

- Цуваагаар алхах, зөөлөн гүйх
- Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон 4-6 дасгалыг багш дагуулж хийнэ.

Алхам 2. Зөв үсрэх аргыг таниулах


- Сурагчид 4 эгнээгээр, хөлдөө мөрний хэмжээний зайтай зогссон байдлаас: 1-хөлөө нугална. 2- хөлөө тэнийлгэж дээш үсэрнэ.
- Дээрх байдлаас хөлөө нугалахдаа гараа арагш болгоно, хөлөө тэнийлгэхдээ гараа урагш-дээш саван үсэрнэ.
- Багш тоонд тохируулан дагуулж хийнэ. Хөлөө нугалбал хүчтэй үсрэхэд хялбар байна гэдгийг хэлнэ.

Алхам 3. 7 хүүхдийг нэг баг болгон сагсан бөмбөгийн дугуй болон нэмэлт дугуй дүрс зурж тоглоомыг явуулна.

	- Тоглохдоо тойргоор үсрэх бөгөөд бие биеийнхээ бие болон хөл дээр гишгэж, хүрч болохгүй - Багшийн шүглийн дуугаар тоглоно. - Дүрмийн дагуу тоглох бөгөөд баяр баясгалантай чанга инээж, ярьж болно. - Хоёр хөл дээрээ үсрээрэй! - Баруун тийш үсрээрэй! гэх үйлдлүүдийг хэлэх ба түүнийг биелүүлнэ
Багшид санамж: Хүүхдүүдийг 1,5 алхамын зайтай байхаар тооцоод дугуй тойрог зурна. - Хүүхдүүдэд тойрог зурааснаас 1 алхамаас илүү холдож болохгүйг анхааруулна. - Шүглийн дуугаар үсэрнэ. - Хэрхэн үсрэхийг нь хэлээд шүглээ үлээхэд хүүхдүүд тэр камондыг биелүүлнэ. - Хүүхдүүд бие биеийн хөдөлгөөний үйлдлийг тооцохгүй мөргөлдөх, унах тохиолдол их тул та бүхэн энэ бүхнийг тооцох, эсвэл ийм тохиолдолд зогсоогоод “Хэн нь яах ёстой байсан вэ? гэж асуун шийдлийг нь гаргуулан ярилцана.	

Алхам 4. Байрнаасаа янз бүрийн чиглэлд үсрэх

- Хоёр хөлөөр урагш хоёр, арагш, баруун, зүүн тийш ээлжлэн үсрэх
- Нэг хөлөөр урагш нэг, арагш нэг, баруун, зүүн тийш тус бүр нэг үсрэх
- 15-20 см өндөр саадыг давж нэг ба хоёр хөлөөр үсрэх

		Багшид санамж: Дээш үсрэхдээ 2 хөлөөс түлхэлтээ дээш хийнэ. Сандлаас 2 хөлөөр түлхэн газар буухдаа хөлийн өлмий дээр буух сандал нь хөдөлгөөнгүй байх Гараа савах хол биш дээш түлхэнэ.
---	---	---

 Багш үсрэх чиглэлийг үгээр хэлэхээс гадна гараараа зааж болно. Сурагчдын үсрэх чадварыг харгалзан үргэлжлүүлэн үсрэх тоог таван удаа болтол нэмэгдүүлж болно.

Гэртээ (<https://medle.mn/telelesson/1/23/725>) линкээр теле хичээлийг үзэж өөрийн үсрэлтийн чадвараа сайжруулах даалгавар өгнө.

Хичээл №23. Хөлийн түлхэлт сайжруулах дасгалууд

Зорилго: Үсэрч харайх тоглоомоор сурагчдыг хөгжүүлэх

Алхам 1.

- Байрандаа гүйлт, хөнгөн үсрэлтийн дасгалаар бие халаалт хийнэ.

Алхам 2. Үсрэлт, харайлтын хувилбаруудыг гүйцэтгэх




- Байрандаа хоёр хөл дээр үсрэх 10 х 3 удаа
- Мэлхий үсрэлтийг дуурайж, хоёр хөлөөр түлхэн урагш хол үсэрч явах 6 м х 3 удаа
- Байрнаас хоёр хөлөөр түлхэж баруун урагш, зүүн урагш аль болох хол харайх 4 удаа
- Зураасны араас 60-80 см зайд тавьсан дээсийг давж харайх – 6 удаа
- Хооронд нь 50 см зайтай байрлуулсан цагаригаас цагариг руу харайх – 3-4 удаа



Юуны өмнө зөв түлхэж, хөнгөн газардаж сурах ёстой. Буухдаа хөлийг эхлээд өлмийгөөр газарт хүргээд бүтэн улан дээр шилжүүлнэ. Гарын савалтад нэг их анхаарах хэрэггүй. Учир нь энэ насны сурагчид нисэлтийн үеийн хөдөлгөөний эвсэл бүрэн тогтоогүй байдаг.

Алхам 3. Гүйлтээс үсэрч харайх чадвараа хөгжүүлэх

- 20 см өндөртэй саадыг 15-20 м газарт цувуулан байршуулна. Зурагт үзүүлснээс өөрөөр байрлуулж болно.
- Баруун ба зүүн хөл дээр догонцож үсрэх
- Гүйлт дундаа нэг хөлөөс түлхэн үсэрч, нэг хөл дээр үргэлжлүүлэн гүйнэ.



Алхам 4. Үсэрч харайх тоглоом тоглох

- Саадуудыг давж үсрэн уралдах тоглоомыг зохион байгуулахдаа 10 м гүйгээд, хооронд нь 1,5 м зайтай байрлуулсан 20 см өндөр бартааг үсэрч даван
- Хэн хол харайх вэ?



Тоглоомын аргаар харайлтын дасгалыг өгөхөд сурагчдын сэтгэхүйд их ачаалал болохгүйгээр олон удаа хөлийн түлхэлт гүйцэтгэх боломжтой байна. Сурагч бүрийг тоглоомд жигд идэвхтэй оролцуулаарай.

Багшид санамж: Хичээл бүр шинээр явагдаж байгаа тул хамгийн эхлээд бүх зүйлийг зөв хийх, буруу хийх явцад тэр бүрд нь засаж байж бид хүүхэд бүрийн бие бялдрын хөгжлийг дэмжин цаашид сайн сурах байдлыг дэмжих тул багшийн гол анхаарах зүйл нь хүүхэд бүрийн гүйцэтгэлийг хянах явдал юм. Тухайн зүйлийг буруу хийх үед дагуулан хийлгэх, өөрөө хийж үзүүлэх, сайн гүйцэтгэж байгаа сурагчаар хийлгэн харуулах зэрэг аргууд байгаагаас хамгийн сайн арга нь хүүхэд тухайн зүйлээ хэрхэн хийж байгаагаа мэдрэн өөртөө үнэлэлт өгөх явдал юм. Би энэ дасгалыг хийж чадахгүй байна! Яагаад гэвэл..... гэсэн өөрийн үнэлгээг нь маш сайн дэмжих нь биеийн тамирын хичээлийн гол зорилгуудын нэг бөгөөд ингэснээр хүүхэд өөрийн хөдөлгөөнөө хянаж илүү сайжрах болно. Иймээс биеийн тамирын хичээл даган дуурайн хийх хичээл бус бодож, сэтгэн, асуудлаа шийдэх хичээл тул багаас нь энэ тал уруу илүү чиглүүлэх шаардлага байна.

Хичээлийн №28. Резин тоглох, өндөрт татсан резин дээгүүр харайх

Зорилго: Резиндэж тоглонгоо үсрэх чадвараа хөгжүүлэх

Алхам 1. Бие халаалт. Зөөлөн гүйх, туузан шат, цагариг дотор гишгэж гүйх, хөнгөн үсрэх, БЕХД- ыг багш дагуулж хийнэ.

Алхам 2. Резиндэж тоглох

- 4-5 сурагчийг нэг хэсэг болгоно. Хэсэг дотроо зураглалын дагуу резиндэж тоглоно.

Зураглал 1. Эхний резинд хоёр хөлөөс үсрээд резиний голд хоёр хөлөө зэрэгцүүлэн бууна. Хоёр дахь резинийг давж мөн адил хоёр хөлөөр үсрэн хоёр хөл дээр бууна.

Зураглал 2. Резиний голд хөлөө нийлүүлэн зогсоно. Үсэрч хөлөө салган, хоёр талын резиний гадна талд гишгэнэ. Үсэрч резиний голд хөлөө зэрэгцүүлэн бууна.

Зураглал 3. Резиний голд хөлөө нийлүүлэн зогсоно. Үсэрч хоёр талын резин дээр гишгэнэ. Үсэрч резиний голд хөлөө зэрэгцүүлэн бууна.

Зураглал 4. Хоёр талын резин дээр гишгэж зогсоно. Үсэрч эргэн хоёр хөлөөр резин дээр гишгэж бууна. Эсрэг тал руу эргэн үсэрч хоёр хөлөөр резин дээр гишгэнэ.



Багш өмнөх хичээлийн даалгаварт 4-6 м резин баг бүр бэлтгэн ирэхийг сануулна. Эхлээд 20 см өндөр резин дээр тоглоно. Дээрх гурван даалгаврыг бүгдийг алдалгүй биелүүлсэн сурагч 30 см өндөр резин дээр даалгаврыг гүйцэтгэнэ. Ийм байдлаар резинийг 10 см орчим хэмжээгээр өндөрсгөн тоглоход хамгийн сүүлд үлдсэн сурагч ялагч болно. Багш резинд үсрэх заавартай зураглалыг хэсгийн тоогоор бэлтгэн ирж тараах ба хананд байрлуулж болно. Сурагчид зураглалыг уншаад дүрмээ хамтран ярилцаж тоглоно. Багш багуудын дундуур явж алдааг засан зөвлөн тусална.

Алхам 3. 15-20см өндөр татсан резин дээгүүр 2 хөлөөр үсэрч давах

- Эхний удаа резинээ 15 см-т байрлуулна
- Хүүхдүүд 2 хөлөөс үсэрч давах
- Давахдаа резинийг огт хөдөлгөж шүргэхгүй давахыг сануулна.
- Үсрэхдээ дээш үсрэн 2 хөлийн өлмий дээр зөөлөн газардана.


Хичээл №28. Бөмбөг шидэх өнхрүүлэх дасгалууд

Зорилго: 1. Сурагчдын хоёр гараар бөмбөг шидэх, өнхөрүүлэх чадварыг дэмжин, хөгжүүлэх
2. Орон зайн баримжаалан хүчээ тохируулах чадвар эзэмших

Алхам 1. Хичээлийн эхний хэсэгт: цуваагаар алхах, зөөлөн гүйх, гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон 4-6 дасгалыг багш дагуулж хийнэ.

Алхам 2. Хоёр гараар бөмбөгийг дээш шидээд барьж авах

- Бөмбөгийг урдаа барьж зогсоод толгойны орчим өндөрт шидэн хоёр гараар тосож авах – 10 удаа
- Бөмбөгийг толгойноос дээш өндөрт шидэн хоёр гараар тосож авах 8-10 удаа
- Бөмбөгөө урдаас, толгой дээрээс татсан олсон дээгүүр шидэх дасгал 6 удаа
- Суугаад бөмбөгийг биеэ тойруулан эргүүлнэ.



Дунд зэргийн хэмжээтэй зөөлөн бөмбөг ашиглавал зохино. Бөмбөг шидэх, барих чадварыг хэрхэн гүйцэтгэж байгааг харж зайг холдуулах, арай өөр аргаар шидүүлэх зэрэг аргыг цаг тухайд нь тохируулан өгнө. Бөмбөгөө ямарч тохиолдолд барьж авч чаддаг болсны дараа өөр дасгал өгнө.

Алхам 3. Хоёр гараар бөмбөгийг урагш шидээд барьж авах

- 1 м, 2 м зайнаас хана руу бөмбөгийг хоёр гараар шидээд барьж авах
- Хоорондоо 1 м зайнаас бие бие рүүгээ бөмбөгөө шидэж дамжуулан барьж авах
- Бөмбөгөө оновчтой дамжуулж, сайн барьж авч буй сурагчид 2 м зайнаас бие бие рүүгээ



бөмбөгөө шидэж дамжуулан барьж авах

- Өвдөг дээр зогссон байдлаас бие бие рүүгээ бөмбөгөө шидэж дамжуулан барьж авах



Бөмбөгийг найзынхаа цээжний орчимд очихоор баримжаалан дамжуулахыг хэлээрэй. Бөмбөгөө найздаа дамжуулахдаа хэт хүчтэй шидвэл бөмбөг хаана очих вэ?, Хүч дутвал бөмбөг хаана унаж байна гэх зэргээр асууж ярилцах хэрэгтэй. Шидэх зайг хязгаарласан шугам татаж өгвөл сурагч шугамаас урагш гарахгүй шидэх болно.

Багшид санамж: Бөмбөгтэй дасгал өгөхдөө аль болох зөөлөн бөмбөг ашиглана. Хүүхэд бөмбөгийг дээш шидэхдээ шулуун шидэж чадахгүй бол волейболын татсан тор ашиглаж болно. Бөмбөгийг торыг дагуулан дээш шидээд барьж авах дасгалыг хийлгэх ба дараагийн удаа хана дагуулан дээш шидэн барьж авах дасгал хийлгэнэ. Аль болох бөмбөг болон бусад зүйлийг мэдрэн зөв хариу үйлдэл үзүүлэх чадварт сургах нь чухал.

Хичээл №34. Бай онох шидэлт

Зорилго: Бөмбөгөөр бай онож шидэх чадвараа сайжруулах

Алхам 1. Бие халаалт.


- Заал тойргоор зөөлөн гүйх. Чиглүүлэгчийн араас нэгийн цуваанд гүйлгэнэ.
- Гүйхдээ хуруу гарын дасгалыг хийлгэнэ.



Гүйх талбайг урьдчилан бэлдсэн байна. Зарим нэг газар тойрон гүйх, даган гүйх тэмдэглэгээ хийх ба дууны ая тавьж өгөөрэй.

Алхам 2. Бөмбөг шидэж бай онох

- Бөмбөгийг хоёр гараар шидэж газарт тавьсан цагирагт оруулах
- Бөмбөгийг хоёр гараар шидэж тавьсан байг онох
- Байрлуулсан бай руу бөмбөгийг шидэж оноод газарт ойлгон барьж авах
- Жижиг хаалга хийж бөмбөг өнхрүүлэн оруулах



Шидэх үед: Гар шулуун, байгаа сайтар харах, анхаарал, орон зайн баримжаа, гарын хүч зэргийг зохицуулна.



Сурагчид бөмбөгийг шидэж байнд оруулахдаа өөрт тохирсон аргыг сонгон хэрэглэнэ. Бөмбөгөө заавал хоёр гараар шидэхийг анхааруулна. Энэ дасгалын дараа хананд 2-2.5 м өндөрт 1.5 м диаметртэй 6-10 ш байг байрлуулан бэлтгэнэ. Дасгал бүрийг 6-8 удаа гүйцэтгэнэ.

Алхам 3. Бөмбөг дамжуулж тоглох

- Эхний сурагч бөмбөгөө дамжуулах сурагчийн нэрийг нь дуудан, түүн рүү бөмбөгийг дамжуулна. Бөмбөг авсан сурагч өөр сурагчийн нэрийг дуудан бөмбөгөө дамжуулах байдлаар үргэлжлүүлэн тоглоно.



6-8 сурагч нэг баг болно. Аюулгүй байдлаа ханган бөмбөгөөр цохиулахаас сэргийлэх, - бие биедээ тусалж дэмжин хүндэтгэлтэй харилцахыг анхааруулна.

Багшид зөвлөмж: Багшид зөөлөн жижиг бөмбөг байхгүй тохиолдолд цамц, подволк, оймс зэргээр хэрхэн жижиг бөмбөг хийж байсан ТВ хичээлийг эргэн санаж хүүхдүүддээ үзэхийг санал болгох ба гэртээ зөвхөн өөрөө хичээл дээрээ хэрэглэх хэрэглэгдэхүүн бэлдүүлэн ашиглаж болно. Жижиг бөмбөг гэж 10 см хүрэхгүй диаметртэй бөмбөг, Дунд зэргийн бөмбөг гэдэгт 11-20 см диаметртэй бөмбөг, Том бөмбөг гэдэгт 21 см-ээс дээш диаметртэй бөмбөгийг оруулна.



Ашигласан материал:

1. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж, Биеийн тамир 1-5-р анги, 2019 он ([meds.gov.mn/curriculum-baga.](https://www.meds.gov.mn/curriculum-baga), https://www.mier.mn/images/product_images/48a0f-biyiin_tamir_baga.pdf)
2. “Суурь, бүрэн дунд боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур” Биеийн тамир, 2021 он
3. “Биеийн тамирын багшийн ном– I”, 2014
4. “Биеийн тамир”-ийн 10 теле хичээл (medle.mn)
5. “Биеийн тамир”-ийн 2 интерактив хичээл (medle.mn)
6. “Эрүүл биед саруул ухаан-Дасгал, хөдөлгөөний ач тус” нэмэлт контент (<https://econtent.edu.mn/additional/261/100001345534375>)
7. “Өвчнөөс хамгаалах-Ханиаднаас урьдчилан сэргийлэх” нэмэлт контент (<https://econtent.edu.mn/additional/261/100001345534374>)
8. “Онцгой нүдний шил-Хараа хамгаалах, ялгаатай байдал” нэмэлт контент (<https://econtent.edu.mn/additional/261/200002440538279>)



3.1. ХАВСРАЛТ

1.1. Зургаан настай хүүхдийн хөгжлийн онцлог, судлах арга зүй

Сургуульд орсон эхний өдрөөс хойш хийх ярилцлага

Гол зорилго: Хүүхэд өсөж том болох үед дурсамж бүтээх, тэдний өсөлт хөгжил хэрхэн өөрчлөгдөж байгааг харах, дүгнэх юм.

Ярилцлага хийх заавар: Судалгааг ганцаарчилсан хэлбэрээр явуулбал илүү тохиромжтой.

Асуултын чиглэл: Нийт 12 багц асуултаас бүрдэнэ.

Анхаарах зүйл: Багш та хүүхэдтэй ярилцлага хийхдээ асуултыг нэмэх болон хасах боломжтой.

Сургуульд орсон эхний долоо хоногт багтан хүүхэдтэй хийх ярилцлагын жишиг загвар ашиглах хувилбар

д/д	Асуултын чиглэл	Хүүхдийн хариулт
1	Чиний нэр хэн бэ? (Хүүхэд өөрөө нэрээ хэлэх, хэн гэж дуудуулахыг хүсэж байгааг тодруулна)	
2	Чи хэдэн настай вэ? (Хүүхэд өөрийнхөө тухай мэдэж байх энгийн түгээмэл асуулт)	
3	Энэ зуны амралтаараа чи юу хийсэн бэ? (Дараагийн асуулт руу орохоос өмнө дасгах асуултын хэлбэр бөгөөд хүүхэд чөлөөтэй ярих сэдлийг төрүүлнэ)	
4	Чи сургуульд явах дуртай юу? (Сургуульд суралцах сонирхол, сэтгэл зүйн байдлыг тодруулна)	
5	Чи сургуульд орохын тулд яаж бэлдсэн бэ? (Сургуульд суралцах сэтэл зүйн бэлтгэлийг тодруулах асуулт. Энэ асуулт нь маш чухал асуултын нэг)	
6	Сургуулийн хамгийн гоё зүйл нь юу байна вэ? (Энэхүү асуулт нь сургуулийн талаар эерэг бодлыг төрүүлэхэд ач холбогдолтой)	
7	Чи хэнтэй найзалж байна вэ? (Хүүхэд харилцааны талаар хэрхэн суралцаж байгаа, шинэ найз нөхөдтэй болсон эсэх, тэдний талаар олон зүйлийг илрүүлэх асуулт)	
8	Маргааш сургууль дээрээ юу хийх вэ? (Үйл ажиллагааг төлөвлөх, өмнөх өдрүүдэд хэцүү байсан ч дараагийн удаа хичээх, урамшуулах талаас анхаарч ярилцах нь эерэг хандлагатай болгоход нөлөөлнө)	
9	Өнөөдөр болсон хамгийн хөгжилтэй зүйл юу байсан бэ? (Сургууль бол гунигтай биш, хөгжилтэй, аз жаргалтай байх орчин)	
10	Өнөөдөр шинээр сурсан зүйл юу вэ? (Шинээр сурсан зүйлийг нь тодруулах өөртөө итгэлтэй болох, сайн хийсэн сурсан зүйлийг нь бататгах)	
11	Чамд таалагдаагүй зүйл юу байсан бэ? (Хүүхэд найзгүй байсан, таагүй зүйлийг илрүүлэх, мөн цаашид тохиолдох бэрхшээлүүдээс урьдчилан сэргийлэх)	
12	Юу хийвэл маргаашийг илүү сайхан өдөр болгож болох вэ? (Анхаарлыг төвлөрүүлэхэд туслах, маргааш юу хийхийг нь сонгоход туслах)	

Ярилцлагын үр дүнг боловсруулах

Дүн шинжилгээ хийх зөвлөмж:

1. Сэтгэл зүйн үүднээс ярилцлагын асуултад хэрхэн хариулсан, хариулт тус бүрийг задлан шинжлэх хэрэгтэй.
2. Хүүхдийн хөгжлийн онцлог, ярих, илтгэх чадвар, харилцаа хандлага, сэтгэл хөдлөлийн илрэл, сурах үйл ажиллагааны сэдэл тэмүүлэл, цаашдын нөөц боломж, тулгарч буй асуудал түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход тус дөхөм үзүүлэх талаар санал зөвлөмж боловсруулах.



Хүснэгт 1. Эхний долоо хоногт багтан эцэг эхтэй (асран хамгаалагч) хийх ярилцлагын асуултын жишиг загвар ашиглах хувилбар

д/д	Асуултын чиглэл	Эцэг эхийн хариулт
1	Та яагаад манай сургуулийг сонгож хүүхдээ суралцуулах болсон бэ? Сургуулийн онцлог шинж чанарын талаар ярина уу? (Тухайн сургуулийг сонгох болсон шалтгаан, сургуулиас юу хүлээж байгааг тодруулах зорилготой.)	
2	Танайх хаана байдаг вэ? гэрийнхээ хаягийг тодорхой хэлж өгнө үү? (Хүүхэд сургуульдаа ирж буцахад хэр хол ойр байгааг тодруулахыг хүсэж байна. Жишээ нь гэр хол бол хүүхэд автобусаар явах тээврийн хэрэгслийг санал болгох зорилготой)	
3	Та ажилтай юу? (Таны ажил эрхлэлтийн байдал санхүүгийн чадавхыг тодорхойлох)	
4	Танай хүүхэд тусгай хэрэгцээтэй юу? (Багш нар хүүхдэд хэрэгтэй байж болох онцгой анхаарал шаардлагатай өвөрмөц хэрэгцээг мэддэг байх ёстой)	
5	Та өөрийнхөө тухай дэлгэрэнгүй ярихгүй юу? (Таны боловсрол, хүүхдэдээ хэрхэн тусалж чадах, гэрийн даалгавар хийхэд нь туслах гэх мэт)	
6	Таны гэр бүлийн байдал ямар байна вэ? (Гэр бүл хэдэн гишүүнтэй вэ? ганц бие эцэг эх үү? Эцэг эх гэр бүлийнхээтүхай илүү тодруулж асууснаар гэр бүлийн байр байдлыг мэдэхэд тусалдаг)	
7	Таны хүүхдийн талаар би мэдэх ёстой зүйл байна уу? (Хүүхдийн зан чанар, авьяас чадварын талаар хэлээрэй)	
8	Та хүүхдээ хэрхэн хүмүүжүүлдэг вэ? (Хүүхэд алдаа гаргасан тохиолдолд та ямар арга хэмжээ авдаг вэ? гэх зэргээр тодруулах)	
9	Та хүүхдээ ариун цэврийн өрөөнд зөв бие засаж сургасан уу? (Сургуулийн өмнөх боловсролд бас энэхүү асуултыг асуудаг түгээмэл асуулт юм.)	
10	Хүүхдийн тань хооллох зуршил ямар байдаг вэ? (Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа энэ нөхцөлд хүүхдийн хооллох зуршлын талаар мэдээлэл авах нь сургуулийн амин чухал асуудлын нэг юм)	

Ярилцлагын үр дүнг боловсруулах

Зөвлөмж:

1. Сэтгэл зүйн үүднээс ярилцлагын асуултад хэрхэн хариулсан, хариулт тус бүрийг задлан шинжлэх.
2. Гэр бүлийн байдал, хүүхдэдээ хандах хандлага, хүмүүжлийн арга хэлбэр, хүүхдийн хөгжлийн талаар тал бүрийн мэдээлэл олж авах.
3. Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах талаар санал дэвшүүлэх.
4. Эцэг эхэд зөвлөгөө өгөх, сургалт явуулах ажлуудыг төлөвлөх талаар баримжаална.

Хүснэгт 2. Хүүхдийн сонирхлын чиглэлүүдийг ажиглах жишиг загвар ашиглах хувилбар

Ажиглалт хийх он сар өдөр	Дотоод ажиглалт (давтамж)		Гадаад ажиглалт (давтамж)	
	Эхлэх цаг	Дуусах цаг	Эхлэх цаг	Дуусах цаг
	тэмдэглэл	Нийт давтамж	тэмдэглэл	Нийт давтамж
1. Биеийн хөгжил болон хөдөлгөөний хэрэгцээ сонирхол				
Дасгал хийх				
Авирах, дүүлэх				
Дугуй унах				
Барилдах, ноцолдох				
Гүйх, уралдах				
Хөдөлгөөнгүй суух				
2. Танин мэдэхүйн хөгжил сонирхол				
Шинжлэх ухаан				



Ном унших				
Тоо бодох				
Бичиж тэмдэглэх				
Туршиж хийж үзэх				

3. Хөгжим тоглох, дуу дуулах сонирхол, хэрэгцээ

Дуулах дуртай				
Хөгжмийн зэмсгээр тоглох дуртай				
Хөгжим сонсох дуртай				
Олон дуу шүлэг мэддэг, амандаа дуу аялах нь олон				

4. Тоглох хэрэгцээ, сонирхол

Зохион байгуулалттай тоглох				
Баатар болж тоглох				

Өрж байгуулах тоглоом /лего/				
Жүжиглэж тоглох				
Ганцаараа тоглох				
Компьютер, гар утсаар тоглох				

5. Хэл ярианы хөгжил болон бусадтай харилцах, хэрэгцээ сонирхол

Бусадтай ярилцах дуртай				
Үгийн нөөц, баялаг яриатай				
Үгийн сүлжээ, оньсого таавар зэргийг тоглох сонирхолтой				
Ээдрээтэй хүнд зүйл ярих, сонсох, утгыг нь тайлбарлах сонирхолтой				
Найз нөхөд олон				
Олон хүмүүсийн дунд байх дуртай				

6. Сурах сонирхол, хэрэгцээ

Бүтээх, дүрслэх урлах сонирхолтой				
Шаргуу, эхэлсэн ажлаа дуусгадаг				

Хүснэгт 3. Хүүхдийн тоглох үйл ажиллагаа болон нийгмийн харилцааны чадварыг ажиглах жишиг загвар ашиглах хувилбар

Ажиглалт хийх он сар өдөр	Дотоод ажиглалт (давтамж)		Гадаад ажиглалт (давтамж)	
	Эхлэх цаг	Дуусах цаг	Эхлэх цаг	Дуусах цаг
Хүүхдийн тоглох үйл ажиллагаа болон нийгмийн харилцааны чиглэл	тэмдэглэл	Нийт давтамж	тэмдэглэл	Нийт давтамж
Ганцаараа тоглох: Үе тэнгийнхэн болон нийгмийн харилцааг эрэлхийлдэггүй				
Зэрэгцэн тоглох: Хэн нэгний хажууд тоглодог боловч шууд харьцдаггүй				
Эвсэж, холбогдож тоглох: Бусадтайгаа тоглоомоо хуваалцдаг, ярилцдаг				
Хоршиж тоглох: Үе тэнгийнхэнтэйгээ тоглодог дүрэм журамтай, зохион байгуулалттай, ээлжилж тоглодог				
Үе тэнгийн харилцаа: Хөвгүүдтэй тоглодог				
Үе тэнгийн харилцаа: Охидтой тоглодог				



Багштай харилцах харилцаа: –Багштай ярилцах / санал бодлоо хуваалцах/ тусламж хүсдэг				
Хөндлөнгөөс оролцох: Хашхирч, хэрүүл маргаан дэгдээсэн /өдөөсөн/				
Маргаан: Цохих, үе тэнгийн рүүгээ орилж хэрүүл маргаан, зөрчил гаргадаг				
Асуудал шийдвэрлэх: Багшийн тусламжгүйгээр харилцан ойлголцож маргааныг шийдвэрлэх чадвар				
Багштай харилцах харилцаа: Багш нь үе тэнгийнхний маргааныг шийдвэрлэхэд туслах				

Жич: Ажиглалтын тэмдэглэл хөтлөх, төлөвлөгөөтэйгөөр хүүхдийн хөгжлийг өдөр өдрөөр ажиглах тэдний хэрэгцээ, мөн хөгжлийн цаашдын хүсэл зорилго нь юу вэ? гэдгийг хайж байдаг. Хүүхэд бүрийг ажигласан тэмдэглэл нь хувийн архив болон хадгалагдаж өнгөрснийг эргэн харах боломжтой. Хэрэв хүүхдийн шалтгаан нь эцэг эх, ар гэрээс нь болж байвал ар гэртэй нь уулзах, ярилцлага хийх гүнзгийрүүлэн судалж болно.

Үүний дараа хүүхдэд ямар бэрхшээл байгаа, хэрхэн хөгжүүлэх талаар олж харахад тусалдаг. тэдэнтэй ажиллах хөтөлбөр боловсруулах, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран ажиллах бүрэн боломжтой болно. Өдөр бүр хүүхэдтэй ажилласнаар хүүхэд бүрийн хөгжлийг илүү сайн танин мэддэг. Эрүүл мэндийн асуудалтай холбоотой шалтгаан байвал эмч, эцэг эхтэй холбоо тогтоож ажиллана.

Хүснэгт 4. Зан араншин ба зан үйлийн давтамжит чиглэлийг ажиглах загвар

Ажиглалт хийх нөхцөл: Ажиглалтын зорилго:

Судлаач:	Хүүхдийн нас
Хүүхдийн нэр:	Сургууль
Ажиглалт хийсэн он сар өдөр	
Ажиглалт хийх хугацаа:	

Ажиглалт хийх он сар өдөр	Дотоод ажиглалт (давтамж)		Гадаад ажиглалт (давтамж)	
	Эхлэх цаг	Дуусах цаг	Эхлэх цаг	Дуусах цаг
Зан араншин ба зан төлөвийн шинжүүд	тэмдэглэл	Нийт давтамж	тэмдэглэл	Нийт давтамж
Идэвх өндөртэй: Хөдөлгөөнгүй суух нь ховор, маш их холхидог, бусадтай уралддаг				
Анхаарал амархан сарнидаг : Үйл ажиллагаагаа өөрчлөхийн өмнө даалгавраа дуусгах /олон удаа харсан				
Төвлөрсөн: Даалгавраа дуусгахнаас өмнө өөр даалгавар луу шилждэг, заримыг нь гүйцэтгэсэн				
Хүчтэй хариу үйлдэл: Бусдад хариу үйлдэл үзүүлэхдээ сэтгэл хөдлөлийн илрэл нь маш хурц (орилох, чарлах, уйлах)				
Тайван байх: Аливаад шилжилт хийх чадвартай, урсгалаар явдаг, маргаан мэтгэлцээнд ордоггүй				
Мэдрэмтгий: Хүрэхэд зайлсхийж биеэ татах нүдээ аних, зарим хэсэгт хүргэхийг хүсдэггүй				
Болгоомжлох: Үйл ажиллагаанд орохоосоо өмнө эргэлздэг, хүмүүст дасахад цаг хугацаа шаарддаг				



Сайхан ааштай байдаг: Мишээх (ихэнхдээ инээх , бусадтай хөөрч тааламжтай байдаг)				
Ширүүн огцом ааштай: Шилжилт хийхэд бэрхшээлтэй өндөр ба доод түвшинг харуулдаг Бусадтай харьцахдаа инээмсэглэх нь ховор байдаг.				

Зөвлөмж: Хүүхдийн хөгжлийг дээрх арга зүйн тусламжтайгаар ерөнхий баримжааг багш та судалж үр дүнг тооцож гаргасан бол дараах дүгнэлтийг бичиж хүүхэд нэг бүрийн хөгжлийг үнэлж дүгнээрэй. Үүний дараагаар хүүхдэд тохирох хөгжлийн хөтөлбөр, дэмжих арга зүйг төлөвлөж, хэрэгжүүлснээр тухайн хүүхдийн хөгжилд ахиц гарах боломж бүрдэх юм.

2.1. Бэлтгэл хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй

Алжаал тайлах тоглоом

- | | |
|------------------------|-------------------|
| 1. Эрхий чи хаа байна. | Таны бие сайн уу? |
| Эрхий чи хаа байна. | Миний бие сайн |
| Би энд байна | Баярлалаа |
| Би энд байна | Баяртай |

Заавар: Хоёр гарын хуруунууд хоорондоо мэндэлнэ. Жишээ нь хоёр эрхий хуруугаа урд урдаас нь харуулан хооронд нь харьцаж байгаа мэт хөдөлгөөн хийж дуулна. Гарын таван хуруу тус бүр дээр дуулна.

2. Тоорой, тоорцог, тогоруу тоглоом

Заавар: Тоорой гэхэд хамраа дарна. Тогоруу гэхээр гараа алдалж нисэх хөдөлгөөн хийнэ. Тоорцог гэхлээр гараа толгой дээрээ тавина. Багшийн зааврын дагуу хэлсэн амьтныг нэгэн зэрэг дуурайж хийнэ. Мөн энэ тоглоомтой адил “Хэрээ, хэрэм” гэдэг тоглоомыг ашиглаж болно.

- | | |
|---------------------|-----------------------|
| 3. Нар гарлаа 1 2 3 | Мод ургалаа 1 2 3 |
| Бороо орлоо 1 2 3 | Салхи салхиллаа 1 2 3 |

Заавар: Нар гарлаа гэхээр сурагчид хоёр гараа өргөн хөдөлгөнө. Мод ургалаа гэвэл гараараа модны навчны ургаж байгааг дүрсэлнэ. Бороо орлоо гэвэл хуруугаараа ширээн дээр хөнгөхөн товшино. Салхи салхиллаа гэхээр хоёр гараар найгах хөдөлгөөн хийнэ.

- | | |
|------------------------------------|------------------------------|
| 4. Толгой, мөр өвдөг, хөл \2 удаа\ | Нүд, чих, хамар, ам \2 удаа\ |
|------------------------------------|------------------------------|

Заавар: Энэ дасгалыг хийхдээ толгой гэвэл толгойгоо, мөр гэхэд мөрөө, өвдөг гэхэд өвдгөө зааж хэлээд 2; 2 удаа давтана.

- | | |
|-------------------------|-----------------------|
| 5. Алгаа ташаарай 1 2 3 | Өвдгөө цохиорой 1 2 3 |
|-------------------------|-----------------------|

Хөлөө дэвсээрэй 1 2 3 Заавар: Дээрх үгүүдийг багшийн дараа давтан хэлээд хөдөлгөөнийг хамтад нь хийнэ.

6. Хоёр хулгана гаднаас ирээд

Нүхэнд ороод шуугиан тарилаа

Жууг жууг гэж чанга ярилаа

Заавар: Нэгээс тав хүртэлх тоог цээжээр тоолоход ашиглана. Хоёр хулгана, гурван хулгана гэх мэтээр давтан дуулна.



2.2. Монгол хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

№	Зурлага	Зурлагын нэр
1		Богино, урт шулуун зурлага
2		Орхицтой богино, урт шулуун зурлага
3		Дэгээ эхлэлтэй богино шулуун зурлага
4		Дэгээ эхлэлтэй орхицтой богино, урт шулуун зурлага
5		Машуу зураас эхлэл төгсгөлтэй богино, урт шулуун зурлага
6		Дугуймж эхэлсэн налуу богино, урт шулуун зурлага
7		Цацлага
8		Толцоо төгсгөлтэй урт шулуун зурлага
9		Толцоо эхлэлтэй урт шулуун зурлага
10		Хурц өнцөг төгсгөлтэй урт шулуун зурлага
11		Жижиг, тал бүтэн зууван дугуй зурлага
12		Баруун гар тийш харсан тал, жижиг зууван дугуй зурлага
13		Зүүн гар тийш харсан тал, жижиг зууван дугуй зурлага
14		Доошоо харсан хагас зууван дугуй зурлага
15		Хондлон шулуун зурлага
16		Дугуймж эхэлсэн хондлон шулуун зурлага
17		Зангилаа
18		Зартил
19		Хос цэг /дусал/

ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ: "Тт" ГИЙГҮҮЛЭГЧ АВИА, ҮСЭГ


Зорилго: "Тт" гийгүүлэгч авианы дуудлага, бичлэгийг таниулж, уншиж, бичиж сургах
Зорилт:

- "Тт" гийгүүлэгч авиаг үгийн бүтцээс ялган сонсож, зөв дуудаж сурах
- Үг, өгүүлбэрээс дармал ба бичмэл "Тт" үсгийг ялган таних
- "Тт" үсэг бүхий үе, үг, холбоо үг, өгүүлбэр уншиж сурах
- "Тт" үсэг, үе, үгийг элементийн дагуу бичих

Хэрэглэгдэхүүн: "Тэмээ" эх, битүү, задгай үеийн карт, зурагт үзүүлэн, видео бичлэг

Сургалтын арга: Авианы задлаг, нийлэг арга

Хичээлийн явц


Задлан хийх алхам	Хэрэглэгдэхүүн																																
Багш дэлгэцэнд богино хэмжээний бичлэг үзүүлэн /өөр бичлэг сонгож болно / түүнд тохирсон зургийг гарган асуулт асууж ярилцах Жишээ асуулт: • Бичлэгт юуны тухай гарсан бэ? • Өндөр өндөр байшинтай газрыг юу гэж нэрлэдэг вэ? • Хотын төв хэсэгт юу байдаг вэ? • Хот юугаараа онцлог вэ? Чи хаана амьдардаг вэ? гэх мэт	https://www.youtube.com/watch?v=6RyKxB8g_HY 																																
Эхээс өгүүлбэр сонгох : - Өндөр өндөр байшин хаана байдаг вэ? - Чи энэ хоёр газрын алинд нь амьдардаг вэ? /асуултыг өөрсдийн онцлогт тохируулан өөрчилж болно/	1. Өндөр өндөр байшин хаана байдаг вэ? 2. Чи энэ 2 газрын алинд нь амьдардаг вэ?  Өндөр байшин хотод байдаг. Би хотод амьдардаг.																																
Өгүүлбэрээс тулгуур үг сонгох: - Ямар үг хамгийн олон давтагдав? /хот/																																	
Шинэ авиа таниулах: Дараах асуултын дагуу ярилцана: • Багш сурагчдаас анхааралтай сонсохыг хүсээд “ХОТ” гэж 2-3 удаа хэлнэ. • Өмнө бидний үзсэн ямар авиа сонсогдож байна вэ? /х,о,т авиаг салган хэлж болно: • Бидний үзээгүй ямар авиа сонсогдож байна? /Т/ • “Т” авиаг хэлэхэд өгүүлэхийн ямар эрхтэн оролцож байна? гэж асуугаад сурагчдаар давтан хэлүүлнэ, ажиглуулна. / хэлний үзүүр дээд шүдний угт хүрч байна./ • “Т” гийгүүлэгч ямар авиатай ойролцоо хэлэгдэж байна вэ? /д/ • Сурагчдаар “Тт” авиаг хэд хэдэн удаа давтан хэлүүлнэ	/https://www.youtube.com/watch?v=_In-wa9A1CBc үзүүлж болно. “Т” /Хийн урсгалын хүчтэй түрэлт хэлний үзүүрийг шүдэнд тулган хамжсан хаалтыг задалж хэлэгдэнэ. Ардаа болон урдаа эгшиггүй хэлэгдэнэ  Т, Д (Н)																																
Шинэ үсэг таниулах: • Багш одоо тэгвэл “Тт” авиаг тэмдэглэдэг үсэгтэй танилцъя гээд дармал том, жижиг үсгийг харуулж юутай тасаатэй байгааг ярилцана. • Дармал том, жижиг Тт үсгийн төсөөг баримлын шавар, эсвэл шагайгаар хийлгэж болно.	Тт 																																
“Тт” үсэг орсон үг, өгүүлбэр унших: Зургийг ажиглаарай. Бидний үзсэн авиа хаана сонсогдож байгааг ярилцаарай. <table border="1"><tr><td></td><td>т</td><td>т</td><td>т</td></tr><tr><td>а</td><td>ат</td><td>аат</td><td>айт</td></tr><tr><td>э</td><td>эт</td><td>ээт</td><td>эйт</td></tr><tr><td>и</td><td>ит</td><td>ийт</td><td></td></tr><tr><td>о</td><td>от</td><td>оот</td><td>ойт</td></tr><tr><td>у</td><td>ут</td><td>уут</td><td>уйт</td></tr><tr><td>ө</td><td>өт</td><td>өөт</td><td></td></tr><tr><td>ү</td><td>үт</td><td>үүт</td><td>үйт</td></tr></table> Шатыг уруудуулан болон өгсүүлэн үеэ амилуулан уншаарай.		т	т	т	а	ат	аат	айт	э	эт	ээт	эйт	и	ит	ийт		о	от	оот	ойт	у	ут	уут	уйт	ө	өт	өөт		ү	үт	үүт	үйт	 ш а а р э м э э ш а ү г а л Зургийг ажиглан сурагчид хаана сонстож байгааг хэлнэ. 
	т	т	т																														
а	ат	аат	айт																														
э	эт	ээт	эйт																														
и	ит	ийт																															
о	от	оот	ойт																														
у	ут	уут	уйт																														
ө	өт	өөт																															
ү	үт	үүт	үйт																														

Нийлэг хийх алхмууд**Үсэг бичих:**

- * Бичмэл том, жижиг “Т,т” үсгийг харуулж, дармал үгээс ямар ялгаатайг ярилцана.
- * Эхлээд жижиг “т” үсгийг бичих дарааллыг тайлбарлаад агаарт бичүүлнэ. Дараа нь дэвтэрт бичүүлнэ.
- * Дараа нь том Т үсгийг бичих дарааллыг тайлбарлаад агаарт дараа нь дэвтэрт нь бичүүлнэ.
- * Дэвтэрт 2-оос илүү мөр хэтрүүлэхгүй бичүүлнэ.

**Үе, үг унших:**

- * Эхлээд битүү үеийг сайтар уншуулж, давтан давтан унших дасгал хийлгэнэ.
- * Дараагаар нь задгай үеийг уншуулах зэргээр сурагчдадаа үеүдийг уншуулан тогтоолгоно.

**Үг уншуулах, тайлбарлан бичүүлэх аргачлал:**


- * Богино үетэй үсгийг нөхүүлэн уншуулж шинээр үзсэн авиа үгийн хаана сонстож байгааг ярилцана.
- * Дараа нь сурах бичигт байгаа холбоо үгийг уншуулна.
- * Үгийн харьцуулан уншуулж үгийг утгыг тайлбарлан хэлж өгч үгийн санг нэмэгдүүлнэ. / Д,Т авианы хэлэгдэх байдлыг сайн ойлгуулахын тулд дээрх үсгийг уншуулж, авиа бүр өөр утга ялгадаг тул хольж сольж хэрэглэвэл үгийн утга өөрчлөгдөнө гэдгийг ойлгуулах./

**Өгүүлбэр дэлгэрүүлж тайлбарлах аргачлал:**

- * Багшийн самбарт гаргасан зургийг ажиглан холбож уншаад өгүүлбэр бүтээх
- * Бүтээсэн өгүүлбэрээ дэвтэртээ бичих, түүнийгээ найзууддаа уншиж өгөх

**Эх уншуулах, яриулах, бичих үйлд хөтлөх аргачлал**

- * Эхийг уншуулахдаа өнгөөр ялгасан хэсгийг шууд уншиж чадахгүй сурагчдаар үелүүлэн уншуулах
- * Эхийн утга санааг анги нийтээр нь асуултаар асууж
- * Эхээс өөрт төөлөгдсөн нэг өгүүлбэрийг бичүүлэх зэрэг үйлийг хийлгэж болно

**Үнэлгээ:**

Хичээлийн явцад өөрийн хичээлийн арга зүйд тохирсон аман болон урамшуулах, карт өгөх, хосоор үнэлэх зэрэг аргыг ашиглан хэрэглэж болно.

Бие дааж хийх ажил:

- Чөлөөт цагаар нь бие даалган бие даан ажиллах дэвтрийн гийгүүлэгч үсэг орсон дасгал даалгаврыг хийлгэж болно.

http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/01_tsagaan_tolgoi_uy.pdf





№	Чадвар	Агуулга	Хичээлийг бататгах сэдвийн нэр	Суралца-хуйн зорилт	Линк, QR код
1	Унших	Цагаан толгойн үе	Эгшиг үсгээ ялган нэрлэж, зөв уншъя	0.2a	 http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/01_tsagaan_tolgoi_uy.pdf
			"М, С" гийгүүлэгч үсгийг ялган таньж, зөв уншъя	0.2б	
			"Р, Х" гийгүүлэгч үсгийг ялган таньж, зөв уншъя	0.2б	
			"В, Л" гийгүүлэгч үсгийг ялган таньж, зөв уншъя	0.2б	
			"Н, Ш" гийгүүлэгч авиа үсгийг ялган таньж, зөв уншъя	0.2б	
			"М, С, Р, Х, В" гийгүүлэгчийг нүдэлж тогтоон, зөв уншъя	0.2б	
			"Б, Г, Д, Т" үсгүүдийг нүдэлж тогтоон, зөв уншъя	0.2в	
			"Ч, Ц, З, Ж" үсгүүдийг нүдэлж тогтоон, зөв уншъя	0.2в	
			"Ъ, Ъ" тэмдэг үсгийг ялган таньж, нүдэлье	0.2г, 0.2е	
			Онцгой "П, К, Ф, Щ" гийгүүлэгч үсгийг ялган таньж, зөв уншъя	0.2д	
		Эхийн агуулгыг ойлгох	Цуврал зурагт эхийг уншиж, ойлгоё	1.1б	http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/02_ehiin_aguulga_oilgoh_1.pdf
			Эхийг уншиж, ойлгоё	1.1б	
		Эхийн агуулгыг ойлгосноо тоочих, тайлбарлах	Үйл явдлын дарааллыг тоочъё	1.1в	
			Эхээс баатрын хийсэн үйлийг тоочъё	1.1г	
		Ойлгож уран унших	Цээжилснээ бусдын өмнө тод чанга дуугаар уншъя	1.1д	http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/05_oilgoj_uran_unshih_1.pdf
2	Бичих	Зөв бичих	Өгүүлбэр болон хүний нэрийг том үсгээр эхлэн зөв бичье	1.2б	 http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/07_zuv_bi-chih_1.pdf
			Цэг тэмдгийг зөв бичье	1.2б	
		Зохион найруулж бичих	Бүдүүвчид тохирсон өгүүлбэр зохиож суръя	1.2в	 http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/08_zohion_nairuulj_duurain_nairuulj_1.pdf
			Зурагт тохирсон өгүүлбэр зохиож суръя	1.2в	
			Загварын дагуу эх зохиож бичье	1.2д	
			Асуултаар эх зохиож бичье	1.2д	
			Зургаар эх зохиож бичье	1.2д	
			Өөрийгөө танилцуулан бичье	1.2е	
3	Хэл зүй,	Хэл зүй, үгсийн сан	Эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган танья	1.4a	 http://43.228.131.34/mieredu/bdsad/mh_baga/09_helzui_ugi-insan_1.pdf
			Үгсийг хэн? юу? яав? асуултаар ялгая	1.4б	
			Өгүүлбэрийг 1-2 асуултаар дэлгэрүүлъя	1.4в	
			Өгүүлбэрт цэг, асуултын тэмдгийг зөв хэрэглэе	1.4г	
4	Ярих - сонсох		Ойд төөрсөн найзууд		https://econtent.edu.mn/additional/261/200002440516631



2.4. Хүн ба Орчин-І “ЯМАР АМТТАН БЭ?” туршилттай хичээлийн ажлын хуудас

1. Бичлэгийг сонсоод юу байж болохыг таамаглаарай.

Сайн найзын төрсөн өдөр /Тааварт өгүүлэг/

Болдоо хүү энэ жил сургуульд ороод олон шинэ найзтай болсон. Нэг баг болж дасгал хийсэн Оюун, Туяа, Сүлдээ, Батаа дөрөвтэй дотно найзууд боллоо. Тэд дараагийн удаа Батаа найзынхаа төрсөн өдөрт уригдлаа. Болдоо найздаа бэлэг авах гэж яваад жаахан хожигдож очжээ. Болдоог очиход баярын ширээн дээр янз бүрийн амттан өнгө алаглан өрөөстэй, найзууд нь аль хэдийн ирчихсэн байлаа. Батаа найз нь түүнийг ширээнд урьж суулгаад, аяганд цагаан өнгөтэй шингэн уух зүйл аягалж өгөв.



1. Болд түүнийг болгоомжтойгоор авч удаан гэгч нь оочлон уув.

/Тэр юу байсан бэ?/

2. Яагаад удаан, оочилж уусан бэ?

3. Харин Оюун бөв бөөрөнхий, ув улаан зүйлийг амтархан идэж харагдана. /Тэр юу байсан бэ?/

4. Туяа үргэлж идэх дуртай зүйлээ авч шаржигнуулан идэв. /Тэр юу байсан бэ?/

Таамаглал: Тэр юу вэ? гэсэн асуулт тус бүрт хариулагдах зүйлсийг зураарай

1.	2.	3.	4.	5.	6.

Туршилт: Юу байсан бэ? Сонсоод түүнийгээ амталсан туршлагаараа тэмдэглээрэй.

А хэсэг

	Мөн ☐ Биш ☐		Мөн ☐ Биш ☐		Мөн ☐ Биш ☐
---	--	---	--	---	--

Б хэсэг

	Мөн ☐ Биш ☐		Мөн ☐ Биш ☐		Мөн ☐ Биш ☐
---	--	---	--	---	--

В хэсэг


	Мөн ☐ Биш ☐		Мөн ☐ Биш ☐		Мөн ☐ Биш ☐
---	--	---	--	---	--

Бататгах дасгал 1. Чихэрлэг болон исгэлэн амттай зүйлийг ялгаж, байрлуулна уу.



Бататгах дасгал 2. Эрүүл мэндэд ач тустай зүйлсийн ард + тэмдэг бичээрэй.



Сэдвийн үнэлгээ:

	①		②		③		④
БОЛД		НЯЛХ ХҮҮХЭД		ТУЯА		ОЮУН	
	☐		☐		☐		☐
				СҮҮТЭЙ ЦАЙ			

2.5. Иргэний ёс зүйн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

Багш, та

Анхаа сургуулийн сурагч болоод удаагүй байлаа. Анхны эцэг эх, сурагчдын хамтарсан хуралтай өдөр аав ээж нь хоёулаа завгүй байсан тул Анхаагийн эмээ нь хуралд суухаар иржээ. Хүүхдүүд багшийгаа “Та” гэж дуудах нь мэдээжийн хэрэг боловч эцэг эхчүүд ч гэсэн багшийг нь та гэж дуудахад Анхаа ихэд гайхав. Хурлын хамгийн өндөр настай хүн нь болох эмээ нь хүртэл “Багш аа, та” гэж ярих нь Анхаад тун хачирхалтай санагджээ. Багш:

- За цаг зав гаргаж ирсэн эцэг эхчүүддээ баярлалаа. Та бүхэн сайхан амраарай . гэхэд Эмээ:
- Баяртай багш аа, баярлалаа. Таны ажилд амжилт хүсье ! Анхаа харих замдаа эмээгийнхээ гараас хөтлөөд бодол болон алхаж явлаа. Анхаа:
- Эмээ та манай багшаас олон насаар ахмад, Тийм ээ ? Эмээ:
- Тиймээ хүү минь . Анхаа: - Бид нар өөрөөсөө ахмад хүнийг л та гэдэг, тийм ээ? Эмээ:
- Тийм ээ, Тэгэлгүй яах вэ. Анхаа:
- Тэгвэл та яагаад багшийг та гээд байсан юм бэ? Багш танаас хамаагүй дүү биз дээ? Эмээ нь:
- Тэр дороо зогсоод ямар нэгэн зүйл бодох мэт алсыг ширтэн байснаа Анхааг дагуулан ойролцоох мухлагт хүрэн хоёр мөхөөлдөс авч дэргэдэх сандал дээр тухлан суугаад сая л хариулж эхэллээ. Эмээ:
- Эмээ нь ч бас чам шиг жаахан байхдаа сургуульд орж, А үсэг заасан ачит багштайгаа учирсан юм. Багш минь бидэнд эрдэм сургаад зогсохгүй энэ хорвоод хэрхэн зөв, сайн хүн болж амьдрахыг зааж, чиглүүлж өгсөн юм даа. Анхаа:
- Манай багш ч бас бидэнд олон зүйл зааж өгөх үү? Эмээ:
- Тэгэлгүй яах вэ. Эмээд нь их олон багш байсан. Бага ангийн багш , дунд сургуулийн багш нар, ахлах сургуулийн багш, их сургуулийн багш, дугуйлангийн багш гээд бүгд л эмээгийн сайн сайхан амьдрахад маш их тусалсан. Анхаа:
- Гэхдээ манай багш танд туслаагүй шүү дээ. Эмээ:
- Хэний багш байх нь хамаагүй ээ хүү минь. Багш л бол багш. Багш хүн бүр сурагчдаа сайн сайхан байгаасай л гэж чин сэтгэлээсээ хүсдэг болохоор маш их цаг хугацаа, сэтгэл зүрхээ зориулж энэ ажлыг хийдэг байхгүй юу. Иймээс л эмээ нь багш хүн бүрийг хайрлаж, хүндэтгэж явдаг юм аа. Анхаа:
- Хайрлаж хүндэтгэсэн учраас “та” гэж дуудсан юм байна? Тийм ээ? Эмээ:
- Яг зөв чи анзаарсан байх аа. Өнөөдөр эцэг эхийн хурал дээр багшийг “Чи” гэж дуудсан нэг ч хүн байгаагүй тийм биз. Анхаа:
- Тийм тэгээд л би гайхсан юм. Эмээ:
- Хүн бүрийн амьдралд багш нар маш их үүрэг гүйцэтгэсэн болоод л тэр шүү дээ. Монголчууд бид хөгшин залуу, дарга цэрэггүй багш хүнийг “Та” гэж дууддаг сайхан соёлтой хүмүүс дээ. Анхаа эмээгийнхээ яриаг тун анхааралтай сонссон болоод ч тэр үү энэ өдрөөс хойш өөрийн эрхгүй багш нарыгаа хүндэлж, илүү дотночлон санах болжээ.

Эх сурвалж: www.medle.mn \Нэмэлт контентоос хэсэгчилж авав \ <https://medle.mn/additional/261/200002440538275>

АЖЛЫН ХУУДАС

1. Чи аав ээж, эмээ өвөө, багш нарынхаа үг, захиасыг хэр биелүүлдэг вэ? Бодож байгаад, тохирох бөмбөгийг будаарай



2. Дуулгаваргүй дэгдээхэйүүд” эхийн үйл явдлын зургийг дарааллын дагуу, дугаартай нь холбоорой



3. Дуулгаваргүй дэгдээхэй үг сонссохдоо ямар байсан вэ? Хариултыг сонгоорой



Үг сонсдог, дуулгавартай



Үг сонсдоггүй, дуулгаваргүй

4. Тохирох үгийг сонгож өгүүлбэрийг гүйцээгээрэй. Сонгох үгс: *сайн , муу*

Багш, энэ эх, асран хамгаалагч, ахмад настны үг сургаалыг дуулгавартай сонсож далавал хүүхэд болно.

5. Зүйр цэцэн үгийн утгыг ойлгон цээжлээрэй

Дуслыг хураавал далай
Дүүлсныг хураавал эрдэм

Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн хөтөлбөр ба сурах бичгийн агуулгын уялдаа
Нэгдүгээр анги

Нэгж хичээлээр		Ээлжит хичээлээр		Нэмэлт агуулга
Хөтөлбөрт	Сурах бичигт	Сурах бичигт	Ээлжит хичээлийн цахим контент	
Мэндлэх ёс	Мэндлэх ёс	“Мэндийн үг” “Гэгээн өглөө” “Амархан сайн байна уу?”	“Мэндийн үг”- “Мэндлэх ёс”, “Гэгээн өглөө” – “Амар сайн байна уу?”, “Амархан сайн байна уу?”- “Ахмадаа хүндэлье”, “Бусадтай хэрхэн мэндлэх вэ?”, “Зочноо угтах ёс”, “Эелдэг зөв мэндлэхийн учир”, “Биеэр хүндлэл илэрхийлэх”, “Мэндлэх хүндлэх үйлд тусалъя”	
Эрдэм номд хичээнгүйлэн сурах ёс	Хичээлээ анхааралтай сонсож сурах	“Зөв сууж сурцгаая”, “Анхаарай”, “Азтай мөндөл”, “Авхаалж самбаагаа сориорой”, “Сайн сурахад юу хэрэгтэй вэ?”	“Аль нь зөв бэ?”, “Зөв сууж сурцгаая”, “Анхаараарай” – “Анхаарал”, Анхааралтай сонсох арга”, “Авхаалж самбаагаа сориорой”, Анхааралтай сонсохын ач тус”, “Азтай мөндөл” – “Анхааралтай зөв сууцгаая” “Зөв сэтгэлээр сонсох арга”	“Ангийн найзууд”, “Эвийн хүч их”, “Эвсэг найзууд”, “Ангийн дүрэм”, баярлалаа”, “Уучлалт гуйх”, “Ажилсаг хүүхдүүд”
	Хичээлээ өөрийн болгон эзэмшиж сурах		“Бодлоо удирдаж суръя”, “Миний хичээл”, “Хичээлээ хэзээ давтах вэ?”, “Сайн сурахад юу хэрэгтэй вэ?” “Чармайн сурахын ач тус”, “Би чадах болов уу?”, “Би чадна”	
Сайн сурагч	Сайн сурагч	“Сайн сурагч”, “Дуулгаваргүй дэгдээхэйнүүд”, “Би хэн бэ?”, “Хүүхдийн дуртай дургүй зүйл”, “Би чадна”, “Сайн уу муу юу?”	“Үг сургаал сонсохын ач тус”-“Сайн сурагч”, “Үг сургаал үл сонсохын гэм”- “Дуулгаваргүй дэгдээхэйнүүд”, “Үг сургаал сонсох арга”, “Ахмадын сургаал алт”, “Өдөр бүр сана”, “Сайн уу муу юу?”, “Сайныг дагаж хэвшүүлъя”	
Багшийг дээдлэх ёс	Багшийг дээдлэх ёс	“Багшаа дээдлъя”, “Ангийн багш”, “Багшаа баярлуулъя”, “Багшийгаа танихгүй хөгөлсөн нь”, “Багш сурагч хоёр”	“Багшаа дээдэлье”, Багшаа дээдлэхийн учир”, “Ангийн багш”, “Багшаа дээдлээгүйн хор”, “Багшаа танихгүй хөгөлсөн нь”, Багшийн эрдэм”, “Багшийн ачийг саная”, “Багш сурагч хоёр”, “Багшаа баярлуулъя”, “Би чадна”	
	Эв эе		“Багш сурагчийн харилцаа”- “Баярлалаа” Найз нөхдийн харилцаа”, “Ангийн найзууд”, “Талархахын учир”- “Эвсэг найзууд”, “Уучлалт хүсэхийн учир”, “Уучлалт гуйх” “Ангийн дүрэм”, “Эелдэг зан чанар”- “Эвийн хүч их”, “Эвсэг найзууд”, “Ажилсаг хичээнгүй зан чанарт суралцах-Ажилсаг хүүхдүүд	
Таван хошуу мал	Уламжлалт баяр	“Миний тус”, “Жилийн эхэн хавар”, “Миний дээл”, “Амар байна уу?”, “Цагаан сарын мэнд”	Цагаан сар-Цагаан сарын мэнд”, “Битүүлэх ёсон-Жилийн эхэн хавар” “Шинэлэх ёсон”, “Золгох зан заншил, үг хэллэг”-Амар байна уу?, “Ураг удмаа мэдье”, “Ажил хөдөлмөрийн амт- Миний тус”, “Монгол гоёл-Миний дээл”	
Монголын уламжлалт баяр ёслолтой холбоотой зан үйл	Таван хошуу мал	“Бог бод мал”, “Малаа хайрлах монгол сэтгэл”, “Халзаадай”, “Эцэг эх, төл мал”	“Таван хошуу мал”, “Бог мал”, “Бод мал”, “Эцэг мал ба эх мал”, “Таван хошуу малын ашиг шим- Малаа хайрлах монгол сэтгэл”, “Халзаадай”, “Үндэсний баяр наадам” Уралдаан”	



2.7. Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1. ГАММ - Эгшгүүдийн цуваа

до	ре	ми	фа	соль	ля	си
C	D	E	F	G	A	H

2. Ноот - Эгшиг авиаг тэмдэглэх дүрс

3. Лига - Холбоос. Аливаа хоёр ижил эгшгийг нумаар холбохыг хэлнэ. Ийм нөхцөлд эгшгийн ерөнхий урт тухайн хоёр эгшгийн нийлбэртэй тэнцэнэ.

4. Легато - Холбоос. Эгшгүүдийг өөр хооронд нь салгалгүйгээр холбон дуулах, хөгжимдөх тэмдэг

5. Стаккато - Хөнгөн хурц тоглолт, цэгээр тэмдэглэнэ. Эгшгийг огцом тасалдуулан дуулах, хөгжимдөх арга. Эгшгийн дээр нь эсвэл доор нь цэг тавина.

6. Метр - Хэмжээ. Хүчтэй сул хувиудын тэгш хэмжээтэй дараалал

7. Камертон - Хөглүүр. Өнгө эгшгүүдийг зөв тогтооход хэрэглэх эгшиг дуурьсгагч багаж. Энэ багажийг хөгжмийн зэмсэг хийх болон хөгжмийг хөглөхөд хэрэглэдэг.

8. Ньюанс - Ялгаа

9. Октав - Наймц. Ижил нэртэй 2 эгшгийн хоорондох зай.

10. Ритм - Хэмнэл. Янз бүрийн урттай эгшгүүдийн зохион байгуулалттай дараалал.

11. Регистр - Дуучны хоолой болон хөгжмийн зэмсгийн царааны өнгөний ялгаа бүхий хэсэг.

12. Такт - Айзам. Нэг хүчтэй хувиас дараагийн хүчтэй хувь хүртэлх зай. Тактыг хүчтэй хувийн урдуур босоо зураасаар тэмдэглэнэ.

13. Тембр - Эгшиглэгээ өнгө аяс. Нэг эгшгийг өөр өөр хөгжмийн зэмсэг, өөр өөр хоолойгоор дуулах, хөгжимдөхөд ялгарах шинж.

14. Темп - Хурд. Хөгжмийн зохиолыг дуулах, хөгжимдөх хурд. Хурдыг зохиолын эхэнд үгээр тэмдэглэнэ.

15. Хор - Найрал дуу. Олноороо дуулах хамтлаг. Найрал дууны хамтлаг нь эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн гэж дагнасан байхаас гадна холимог байж болно.

16. Оркестр - Найрал хөгжим. Хөгжимчдийн хамтлаг. Симфони найрал хөгжим, үндэсний найрал хөгжим, үлээвэр найрал хөгжим гэх мэт.



Сурахуй бол сурагч өөрийн мэдлэг, туршлага, хэрэгцээ сонирхолдоо тулгуурлан мэдлэг, чадвар, арга барил, хандлага, зан үйлийг бие даан эзэмших, шинэ мэдлэг, стратеги бүтээх, өөрийгөө өөрчлөх бүтээлч үйл явц юм. Тиймээс дижитал эриний шинэ сурагчийн суралцахуйг ба та хэрхэн өдөөж, өгөх вэ гэдэг нь суралцахуйн онол, арга зүйн хувьсалтай салшгүй холбоотой. Багш та 1-р ангийн сурагчийн суралцахуйн үйлийг удирдан чиглүүлэхдээ дараах нээлттэй эх сурвалжуудыг бүрэн дүүрэн ашиглаарай.

Судлагдахуун	Судлах цаг	Суралцахуйн зорилт	Теле хичээл	Интерактив хичээл	Нэмэлт контент /аудио/
Монгол хэл	203	36	56	7	
Математик	116	15	38	7	
Хүн ба орчин	58	16	29	6	
Иргэний ёс зүйн боловсрол	58	28	16		
Дүрслэх урлаг, технологи	58	18	12	1	
Хөгжим	58	19	13	1	
Биеийн тамир	58	25	10	1	
Нэгдмэл агуулга			5	10	44

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн цахим хаягаар орж сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж болон бусад нэмэлт, гарын авлага, судалгааны материалуудыг авч ашиглах боломжтой.

(www.mnier.mn)

Боловсролын хүрээлэнгийн цахим хаягаар орж даалгаврын сантай танилцах, хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур, түүнийг хэрэглэх зөвлөмжүүдийг авч хэрэглэх боломжтой.

(www.mnier.mn)

Боловсролын мэдээлэл, технологийн төвийн цахим хаягаар орж сурах бичиг, теле хичээл, интерактив хичээл болон цахим хичээлийн төлөвлөлтүүдтэй танилцах боломжтой.

(www.medle.mn)

Боловсролын ерөнхий газрын цахим хаягаар орж багшид зориулсан зөвлөмж, зөвлөгөө, боловсролд хийгдэж буй цаг үеийн ажлын мэдээллүүдийг авах боломжтой.

(www.edu.gov.mn)



Тэмдэглэл

Handwriting practice area consisting of 20 horizontal dashed lines.





Хэвлэсэн тоо 1000ш

"ЭНХҮҮД ПАБЛИШИНГ" ХХК-д хэвлэв. 2022 он